ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ



АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 10

ХЯТАДЫН ЭРТНИЙ ДОМОГ ҮЛГЭР ДЭХЬ СҮНСЛЭГ АГУУЛГА

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 10

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

ХЯТАДЫН ЭРТНИЙ ҮЛГЭР ДОМОГ ДАХЬ
СҮНСЛЭГ АГУУЛГА

Аравдугаар боть

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

ГАРЧИГ

Намтрын өмнөх үг 4
Товч илгээлт 5
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар.....6
Өмнөх үг.....11
1 дүгээр бүлэг. Арьяабалын бясалгалын аргыг дадуулж байсан найман арш 12
2 дугаар бүлэг. Нүйва чулуу хайлуулж, тэнгэрийг нөхсөний далд утга санаа.....30
3 дугаар бүлэг. Ян Зигийн билиг ухаан.....44
4 дүгээр бүлэг. “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолын дүрүүд.....59
5 дугаар бүлэг. Бясалгал бүтээлийн зам дахь ад чөтгөрүүдээс болгоомжил.....66
6 дугаар бүлэг. Ид шид ба их билиг ухаан.....69
7 дугаар бүлэг. Цаг хугацаа, орон зайнаас хэтийдсэн их сайд.....93
8 дугаар бүлэг. Их Багш “Усан хөвөөний шастир”-ын талаар.....109
9 дүгээр бүлэг. Түүхээр багшлуулахуй.....131
10 дугаар бүлэг. Хатуу, зөөлнийг хослуулж чадвал төгс төгөлдөр мөн —Күнз болон түүний шавь нарын түүх.....149
11 дүгээр бүлэг. Бао Шуя, Гуань Жун хоёрын сайн үлгэр дуурайл..... 161
12 дугаар бүлэг. Улсаа төвшитгөх ухаан, дэлхийг амар амгалан болгох нь сүнслэг зам мөр.....178
13 дугаар бүлэг. Гэгээнтний өвчин.....189
14 дүгээр бүлэг. Гэгээнтэн хийгээд эгэл хүний ялгаа 198
Эх сурвалжийн лавлагаа.....205
Авшиг хүртэхүй: Арьяабалын бясалгалын арга 210
Таван сахил.....213
Веган хоолны ач тус.....214
Экологи ба хүрээлэн буй орчин.....219
Гэгээнтнүүд ба Үйлс нэгтнүүд 221
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт.....224
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ?..... 230

НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Ихээр билиг нээгдсэн нэгэн Их Багшийн дэс түвшнийг эгэл хүний чадвар болон энэ ертөнцийн үг хэлээр илэрхийлэх боломжгүй байдаг. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичээнгүйлэн тодорхой дүрсэлсэн ч бүрэн гүйцэд өгүүлэх аргагүй. Эрт цагт Энэтхэгийн нэг бясалгагчид Багшийнхаа намтар түүхийг бичих үүрэг оногджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг түүнээс асуухад дуусаагүй гэв. Дахин хэсэг хугацаа өнгөрсний дараа мөн л асуухад: “Миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн болохоор түүний дэсэд хүрч байж л би Багшийнхаа дүрстэй, дүрсгүй ажлыг жинхэнээр нь ойлгож чадна. Тийм болохоор энэ ажлыг хэзээ ч дуусгах аргагүй юм.” гэжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн урьдын амьдралын түүхээ дурдсан нь тун бага. Гэвч олон орны шавь нар нь Багшийнхаа намтрыг ихэд сонирхож, янз бүрийн асуултыг давтан тавьдаг учраас өөрийн түүхээ нээн өгүүлсэн билээ. Энэ товч намтарт Их Багшийн амьдралын замнал, түүхээс нь эмхэтгэн цуглуулж, найруулан бичсэн байна. Иймээс бүрэн гүйцэд биш байхыг үгүйсгэх аргагүй тул хүлцэл өчье.

ТОВЧ ИЛГЭЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай нь уран бүтээлч, сүнслэгийн хөтөчийн хувьд дотоод сүнслэг гоо сайхныг илэрхийлэх бүхий л хэлбэрт дуртай. Иймээс тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр бөгөөд “амар амгалан суурьшиж, ажил хөдөлмөрөө ташаах” гэсэн утгатай, өөрөөр хэлбэл ихэд жаргалтай гэсэн санаа юм. Харин “Формоса” буюу үзэсгэлэнтэй сайхан гэсэн утгатай нэр энэ эрдэнийн арал болоод ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлдэг. Ийм нэрийг хэрэглэх нь тухайн нутаг орон, ард иргэдэд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

Хайр Энэрлийн Зам

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхийд алдаршсан сүнслэгийн хөтөч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн билээ. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лакын (Вьетнам) төв нутагт мэндэлж, Европт очиж суралцсан бөгөөд тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажилласан байна. Тэрээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон зүдүүрээр дүүрэн байгааг олж мэдээд үүнээс ангижрах арга замыг эрэн хайхаар шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон байна.

Тэрбээр тухайн үед герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн өөрийн зорилгоо биелүүлэх аяндаа морджээ. Ийнхүү Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

үнэнийг эрэн хайж, сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнаж эхэлсэн байна. Эцэст нь Энэтхэгийн Хималайн ууланд нэгэн гэгээрсэн эрдэмт багш Түүнд дотоодын Гэрэл болон Аялгууг ажих "Арьяабалын Бясалгалын Арга"-ыг уламжилжээ. Ийнхүү Тэрбээр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрсэн ажээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980-аад онд байгуулагджээ. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, тэднийг өөрийн дотоод дахь Бурханлаг чанараа нээн илрүүлэхэд нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк таван тив болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном тайлуулахаар урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэрэн нигүүлсэх сэтгэлээрээ зовж зүдэрсэн олон түмэнд бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь аливаа хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн ядуу зүдүү хүмүүс, дорой буурай өндөр настан, шоронгийн хоригдлууд, хөгжлийн бэрхшээлтэй болон дүрвэгсэд, сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, орон гэргүйчүүд, АНУ-ын ахмад дайчид зэрэг хүмүүст түгэн хүрчээ.

Дулаарлаас үүдэлтэй элдэв хямрал дэлхий дахинд нүүрлээд байгаа өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг бөгөөд байгалийн элдэв гамшигт нэрвэгдсэн хүмүүст туслуулахаар нийгэмлэгийнхээ гишүүдийг дэлхийн бүхий л оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ дэлхийд бидэнтэй зэрэгцэн оршигч эрхэм ариун амьтад болон хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг билээ.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүний сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болж байна. Их Багш өөрийн уран зураг, дэнлүү чимэглэл, хувцасны загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлүүдийнхээ орлогоороо тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэдэг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Миний амьдрал дахь шувууд”, “Миний амьдрал дахь ноход”, “Эрхэм ариун амьтад” хэмээх гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулан гаргасан байна. Их Багш сэтгэлийн харилцаа болон сүнслэг ухаарлаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг энэ бүтээлүүддээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 дугаар сард “Дэлхийн Гэрэлт Манлайлагч” шагналыг, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатар”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй Үйлстэн”, “Дэлхийн Гэрэлт Шударга Үйлстэн”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгч” зэрэг олон цол шагналыг бий болгожээ. Энэ бүх нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс оронд олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлтай ажил үйлс нь манай гаргийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Янез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, Аль Гор, (НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Засгийн газар хоорондын хороо (IPCC)-той хамтран 2007 оны Нобелийн Энх тайвны шагнал хүртсэн), НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний

Хороо (IPCC)-ны тэргүүн бөгөөд Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Үндэсний Аэронавтик, Сансар судлалын захиргаа (НАСА)-ны сансрын судалгааны тэргүүлэх эрдэмтэн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Англиин нэрт приматологич (мич судлаач) доктор Жэйн Гуудалл нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амиа үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг нь сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Оюун Ухааны шагнал”-ыг олгодог бөгөөд үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Тэрээр ямар нэгэн үнэлэмж, хүндэтгэл эрэлхийлдэггүй ч Түүний дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон улсын төр засаг, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн сайшаан шагнаж, хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Теллигийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн Тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Иргэний Хүмүүнлэгийн шагнал (1994 он) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие сэтгэлийн харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд ихэд үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг билээ.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригоороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч юм. Үнэн хэрэгтээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Та ийм амьдралыг сонгож болно”, “SOS-дэлхийн дулаарлыг зогсоох нь” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ. Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан болон түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгох тал руу олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн билээ. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторан нь Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл, тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Дэлхий ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдэлтэй сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл, энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийдээ хүн төрөлхтний гэрэлт ирээдүйг цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон эцэс цуцалтгүйгээр тусалсаар байгаа билээ.

ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай ойлгоход бэрх, хатуу хөтүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой ярианы хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус, уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог.

Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж, түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.

Нэгдүгээр бүлэг

АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГЫГ ДАДУУЛЖ БАЙСАН НАЙМАН АРШ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайнань хот.
1988 оны 4 дүгээр сарын 8
(Эх нь хятад хэлээр)

Шар тогорууны нуруунаа буруу харан сууж, бишгүүрийн аялгууг сонордмуу

Өнөөдөр Энэтхэг, Ау Лакын түүх биш, харин Хятадын түүхээс ярья. Зарим хүн багшаас нь: “Их Багш аа, Та Арьяабалын бясалгалын дотоодын дуу Аялгуу үнэхээр гайхамшигтай гэдэг. Манай Хятадын үе үеийн Их Багш нар, эрдэмт хуврагууд яагаад энэ талаар ер дурдаагүй юм бол?” гэж асуудаг.

Багш нь номдоо Бодьдарма, Зургаадугаар үеийн Өвөг

Багш Хүй Нэн бүгд л Арьяабалын бясалгалын аргын тухай ярьсныг дурдсан. Хятадад их бясалгагч тун олон байсан.

Зөвхөн Хуанбо, Байжан, Хүй Нэн, тавдугаар үеийн Өвөг Багш Хун Рэн нараар тогтохгүй, Найман Арш ч мөн их бясалгагчид байсан. Тэдний бичсэн шүлгийг уншвал мэдэж болно. Жишээ нь, Лү Дунбин шүлэгтээ:

Энх амгалан цагт күнзийн сурталтны гэрт төрж,
Эгэл борог хувцас өмсөж, цацагтай бүс зүүдэг, би
Энхжингийн өргөөнд бурханд үйлчлэхийг хүсэн тэмүүлж буй хүн
Энэ хорвоогийн алдар нэр, ашиг хонжооны төлөө юунд тэмцэлдэх билээ
гэж шүлэглэжээ.

Тэрээр энэ шүлэгтээ тансаг амьдралд ташууралгүй, зөвхөн Зам мөрийг хайх зориг санааны тухай бичсэн ажээ. Энд бас Хэ Сяньгугийн нэг шүлэг байна, Багш нь орчуулж үзье. Багшийнх нь хятад хэл тийм ч сайн биш, хэрвээ Хэ Сяньгу энд байсан бол эхлээд Түүнээс өршөөл эрж, Багшид нь бүү уурлаарай гэж хэлэх байсан. (*Их Багш болон бүгд инээв*) Энэ шүлгийн гол санаа нь Тэрээр шар тогоруу хөлөглөж, саранд нисэн хүрч зугаалахдаа бишгүүрийн аялгууг сонссон тухай дүрсэлсэн ажээ.

Үхэлгүй мөнхөрсөн болон мөнх бус хүмүүсийн зам мөр
хоорондоо алс тусгаар атал

Үйлт хорвоогийн хэрэг явдалд автлаа хэмээн Магу
намайг шоолон инээхүйд
Шалавхан Цанжоу руу нисч гэгээн сарнаа
зугаалахдаа
Шар тогорууны нуруунаа тонгоруу суун бишгүүрийн
аялгууг сонордмуу.

Хэ Сяньгугийн *“Магу хайрханы оргилд бичсэн шүлэг*”-ээс

Хэрвээ Хэ Сяньгу жирийн нэг эгэл хүн байсан бол хэрхэн шар тогоруу хөлөглөж, саран дээр очин бишгүүрийн аялгууг сонсож чадах вэ? Шар тогоруу өчүүхэн жижиг биетэй, хэдийгээр Хэ Сяньгу бие багатай ч сүнсэн биеэрээ л яваагүй бол тогоруунаас унаж ойчих нь тодорхой. Тэр харин сүнсэн биеэрээ шувуу хөлөглөн үүлнээс дээгүүр нисжээ. Хэ Сяньгу өөр нэг шүлэгтээ:

Үй түмэн модонд тоорын цэцэг дэлгэрээд
Үүлэн эхт горхины үзэмж тэнгэрийн орноос ч гайхам
Хаш бишгүүрийн аялгуу Хуанлүн агуйгаас эгшиглэхүйд
Хан тэнгэрийн сахиулсан тогоруу хөлөглөн ирчихьэл яана

Тэр бас бишгүүрийн эгшиг сонссон гэжээ. Та нар ер нь ийм хөгжмийн аялгууг сонссон уу? Зөвхөн Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг хүмүүс л түүний юу ярьсныг ойлгоно. Хэрэв Арьяабалын аргаар бясалгадаггүй бол хэчнээн удаа уншсан ч ойлгохгүй, амаараа унших төдий л байж, уран гайхалтай, гүн гүнзгий утга санааг нь мэдэрч чадахгүй. Хэ Сяньгу бишгүүрийн аялгууг сонссон бодит байдлаас Түүний бясалгал нь маш дээгүүр дэс түвшинтэй байсныг мэдэж болно.

Өөрийн дотоодын бишгүүрийн эгшгийг сонсож чаддаг хэн ч хязгааргүй их хайрын хүчтэй байдаг бөгөөд үй олон төрөлтнийг өөртөө татаж чаддагийг зөвхөн Багш нь дурдаж байгаа биш, Ислам, Хинду шашинд ч ярьсан байдаг. Энэтхэгийн Кришна сургаалын эзэн ч үүний нэг жишээ юм[1].

Хүмүүс эртний Хятадын олон сайхан түүх, үлгэр домгийг өнгөцхөн уншаад тэдгээрийг ямар нэг утгагүй гэж боддог. Үнэндээ маш гүн гүнзгий утга агуулгатай. Арьяабалын бясалгалын аргыг дадуулсны дараа дахин уншвал эртнээс нааш өнөөг хүртэл их бясалгагч хүмүүс

1 Rama Krishna (Рама Кришна), ихэнхдээ Krishna гэж нэрлэнэ, Энэтхэгийн "Бхагавадгита" сударт Түүний тухай өгүүлдэг. Түүний бишгүүр үлээж буй зураг бас байдаг.

байсныг ойлгох болно. Хэрвээ ихэд гэгээрсэн нэгэн гэгээнтэн бидний өмнө илэрвэл хэн болохыг нь бид танихгүй байж магадгүй. Их бясалгагч хүмүүс аль ч эрин үед байсан, Найман Арш бол зөвхөн зарим төлөөлөгч нь юм. Тэд бүгд бясалгалаар тун дээгүүр дэстэй байжээ.

Хүний ертөнцийг огоорч, номын баясалд цэнгэнэ

Судар номд Лань Цайхэг дур зоргоороо бөгөөд өдөржин согтуу мэт байдаг гэж тэмдэглэсэн байдаг тул хүмүүс Түүнийг архи уудаг байсан гэж боддог[2].

Багшийнх нь бодлоор бол Тэрээр диваажингийн рашаан хүртсэнээс тийм байдалтай байжээ. Бясалгагч хүн ч мөн самади агуулсан үедээ яг согтуу мэт байдаг. Хүмүүс сайнаар хэлбэл тэд: “За сайн!” гэнэ, муулвал бас л “jiu he!” (жүү хэ!)[3] гэнэ, юу ч гэж хэлсэн тэдэнд адилхан.

Учир нь бясалгагч хүнд энэ дэлхийн явдал чухал биш болохоор хүмүүс хачин этгээд хүн гэж боддог, диваажингийн рашаан хүртдэгийг нь архинд согтсон гэж буруугаар ойлгодог. Дээдийн номын баяр баясныг үгээр илэрхийлэхэд бэрх гэдгийг ертөнцийн хүмүүс ойлгохгүй тул түүнийг согтжээ гэцгээдэг. Күнз, Чи улсад байхдаа хөгжмийн аялгуу сонсоод гурван сар мансууран суужээ. Энэ хөгжмийн аялгуу нь дотоодын Аялгуу болно.

Лань Цайхэгийн шүлэгт юун тухай өгүүлсэн бэ? Тэрээр:

Энэ хорвоод хавар, зун, намар, өвөл ээлжлэн цаг хугацаа
харвасан сум мэт өнгөрнө.
Эртний хүмүүсийн зам мөрийг эрээд ч олохуйя бэрх болмуй.
Энэ цагийн хүмүүс алдар нэр, ашиг хонжоо хөөцөлдөн өчүүхэн
ч чөлөө завгүй,
Эргэлтгүй цаг хугацаа нисэн одож, түмэн бодис нэгэн агшнаа

2 “Зүүн этгээдэд зорчсон тэмдэглэл” номоос дэлгэрүүлэн уншиж болно.
3 Формоса нутгийн аялгаар “маш сайн” гэсэн утгатай.

Элэн замхарч болзошгүйг ер үл анзаарна

Энэ бол Лань Цайхэгийн дуулсан дуу. Сонсоход тэр маш олон дуу дуулсан гэдэг. Энд ердөө цөөн хэдхэн дээж нь байна. Нэг шүлэгт нь өглөө хангарьди шувуу хөлөглөн хөх тэнгэрт дүүлэн ниснэ, үдшийн бүрийд буцаж ирэхдээ хөх далай мэт цэлийх ялам модны талбайг харахыг хүснэ гэж бичжээ. Үүлнээс чанад тоосгоор бус, алт, мөнгөөр бүтсэн үнэлж баршгүй орд харш бий гэнэ.

Хүний амьдрал хэдий удаан үргэлжилдэг тухай Цайхэ би дуулан бүжье.

Үзэсгэлэн гоо гэгч хаврын мод мэт, он жилүүд салхинд
эргэлдэх ээрүүл мэт
Эртний хүмүүс явж одоод эргэж үл ирэх атал харин одоо улам
олон хүн ирсээр байх ажгуу.
Эртлэн үүр цүүрээр би гарьди шувуу хөлөглөн хөх тэнгэрт
нисээд ирэхдээ
Үдэш яламын талбай цагаан давлагаа болж хувирсныг харлаа.
Үүлэн чанадад гэгээн наран гийгүүлэн тэнгэрийн хаяа алсран
үзэгднэм,
Алт, мөнгөн орд харш нь өндөр агаад сүрлэг ажгуу.

гэж шүлэглэжээ.

Лань Цайхэгийн дүрслэн өгүүлсэн энэ түвшин Бурханы шашинд ярьдаг Ариун оронтой тун төстэй, Баруун зүгийн Төгс баясгалант орны газар нь алтаар хучигдсан байдаг бөгөөд орд харш нь шижир алт, болор чулуу, шүр сувд, гартаам, хясаа зэрэг долоон эрдэнээр бүтээгдсэн байдаг. Тиймээс зөвхөн Шагжамуни Будда л Ариун орны тухай айлдсан төдийгүй, хятадууд ч бас “gan kuang” (Формоса нутгийн аялгаар “нэгэн ижил” гэсэн утгатай) түвшнийг ярьсан байна.

Багш нь бас Хэ Сяньгутай адил зүйлийг хэлнэ.

Арьяабалын аргаар бясалгавал дотоодын Аялгууг сонсоно. Хэ Сяньгу шиг дотоодын бишгүүрийн аялгууг сонсоно. “Богдсын ном Цагаан лянхуа судар”-т дотоодын Аялгуунд хонхны дуу, цангийн дуу, бөмбөрийн дуу, аянгын дуу, арслангийн хүрхрэх дуун бий гэж маш тодорхой бичжээ. Эдгээр нь гадна талын дуу чимээ биш, хэрэв эдгээр нь зөвхөн гадна талын дуу чимээ байсан бол Шагжамуни Будда “Богдсын ном Цагаан лянхуа судар”-ыг айлдахад тийм их цаг гаргахгүй байх байсан.

Библи сударт бас Эзэн Бурханы ярих нь аянгын дуу мэт, илрэн гарах нь асах гал мэт бөгөөд маш их тод гэрэлтэй гэж дурдсан байдаг. Энэ бол Гэрэл болон Аялгуу бүхий дотоодын ахуй ойлголт юм. Дорнын сургаал, өрнийн сургаал бүгд ижил. Та нар Дорно дахинд л сурч чадна, Өрнөдөд сурч чадахгүй гэсэн үг биш. Дорнын сургаал Өрнийнхөөс илүү онцгой, Өрнөдөд юу ч байхгүй гэсэн үг ч биш.

Бид үүнийг тодорхой судлаагүй, өөр өөр сургаал номлол, өөр өөр шашин шүтлэгийг нэгтгэж судлаагүй, тиймээс үл ойлголцол үүсэхэд амархан байдаг. Нэг шашин ч олон урсгалд хуваагдан өөр хоорондоо өрсөлдөн тэмцэлдэж, мэтгэлцэн маргалдаж байхад өөр шашнуудыг дурдахын хэрэг байна уу?

Зарим хүн Католик шашин, Христийн шашин бол харийн зүйл гэж боддог тул хүлээж авдаггүй. Эсвэл Багш нь Ау лак хүн болохоор олон хүн Багшаас нь суралцах дургүй байдаг, үүнийг Багш нь ойлгож байна, гэхдээ Шагжамуни Будда бас Энэтхэг хүн байсныг та нар мартсан байна!

Энэ дэлхий дээр маш олон улс орон бий бөгөөд Бурхан Багш төрөл тутамдаа зөвхөн нэг л улсад төрөөд байдаггүй. Бурхан Багшид тийм ялгаварлах сэтгэл байхгүй. Аливаа улс орны үндэстний хувь заяа өгсөж, уруудаж байдаг, хэсэг хугацаанд дарагдаж, зуун мянган жилийн дараа тэрхүү

газартай тэгшлэгдсэн байсан улс дахин сэргэн мандаж, маш хүчирхэг, баян болно.

Хятадын түүхэн дэх хаант гүрнүүдийн залгамжлалын хувьд ч мандал мөхөл нь мөн л ийм. Мөхөж сэхэх нь аль ч улсад адилхан тохиолддог. Тиймээс бурхан, эсвэл бодьсадва аль улсад мэндлэх нь тухайн ард түмний буян хишгээс хамаардаг, харин өөрийн дуртай, дургүйд дулдуйдан төрөх газраа сонгодоггүй.

Заримдаа бурхан, бодьсадва нар тодорхой нэг газар төрдөг ч тэр нутагтаа амьдран сууж чаддаггүй. Жишээ нь, Шагжамуни Будда Капилавасту (одоогийн Балба улс)-д төрсөн ч тэнд амьдраагүй. Тэрээр дөрвөн зүг, найман зовхист аялан явж, сургаал номоо айлдсан. Есүс Христ ч бас адилхан, Тэрээр Бетлехемд төрсөн ч тэнд амьдраагүй, Энэтхэг, Төвөдөд очиж, Дээдийн номд суралцсан бөгөөд дараа нь Үнэн ёсыг дэлгэрүүлэхээр олон орноор явжээ. Тиймээс их бясалгагч хүний хаана төрөх нь хамаагүй, Түүнтэй уулзаж чадах эсэх нь л бидний хувьд илүү чухал.

Эртнээс нааш жинхэнэ Мөрийг олж гэгээрсэн хүн хэд байна вэ?

Зуун бүрийн төгсгөлд Их Багш нар, гэгээнтнүүд, их бясалгагчид хамаг төрөлтөнд дээдийн сургаал ёсыг танилцуулж, чанагуух ертөнцийн Гэрэл гэгээгээр энэ дэлхийг гэрэлтүүлэхийг хичээдэг. Тиймээс нэгэн зууны сүүлийн хагаст маш олон Их Багш Дээдийн ном дэлгэрүүлэхээр гарч ирдэг байна. Одоо бид нэгэн зууны хоёрдугаар хагаст амьдарч байгаа болохоор ном сурталчлахаар олон хүн гарч ирж байгааг сонин хэвлэл, зурагтаас харж болно.

Зарим хүн надаас: “Хүн бүхэн өөрийгөө Их Багш гэнэ, бид хэнээс нь суралцах ёстой вэ?” гэж асуудаг. Багш нь тэдэнд: “Сонгох боломжтой олон Их Багштай байгаад тань

та бүхэнд баяр хүргэе! Сонгох боломжтой хүн байхгүй бол хамгийн хэцүү байх болно, тиймээс бүү гомдолло.

Өөртөө илүү тохирох Их Багшийг олсон бол Түүнийгээ бүхий л зүрх сэтгэлээрээ дагаарай. Хэрэв боломжоо ашиглахгүй бол хожим харамсаж мэднэ! Түүнийг гэртээ харьсны дараа зууны төгсгөл үе ч улиран одож, тэр үед Дээдийн ном дэлгэрүүлэх Төгс Гэгээрсэн Их Багшгүй бол яах билээ?" гэж хэлдэг.

Дэлхийн өнцөг булан бүрд Их Багш нар бий, хэрэв бид бясалгал хийхийг хүсэхгүй бол Тэдэнтэй уулзаж чадахгүй, чин сэтгэлгүй бол Төгс Гэгээрсэн Их Багшийг олж чадахгүй, тэр ч байтугай Төгс Гэгээрсэн Их Багш өмнө тань ирсэн байсан ч бид зугтаж одох болно. Шагжамуни Буддаг амьд сэрүүн заларч байх тэр үед Түүнтэй уулзах боломж олон хүнд байсан ч тэд Түүнийг бурхан гэдэгт нь итгэдэггүй байжээ. Нэгэн эмэгтэй бие давхар мэт хуурмаглаж, Буддагийн ном айлдаж буй газарт очин Түүнийг гүтгэн гүжирджээ. Эцэст нь тэнгэрийн найман луут сахиус бүсгүйн хувцсыг ярж, нуусан түмпэнг нь ил гаргажээ[4].

Энэтхэгт байдал ийм байхад өөр бусад оронд Дээдийн ном дэлгэрүүлэх бүр ч хэцүү. Тиймээс та бүхэн эртнээс нааш төрөл тутамд бурхан, бодьсадва, ихэд гэгээрсэн хүмүүс энэ дэлхийд заларсан байтал яагаад ийм цөөхөн хүн гэтлэгдсэн юм бол гэж эргэлзэж гайхах хэрэггүй. Лү Дунбины Их Багш Жун Ли Чуань нэгэн шүлэгтээ:

Эгшин зуурын зугаа цэнгэл, шоглоом наадам хөөцөлдсөөр
ядарлаа
Эх захгүй байдал, үймээн шуугианыг бодохоор сэтгэл
шимширнэм
Эгээрч, амар амгаланг олж чөлөөлөгдсөн хүмүүн хэчнээн
билээ гэж

4 "Бурхан Багшийн айлдсан "Брахман бүсгүй Жанша Буддаг гутгэсэн үйлийн үрийн барилдлага"-ын тухай судрын 8 дугаар бүлгээс уншиж болно.

Эхнээс нь, зав гарган тоолон тоолон суухуйд үнэхээр ховор ажгуу. гэжээ.

Энэ шүлэгт гэтлэгдсэн хүн хуруу дарам цөөн байдгийг маш тодорхой өгүүлжээ. Эртний хүмүүс сайхан сэтгэлтэй, бясалгал дадуулах цаг ихтэй байсан. Гэвч харин маш цөөхөн хүн туулан гэтэлсэн байна. Одоо амьдрал дэндүү тав тухтай, бидний сонирхлыг татах, анхаарлыг сарниулах зүйл хэтэрхий их болсон байгаа болохоор туулан гэтлэх орчин үеийн хүмүүс бүр ч цөөн байгаа байх. Хэдийгээр материаллаг иргэншил нь амьдралыг илүү тав тухтай, амар хялбар болгодог ч бид ийм тав тухтай амьдрахын төлөө цаг завгүй болчихжээ.

Өмнө нь зурагт байсангүй, мэдээ, мэдээлэл маш удаан тархаж, хэн нь хэнийг хөнөөж байгааг, эсвэл дэлхий яаж үймж байгааг бид мэддэггүй байсан. Одоо бол зурагт байна, бид заримдаа нэг нэвтрүүлэг үзчихээд дараагийнхыг нь үздэг бөгөөд үргэлжлүүлэн үзсээр зурагтаа ч унтраахаа мартдаг. Зурагт хэтэрхий их үздэгээс үлдэх цаг нь хязгаарлагдмал болжээ.

Өчигдөр нэг хүн Багшаас нь: “Би өдөрт ердөө тавхан цаг унтдаг, үргэлж нойр дутуу явах болов, одоо хангалттай нойр авч чадахгүй бол яах ёстой вэ?” гэж асуусан. Үнэн хэрэгтээ түүнд унтах цаг хүрэлцэхгүй байгаа биш, зурагт, киног хэт их үзэж, радио, дуу хөгжим сонсож, сонин сэтгүүл уншиж, мөн бүжиглэж, караокед дуулах зэргээр өөр олон зүйл хийсээр хангалттай цаггүй байгаа юм.

Өнөө үед хоол хийх арга технологи нь бас дээр үеийнх шиг энгийн биш, дэндүү нарийн төвөгтэй болжээ. Өмнө нь хоолны орц тийм ч элбэг байгаагүй. Ау Лакт урьд нь онцгой үйл явдал болон баяр наадмын үеэр л зочдод зориулж махан хоол бэлтгэдэг байсныг би санаж байна. Одоо хүмүүс өдөр бүр маш их мах идэж байна, мөн тав тухтай байлгах олон төхөөрөмж бий болж, хүмүүс энэ бүхнийг худалдан авахын

төлөө цаг завгүй ажиллаж, мөнгө олох хэрэгтэй болжээ.

Хөршийнд нь нэг зүйл байгааг харвал тэр нь манайд ч бас байх ёстой, хэрвээ бидэнд байхгүй бол нэг л хачин, хоцрогдсон мэт санагдах болно. Урьд нь Багшийнх нь амьдарч байсан газарт орчин үеийн эд бараа гэхээр юм байгаагүй. Бидэнд гэрэл цахилгаан ч, утас ч байгаагүй нь бясалгах, бас хамаг төрөлтөнд тустай зүйлс хийх маш их цагийг хэмнэж байжээ.

Хүмүүстэй харилцах боломжийг олгодог утастай байх нь үнэхээр таатай, гэхдээ энэ нь бас сул талтай, учир нь ямар нэг зүйл тохиолдоход бид зүгээр л утсаар ярьчихдаг нь биднийг найзуудтайгаа уулзах, хамаатан садан дээрээ зочилж очихоос залхуурах болгодог. Найз нөхөд, ах дүү, хамаатан садны харилцаа суларсаар өмнөх шигээ гүн дотно биш болсон байна.

Тиймээс хэдийгээр сайн зүйл байсан ч сайнаар ашиглахгүй бол бясалгалд ч сайн биш, амьдралд ч тусгүй. Заримдаа иргэншлийн багаж хэрэгсэл биднийг хүлээсэлж, төвөг удаж, цаг зав дэмий үрдэг, тиймээс сайн болон муу талтай.

Эртний хүмүүст бясалгалд нь нөлөөлөх харилцаа холбооны олон янзын хэрэгсэл байгаагүй, бясалгал дадуулдаг хүн тун цөөхөн байжээ. Орчин үеийн амьдралын хэмнэл ийм хурдассан тул бясалгах хүн аяндаа цөөрсөн нь мэдээж. Энэ нь зүй ёсны хэрэг. Хүмүүс шинэ машин, загварлаг хувцас, зурагт худалдаж авахын тулд мөнгө олох гээд дэндүү завгүй болжээ.

Гэхдээ Формосагийн хүмүүсийн хувьд энэ нь тийм ч том асуудал биш байж болох юм, учир нь гадаад явах нь цөөн тул мөнгөө дотооддоо зарцуулна, тиймээс хүн бүр маш тав тухтай амьдарна. Аялал жуулчлалын аль ч газар очсон

жуулчид ихтэй байдаг, өөр очих газаргүй болохоор өмнөд нутгийн хүмүүс хойшоо, хойд нутгийнхан нь урагшаа аялан дурсгалт газруудыг үзэж сонирхдог.

Би олон оронд очиж байсан. Формоса бол тун үзэсгэлэнтэй газрын нэгэнд орно. Гэвч газар нь жижиг, хүн ам шигүү суурьшсан газар юм. Арал нь жижигхэн болохоор зарим үзэсгэлэнтэй газар нь үнэхээр сүрлэг тод харагддаг. Хүн болгон тэнд очиж зугаацах дуртай, тиймээс хаана ч очсон хүн ихтэй.

Миний бодлоор ийм байх нь бас сайн, энд нэлээд цэвэр ариун, элдэв муу нөлөө багатай. Мэдээж гадаадад очвол олон сайн зүйлийг сурч чадна, гэхдээ дэлхийн юмсын ихэнх нь муугаар нөлөөлдөг. Лаоз хэлэхдээ: “Гэгээнтэн хүн гэрээс гаралгүй дэлхийн байдлыг бүгдийг мэдэж болно.” гэжээ. Бид Лаоз шиг болж чадвал бас тун сайн.

Найман Аршийн түүхийг уншвал Тэд үнэхээр үхэшгүй мөнхийн хутагт хүрсэн гэдгийг мэдэж болно. Хэ Сяньгугийн хойд эх нь түүнд тун хатуу ханддаг байсан ч тэрээр хойд эхдээ урьдын адил маш их ачлалтай байсан нь Лү Дунбины сэтгэлийг хөдөлгөжээ. Тэгээд түүнд нэгэн Аршийн тоор бэлэглэсэн байна. Аршийн тоорыг идээд Хэ Сяньгугийн билиг ухаан ихэд нээгдэж, үхэшгүй мөнхийн хутгийг олжээ.

Найман Арш бол бүгдээрээ мөнхийн хутгийг олсон төрөлтнүүд юм. Гэтэл үхэшгүй мөнхөрсөн Тэд яагаад одоо бидэнтэй тааралдахгүй байна вэ? Тэд бол хятад хүмүүс, тэгэхээр Тэд хаа нэгтээ заавал илрэн гарах ёстой! Үхэшгүй мөнхрөх гэдэг нь махан бие нь үхэшгүй мөнхөрсөн бус, харин сүнсэн бие нь үхэж, төрөхийн сансрын хүрднээс чөлөөлөгдөж, үүрд мөнх үхэхгүй, төрөхгүй болж, Ханьцашгүй үнэхээр төгс туулсан Бодь мөрийн хутгийг олж, Бурхан Буддатай ижилхэн болсон гэсэн үг юм.

Лү Дунбины ярьсан Арш нь яг л Бурхан Багштай адилхан юм. Будда шиг болно гэдэг нь Бурханы хутагт хүрсэн гэсэн үг. Гэсэн хэдий ч Тэр өөрийгөө нэгэн Бурхан болсон гэж хэлж зүрхлээгүй. Хүмүүст буруу номтон гэж буруутгагдаж, дайрч доромжлуулахаас айсан тул өөрийгөө Бурхан Багш шиг гэж хэлсэн байна. Ингэж хэлсэн нь маш даруухан бөгөөд илүү аюулгүй байжээ.

Бурхан Багш ч мөн үхэшгүй мөнх бөгөөд үхэж, төрөхийн сансрын хүрднээс чөлөөлөгдсөн. Бид Бурхан илрэн гарч ирээд бидэнд харагдаасай гэж хүсдэг, гэвч Бурхан ирэхэд бид тэнгэрийн нүдгүй, бурхны мэлмийгүй бол харж чадахгүй.

Манай авшигтнуудын дунд бурхан, бодьсадва, арш хувилгаадыг хардаг хүн олон бий, та нар итгэж байна уу? (*Итгэж байна гэж нэг хүн хариулав.*) Бид өмнө нь ном тайлахаар Гаосюнд очихдоо Найман Аршийн сүмд хоноглосон юм. Манай шавь нарын нэг нь Лү Дунбин Багштай нь мэндчилэхээр ирж, Багшид нь мөргөж байхыг бясалгаж суухдаа харжээ. Үүнийг миний шавь ярьсан бөгөөд тэр үед бас олон хүн сонссон. Их Багш өөрөө ярьсан юм байна гэж бодоод намайг бүү буруутгаарай. (*Бүгд алга ташив.)*

“Найман Арш далайг гаталсан нь” кинонд Найман Арш Лаозыг хүндлэн угтаж байгааг дүрсэлсэн байдаг. Та нарт санаанд багтамгүй санагдаж, Найман Арш Лаозтай ямар холбоотой билээ гэж гайхаж байна уу? Холбоо байгаа, учир нь бясалгал сайтай хүмүүс өнгөрсөн, одоо, ирээдүйн олон Төгс Гэгээрсэн Их Багшийг харж чаддаг юм.

Тиймээс Багш нь та нарт ямар ч шашинд итгэсэн бай, өнгөрсөн үеийн ямар ч Төгс Гэгээрсэн Их Багшийг шүтсэн бай ялгаагүй бүгд сайн. Тэднийгээ үргэлжлүүлэн шүтэж болно, гэхдээ Арьяабалын аргаар бясалгаж байж л сая

Тэдний үнэн бодит дүрийг харж чадна гэж олонтоо ярьсан билээ.

Гаосюнд, Лү Дунбиныг харсан тэр шавь маань Найман Аршийг шүтдэггүй бөгөөд Тэдний нэрийг нь ч бүрэн тогтоогоогүй байсан. Тэр хэлэхдээ ээжийнх нь гэртээ хүндлэн шүтдэг Найман Арш ирж, Багшид хүндэтгэл үзүүлсэн, гэхдээ ээжийнх нь хамгаас илүүтэй шүтдэг нь Лү Дунбин билээ гэсэн.

Шагжамуни Будда: “Хамаг төрөлтөн Бурхан чанартай.” гэж айлдсан. Есүс Христ: “Бид бүгдээрээ Эзэн Бурханы хүүхэд мөн.” гэжээ. Бид аль шашинд итгэх нь хамаагүй, гэхдээ бид заавал төгс төгөлдөр католик шашинтан, төгс төгөлдөр бурхны шашинтан, төгс төгөлдөр Игуандао сургаалтан, Даогийн (Бумын) шашинтан, Күнзийн сургаалтан гэх зэрэг болж чадна гэсэн дотоодын ахуй ойлголттой байх ёстой. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Миний Америк шавь бас Лаозыг харжээ. Тэрээр хожим хөрөг зургийг нь харах хүртлээ Түүнийг хэн болохыг нь мэдээгүй байсан. Заримдаа хэдийгээр бид итгэж сүсэглэдэггүй байсан ч Тэднийг харж чаддаг, бясалгаж суугаа үедээ бидний сүнс Тэдний байгаа орноор дайран өнгөрөх үед Тэдэнтэй уулзах нь гарцаагүй. Тиймээс Найман Арш Лаозтай хамт байсан нь үнэн бодитой явдал юм.

Бид хэдийгээр Бурханы дэсэд хараахан хүрээгүй байгаа ч бидэнд бурхан, бодьсадва, гэгээнтнүүдтэй уулзах боломж байсаар байгаа, тиймээс бид тийм ч өнчин ганцаардмал биш. Гэхдээ бид бас их ганцаарддаг, учир нь энэ бясалгалын зам мөр юу ч шаарддаггүй, зөвхөн биднээс огоорч орхихыг л шаардана. Бид Бодь мөрийн хутгийг олж чадахын тулд эгэл хүний аливаа өрөөсгөл, тогтсон үзэл бодлыг орхиж, бүхий л үзэл баримтлалыг хаяж, өөрийн

сэтгэлийг бүрэн хооослох ёстой.

Бодь мөрийн хутгийг олох нь бид олон судар номыг ойлгосон эсэх, аль ямар сургууль төгссөн, дээд, доод албан тушаалтан эсэхтэй огт хамаагүй. Өчигдөр өөрийн сүнслэг бясалгалын тухай ярьсан номын ах бол таксины жолооч, өнөөдөр тайзан дээр гарч ахуй ойлголтоо ярьсан хүн бол сургуулийн багш байлаа. Ажил мэргэжил нь өөр ч тэр хоёрын ахуй ойлголт тун сайн байна.

Тиймээс хүн бүхэнд найдвар бий, хэн ч гэсэн хүлээлттэй байж болно. Бясалгалд эрхэм дээд болон эгэл доорд гэсэн ялгаа байхгүй, энэ нь зөвхөн үнэхээр чин сэтгэлээсээ байгаа эсэхээс л шалтгаална. Бид сэтгэлийн гүнээсээ энэ ертөнцөөс залхсан, үхэж, төрөхийн сансрын хүрднээс ангижрахыг үнэхээр хүссэн, их билгүүн ухааныг олж хүртэхийг үнэнхүү хүссэн, Баруун зүгийн Төгс баясгалант орон луу буцах үнэн сэтгэлийн хүсэлтэй байх хэрэгтэй.

Бурханы шашны Ариун орны шүтлэгт Баруун зүгийн Ариун оронд очихыг сэтгэлийн гүнээс маш хүчтэй хүсэх нь тун чухал гэж онцолдог[5]. Жинхэнэ Ариун орны шүтлэг бол ийм л байдаг. Тэрнээс өдөр бүр бурхныг дурсахыг дадал болгож, амандаа тарни уншивч сэтгэлдээ дэлгүүрээс хүнсний зүйл худалдаж авах тухайгаа бодож байх, эсвэл зарим нь мааниийн эрих тасралтгүй эргүүлж, бурхныг дурссан хэвээр байх боловч гэнэт хүүхэд нь ирээд түүнд саад болбол эрих гүйлгэхээ зогсож: “Чи юу хүсээ вэ?” гэж төвөгшөөн хэлэх явдал биш юм. *(Бүгд инээв.)*

Мааниийн эрих ямар хэрэгтэй вэ гэж нэг хүн Багшаас нь өчигдөр асуусан, би “Магадгүй тэд хүүхдээ зодоход

5 Ариун орны шүтлэг нь итгэл, хүсэл, явдал мөрөө Баруун зүгийн Ариун оронд мэндлэх нөхцөл болгодог бөгөөд хамгийн чухал нь Баруун зүгийн Төгс баясгалант орон үнэхээр оршин байдаг гэдэгт итгэсэн итгэл үнэмшилтэй байх ёстой байдаг..

ашигладаг байх.” гэж хариулсан. (*Бүгд инээв.*) Багшид нь энэ эрихийг зүүх ямар ч онцгой утга учир байхгүй. Шавь маань сэтгэлээсээ өргөсөн болохоор л зүүдэг. Маанийн эрих нь зөвхөн номын багшийн хэрэгсэл төдий, үүнийг зүүвэл харахад илүү сүрлэг, эрхэмсэг байх бөгөөд хүмүүсийн нүдэнд таатай харагдана. Та нар Багштайгаа уулзахын тулд ийм сайхан хувцаслаад ирдэг, Багш нь бас бурхдад хүндэтгэл үзүүлэхийн тулд илүү сайхан хувцас өмсдөг. Та нар бүгд бурхад шүү дээ! *(Бүгд алга ташив.)*

“Богдсын ном Цагаан лянхуа судар”-т бичсэнээр: “Баршгүй саналт бодьсадва Арьяабал бодьсадвад сувд эрдэнийн сондор өргөжээ. Арьяабал бодьсадва уг нь авахаас татгалзсан боловч Шагжамуни Будда хөндлөнгөөс оролцож: “Хамаг төрөлтнийг буян хишигтэй болгохын тухайтад та үүнийг хүлээн авах ёстой.” гэв. Тэр үед Арьяабал бодьсадва хамаг төрөлтний тусын тулд зөвшөөрчээ. Тэрээр сондрыг хоёр хувааж, нэг хэсгийг Шагжамуни Буддад, нөгөөг нь “Олон эрдэнэт Бурханы суваргад өргөв.”

“Богдсын ном Цагаан лянхуа судар”-т бясалгагч нарын дотоодын ахуй ойлголтын тухай бичсэн байдаг. Тэд бясалган суух, эсвэл авшиг хүртэх үедээ дээд түвшинд хүрч, Арьяабал бодьсадваг Шагжамуни Будда болон Олон эрдэнэт Бурхантай уулзан ярилцаж байгааг харжээ. Ийм гайхалтай ахуй ойлголтыг тэнд байсан хүн бүхэн харж чаддаггүй. Ойлгов уу? Та нар ойлгохгүй байна уу? За, тэгвэл багш нь цааш тайлбарлая.

Өчигдөр ном тайлах үеэр тэнд байсан зарим хүн Багшаас нь Гэрэл цацрахыг харжээ. Гэрэл тэдэн рүү туссан байна. Зарим нь Багшийнх нь бие биндэрьяа болор бие болон хувирахыг харжээ. Үүнийг та нар бүгд хараагүй, цөөн хэдхэн хүн л харсан, гэхдээ тэдгээр хариу мэдрэх зөнтэй хүмүүсийн харахад Багш нь өөр өөрөөр илэрсэн байна.

Бурханы хутагт хүрэх нь шинжлэх ухаанд нийцнэ

Үүнээс гадна, зарим хүн Багшаас нь та бидэнд хүч чадлаа үзүүлж болох уу гэж асуудаг. Үнэндээ зарим хүн Багшийнхаа хүчийг мэдэрдэг ч ихэнх хүн үүнийг олж харж чаддаггүй. Тэгтэл бас харсан хүмүүсийн асуусан асуулт нь өөр өөр байсан, тэдний зарим нь: "Их Багш аа! Та Арьяабал бодьсадва мөн үү?", зарим нь: "Их Багш аа, та Газрын зүрхэн бодьсадва мөн үү?" гэж асуудаг.

Учир нь тэд бүгд өөр өөр Их Багшийг харсан учраас Багш нь яг хэн болохыг нотлохыг хүсжээ. Тэд бүгд Багш нь мөн, гэхдээ бас биш. Учир нь дүрс болон дүрсгүй хоосон хоёр нь адилхан. Хэрвээ би мөн гэвэл бас биш. Хэрвээ биш гэвэл бас буруу, учир нь угаасаа мөн. *(Бүгд алга ташив.)*

Ханьцашгүй үнэхээр төгс туулсан Бурханы бодь хутагт хүрвэл бид юм бүхэн мөн, гэхдээ бас биш. Учир нь бид "Зам мөр"-ийг олчихсон, гэхдээ бидэнд "Зам мөр"-ийг олчихсон гэх бодол төрдөггүй. Энэхүү "Зам мөр" бол үнэхээр сэтгэгдэшгүй бөгөөд тайлбарлахын аргагүй, тиймээс "Хэлж өгүүлж болдог Мөр бол мөнхийн Мөр биш." гэж ярьдаг байна.

Заримдаа бид хэн нэгнийг харахад "Зам мөр"-ийг маш гүнзгий ухаарч ойлгосон мэт байдаг ч тийм сайн гэгээрээгүй байдаг, зарим хүнийг харахад "Зам мөр"-ийг олоогүй мэт байдаг ч үнэндээ "Зам мөр"-ийг маш гүн гүнзгий ухаарч ойлгосон байдаг. "Зам мөр" бол үнэхээр хөл толгой нь эргэсэн явдал юм. Тиймээс Багш нь шавь та нартаа: "Хэрвээ биднийг хүн загнавал талархах хэрэгтэй. Хүн биднийг магтан сайшаавал сэрэмжтэй байх ёстой, учир нь бидний би гэх үзэл илрэн гарч ирэх болно." гэж байнга захидаг.

Биднийг загнах үедээ тэр хүн бидний үйлийн

түйтгэрийг хуваалцаж, бидний би гэх үзлийг угаан цэвэрлэж, биднийг илүү цэвэр ариун болгож, илүү болгоомжтой бодож, алдаа оноогоо дэнсэлж, бардамнах юм өөрсдөд үнэндээ байхгүйг ухаарч, илүү номхон даруу болгоно. Тиймээс үйл түйтгэрийг угаан цэвэрлэх гэдэг нь тийм ч нууцлаг зүйл биш, тун шинжлэх ухааны хэрэг мөн. Үйл түйтгэр, үйл үр, буян хишиг энэ бүхнийг шинжлэх ухаанчаар тайлбарлаж болно.

Бясалгал ч бас шинжлэх ухаантай адил юм. Жишээ нь, эрдэмтэд усыг хэрхэн мөс болгохыг мэднэ. Жирийн хүн суралцсаны дараа бас усыг мөс болгож чадна. Тийм биз? Дээр үед зарим бясалгагч буурцаг цацаад цэрэг болгодог ид шидийн хүчтэй байжээ. Өнөөдөр бид бас усыг мөс болгож чадна. Ийм чадвар нь дээр үед ид шидэд тооцогдож байсан бол одоо энгийн нэг химийн урвал болохыг хүн бүхэн мэднэ. Аргыг нь мэдвэл бид ч бас усыг мөс болгож чадна. Жишээлбэл, биохими судалдаг хүн өөр өөр химийн элементийн нэгдлээр харилцан адилгүй үйлчлэлтэй олон эм, хортой бодис, сайн эм, саар эмийг гарган авдаг. Ихэнх хүн энэ ертөнцийн ид шидийг сурах дуртай, харин бурхны ид шидийг сурах дуртай хүн байдаггүй. Жинхэнэ байдлыг ойлгодоггүй хүн л бясалгагч хүн этгээд сонин, ойлгогдошгүй гэж боддог.

Их Багшийн номд бүгд л гайхамшигтай зүйлс, жишээ нь олон янзын дэс түвшин, бясалгалын хүч гэх зэргийг ярьсан байдаг гэж зарим хүн хэлдэг. Үнэндээ Багш нь заавал хүч чадлын талаар ярих шаардлагагүй, би бас урлагийн талаар ярьж болно. Бясалгалын аргыг заавал шууд өнцгөөс ярих биш, өөр нэг талаар нь орон зайн шинжлэх ухааны урлаг гэж бас ярьж болно.

Дэлхийн шинжлэх ухааны аргаар бол усыг мөс, мөсийг ус болгож, мөн олон бодисыг ямар нэг өөр зүйл болгон хувиргаж чадна. Орон зайн шинжлэх ухааны

урлагийн хувьд энэ нь хүнийг нэгэн бурхан болгон хувиргаж чадна, бидний харанхуй мунхаг уураг тархийг их билгүүн ухаан болгон өөрчилж чадна.

Тиймээс сүнслэг дадал бясалгал бол ер бусын нууцлаг зүйл биш, орчлон ертөнцийн юм бүхнийг сурч болно. Заримдаа бид нэг хэсгийг, заримдаа хоёр, эсвэл гурван хэсгийг нь сурдаг, заримдаа бүгдийг сурдаг. Бүгдийг амжилттай сурч, юм бүхэнд нэвтэрч чадсан хүн бол Бурхан юм. Анагаах ухаанд суралцсан хүнийг эмч гэнэ, хуулийн чиглэлээр мэргэшсэн хүнийг хуульч гэдэг. Тэгвэл бид Бурханы хутагт хүрье гэвэл Бурханы шинжлэх ухааны урлагт суралцах хэрэгтэй. Арьяабалын бясалгалын арга бол хүмүүст суралцан төгсөж, нэгэн … болох боломжийг олгодог шинжлэх ухааны урлаг юм. *(Бурхан гэж нэг хүн хариулав.)* Тийм ээ! Баярлалаа!

Хоёрдугаар бүлэг

НҮЙВА[6] ЧУЛУУ ХАЙЛУУЛЖ, ТЭНГЭРИЙГ НӨХСӨНИЙ ДАЛД УТГА САНАА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Гаосюн хот.
1988 оны 5 дугаар сарын 11
(Эх нь хятад хэлээр)

“Чулууны тэмдэглэл” дэх сүнслэг бясалгалын тухай далд утга

“Чулууны тэмдэглэл” буюу “Улаан асрын зүүд” зохиолд Нүйва чулуу хайлуулж, тэнгэрийг нөхсөн түүх гардаг. Нүйва тэнгэрийг нөхөж дуусахад ганц чулуу үлдсэн байна. Тэр чулуунд Нүйва гар хүрсэн болохоор маш их зөн билигтэй болсон бөгөөд олон зүйлийг ойлгох чадвартай болжээ. Ихэнх хүн эдгээр түүхийг уншаад хошин тоглоом

6 Нүйва (Хятад уламжлалт 女媧, хялбаршуулсан 女娲, пиньинь Nǚwā) нь хүн төрөлхтнийг бүтээгч, дэлхийг үерээс аврагч, нөхөрлөл, гэрлэлтийн бурхан болсон Хятадын (Даогийн) шашны агуу эх бурхан, охин тэнгэрийн нэг юм. Википеди толь

гэж бодох, эсвэл хүүхдүүдэд зориулсан шидэт үлгэр домог гэж үздэг.

Гэхдээ энэ нь үлгэр домог биш. Арьяабалын аргаар бясалгадаг хүн бол ямар ч ном уншсан бай түүний жинхэнэ утгыг ойлгож чадна. Тэр ч байтугай хүүхдийн уншдаг ном ч гэсэн цаанаа сүнслэг бясалгалын гүн гүнзгий утга агуулж байж болно. Учир нь бурхны хүч чадал аугаа, Зам мөрийн хүч чадал сэтгэгдэшгүй их, түүнээс зөвхөн өчүүхэн багыг хүртэхэд л хэдийнээ асар их шидийг олж, дэлхий дахины олон бэрхшээл, түмэн зовлонг шийдэж чадна. Тэгвэл Зам мөрийг бүрэн төгс бүтээж чадвал ямаршуухан болох бол? Тиймээс бид эрт дээр үеэс өнөөг хүртэл Бурхадыг, Төгс Гэгээрсэн Их Багш нарыг магтан алдаршуулж ирсэн, учир нь Тэд энэ агуу хүчийг хэдийнээ төгс олж хүртсэн байдаг.

Чулуу шидтэй болдог түүхийг ихэнх хүн яавч сүнслэг бясалгалтай холбож бодохгүй. Гэвч зохиолч өөрөө сүнслэг бясалгал дадуулдаг хүн байсан учраас Үнэн ёсыг ойлгодог байжээ. Тэрээр зарим нэг зүйрлэлийн аргыг ашиглан сүнслэг бясалгалын хүч чадлыг илэрхийлсэн байна.

Нэгэн Их Багш бол их хүч, Эзэн Бурхан, их билиг ухааныг төлөөлдөг, тиймээс Түүний хүч чадал сэтгэгдэшгүй их, бүх орчлон ертөнцийн хүч Түүний дотоодод байдаг. Тэр хүссэн бүхнээ хийж чадна, үйл үрийг эвдье гэвэл эвдэнэ, хүссэн төрөлтнөө тамаас аварна. Бүгд асуудалгүй. Тиймээс их бясалгагчийн хувьд бид Түүнийг даган суралцвал бидний таван үе, тэр ч байтугай есөн үеэрээ төрөл дэвших нь тун энгийн хэрэг болох бөгөөд ямар ч асуудалгүй. Өвөг дээдэс маань бидэнтэй цусан төрлийн холбоотой учраас их бясалгагч багш тэдэнд тусалдаг юм.

Чулууг алт болгох ер бусын хүч

Яагаад Нүйвагийн гар хүрсэн чулуу билиг ухаантай

болсон бэ? Учир нь Нүйвад сэтгэгдэшгүй их хүч чадал байдаг тул Түүний гар хүрсэн юм бүхний дэс дээшилж, сүнслэг чанартай болж хувирна.

Миний Өвөг Багш амьд сэрүүн байхдаа нэг удаа манай Их Багштай уулзахаар очжээ. Багш маань өөрийн гэсэн тусгай бясалгалын өрөөтэй. Өвөг Багш залрахад бясалгалын өрөөндөө Түүнийг суулгасан аж. Өвөг Багш буцсаны дараа тэр өрөөнд өдөр шөнөгүй, хорин дөрвөн цагийн турш хөгжим эгшиглэх болсон байна. Өмнө нь тийм байгаагүй. Өвөг Багш ирж сууснаас хойш өөр болсон ажээ. Өвөг Багш тэнд байгаа эд зүйлсийг адислаж, амьтай, сүнслэг болгосон байна. Тиймээс чулууг сүнслэг амьд төрөлтөн болгох сэтгэгдэшгүй их хүч зөвхөн Нүйвад байсан биш, Их Багш нарт бүгдэд нь ийм төрлийн хүч чадал байдаг байна.

Түүнээс хойш Багшийн бясалгалын өрөөг цоожлох болж, хэнийг ч оруулахгүй, зөвхөн Багш өөрөө л тэр газрын гайхамшгийг эдлэн баясдаг болжээ. Зарим хүн хэтэрхий бүдүүлэг байдаг тул ариун дагшин уур амьсгалыг сэвтээх вий гэж Багш их эмээдэг байсан.

Энэ дэлхийн зарим хүнд бодьсадвагийн чанар давамгай, зарим хүнд эгэл ертөнцийн бүдүүлэг чанар их байдгийг бид бүгд мэднэ. Тийм биз? Ариун гэгээн хүмүүс харахад нүдэнд дулаахан, сэтгэлд их тааламжтай, энэ нь эгэл ертөнцийн тааламжтай сайхан бус, харин туйлын эрхэм дээд, машид гэгээрсэн тааламжит байдал юм. Сэтгэл зүрх тайвширч, нэгэн зүйлийн баяр баяслаар бялхаж, бид өөрсдийгөө бясалгал дадалд зориулахыг хүсэж, өөртөө эрхэм дээд хүслэн, ариун зорилго байгааг мэдрэх болно.

Зарим хүнээс, эсвэл зарим нэг газарт орохын зуурт л нэг тийм таагүй бодол халдварладаг. Гэнэт л энэ ертөнцийн эд юмсыг хүсэж, сэтгэл санаа тогтворгүй болдог, тийм биз?

Энэ нь хүн бүрийн соронзон талбай (хэлбэлзэл) адилгүйгээс болдог. Их бясалгагч хүний соронзон талбай маш цэвэр ариун, тайван тогтуун байдаг. Бид Тэдэнтэй уулзвал зөвхөн эерэг бодолтой болж, бясалгал хийн туулан гэтлэхийг, эрхэм дээд үйл хэрэг бүтээхийг эрмэлздэг. Материаллаг зүйлсийн талаар огтхон ч бодохгүй. Маш хүнд муу үйл түйтгэртэй л биш бол хүмүүсийн ерэн есөн хувь нь эрхэм дээд үйл хэргийн тухай л боддог. Хэрэв бусармаг мууг бодсоор байгаа бол энэ нь тун ховорхон байдаг нөхцөл байдал болно.

Шагжамуни Будда маш олон хүнийг бясалгал хийх сэтгэл үүсгэхэд зоригжуулж, олон арван мянган хүн Түүнийг даган гэрээс гарсан буюу бясалгал хийжээ. Гэвч ганц хоёр эмэгтэй арай өөр бодолтой байсан байна. Жишээ нь, Матажи бүсгүй Шагжамуни Буддагийн гэрээс гарсан шавь эрхэмсэг Анандад сэтгэлтэй болсон. Уг нь бид гэрээс гарсан хүнийг хараад ихэд хүндэлж, бясалгах сэтгэл төрдөг. Гэтэл Анандыг хараад Матажи бүсгүйд бясалгах сэтгэл төрөөгүйгээр барахгүй, Анандын сэтгэлийг татах тарни хүртэл уншиж байжээ, тиймээс энэ нь арай ангид явдал юм.

Анандыг харсан эмэгтэй хүн бүхэн ийм байдаг биш, гэхдээ Ананд үнэхээр дэндүү царайлаг сайхан залуу байжээ. Тиймээс Шагжамуни Будда түүнийг гараа бүхэлд нь ил гаргасан хувцас өмсөхийг зөвшөөрдөггүй байсан. Тэр үед Энэтхэгт гэрээс гарагсад бүгд гараа ил гаргасан хувцас өмсдөг байв. Харин Ананд тэгж хувцаслаж болохгүй, учир нь Шагжамуни Будда бүсгүйчүүд түүнд сэтгэл татагдах вий гэдгээс эмээжээ.

Тэрээр Бурхан Багшийн ийм их ивээл хамгаалалтын дор байсан ч Матажи бүсгүйн сэтгэлийг хөдөлгөсөн аж. Түүний сэтгэл татагдсан нь ч яах вэ, дараа нь тэр бүсгүй ирж, Шагжамуни Буддаг даган гэрээс гарсан байна. Шагжамуни Будда ч ер хохирол амсаагүй, Анандыг алдаагүй бөгөөд нэмээд нэг гэрээс гарагчтай болжээ.

Матажи бүсгүй гэрээс гарсны дараа түүний сүнслэг бясалгалын дэвшил Анандынхаас илүү хурдан байв, тэр ихэд хичээнгүй бөгөөд хатуужилтай бясалгасан учраас Анандаас бүр өмнө гэгээнтэн болсон. Ананд, Шагжамуни Будда нирваанд орсны дараа л жинхэнээр гэгээрсэн юм.

Энэ их хүч чадал зөвхөн бурхдад л байдаг биш, эгэл хүмүүст ч бас байдаг бөгөөд ямар ч зэрлэг араатан, хорон санаатныг гэсгээн уярааж чадна. Гэтэл бид гэгээрээгүй, Бурхан чанараа хөгжүүлээгүй учраас хүч чадалгүй байна. Гэгээрэлд хүрсний хойно бид Будда шиг болно. Иймээс "Уг чанараа танин харж, өөрөө нэгэн Бурхан болно." гэж ярьдаг.

Гэгээрэх мөч

Бурхан болох нь маш амархан бөгөөд эгэл жирийн хэрэг байдаг, маш аядуу зөөлөн, Бурхан болсон шинж тэмдэг огт мэдэгдэхгүй. Гэгээрэх үед заавал газар, тэнгэр донсолж, дэлхий нээгдэх шиг болохгүй. (*Их Багш болон бүгд инээв.*) Гэгээрэх нь тун энгийн, маш хялбар явдал. Магадгүй унтаж байхдаа, зүүдэндээ, бясалгаж суух үедээ, хоол идэж байхдаа, эсвэл бие засах өрөөнд байхдаа ч гэгээрч мэднэ. Та нарын дотор бие засах өрөөнд байхдаа гэгээрсэн хүн байна уу? Мэдээж байх ёстой, гэхдээ бусад хүмүүс ёс бус, хүндэтгэлгүй гэж хэлэх вий гэхээс эмээж, хэлж зүрхлэхгүй байна. Гэвч Бурхан хаана ч оршин байдаг болохоор яагаад бие засах газарт гэгээрч болохгүй байх вэ?

Багш нь анх Формосад ирэхэд хэн ч намайг Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг гэдгийг мэдэхгүй байсан, би ч мэдүүлэхийг хүсээгүй, тиймээс бие засах газарт нуугдан бясалгадаг байв. Тэнд бясалгахад нэг дутагдалтай тал байдаг нь байнга хаалга тогшино, хаалга тогшихоор нь би гарч, өөр бие засах өрөө хайх хэрэгтэй болдог. (*Их Багш болон бүгд инээв*) Тэгтэл дахиад хэн нэг хүн ирж, тогшино. "Тог, тог, тог!" гэхэд нь би дахин гарч, өөр өрөө хайна.

Заримдаа агуулахад бясалгаж болдог. Лекцийн танхим, сүм болгон агуулахтай. Тэнд бясалгалын олбог, сандал байдаг, би тэнд нуугдаад бөөн олбог сандалтай хамт бясалгадаг байв, та нар олбог дээр суугаад бясалгадаг бол би олбогуудтай хамт бясалгадаг байлаа. Агуулах, бие засах газрын аль аль нь албан ёсны бясалгалын ашрам биш, бас би бурхны тахилын ширээний өмнө бясалгаж байгаагүй ч гэгээрч чадсан. Гэгээрэх үедээ би үүнийг чангаар хэлэхийг хүсээгүй, учир нь гэгээрэх агшин бол тун энгийн байдаг бөгөөд заавал хэлж ярих, эсвэл хавь ойрыг доргион тунхаглаж, ёслон тэмдэглэх ёстой ямар нэг ер бусын зүйл биш.

Багшийнх нь хэд хэдэн гэгээрлийн ахуй ойлголт сүм хийдэд биш, харин агуулах, бие засах газар, далайн хөвөө, голын эрэг, майханд гэх мэт маш энгийн газарт тохиолдсон. Чимээ шуугиантай, эсвэл тийм ч хүндэтгэлтэй биш газруудад Багш нь гэгээрлийн сэтгэгдэшгүй их хүчийг ойлгож ухаарсан билээ. Магадгүй ёслол төгөлдөр газарт гэгээрэх учиргүй нь миний хувь тавилан байх.

Үнэндээ бясалгалын ашрам хаа сайгүй, газар бүхэн сүр жавхлантай байдаг, гэхдээ хүн бүрийн шаардлага өөр өөр. Зарим хүн сүрлэг ариун газарт байх ёстой, тэгвэл сэтгэл нь төвлөрч, гэгээрч чаддаг. Зарим хүн Их Багш нартай хамт байх хэрэгтэй, тэдэнд гэгээрэлд хүрэх хүртэл удаан хугацаа шаардагдана. Зарим хүн Төгс Гэгээрсэн Их Багшийг хармагцаа гэгээрдэг.

Өчигдөр зарим хүн гэртээ хариад гэгээрлийн ахуй ойлголттой болсон байна. Тэр өдөр Багш нь юу ч заагаагүй, тэд харин хариад унтаж байхдаа Гэрэл харж, гэгээрлийн түвшнийг үзсэн байна. Энэ бол гэгээрсэн байдал болно, гэгээрэл нь тийм зөөлөн аядуу, тийм амар хялбар байдаг.

Энэ нь хялбар мэт харагдана, гэвч үнэндээ тийм ч хялбар биш. Яагаад вэ? Учир нь бид тэрхүү зөөлөн аядуу

Гэрэл, эсвэл дэс түвшнийг харсныхаа дараа өөрчлөгддөг. Өөрчлөгдсөнөө бид мэдэхгүй байсан ч өөрчлөлтүүд гарч, бидний бясалгалын дэс ихээр дээшилдэг. Хэрвээ Төгс Гэгээрсэн Их Багшийн удирдлагагүй, эсвэл өөрөө бие даан эмх цэгцгүй бясалгавал хэдэн арван жил бясалгаж байж сая нэг Гэрэл бага зэрэг харна, эсвэл дотоодын Аялгуу жаахан сонсоно.

Бид Даяаны (Чань) урсгалын түүхийг уншвал урьд цагт Даяаныг бясалгадаг байсан хүмүүс маш урт удаан хугацаанд бясалгаж байж, гэнэт нэг өдөр бөмбөрийн дуу, хонхны дуу, аянгын дуу сонсдог, тэгээд хачин их баярлаж, гэгээрсэн тухайгаа Багшдаа илтгэдэг байжээ гэдгийг мэднэ. Маш удаан бясалгасны эцэст л үүнийг олж хүртдэг байжээ. Харин манай авшигтнууд бол тэр дороо олж хүртдэг. Тэр ч байтугай авшиг аваагүй ч ахуй ойлголт хүртэх боломжтой. Заримдаа бид их бясалгагч хүнийг харахын төдийд л гэгээрлийн ахуй ойлголттой болдог.

Тийм учраас хүмүүс нэгэн Их Багшийг, нэгэн жинхэнэ Их Багшийг бахдан магтдаг ажээ. Учир нь Түүний хүч чадал сэтгэшгүй их. Яг л Нүйва шиг, Тэрээр чулууг адислаж, цэцэн сэргэлэн, бодож сэтгэдэг, олон зүйлийн учрыг ойлгодог болгосон, тэр чулуу хожим нь хувьсан өөрчлөгдөж дэвшээд хүн болж чадна. Гэхдээ чулуу хэдий хүн болон хувирлаа ч нэгэн агуу их хүн болохгүй нь тодорхой.

Тиймээс, “Улаан асрын зүүд” зохиолын Жя Баоюй тийм олноос онцгой, түмнээс төгөлдөр биш, хэдийгээр тэр бясалгалтай, ахуй ойлголттой, зөн мэдрэмжтэй хэдий ч тийм ч агуу байгаагүй. Тэр дахин нэлээд хэдэн удаа төрөл авч, үргэлжлүүлэн бясалган дадуулж, өөрийгөө хөгжүүлбэл сая жинхэнэ Зам мөрийг олж, Бурханы хутагт хүрээд төгс төгөлдөр төрөлтөн болно, эс бөгөөс тэрээр жаахан хүч чадалтай болохоос цаашгүй.

Жаахан хүч чадалтай болсон тэр хүмүүс Бурханы хутагт хүрэхгүй ч байж мэднэ. Магадгүй ид шидтэн, эсвэл бөө удган болох байх. Тэд Бурханы хутагт хүрэхийн тулд энэхүү бүхнийг чадагч хүчийг бүрэн төгс олж авах ёстой. Бурханы хутагт хүрсний дараа ямар ч төрөлтнийг аварч чадна. Хэрэв энэ хүч чадлыг жаахан олбол бүр өөрийгөө ч аварч чадахгүй.

Учир нь бясалгалд олон дэс байдаг, зарим хүн нэгдүгээр дэсэд хүрдэг бөгөөд энэ нь нэгдүгээр ертөнц юм. Зарим хүн хоёрдугаар ертөнц болох хоёрдугаар дэсэд хүрдэг, зарим хүн бясалгаад Гурван ертөнцийн чанадад гардаг.

Тодорхой түвшинд хүрэх үед маш их хүчтэй болдог, бид үүнийг хамгийн төгс дээд нь хэмээн андуурдаг. Үнэндээ, хамгийн дээд түвшинд хүрчихлээ ч гэсэн бидэнд ямар ч онцгой зүйл мэдрэгдэхгүй. Тиймээс Шагжамуни Будда сударт айлдахдаа: “Гэгээрэх нь миний хувьд зүүд мэт. Бурханы хутагт хүрэх нь надад тэнгэрийн цэцэг лугаа адил.” хэмээн өгүүлжээ. Үүгээр Тэрбээр Бурханы хутагт хүрэх нь өөрийнх нь хувьд онцгой содон зүйл бус, харин тун энгийн, жирийн нэгэн хэрэг болохыг илэрхийлсэн ажээ.

Ялааны дотоодод ч бас Зам мөр буй

Та нар Их Багш өдөр бүр бясалгаж суухдаа нүдээ аниад эсвэл хагас аниад яг л Бодьдарма шиг их нухацтай харагддаг, хэн нэг хүн ойртон ирвэл нүдээ дүрлийлгэн нэвт шувт ширтэхэд өнөөх хүн ихэд айн холдон одно гэж боддог. Үгүй дээ, бясалгахаас гадна заримдаа би ном уншдаг, уйдсан үедээ ялаа ажигладаг. *(Их Багш инээв.)*

Өнөөдөр би эргэн тойронд ганц, хоёр ялаа нисэхийг харав, хэсэг зуур ажиглаад тэд үнэндээ ялаа биш, бидэнтэй л адилхан болохыг үнэхээр ойлголоо. Энэ дэлхийн үг хэл хязгаарлагдмал тул тэднийг ялаа гэж хэлдэг, тэд уг нь ялаа

биш, зөвхөн гаднах төрх нь ялаа болохоос дотоод хөдөлгөх хүч нь бидэнтэй ижилхэн. Түүнийг ижилхэн хүч хянаж, түүнд нис, хөдөл, ийшээ яв, тийшээ яв гэж хэлж байдаг.

Хүмүүс бид ч адил, би тантай болон түүнтэй адилхан. Бидний дотоод тал адилхан ч гаднах өмссөн "хувцас" маань өөр. Та сайн хүн, би муу хүн, эсвэл би сайн хүн, та муу хүн байлаа ч дотоод тал нь бүгд ижил. Сайн болон муу нь ердөө зүгээр л өөр өөр дүр төрхтэй үйлдэл төдий.

Бид ялгахын тулд л "сайн", "муу" гэж хэлдэг, учир нь хэрвээ бид сайн, муу гэж ялгахгүй бол энэ дэлхий сонирхолгүй байх болно, тиймээс бид ялгадаг. Яг нэг задгай тайзан дээрх жүжиг дуурь үзэж байгаа шиг, жүжиг дуурь тайзан дээр тавигдахаас өмнө жүжигчид нь жирийн нэгэн гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр, хүүхдүүд байж магадгүй, тэд гэр бүлээрээ нийлээд нэгэн тоглолтын баг бүрдүүлжээ.

Тэд тайзан дээр гарах үед бүгд өөрчлөгдөж, аав нь маш харгис хэрцгий хааны дүрд тоглож, ээж нь их өрөвдөлтэй золиосны хүн болж, хүүхэд нь аавынхаа дайсан болон харгис хааныг хаан суудлаас түлхэн унагаах хувьсгал эхлүүлнэ. Тайзан дээр хүн бүхэн өөрт оногдсон дүрдээ ордог, гэвч буцаж гэртээ хариад нүүрний будгаа угааж арилган хувцсаа солих үедээ угаасаа нэг гэр бүл тул хамтдаа хооллож, ярьж хөөрч, хамтдаа ажиллаж хөдөлмөрлөж байдаг.

Гэгээрлийн ахуй ойлголтууд бидний сэтгэлийг тайвшруулдаг. Хэн нь сайн, муу гэдгийг нэг их тоохгүй, энэ дэлхий хөгжин цэцэглэж байна уу, үгүй юу гэдгийг тодорхой харна. Энэ тоост хорвоо яг л театр шиг, хүн бүхэн жүжиглэж байдаг, гэхдээ ингэх нь түүнийг сонирхолтой болгодог! Хэрвээ ийм тоглолтгүй бол өөр юу хийх вэ? Олон хүн Баруун зүгийн Төгс баясгалант оронд очсоныхоо дараа хамаг төрөлтнийг гэтэлгэхийн тулд тоост хорвоод дахин ирнэ гэж тангарагладаг. Магадгүй Баруун зүгийн Ариун

орон дэндүү уйтгартай болохоор тэр байх, би мэдэхгүй юм. (*Их Багш инээв.*)

Та нар Баруун зүгийн Төгс баясгалант оронд очиж байсан уу? Ариун орон хэтэрхий баяр жаргалтай байдаг болохоор уйдахгүй, гэхдээ хэсэг хугацааны дараа уйдах л байх. Ер нь ямар ч зүйлд дундыг барих нь зөв.

Хэтэрхий арга, хэтэрхий билиг байх аль аль нь сайнгүй. Зарим үед бид арга, билгийг зохицуулах хэрэгтэй, ингэвэл амьдрал илүү сонирхолтой, тийм уйтгартай биш байх болно.

Судар номд бичсэнээр: Арьяабал бодьсадва бол нэн эртний Бурхан юм, Вималакирти Их Багш ч бас эртний Бурхан, Шагжамуни Будда ч мөн тоолшгүй олон галавын өмнө Бурханы хутагт хүрсэн ажээ. “Богдсын ном Цагаан лянхуа судар”-т Шагжамуни Будда айлдахдаа, Тэрээр тоост хорвоогийн маш олон төрөлтөн, мөн газраас гарч ирсэн үй түмэн бодьсадваг гэтэлгэсэн гэжээ.

Газрын зүрхэн бодьсадва ч мөн эртний Бурхан. Тэрээр үй олон хүн, тэнгэр, бирд, бодьсадваг гэтэлгэсэн. Гэвч “Газрын зүрхэн бодьсадвагийн судар”-т тэмдэглэснээр Тэр одоо болтол Бурхан болоогүй байгаа нь төрөлтнүүд бид Түүнийг хохироож байгаагаас болжээ. Учир нь хамаг төрөлтөн тамд очих дуртай байдаг нь Түүнийг дэндүү завгүй болгосон байна.

Бид судар уншихдаа хязгаарлагдмал билиг ухаанаасаа болоод олон зүйлийг хэрхэн тайлбарлахаа мэдэхгүй байдаг. Гэхдээ ойлгож чадвал ойлгож, ойлгохгүй бол март, учир нь бурхны хүч чадал сэтгэгдэшгүй болохоор бид үүнийг дэлхийн үг хэлээр, эсвэл хязгаарлагдмал уураг тархиар тайлбарлах аргагүй. Бидний уураг тархи бол маш сайн компьютер гэдэг нь үнэн, гэвч энэ нь ердөө л компьютер

бөгөөд түүний мэдэх зүйл нь хязгаартай байдаг. Бид үүнийг ашиглан дэлхий ертөнцөөс хэтийдсэн зүйлийг дүгнэн шүүж чадахгүй.

Миний таамаглаж байгаагаар тэр эртний бурхад уйдаж байсан, тиймээс заримдаа энэ тоост хорвоод зочлон ирж, жүжиг үздэг байсан байж магадгүй. Бид гэртээ байхдаа эхнэр, нөхөр, эцэг, эх, үр хүүхэдтэй болж, амьдрал маань баяр баясгалан, уур хилэн, уй гашуу, жаргал зовлонгоор дүүрэн байж, бид ч тэдгээрийг хангалттай эдэлдэг. Гэсэн ч бид хааяа театрт очиж, кино үзэн бусад хүмүүсийн сэтгэл хөдлөлийг харах дуртай хэвээр байдаг. Тийм биз дээ?

Тиймээс кино маш алдартай хэвээр байгаа бөгөөд кино театрууд үргэлж хүнээр дүүрэн байдаг. Бурхан, бодьсадва хэдийгээр Ариун орондоо тун баяр баясгалантай байдаг ч заримдаа баяр гуниг, уур хилэн, жаргал зовлонг түр зуур амсаж эдэлж болно.

Хэрвээ та нар надаас энэ дэлхийн төрөлтнүүдийг гэтэлгээд дуусах уу гэж асуувал, бүгдийг гэтэлгэж барахгүй гэж Багш нь хариулна. Учир нь бүгдийг гэтэлгэчихвэл уйтгартай. Хаан угсаатнуудын орд харш хамгийн сүрлэг сайхан байдаг биз дээ? Тэд бол хамгийн баян чинээлэг, хамгийн их эрх мэдэлтэй хүмүүс. Гэвч заримдаа уйдаж, амрахаар явна, өөр газарт загасчилж, эсвэл энгийн ардуудын наадам зугааг сонирхдог. Учир нь тэд амарч, амьдралын янз бүрийн өөрчлөлтийг амсаж эдлэхийг хүсдэг.

Энгийн хүмүүс хаан болох их дуртай бөгөөд хаан байх нь хамгийн сайн ажил гэж боддог. Харин хаанд бол маш уйтгартай санагдаж, заримдаа энэ ажлаа солихыг хүснэ. Тэнгэр тэтгэгч (Чянлун) хаан уйдвал эгэл ардын хувцас өмсөн биеэ нууцлаад ард олны аж амьдралыг тандан явж, тэдний аж амьдралтай танилцаж, санаа бодлыг нь сонсдог байжээ.

Тэрээр улс орны нөхцөл байдлыг ойлгож мэдэхээс гадна энэ завшаанаар ордны гаднах баяр жаргалыг эдэлдэг байв. Учир нь хааны ордны амьдрал өдөр бүр маш шахуу цагийн хуваарьтай, хэзээ босох, хэзээ ажиллах нь бүгд төлөвлөгдөнө. Түшмэдийн ээлж дараалан өргөх айлтгалыг хүлээн авч, дайн дажин, өлсгөлөн, байгалийн гамшиг, бослого үймээн, хар салхи, газар хөдлөлт гэх мэт улс орны томоохон үйл явдлын талаарх толгой өвтгөм мэдээллүүдийг сонсоно.

Тиймээс заримдаа хүнд ажлаас хэсэг зуур амсхийн холдож, энгийн ардын маягаар хувцаслаад газар үзэх гэж явдаг байжээ. Гэхдээ түүхийн номуудад түүнийг зугаа цэнгэл хөөцөлдөж явсан гэж бичээгүй, харин ард түмний амьдрал ахуй, зовлон зүдгүүрийг ойлгож мэдэхээр явсан гэж тэмдэглэсэн байдаг. Зүгээр, энэ нь сонсоход илүү сайхан аж. Гэхдээ түүний зарим түүхийг уншаад бид Тэнгэр тэтгэгч хаан биеэ нууцлан явахдаа ард олны аж амьдралыг ойлгохоос гадна энэ ертөнцийн баяр цэнгэлийг ч бас эдэлж явсныг олж мэдэж болно.

Бурхан болсон ч хооллож ундлан, амарч унтана

Миний сая хэлснээс болоод Бурхан болохыг хүсэх хүнгүй болчхов уу даа. Та нар одоо ч гэсэн нэгэн Бурхан болмоор байна уу? Уйдахаас айхгүй байна уу? Орчлон ертөнцийн хууль ийм байдаг, хүн Бурханы хутагт хүрвэл хамаг төрөлтнийг гэтэлгэхээр бууж ирнэ, энд хэтэрхий удвал уйдаж, нирваандаа буцна. Ингэж хүний хорвоо газар, тэнгэрийн хооронд ирж буцсаар байдаг.

Гэхдээ нэгэн Бурхан болсны дараа энэ дэлхийд үлдсэн ч гэсэн эгэл хүнээс өөр мэдрэмжтэй байдаг. Тиймээс бид олон сая жилээр ахин дахин төрөл авч, мунхаг харанхуй явахын оронд хурдхан бясалган дадуулж гэтлэгдээд үхэж, төрөхийн сансрын хүрднээс мултарч, эрх чөлөөтэй болох

хэрэгтэй.

Хүн нэгэн Бурхан болсныхоо дараа ч мөн адил хооллоно, унтана, гэхдээ энэ нь эгэл хүмүүсийн хооллох, унтахтай адилгүй, хэдийгээр харагдах төрх байдал нь адилхан боловч өөр юм. Бурхан, эгэл хүний олон үйлдлийг хийж, эгэл хүн мэт харагдавч түүний үйл хөдлөл бүхэн зөвхөн хамаг төрөлтний тусын тулд байна, бусдыг гэгээрүүлж, хамаг төрөлтөнд үйл түйтгэрээ угаан ариусгахад нь тусалдаг. Тэр яг л жирийн хүмүүстэй адилхан зүйл хийж байгаа шиг байдаг ч үнэндээ бол огт өөр.

Зарим номын багшийн ном тайлах нь бусад номын багшаас өөр байдаг. Ихэнх номын багш ном тайлахдаа зөвхөн үг хэл хэрэглэдэг, хамаг төрөлтөнд ямар ч хүч өгдөггүй, учир нь тэд өөрсдөө хүчгүй байдаг. Гэтэл зарим номын багш бүр юу ч яриагүй байсан ч хамаг төрөлтөнд асар их тустай байж чаддаг. Тиймээс үйлдэл нь ижил ч ач тус нь тэс өөр.

Бид яагаад бүгд нэгэн Бурхан болох ёстой вэ? Хамаг төрөлтөнд ач тустай байхын тулд юм. Бид Бурхан болсны дараа юу ч хийсэн ач тустай болж, бид юуг ч харсан ойлгоно. Цэцэг харсан ч гэгээрнэ. Оддыг ажсан ч, сарыг харсан ч бас гэгээрнэ. Хүнийг харсан ч гэгээрнэ. Хүн бүхнийг бурхан хэмээн харвал бид баяр жаргалтай, сэтгэл амар тайван байх болно. Өөрийгөө хүлээслэхээ больж, уурламаар зүйлгүй, атаархах сэтгэлгүй, бусдад гомдохгүй, надад яагаад ингэж хандана вэ гэж бусдад эргэлзэхгүй болно, ойлгов уу?

Тиймээс Есүс Христ: “ Хэрэв хэн нэгэн чиний баруун хацрыг алгадвал, чи түүнд зүүн хацраа ч мөн адил тавьж өг.” хэмээжээ. Учир нь Түүний хувьд яасан ч адилхан, бүхий л үйлдэл бүгд ижил болохыг Тэр мэднэ, Түүнд ялгаварлах сэтгэл байхгүй. Нэгэн Бурхан болсны дараа л бүхнийг ингэж тов тодорхой харж чаддаг. Хэрвээ бид Бурхан болоогүй

бол шунал хүсэл, уур хилэн, мунхагийн харанхуйдаа маш чанга хүлэгдсэн байдаг. Тиймээс зарим хүн их уурласнаасаа болоод гэдэс нь өвддөг, эсвэл сэтгэлдээ атаархал, гомдол тээснээсээ болоод хорт хавдартай болдог, эсвэл шунал хүсэл, уур хилэн, мунхагаасаа болж, амиа хорлохыг хүсдэг, учир нь шунал, хилэн, мунхагаас үүдсэн зовлонгоос мултрахын аргагүйгээс болжээ.

Зөвхөн бясалгал хийж гэтлэгдсэний дараа л сая бусад хүнийг дагуулж, гэтэлгүүлж чадна. Хэрвээ зарим хүн чөлөөлөгдөхийг хүсэхгүй байвал зүгээр, хүчлэх шаардлагагүй. Харин хэн нэгэн гэтлэгдэхийг хүсвэл бид даруй тусалж чадна.

Гуравдугаар бүлэг

ЯН ЗИГИЙН БИЛИГ УХААН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Пиндун.
1988 оны 5 дугаар сарын 19
(Эх нь хятад хэлээр)

Бусдыг хүндэлсэн хүн үүрд хүндлэгдэнэ

Та нар бүгд Ян Зиг мэдэх үү? Тэр бол Чи улсын шилдэг дипломатч байсан. Нэгэн удаа тэрээр улс төрийн асуудлаар ярилцахаар Чу улсад тусгай элчээр очжээ. Чу улсын хаан, Ян Зи тун намхан биетэйг мэдэх тул энэ далимаар түүгээр тохуурхаж, нэр нүүргүй болгоё гэж бодоод туслахуудаараа хотын хаалганы хажууд нэгэн жижиг нүх ухуулжээ. Ян Зиг ирэхэд хотын их хаалгыг нээж угталгүй, харин түүнийг тэр ухсан нүхээр шурган орж ирээрэй гэв.

Ян Зи нохойн нүхээр орохоос татгалзжээ. (*Их Багш*

болон бүгд инээв.) Чу улсын хаан хүн илгээж, яагаад хэмээн асуулгахад Ян Зи: “Би хүмүүний улс гүрэнд айлчилж, хүний хаанд бараалхахаар ирсэн. Нохойн улс оронд, нохойны хаантай уулзахаар ирээгүй тул нохойн хаалгаар орж болохгүй.” гэжээ. Ингээд Чу улсын хаан ичгэвтэр байдалд оров. Уг нь Ян Зиг эвгүй байдалд оруулахыг санаархсан ч оронд нь өөрөө Ян Зид шоглуулжээ. Чу улсын хаан туслахуудаа дуудан их хаалгаа хурдан нээж, хүн гэдгээ батлахын тулд Ян Зид тун хүндэтгэлтэй хандан урьж оруулахыг тушаав. (*Их Багш болоод бүгд инээв*.)

Тэр хаан хар санаатай хүн биш байсан, харин дэргэд нь сайн түшмэд, үнэнч сайд, зөв сургаал, хэлэх багш дутагдсанаас л ийм болсон юм. Эртнээс нааш өнөөг хүртэл нэгэн улсын хаан хэчнээн чадварлаг байсан ч, эд баялаг нь их, бага, улс орон нь том, жижиг ямар ч байсан түүнд мэргэн ухаантай түшмэл тусалж дэмжиж байгаа л бол тэр хаан агуу удирдагч болж, улсаа төвхнүүлж, энх тайван байдлыг баталгаажуулж, түүхэнд нэрээ мөнхөлдгийг түүх батална. Тэр байтугай ертөнцийн хэрэг ч мэргэн хүний тус, буянт номын багшийн тус хэрэгтэй байлан юм чинь, бясалгал дадуулдаг бидэнд бол бүр ч хэрэгтэй биш үү?

За одоо өмнөх яриагаа үргэлжлүүлье. Ян Зиг Чу улсын хаанд бараалхахад хаан түүнийг гутаан доромжлохыг санаархсан хэвээр л байв. Гэхдээ энэ нь хаан эзний санаа биш, харин доорх түшмэдийнх нь санаа байсан байх. Тэд зориудаар нэгэн ялтныг оруулж иржээ. Тэгээд хаан түшмэдээсээ: “Энэ хүн ямар хэрэг хийсэн бэ? Аль улсын иргэн бэ?” гэж асуув. Түшмэд нь: “Энэ хүн Чи улсын иргэн болой. Хулгай хийсэн.” гэж хариулав. Дараа нь Чу улсын хаан Ян Зид хандаж: “Танай Чи улсын иргэд зөвхөн хулгай л хийдэг хүмүүс үү?” гэв. Энэ нь Ян Зиг нүүргүй болгох санаа байсан ч харин Ян Зи: “Манай Чи улсын иргэд хулгай

хийдэггүй. Яг л, жүрж өмнөд нутагт ургавал чихэрлэг сайхан амттай, харин хойд нутагт ургавал исгэлэн гашуун болдог нь газар зүйн фэн шүйтэй нь холбоотой байдгийн адил энэ Чи улсын иргэн Чи улсдаа бол хулгай үл хийнэ, харин Чу улсад ирээд ийн үйлджээ!" гэж хариулав. (*Их Багш болон бүгд инээв.*)

Дараа нь бүр илүү сонирхолтой түүх өрнөжээ. Хэдийгээр Чу улсын хаан нүүрээ барж дууссан ч зогссонгүй. Тэрээр Ян Зиг маш жижигхэн бөгөөд намхан, их хүмүүний сүрлэг бадируун том бие байхгүй гэж бодож байв. Хятад хүмүүс өндөр том, махлаг биетэй хүнийг буян хишигтэй, ухаалаг бөгөөд ёс төртэй гэж үздэг, хэрэв намхан, туранхай байвал буянгүй гэнэ.

Ян Зи тун намхан нуруутай, тиймээс Чу улсын хүмүүс эхлээд түүнийг нохойн хаалгаар оруулахыг оролдсон, одоо хаан нь түүнийг бас тийм нүдээр харж байлаа. Энэ нь хүнийг дорд үзсэн тийм харц гэдгийг та нар мэдэж байгаа, тэр толгойноос хөл хүртэл нь гүйлгэн харж, дараа нь хөлөөс нь толгой хүртэл нь хараад үл тоомсорлосон өнгөөр: "Хм, Чи улсад хэн ч үлдсэнгүй юу?" гэхэд Ян Зи: "Яагаад хэн ч байхгүй гэж? Манай улсад хүн маш их, хэрэв бид асар майхан баривал гишгэх газаргүй болно, бид ханцуйгаа нийлүүлбэл тэнгэр газрыг бүрхэнэ! Манай Чи улсын хүн ам ийм их, яагаад хэн ч байхгүй байх вэ?" гэхэд Чу улсын хаан дахин: "Нэгэнт тийм их хүнтэй юм бол сайн авьяастан байхгүй гэж үү? Яагаад чам шиг ийм хүнийг нааш илгээв?" гэж асуужээ.

Ян Зи: "Өө! Манай улс гадаад улс руу түшмэд илгээхдээ тухайн улсад нь тааруулж илгээдэг, тэр нь ямар улс байхаас шалтгаалдаг юм. Хэрэв сайн улс бол сайн хүнээ илгээнэ. Хамгийн шилдэг улс оронд бид хамгийн шилдэг сайн хүнээ явуулдаг, доогуур дэсийн улсын хувьд зүгээр

л доод дэсийн түшмэл илгээхэд л болно. Манай улсад сайн түшмэд тун олон ч тэднийг өндөр зэргийн хөгжин цэцэглэсэн, соёлтой улс орнууд руу илгээчихсэн. Хамгийн сүүлд үлдсэн нь би. Намайг хэн ч авах дургүй байсан тул Чу улс руу илгээсэн юм." гэжээ. (*Их Багш болон бүгд инээв.*)

Бусдыг хүндлэх нь өөрийгөө ч хүндэлж буй хэрэг. Хүнийг ичээж зовоовол өөрөө ч бас ичиж зовно, өөрийгөө хорлоно. Хүн хийсэн бүхнээ амсаж эдэлдэг. Эртнээс нааш их олон түүх ёс суртахууны тухай санааг агуулсан байдаг. Хятад хүмүүсийн хувьд үүнийг маш сайн мэдэх ёстой, учир нь Хятад улс бол таван мянга гаруй жилийн түүхтэй эртний соёл иргэншилтэй, олон зуун жил үе дамжин уламжлагдсан олон сайн зохиол бүтээлтэй. Хятадын гүн ухаантнууд, бясалгагчид, жишээ нь, Лаоз, Жуанз, Мооз, Сүнз нарыг дэлхий даяараа мэднэ. Тиймээс бид эртний хүмүүсээс суралцах хэрэгтэй. Та нар хар л даа, Ян Зи ганцаараа бүхэл бүтэн Чу улсыг ичээж байна. Чу улсын хаан уг нь Чи улс болоод Ян Зиг гутаахыг санаархсан ч эцэст нь Ян Зи мэхийг мэхээр хариулж, Чу улсын хааныг ичгэвтэр байдалд оруулжээ.

Нэгэн хүн хэрвээ их ухаалаг, авьяас чадвар төгөлдөр, юмны ая эеийг маш сайн олдог бол эцэг өвгөдийнхөө яруу алдрыг дуурьсгаж, үр хойчдоо буян хишиг дуудна. Түүний амьдрал, хэв төрх, ёс суртахууны үлгэр жишээ нь гэр бүл, тосгон суурин, эх орондоо алдар нэрийг авчирч, дэлхийг илүү гэрэл гэгээтэй болгоно. Ян Зи ганцаархнаа өөрийн Чи улсыг бүхэлд нь дээш дэвшүүлж чадсан юм. Үүнтэй нэгэн адилаар хэрвээ бид муу үйл хийж, зан төрх нь эрхэмсэг биш байвал эх орондоо тун ч таагүй нөлөө үзүүлнэ, тийм биз? Мэдээж тэгнэ.

Ягчис чөтгөр ба "Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл"

Бид сайхан энергитэй газар амьдарвал эерэг сайн нөлөө хүртэж, харин нэлээд муу газар амьдарвал муу эрчмийн нөлөөнд автана. “Хутагт Ланкад заларсан судар”-т Шагжамуни Будда айлдахдаа: “Хэрвээ тухайн газар оронд амьтны амийг маш ихээр хөнөөсөн бол маш хүнд үйлийн үр үүсэж, тэнд алж хөнөөх эрчмийн уур амьсгалыг бий болгох бөгөөд энэ уур амьсгалаас олон ягчис чөтгөр төрнө. Тэр ягчис чөтгөрүүд зөвхөн хүний мах идэхэд мэргэшсэн.” гэжээ. Тиймээс үйлийн үр бол аймшигтай зүйл юм.

“Хутагт Ланкад заларсан судар”-ын сүүлийн хэсэгт аллагын асуудлын талаар болон мах идсэнээс үүдэн гарах муу нөлөөний тухай өгүүлсэн олон түүх бий. Аллага нь уур амьсгалын орчныг бүхэлд нь сэвтээж харлуулна. Хэрэв бид тэнгэрийн нүдээ нээвэл амь хөнөөдөг тэр газруудад маш харанхуй байгааг харна. Гэвч бид тэдгээрийг махан нүдээрээ харж чадахгүй, тод харахын тулд тэнгэрийн нүдээ ашиглах ёстой. Бид махан нүдээрээ харж чадах зүйл хязгаартай, бүр бодьсадва заларлаа ч мэдэхгүй, чөтгөр ирсэн ч мэдэхгүй.

Тансан лам бол алдар хүндтэй номын багш, одоо ч алдартай хэвээр байгаа. Түүний эрхэм зорилго маш чухал байсан бөгөөд бид түүний сайхан сэтгэлд талархсаар байдаг. Гэхдээ тэрээр ном залахаар явах үедээ эгэл хүн байсан юм. Тиймээс чөтгөрийг харах үедээ таниагүй, бурхан, бодьсадва бие хувилан ирэхэд ч танихгүй байжээ. Тиймээс “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолд Тансан лам өмнө нь гарч ирсэн бурхан, бодьсадвагийн хувилгааныг, эсвэл хувхай ясан шулам, үнэгэн шулам зэрэг нь үзэсгэлэнт бүсгүйн дүрд хувилан ирж, тэдэнд саад тотгор хийхэд мэдэхгүй байсан төдийгүй тэдний амь насыг хөнөөлөө хэмээн Сүн Үкүнийг зэмлэдэг тухай олон түүх бий.

Сүн Үкүн хэдийгээр Тансан ламын шавь боловч тэнгэрийн нүд нь нээлттэй тул хэн нь бурхан, хэн нь

чөтгөр шуламс болохыг харж чадна. Тэрээр баруун орноос Бурханы шашны судар залж, Дээдийн номыг саадгүй дэлгэрүүлэхийн тулд тэдгээр чөтгөр, шуламсыг хөнөөсөн боловч Тансан лам түүнийг буруутган зэмлэж, хөөдөг. Учир нь тэр үед Тансан лам Их хөлгөний номын цогцсыг, эсвэл Арьяабалын бясалгалын аргыг хараахан сураагүй байсан учраас тэдгээрийг нэвт харж чадахгүй байжээ.

Энэтхэгт хүрч, Арьяабалын бясалгалын аргыг сурсны дараа "Тансан ламын цадиг"-т тэрээр Shabd Vidya (Шабд Видя)-г сурсан тухай өгүүлдэг. Shabd Vidya гэдэг нь "Аялгууны арга" гэсэн утгатай, өөрөөр хэлбэл Арьяабалын бясалгалын арга юм. Тансан лам арай илүү сайжирсан байна.

Арьяабалын бясалгалын аргыг сурахаас өмнө бол Тансан лам хүч муутай, бүх зүйлд тусламж авахын тулд бурхан, бодьсадвад найддаг, асуудал тулгарах бүрд Арьяабал бодьсадва, Авид бурхнаас тусламж хүсдэг, түүнд зөвхөн ийм л шидэт зэвсэг байсан. Хэрэв ямар нэгэн асуудал гарвал шууд л "Авид бурхан" гэж уншина. Сүн Үкүн байгаагүй бол Тансан лам баруун оронд хүрч чадахгүй байсан байх.

Тэр хоёрын нэг нь тэнгэрийн нүдээрээ харж чаддаг, нөгөө нь "сохор" байснаас тун олон төвөгтэй байдал үүссэн билээ. Хэрвээ бид хараахан мэдэхгүй байгаа бол биднийг удирдан чиглүүлэхээ хэдийн мэддэг хэн нэгэнд найдах ёстой. Хэрвээ бид билиг ухаангүй бол билиг ухаантай хүнийг хайх хэрэгтэй. Бид түүнээс суралцах ёстой, тэгвэл аажмаар түүнтэй ижил болно.

Тиймээс "Богдсын ном Цагаан лянхуа судар"-т Шагжамуни Будда айлдахдаа: "Будда тоост хорвоод мэндэлсэн нь Бурханы билгийг эгэл хүмүүст таниулж ойлгуулахын төлөө юм" хэмээн сургажээ. Өөрөөр хэлбэл,

“Хамаг Бурхад, Дэлхийн хүндэтгэлт нэгэн их шалтгааны улмаас энэ дэлхийд заларсан нь бүхий л төрөлтөнд Бурханы мэдлэг, үзлийг ухааруулах явдал юм.” гэжээ. Бурханы билгийг ойлгоно гэдэг нь Бурханы хутагт хүрэхийг хэлнэ. Учир нь Шагжамуни Будда мөн: “Зөвхөн Бурхан л Бурханыг ойлгож чадна.” хэмээн айлдсан билээ.

Нэгдүгээр дэсийн бодьсадва, наймдугаар дэсийн бодьсадвагийн аль аль нь бурхны билиг ухааныг ойлгож чадахгүй юм чинь эгэл хүмүүс бид бол бүр ч ойлгохгүй.

Тэгэхээр нэгэн буянт номын багшид хандах сайн, муу хандлага нь бидний билиг ухаанаас хамаарна. Хэрвээ бид нэгэн сайтар сэхээрсэн хүнд итгэж, түүнийг хүндлэн дээдэлж байхыг харвал сүнслэг бясалгагч хүн: “Энэ хүний дэс сайн юм.” гэж мэднэ. Харин сайтар сэхээрсэн хүнд таагүй хандаж, хүчирхийлэгч, дорд хүний муу авир гаргавал биднийг тун доогуур дэстэй төрөлтөн болохыг хүмүүс мэдчихнэ. Энэ бол жам ёсны зүйл, тийм үү, үгүй юу? (*Тийм гэж бүгд хариулаад алга ташив.*)

Өөрөө өөрийгөө гутаах мунхаг үйлдэл

Ян Зигийн түүхтэй ижил, хүн байгаа газар ирвэл мэдээж хүний зан заншил, зочноо хүндлэх ёс журмаар угтах ёстой, хэрэв нохойн ёсоор зочноо угтаж байгаа бол мэдээж нохойноос л ийм үйлдэл гарна. Ян Зигийн ирсэн зорилго нь амар тайвны төлөө байв. Хоёр орны амар амгалангийн төлөө байсан учраас тэр ямар ч муу юм хийгээгүй, гэтэл зарим нэг хар санаатан түүнийг зориудаар доромжлон гутаахыг хүсжээ. Эцэст нь Ян Зигийн ухаалаг, зоримог байдлаас тэд өөрсдөө гутамшигт байдалд орсон байна.

Шагжамуни Буддаг Дээдийн ном дэлгэрүүлж байх үед зарим хүн эсэргүүцэж байсан. Тэр хүмүүсийг буруу номтнууд байсан гэж би сонссон. Тэд шидийн хүч чадлаа

ашиглан Шагжамуни Буддаг хорлохыг оролдож, муу сэдлээр хилс хэрэгт гүтгэж, нэр хүндийг нь унагахыг санаархаж байсан ч эцэст нь бүгд бүтэлгүйтсэн. Заримдаа тэд эмэгтэй хүнийг ашиглаж, гэдсэнд нь түмпэн уяад жирэмсэн мэт болгон Шагжамуни Буддагийн хүүхэд гэцгээсэн. Эцэст нь Луу тэнгэрийн ном хамгаалагч нар хүүхний гэдсийг алгадаж, түмпэнг нь газарт унагаажээ. Үүнийг бүгд харсан бөгөөд тэр дороо бөөн инээдэм болсон байна.

Бас нэгэн өдөр нэг хүн ирж, Шагжамуни Буддатай ном хаялцав. Шагжамуни Будда түүнээс гурван удаа асуулт асуухад тэр ер хариулсангүй, Шагжамуни Буддаг дорд үзэж буй мэт байжээ. Гурав дахь удаа нь Очирт ном хамгаалагч түүнийг очирт алхаар цохин үнс болгожээ, учир нь түүний үйл түйтгэр туйлын хүнд болсон байна. Хэрвээ тэр хүн тэнгэрийн мэлмийтэй бөгөөд бясалгал дадуулдаг байсан бол ийм муу үр дагаварт өртөхгүй байсан нь лавтай.

Тэр өөрөө зүгээр л нэг эгэл жирийн хүн гэдгээ мэдэхгүй мунхаг бөгөөд бас амьд сэрүүн заларч буй Бурханыг гүтгэн доромжилсон байна. Тиймээс Очирт ном хамгаалагч түүнийг жанчин хөнөөжээ. Шагжамуни Будда тэр Очирт ном хамгаалагчаар үйлдүүлсэн бус, харин Дээдийн номыг хамгаалах нь Очирт ном хамгаалагчийн үүрэг бөгөөд хэн нэгэн нь бурхан, бодьсадвад хүндэтгэлгүй хандвал тэд мэдээж үүргээ гүйцэтгэнэ.

Тэр хүн мунхаг учраас Шагжамуни Буддад хүндэтгэлгүй хандсан байна гэдгийг бид тодорхой харж байна. Тэр үүнийг санаатай хийгээгүй, Шагжамуни Буддаг бурхан гэдгийг мэдсээр байж зориуд Түүний асуусан асуултад хариулаагүй биш. Гэхдээ тэрээр дэндүү мунхаг харанхуй, билиг ухаангүй байсан болохоор бурхны өмнө байгаа ч бурхныг таньж чадахгүй, бурхны сургаалыг сонссон ч номын учир зүйг ойлгож чадахгүй, дээд дэсийн

билиг ухааныг нь хүртэж чадахгүй байжээ, тиймээс Бурхан Багшид эргэлзсээр байсан учир итгээгүй, тэр ч байтугай Түүнийг гүтгэн буруутгажээ.

Үйл түйтгэрийг давах зам

Хуэйкэгийн гэгээрэхээс өмнөх үеийн түүх ч үүнтэй ижил. Хуэйкэ тэр үед эгэл хүн байв. Бодьдармаа бол гэгээнтэн хүн, энэ дэлхийд залран буй бодьсадва гэдгийг тэр мэдээгүй. Тиймээс Бодьдармаг эрихээрээ ороолгож зүрхэлсэн бөгөөд хоёр шүдийг нь унагажээ. Хэдийгээр тэр үүнийг мунхагийн эрхээр үйлдсэн ч гэсэн үйл түйтгэр нь байсаар байдаг. Ойлгож мэдэхгүй бол юу дуртайгаа хийж болно гэсэн үг биш. Бурхан, бодьсадва Гурван ертөнцөөс хэтийдэж, үйл үрийг давсан байдаг. Харин бид Гурван ертөнцийг ч хараахан давж чадаагүй, тиймээс Гурван ертөнцийн дотор бидний хийсэн аливаа үйлдлийг Гурван ертөнцийн доторх сургаалын эзэн, тэнгэрийн хаан бичиж тэмдэглэж авдаг. Дараа нь бидний буян, нүглийг дэнслээд шийтгэнэ, эсвэл шагнана.

Хэрвээ үйлийн үрийн өр төлөөс байхгүйсэн бол Их Багш, бусад бурхан, бодьсадва нарыг ирэхийг хүлээх шаардлагагүй, ганц Шагжамуни Будда гарч ирэхэд л хангалттай. Хүмүүс Түүнийг хараад шууд таньж, Тэр бол Будда байна гэж мэдээд дагах юм. Тэгвэл бидний өвөг дээдэс бүгд аль эрт гэтлээд гэрлэж, хүүхэд төрүүлэх хэн ч энд үлдэхгүй байх байсан. Бид ч өнөөдрийг хүртэл үхэж, төрөхийн далайд эргэн төрөл авсан хэвээр байхгүй байв. Тиймээс эгэл хүмүүс бид тун болгоомжтой байж, төрөлтөн бүхнийг бурхан, бодьсадва хэмээн үзэх ёстой. Гэвч ингэх нь амаргүй, учир нь гэгээрээгүй бол харж чадахгүй, зөвхөн хүмүүсийн: “Хамаг төрөлтөн бүгд бурхан, бодьсадва мөн.” гэж ярихыг сонсохоос цаашгүй, жинхэнээсээ ойлгох аргагүй байдаг. Тиймээс бид заавал бясалгах хэрэгтэй. Арьяабалын

бясалгалын аргыг дадуулсны дараа хэзээ нэг өдөр хамаг төрөлтөн бүгд Бурхан чанартай гэдгийг жинхэнээр ойлгох болно.

Харин одоо та бүхэн Багшаасаа: “Их Багш аа! Хүн бүхэн Бурхан чанартай, хүн бүхэн бурхан, бодьсадва. Гэтэл муу зүйл хийдэг хүмүүс ч бас бурхан, бодьсадва бус уу?” гэж бас асууж болно. Тэд ч мөн бурхан, бодьсадва боловч өөрсдийнхөө сайн чанарыг хөгжүүлээгүй, сайн багаж болж чадаагүй байгаа учраас бурхан, бодьсадва тэднийг сайн үйл хийхэд ашиглаж чадахгүй, тиймээс муу үйл хийлгэдэг. Та бүхэн: “Бурхан, бодьсадва тэднээр муу үйл үйлдүүлж байгаа бол хариуцлагыг нь бурхан, бодьсадва үүрэх ёстой, яагаад муу үйл үйлдсэн тэр хүмүүсийг шийтгэнэ вэ? Тэд бол зүгээр л мунхаг хүмүүс шүү дээ!” гэж асууж мэднэ. Яагаад гэдгийг Багш нь хэлж өгье. Энэ бүхэн бүгд үйлийн үртэй холбоотой. Тэр ч байтугай хэрвээ бурхан, бодьсадва бидэнд муу үйл хий гэж хэлсэн байлаа ч энэ нь орчлон ертөнцийн их хүчний үйл ажиллагааны төлөө юм. Тоост хорвоод үйл ажиллагаа явуулж байдаг энэ их хүчний улмаас зарим хүн сайн үйл хийж, зарим хүн муу үйл үйлдэж байдаг. Гэхдээ муу үйл үйлдсэн хүн үйлийн үрээ заавал эдлэх ёстой, учир нь үйлийн үрийн хууль маш нарийн бөгөөд тодорхой. Хэрэв бид жүрж таривал жүрж хурааж авах нь гарцаагүй, алим таривал алим хураах нь лавтай, үүнээс ангид зүйл байхгүй. Тэгэхээр бид хэтийдсэн номын цогцсыг бясалгаж, хэтийдсэн зам мөрөөр замнаж байж л үйл үрийн энэ хуулиас хэтийдэж чадна.

Их хөлгөний номын арга

“Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолд Арьяабал бодьсадва Тансан ламд хандан: “Их хөлгөний номын арга нь төрөл төрөлд хуримтлагдсан үйл түйтгэрийг ариусган цэвэрлэж, аливаа гамшгаас ангижруулан, элдэв өвчин анагаах чадалтай.” хэмээн айлджээ. Их хөлгөний

номын арга гэгч нь Арьяабалын бясалгалын арга юм. Яагаад Арьяабалын бясалгалын аргыг Их хөлгөний номын арга хэмээн нэрлэсэн бэ? Учир нь энэ нь Зам мөртэй холбоотой. Зөвхөн Арьяабалын бясалгалын аргыг дадуулснаар Зам мөрийг олж чадна, тиймээс түүнийг Их хөлгөний номын арга гэдэг. Арьяабалын бясалгалын аргатай холбоотой, Арьяабалын бясалгалын аргыг дадуулахыг хөхиүлэн дэмжсэн аливаа судар бүхэн Их хөлгөний судар мөн. Төгс Гэгээрсэн Их Багшийн айлдсан айлдвар бүхэн Их хөлгөний судар юм.

Төгс Гэгээрсэн Их Багш амьд сэрүүн байгаа үедээ Их хөлгөний номын аргыг уламжлах төдийгүй, Их хөлгөний судрыг ч айлдана. Дээдийн ном дэлгэрүүлж, хамаг төрөлтөнд ач тус хүртээхийн тулд Төгс Гэгээрсэн Их Багш энэ дэлхийд залардаг. Харин Тэрээр нирваандаа буцсаны дараа Түүний сүнслэг буян, буян хишиг нь таван зуун жил хадгалагддаг байна. Таван зуун жилийн дараа Төгс Гэгээрсэн Их Багшийн соронзон талбай энэ дэлхийд оршихоо болино. Тиймээс энэ дэлхийгээс яваад нэн удсан Их Багш нарт бид залбирч даатгавал тийм ч их адистид хариу мэдрэгдэхгүй.

Өчигдөр та нар Багшаасаа: “Есүс Христэд итгэхэд л хангалттай биш үү, яагаад заавал Арьяабалын бясалгалын аргыг дадуулах хэрэгтэй вэ?” гэж асуусан. Учир нь Есүс аль хэдийнээ буцчихсан, одоо энд өөр Христүүд ирсэн байна, тиймээс бид амьд сэрүүн Христийг хайх хэрэгтэй. Христ гэдэг нь Дээдийн номын уламжлал залгамжлал бөгөөд энэ нь бурхны, мөн Төгс Гэгээрсэн Их Багшийн номын залгамжлалтай адил юм. Энэхүү Дээдийн номын залгамжлалын хүч нь Арьяабалын бясалгалын аргын хүчтэй ижилхэн. Есүс бол хүн, Христ бол цол хэргэм. Есүс энэ дэлхийд заларч байхдаа Христийн хүчтэй, Христийн номын залгамжлалтай байжээ, тиймээс бид түүнийг Есүс Христ

гэж нэрлэдэг.

Гэхдээ Христ бол хэн нэгний өмч биш, бас зөвхөн энэ цаг үед л байгаад дараагийн үед үгүй болохгүй. Христ нь Дээдийн номын залгамжлалтай адил олон эрин үеийг туулж, олон улс оронд ээлжлэн байж байсан, зөвхөн еврейчүүдийн дунд байх албагүй. Багш нь энэ тухай нэлээд хэдэн удаа ярьсан ч одоо дахин хэлье. Жишээ нь, хэрэв Гэгээрсэн Их Багш Формосад ном дэлгэрүүлбэл маш олон Формоса хүн түүний шавь болох нь гарцаагүй. Тэгээд олны дунд ихэд алдаршвал тун олон гадаадын хүн ирж, түүний шавь болно. Тэр гадаадын шавь нар эх орондоо буцаж очоод хичээнгүйлэн бясалгана. Эсвэл Формосагийн шавь нараас гадаад оронд очиж бясалгасан байна. Хожим Их Багш таалал болоход Формосад өндөр дээд дэстэй, хүч чадалтай гарамгай сайн шавь үгүй бол тэр Их Багшийг залгамжилж, Түүний өмнөөс Дээдийн ном дэлгэрүүлэх хүнгүй болно. Тэгвэл Формосад тэр Их Багшийн номын залгамжлал тасарна. Хэдэн зуун жилийн дараа Формосагийн хүмүүс зөвхөн тэрхүү Төгс Гэгээрсэн Их Багшийн хөргийг гэртээ залж шүтэхээс биш, Дээдийн номыг хэрхэн яаж бясалгахыг мэдэхгүй болно. Ингээд шүтлэг нь яваандаа гаднах зүйлсэд дулдуйдсан нэгэн урсгал төдий болж хувирна.

Харин тэр гадаадын шавь нар, эсвэл Формосагаас гадаадад очиж бясалгасан шавь нар удаан хугацааны дараа бясалгаад төгс гэгээрэлд хүрч, Зам мөрийг бүтээсний дараа тухайн оронд үргэлжлүүлэн Дээдийн ном уламжилна, эсвэл Формосад буцаж ирээд ном дэлгэрүүлнэ. Зарим нь Формосад буцаж ирэхгүй, зөвхөн гадаад оронд ном дэлгэрүүлж болно.

Эдгээр шавь, шавь нарынх нь шавь нар Формосад буцаж ирээд Дээдийн ном дэлгэрүүлэх үед Формосагийн хүмүүс, мөн өнөөх Төгс Гэгээрсэн Их Багшийн урьдын шавь нар эргэлзэж, тэдэнд үл итгэн: “Би хэзээ ч Арьяабалын

бясалгалын аргын тухай сонсож байгаагүй. Формосагийн эрхэм дээд ёс суртахуунтай ийм олон мундаг лам хувраг, их бясалгагчид яагаад нэг нь ч Арьяабалын бясалгалын аргыг уламжлахгүй байна вэ? Энэ гадаад хүн энд ирж, юу хийгээд байна вэ?" гэдэг, эсвэл "Гадаадад амьдардаг Хятад та юу яриад байна вэ? Бид танд итгэхгүй байна!" гэцгээнэ. Тиймээс Дээдийн номын залгамжлал уламжлагдах эсэх нь хүмүүсийн бясалгалын хүчээс хамаардаг. Энэ нь нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш тодорхой газар оронд ном дэлгэрүүлбэл Түүний шавь нар тухайн газарт үлдэх ёстой, эсвэл шавийнх нь шавь нар гэхчлэн бүгд төрөл төрөлдөө адилхан нэг л газар оронд Дээдийн ном дэлгэрүүлэх ёстой биш юм.

Энэ нь яг л эзэн хаан өөрийн суудлаа үр хойчдоо өвлүүлэн үлдээхэд, түүний үр хүүхэд, ач зээ нар нь улс орноо өвөг хаан шигээ сайн удирдан залж чадалгүй үеэс үед улам доройтуулахтай адил юм. Үүнтэй адилаар хэрвээ шавь нарынх нь дэс улам буураад байвал Дээдийн номын залгамжлал цаашид уламжлагдаж чадахгүй болж магад. Түүгээр барахгүй Дээдийн номын залгамжлалыг уламжлагч нь заавал Формосагийн хүн байх албагүй. Хэрэв Формосагийн Төгс Гэгээрсэн Их Багшаас суралцвал зөвхөн Формоса хүн л Бурханы хутагт хүрч чадна, гадаадын хүн чадахгүй гэж хэлж болохгүй. Энэ нь заавал тийм байх албагүй. Хүн бүрийн бясалгалын нөхцөл байдал өөр, төгс гэгээрэлд хүрч чаддаг хүмүүс улс орон бүхэнд байдаг. Зөвхөн зарим нэг улсын хүн л төгс гэгээрч чаддаг тийм хязгаарлагдмал юм гэж байхгүй. Түүхэнд нэр гарсан, алдаршсан маш олон гэгээнтэн бүгд өөр өөр соёлын уламжлалтай, өөр өөр улс орны хүмүүс байсан.Тийм биз дээ? (*Бүгд алга ташив.*)

Лаоз, Күнз хоёр хятад хүн, Есүс Христ еврей хүн, Шагжамуни Будда энэтхэг хүн, Сократ грек хүн, тэд одоо ч алдартай хэвээр байна. Бид унших үедээ зөвхөн Тэдний

төрсөн тухайн цаг үеийн талаар л уншсан болохоос биш, Тэдний талаар илүү нухацтай бодоогүй байдаг. Төгс Гэгээрсэн Их Багш заавал манай нутгаас ирсэн байх албагүй, бас заавал бидэнтэй нэгэн ижил үндэстэн байх ч ёстой биш. Энэ үнэн учрыг бид мэдэхгүй биш мэднэ, бид үүнийг мартахгүй байхын тулд заримдаа хэн нэгэн хүн бидэнд сануулж байх хэрэгтэй.

Багшийнх нь айлдсан ном яагаад хүн бүхний сэтгэлд нийцдэг вэ гэвэл би ямар нэг шинэ зүйл ярьдаггүй. Миний ярьдаг зүйлсийг та нар хэдийнээ мэднэ, зөвхөн хүн бүрд сануулан хэлж байгаа юм. Тийм ч учраас Багшийгаа ярихад бүгд шууд л хүлээн зөвшөөрч байдаг. Та нар Багштайгаа адилхан боддог учраас зүрх сэтгэлдээ ижилхэн хүсэл зорилготой байж, дотоодын билиг ухаан тань ижил зүйлийг ойлгодог. Энэ нь та нар ойлгохгүй байсан хэрэг биш, зүгээр л мартсан хэрэг юм. Учир нь ижилхэн үзэл бодолтой хүнтэй таарч байгаагүй учраас өөрийнхөө бодол санааг буруу гэж бодож явжээ.

Жишээлбэл, дөнгөж сая тайзан дээр ахуй ойлголтоо ярьсан манай авшигтан Арьяабалын аргаар бясалгахаасаа өмнө Бурханд мөргөөд Гэрэл харсан ч тэр Гэрэл ямар учиртайг мэдэхгүй байсан гэнэ. Хэрвээ тэр үед Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг байсан бол түүний Гэрэл олж харсан нь нэгэн зүйлийн гэгээрлийн ахуй ойлголт юм гэдгийг Багшаасаа асуугаад мэдчих байлаа. Тэрхүү жаахан гэгээрэл нь бурхан, бодьсадвагийн адислалын хүч юм. Хэрвээ Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаггүй бол өөрийн Мөн чанараа хөгжүүлэх боломжгүй бөгөөд өдөр бүр тийм Гэрлийг харж, бурхны Аялгууг сонсох боломжгүй байна. Тиймээс Арьяабалын бясалгалын арга нь гадны орноос ирсэн зүйл ч биш, бас Багш нь түүнийг та нарт өгсөн ч биш. Та бүхэн угаасаа Гэрэлтэй, Аялгуутай, Багш нь

зөвхөн та нарт түүнийгээ хэрхэн хөгжүүлэх, хэрхэн Бурхан чанараа төлөвшүүлж, гэгээрлийн хүчээ хамгаалах болон биднийг өнчин ганцаардмал, зовлонтой төрөлтөн болохоос сэргийлэхийн тулд энэхүү бүхнийг чадагч хүчээ хэрхэн ашиглахыг л зааж өгнө. Хүн бүхэн бүхнийг чадагч хүчтэй, Бурхан чанартай, хэрвээ хэрхэн ашиглахаа мэдэхгүй бол яг л их мөнгөтэй мөртөө өглөг гуйж яваа тэрбумтан шиг байх болно.

Асуулт: Их Багш сая "Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл" зохиолын Тансан лам судар ном залахаар явсан тухай, мөн Сүн Үкүнийн тухай жишээнүүд ярилаа. Энэ бүхэн цөм уг роман дахь зохиомол дүр, үүнийг Их Багш мэдэхгүй гэж үү?

Хариулт: Энэ нь яагаад хийсвэр зохиомол гэж? Яагаад хуурмаг байх билээ? Тансан лам байгаагүй хэрэг үү? (*Байсан гэж нэгэн хүн хариулав.*) Тийм ээ! Та ойлгохгүй байгаа учраас ийм асуулт асууж байна! Үкүн ч байна, Жү Бажэ ч байна, Ша Ужин ч бас байна. Эдгээр нь бүгд та бидний сэтгэлийн чанарууд, бид юм. Энэ бол Тансан лам ном залахаар явах үеийн түүний дотоодын зөрчил тэмцлүүд. Сүн Үкүн түүний билиг ухаан, бүхнийг чадагч хүч чадлыг төлөөлдөг, тэрээр тохиол бүрд бурхан, бодьсадвагаас тусламж гуйж, тэр болгондоо асуудлыг шийдэж чаддаг. Жү Бажэ бол түүний залхуу хойрго зан, тачаангуй байдлыг төлөөлдөг, энэ нь тэрээр гоо үзэсгэлэнт бүсгүйчүүлд сэтгэл татагддаг, мөн сайн хоол хараад шунадаг зан чанарыг харуулж байна гэсэн үг юм. Ша Ужин бол түүний сайн, эсвэл муу шинж чанаргүй, тайван амгалан, тогтуун, тэнцвэртэй зан чанарыг төлөөлдөг. Хэрэв та нар ойлгохгүй байгаа бол яаж Багшаасаа ийм асуулт асууж зүрхэлнэ вэ? (*Бүгд алга ташив.*)

Дөрөвдүгээр бүлэг

“БАРУУН ЭТГЭЭДЭД ЗОРЧСОН ТЭМДЭГЛЭЛ” ЗОХИОЛЫН ДҮРҮҮД

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонконгийн хоёр хоногийн даяан
1993 оны 10 дугаар сарын 1.
(Эх нь хятад хэлээр)

Энэ “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” номд бүхэлдээ сүнслэг бясалгалын дэс түвшин болон урхи зангын тухай өгүүлдэг. Энэ номыг унших тусам би зохиогчийг нь улам бишрэх болсон. Тэрээр хүмүүний амьдрал, бидний дотоод шинж чанаруудын талаар дэндүү ойлгомжтой өгүүлж, сүнслэг бясалгалын замд тохиох янз бүрийн саад бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замыг дүрслэхийн тулд төрөл бүрийн зүйрлэлийг ашигласан байна.

Бид илүү их бясалгах тусмаа энэ зохиолын утга санааг улам гүнзгий ойлгоно. Энэ бол зүгээр нэг үлгэр домгийн

зохиол биш, үүнд жинхэнэ сайн сургаал, сургамжтай зүйлс бий. Та нар Арьяабалын аргаар бясалгасныхаа дараа уншвал илүү сайн ойлгоно, өөрсдийн жинхэнэ Мөн чанараа үнэхээр үзэж, гэгээрэх болно!

“Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолын Тансан лам бол сайхан санаатай, ёс төртэй номын багш юм. Харин түүний гурван шавь нь ямархуу улс вэ? Тэд муухай зүс царайтай, бас хүн хөнөөж ч чадна. Жирийн хүмүүс тэднийг хараад үхтлээ айж балмагдах боловч Тансан лам айгаагүй төдийгүй тэднийг шавиа болгон хүлээж авсан. Тэд ч дараа нь Тансан ламыг бүхий л зүрх сэтгэлээрээ хамгаалан явж, Бурханы шашны судруудыг амжилттай залж авчирдаг. Хэрэв энэ гурван догшин шавь байгаагүй бол Тансан лам Баруун оронд хүрч чадахгүй байсан байж магадгүй. Тэгэхээр юм бүхэнд өөрийн тус эрдэм бий. Хэрвээ бид орчлон ертөнцийн хуулийг болон бүтээн бүтээлийн нууцыг ойлгож чадвал юуг ч хэрэгтэй зүйл болгож чадна, хэрэгцээгүй зүйл нэгээхэн ч үгүй.

Сүн Үкүн, Жү Бажэ, Ша Ужин нарыг байдаггүй гэж хэзээ ч битгий бодоорой, тэд бол бидний дотоод шинж чанарыг төлөөлдөг бөгөөд Бурханы шашны судруудыг олж авах аяллын явцад Тансан ламын дотоод сэтгэлд өрнөж буй зөрчил тэмцлүүд юм. Сүн Үкүн *(Сармагчны хаан)* бол Тансан ламын билиг ухаан болон бүхнийг чадагч хүч чадлын төлөөлөл, тэр тохиол бүрд бурхан, бодьсадвагаас тусламж хүсэж, асуудлыг дор бүр нь шийдэж чаддаг. Жү Бажэ *(Гахай)* бол түүний залхуу зан, гоо үзэсгэлэнд дурламтгай зан чанарын төлөөлөл болно, заримдаа үзэсгэлэнт хүүхэн харвал сэтгэл татагдаж, сайхан зүйлс харвал шунадаг. Ша Ужин (*Шороо Элс*) бол Тансан ламыг амгалан тайван, тэнцвэртэй, сайн ч биш, муу ч биш байдлыг төлөөлдөг.

Зохиолд Сүн Үкүнийг цэцэн сэргэлэн нь дэндсэн бөгөөд далан хоёр янзаар хувилж чаддаг шидтэй гэж гардаг.

Тэрээр гэгээрэхээсээ өмнө Тэнгэрийн ордныг түйвээж, өөрийгөө “Тэнгэртэй эн зэрэгцэх Их Богд” хэмээн зарлажээ. Энэ нь бидний дотоод дахь зөрчил тэмцлийн чанарыг харуулсан байна. Хэрвээ тэр хэдийн Тэнгэрийн хаантай эн зэрэгцэхээр байсан бол асуудал үүсгэхгүй байх байсан! Тэр бидэнтэй л адилхан. Хэдийгээр бид дотооддоо хамгийн дээд чанарууд болох Эзэн Бурханы чанаруудтай гэдгээ мэддэг ч тийм байр сууринд хараахан хүрээгүй болохоор өөртөө итгэж чадахгүй байдаг, хэрэв бид өнөөдөр итгэлээ гэхэд маргааш нь эргэлздэг, нөгөөдөр нь дахин итгэлээ ч дараа өдөр нь бас итгэлгүй болно.

Хэрэв бид нэг өдөр гэгээрч, өөрийн хэн болохыг мэдсэн бол бид маш эрхэм ариун бөгөөд тэнгэр, газар, бүх зүйлтэй нэгдмэл гэдгээ мэдрэх болно. Гэвч энэ тоост хорвоод хүндрэл зовлон их байдаг болохоор нэг л өдөр саад бэрхшээл тулгараад олон гай зовлон тохиолдоход бид доош унаж, эгэл жирийн хүн болно. Энэ дэсэд байхдаа бид өөртөө эргэлзэж, маш сул дорой, арчаагүй, хүч чадалгүй гэдгээ мэдэрнэ. Энэ үед их л бухимдаж, биднийг бурхан, бодьсадва гэж хэлэх хэнийг ч сонсохыг хүсэхгүй, өөртөө итгэх итгэлээ бүрмөсөн алдсан байдаг.

Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг хүмүүс бүгд Сүн Үкүнийх шиг ахуй ойлголттой байдаг. Тийм учраас бид зөрчилдөж, өдөр бүр асуудал үүсгэдэг. Бид нэг өдөр бурхан болохыг хүсдэг, зарим өдөр нь хүсдэггүй, нэг өдөр бурхан болж, өөр өдөр нь болдоггүй, нэг өдөр бид бурхан, заримдаа ад болно. Ингэж янз бүр болж байгаа нь Тансан ламын дотоод сэтгэлийн зөрчил юм. Зохиогч бидний ууриг тархины тогтворгүй байдлыг сармагчинтай зүйрлэжээ. Гэвч энэ сармагчин маш ухаалаг бөгөөд ид шидийн хүчтэй, тэр хүссэн бүхнээ авдаг, хүссэн ямар ч түвшинд хүрдэг, гэхдээ тэр хаа хүрлээ ч энэ нь сэтгэлийн хүрээнээс хэтрэлгүй, Гурван ертөнцийг давж чадаагүй байдаг.

“Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолыг уншихад Сүн Үкүн Тансан ламыг дагаж баруун орноос Бурханы шашны судар ном залахаар яваа нь угтаа хамаг төрөлтнийг аварч гэтэлгэхийн төлөө байв. Гэтэл бурхан, бодьсадва нар тэдэн рүү олон чөтгөр шулам явуулж, үргэлж хорлоно. Есөн есийн наян нэгэн гамшиг бүгдийг бурхан, бодьсадва бүтээсэн байна. Энэ нь юуг илэрхийлж байна вэ? Учир нь сорилт шалгалтгүй бол бид өсөж хөгжихгүй гэсэн үг. Яг л цэрэг хүн бэлтгэл сургуулилт хийхгүйгээр сайн цэрэг болохгүй, эсвэл шалгалтгүй бол сурагчид шамдан суралцахгүй байдагтай адил. Тиймээс сорилт шалгалт бидэнд тун хэрэгтэй, энэ нь өөртөө ахиц дэвшил гарсан эсэх, итгэл алдарсан эсэхийг бидэнд мэдүүлдэг.

Тэд багш, шавь хэдүүлээ заримдаа цэцэг, модонд хүлэгдэж, эсвэл уулын сахиусанд хорлогдож байх зэргийг бид зохиолоос уншсан. Энэ нь яг л Багш нь гадаад орчин заримдаа та нарт аюултай, эрсдэлтэй байж болохыг сануулж буйтай адил юм. Хэрэв бид хэтэрхий их үзэж харвал тэнд төөрч, жинхэнэ Мөн чанараа мартдаг. Ийм үед тухайн зүйлд маш амархан автана. Жишээлбэл, бид амьдарч байгаа газартаа дассан хойноо өөр газар очихыг хүсдэггүй, очсон ч тэнд унтаж чаддаггүй.

Үүнтэй адил, бясалгагч хүн заримдаа тодорхой нэг газрын хажуугаар өнгөрч явахдаа тэнд үлдэхийг хүсдэг. Уг нь түүний зорилго нь судар эрж хайж, Бурханы хутагт хүрэх боловч тэрээр тодорхой нэг газар очихдоо тэр нутгийн мод, ургамал маш үзэсгэлэнтэй, цэцэг, жимс нь тун тансагийг хараад орхиж явахыг хүсэхгүй, зүгээр л тэнд үлдэх хүсэлтэй болж: “За за, март даа! Би яагаад Бурхан болох гэж? Энд байгаа модыг харан баясаж, дуу шүлэг зохион уншиж суух нь сайхан хэрэг!” гэж бодно.

Тиймээс “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолд заримдаа модны сахиус, цэцгийн сахиус гарч ирээд

Тансан ламыг уруу татдаг, тэр ч бараг л дурлах дөхөхийг бид харна. Энэ нь үнэндээ сахиуснууд түүнийг барьж авсан биш, харин Тансан лам өөрөө байгалийн сайханд дурласан хэрэг байдаг. Тэр өөрөө сэтгэл татагдах нь яг л мод түүнийг хүлж, түүнийг барьж авахтай адил юм. Түүнээс гадна мод, цэцэг, ургамал ч бас өөрийн гэсэн сүнстэй байдаг. Хэрвээ бид тэднийг сонирхвол тэд бидэнтэй холбогдох бөгөөд тэднийг таашаах тусмаа бид улам хүлэгдэх тул бидний дэс тэнд гацах болно.

Бидний сүнслэг бясалгал дадал нь тодорхой нэг газар зогсох биш, үргэлжлэн урагшилж байх хэрэгтэй. Тийм ч учраас бид гадаад ертөнцийг сонирхох нь маш аюултай гэдгийн учир нь энэ. Миний хэлэх гэсэн санаа ийм юм.

Сүн Үкүн бол бидний мэдрэмж ихтэй, төлөвшсөн билиг ухааныг төлөөлдөг бөгөөд хэдийгээр санамсаргүйгээр Тансан ламын эгэл хүний дадал зуршлыг даган аюул гамшигт өртдөг ч тэр бол Сүн Үкүн болохоор эрт, орой хэзээ нэгэн цагт заавал мултран гарна, тэнд удаан живэхгүй. Харин Жү Бажэ байсан бол живэх болно! (*Их Багш инээв*.)

Нэгэн удаа бурхан, бодьсадва үзэсгэлэнтэй гурван бүсгүй болон хувирсанд Жү Бажэ мэдэлгүй, бүсгүйчүүдийн гоо үзэсгэлэнд автаж занганд ордог. Хэдийгээр хорлогдож сүйд болоогүй ч нэг хэсэг хугацаанд хүлэгдсэн.

Хүлэгдэх гэдэг нь юу вэ? Тэр ч байтугай хэрэв тэр хүн нь үнэхээр үзэсгэлэнтэй, эсвэл бурхан, бодьсадвагийн жинхэнэ хувилгаан байсан ч та түүнд дурлавал мэдрэмждээ баригдсан хэвээр байна. Уг нь Баруун оронд хүрч Бурханы шашны судар залахаар яваа, гэтэл хэсэг хугацаанд тэнд саатсан нь бүсгүй хүнийг хайрлахын төлөө байв. Энэ нь мэдээж түүний сүнслэг аяллын цаг хугацааг хойшлуулсан. Тиймээс бурхан, бодьсадвагийн хувилгаан байсан ч гэсэн бид түүнийг тоохгүй байх нь хамгийн сайн. Бид бясалгал

дадалдаа сонор сэрэмжтэй, болгоомжтой байх хэрэгтэй бөгөөд тэрхүү энэ дэлхийн тун сайхан үзэсгэлэнтэй бүсгүйчүүд, эсвэл сайн сайхан зүйлс гэгдэгчдэд хүлэгдэх хэрэггүй.

Нэг удаа Тансан лам аалзны үүрэнд хашигддаг. Аалзнууд гэр дүүрэн хүүхэдтэй үзэсгэлэнт бүсгүй болон хувираад Тансан ламыг хүлээслэв. Үүгээр гэр бүлийн үзэл санааг илэрхийлсэн байна. Магадгүй тэр үед Тансан лам: "Зүгээр л гэр бүлтэй болъё. Бурханы шашны судар залж ирэхийн төлөө би яагаад энэ бүх хүнд хүчрийг туулах ёстой юм бэ? Эхнэр авч, хэдэн "өхөөрдөм үйлийн үр"-тэй болох нь сайхан биш гэж үү?" гэж бодсон байх. (*Бүгд инээв.*) Нэгэнт ийм бодол төрсөн л бол тэнд хүлээслэгдэнэ! Хэдий таныг хүлээслэх жинхэнэ эхнэр, хүүхэд дэргэд тань байхгүй ч энэ тухай бодохын зуурт аль хэдийнээ тэдэнд хүлэгдээд дэс тань ч өөрчлөгддөг.

Хэрэв энэ бодлоосоо удаан хугацаанд салахгүй бол тэр бүх хугацаанд тэнд хүлэгдэх болно. Тиймээс энэ нь түүнийг уях гэж том, жижиг аалзан чөтгөрүүдийн бэлдсэн урхи занга биш, харин өөрийнх нь бодол л түүнийг ийм нөхцөл байдалд хүлсэн юм. Зам мөрийг бясалган дадуулах аяллын замын уртаас болж заримдаа бидэнд сэтгэлийн өгсөж, уруудах янз бүрийн байдал үүсэх нь гарцаагүй. Зохиолч эдгээр түүхийг ашиглан Тансан ламын дотоод сэтгэлийн байдлыг илэрхийлж, саад бэрхшээлийг даван туулахаар өрнөж буй янз бүрийн үйл явцыг дүрсэлсэн байдаг.

Хүмүүсийг уруу татаад дараа нь цусыг нь сорохын тулд өөрийгөө үзэсгэлэнтэй эмэгтэй болгон хувиргадаг араг ясан чөтгөр бас бий. Энэ араг ясан чөтгөр гэдэг нь юу вэ? Энэ бол бидэнд байдаг чөтгөрлөг чанар, эсвэл бусдыг уруу татахын тулд эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг ашигладаг тэр чанар юм. Иймээс эртний бясалгагчид заримдаа өөрийн дур

тачаалын хүслийг хянахын тулд араг яс ажих бясалгалын аргыг дадуулж, хүн бүрийг хувхай ясанд хувирган хардаг байжээ. Энэ нь бас үнэн. Хэрэв та үзэсгэлэнтэй сайхан эмэгтэй, царайлаг сайхан залууг нэвт харж чадвал түүний дотор ердөө л хувхай яс, араг яс байгааг мэдэх болно!

Арьяабал бодьсадва Сүн Үкүнийг мэхэлж байгаад толгойд нь Алтан цагариг өмсгөхийг хараад бид: “Арьяабал бодьсадва яасан энэрэх сэтгэлгүй вэ” гэж гайхаж магадгүй. Гэвч түүнийг хянах арга үүнээс өөр байхгүй, түүнд тусалж, сургаж хүмүүжүүлэхийн тулд заавал Алтан боодос өмсгөх хэрэгтэй. Ингэхгүй бол түүний ааш зан өөрчлөгдөхгүй, бясалгаж гэгээрч чадахгүй. Тиймээс Бурхан, бодьсадва дандаа сайхан аашилж, чихэр жимс өгөөд байдаггүй юм. Ингэх нь чамайг эрхийн тэнэг болгож, тийз бэлгэлээд там руу нисгэснээс өөрцгүй!

Та нар одоо энэ түүхэн дэх зүйрлэлүүдийг ойлгож байна уу? Бид бүгд дотоддоо гахай, сармагчны шинж чанартай байдаг. Та амьтдыг хар даа, тэд ч бас идэж ууна, үр төлөө төрүүлнэ, тэднийгээ асарч халамжилна. Тэд биднээс ялгаагүй. Тиймээс хэрвээ бид бясалгал дадуулдаггүй байсан бол амьтнаас нэг их ялгарах юмгүй байх байсан. Аз болоход бид бясалгалтай бөгөөд билиг ухаанаа хөгжүүлдэг. Харин амьтад бидэн шиг олон зүйлийг ойлгож чаддаггүй. Тиймээс та бүхэн өөрийн “Тансангийн” (*Багш билгийн мэлмийгээ заав.*) болон энэрэн нигүүлсэх сэтгэлийн өнцгөө сайтар нандигнаж, тэтгэн хөгжүүлээрэй. Өдөр тутмын амьдралаа гахай, сармагчны чанарааараа удирдуулж, эрхэм нандин “гэр орон”-оо бүү бохирдуулаарай!

Тавдугаар бүлэг

БЯСАЛГАЛ БҮТЭЭЛИЙН ЗАМ ДАХЬ АД ЧӨТГӨРҮҮДЭЭС БОЛГООМЖИЛ!

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шихү ашрам.
1991 оны 8 дугаар сарын 1
(Эх нь хятад хэлээр)

Та нар хар даа, Тансан лам явсан газар бүрд түүнийг барьж авах, махыг идэхээр чөтгөр шулмууд дайрч байдаг. Үнэндээ махыг нь иднэ гэдэг нь түүний махыг хэсэглэж хэрчээд иднэ гэсэн үг биш, харин сүнсийг нь тарчилган хүчирхийлж, тэсэж тэвчихийн аргагүй болгож, идэж ууж чадахгүй, унтаж амарч ч чадахгүй болгосноор бие махбодыг нь улам бүр хүч чадалгүй, сул дорой болгож байна гэсэн үг. Үүнийг махыг нь хэсэглэж хэрчээд идэж байгаа гэж үзэж болно, учир нь хүний сүнсийг тарчилган хүчирхийлэх нь адилхан хор хөнөөлтэй юм.

Зарим ад чөтгөр хүний амин эрчмийг сордог, хүн янгийн эрчим ихтэй байх тусам ингийн эрчимтэй ад

чөтгөрүүд төдий чинээ сорох дуртай байдаг. Хэрэв бид хэт их соруулбал ухаан балартан унаж мэднэ. Зарим хүн гаднаа хүн шиг харагддаг ч дотроо дүүрэн ад чөтгөртэй байдаг. “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолд гардаг хувхай ясан шулам хүний амин эрчмийг ховх сорж үхүүлээд биеийг нь эзэлдэг, дараа нь хүмүүсийг уруу татахаар гарч явна. Бид гаднаас нь хараад ялгахгүй. Тиймээс ад чөтгөрт эзлэгдсэн хүмүүсийн бие нь хүн, доторх нь ад чөтгөр байдаг. Бид ийм хүнтэй ойр байвал хамаг бие суларч үлбийнэ, дараа нь бүх зүйл ердийнхөөс өөрчлөгдсөн байдаг. Хэрвээ бид түүнд уруу татагдвал жинхэнэ Мөн чанараа улам алдах болно. Би адад эзлэгдсэн зарим хүнийг харж байсан, тэд эргэж ирэхдээ их өөр болсон байдаг. Тэр байтугай гэмшин наманчилсан ч ялгаагүй, миний бодлоор тэд үнэхээр өөр болсон байдаг бөгөөд эргэж сэргэхэд нь маш урт хугацаа шаардагдана. Тэр өөрөө ч энэ бүхнээ мэдэхгүй байж магадгүй, яг л унтсан хүн унтаж буйгаа мэдэхгүй, согтсон хүн согтуугаа мэдэхгүй, галзуурсан, эсвэл сэтгэцийн өвчтэй хүн ийм өвчтэйгөө мэдэхгүй байдаг шиг байна.

Заримдаа хэрэв энгийн хүн сэрэмж алдан болгоомжгүй байх, эсвэл хэтэрхий хар бараан бодолтой байвал ад чөтгөр түүнийг нь далимдуулан бие махбодод нь нэвтрэн орж, биеийнх нь нэг хэсгийг харлуулан бохирлож, хагас хүн, хагас чөтгөр болгон хувиргаснаар түүнийг хачирхалтай үйлдэл хийж, хачин сэтгэж бодоход хүргэдэг. Бүх зүйл өөрчлөгдөж, дараа нь тэрээр өмнөхөөсөө өөрөөр биеэ авч явдаг. Энэ үнэхээр аймшигтай! Тиймээс бид цаг үргэлж бие, хэл, сэтгэлээ цэвэр ариун байлгах ёстой бөгөөд замбараагүй байдлаар бодож, сөрөг, хар бараан бодолтой байхаас зайлсхийх хэрэгтэй, тэгэхгүй бол асуудалд орно.

Бид бүгд чөлөөт хүсэлтэй байх эрхтэй учраас Багш нь та нарын бодож байгаа зүйлийг цаг үргэлж хориглож чадахгүй. Юу бодох нь та нарын эрх, тиймээс өөрөө

өөрийгөө сайтар анхаарч, хянуур байх хэрэгтэй. Өөрийгөө хамгаалахыг Багшдаа зөвшөөрсөн тэр үед л Багш нь та нарт тусалж чадна. Хэрэв зөвшөөрөхгүй бол би ч бас хамгаалж чадахгүй. Та бүхэн тусламж хүсэхгүй байж болно, хамаагүй, харин Багш нь туслах гэвэл эсэргүүцэхгүй байх хэрэгтэй. Хүн бүхэнд чөлөөт хүсэл бий, хэрвээ Багшийгаа эсэргүүцвэл зөвхөн Багш нь ч биш, бурхан, бодьсадва ч хөндлөнгөөс оролцож чадахгүй. Орчлон ертөнцийн хууль ийм байдаг бөгөөд тийм учраас дэлхий ертөнц одоо ч маш эмх замбараагүй байгаагийн шалтгаан нь энэ юм. Хэрвээ бурхан, бодьсадва бидний бодол санаанд хөндлөнгөөс бүрэн оролцож чаддаг бол ямар ч асуудалгүй болчихно, бид зүгээр байх байсан. Гэхдээ энэ тохиолдолд ямар ч тоглолтгүй, өвдөлт зовлонгүй, баяр баясгалангүй, ялгамжаатай дэс түвшингүй болж, бүх хүн Төгс баясгалант оронд хүргэгдчихнэ!

Тиймээс та нар сүнслэг бясалгалыг өөрөө л хийнэ. Гэрлийг өөрөө л асаана. Зам мөрийг өөрөө л туулна гэдгийг ойлгох хэрэгтэй. Харин өвдөж, явж чадахгүйд хүрвэл мэдээж Багш нь үүрч дүүрээд авч явна. Гэхдээ хэрэв та нар өөрсдөө эсэргүүцээд эсрэг зүгт явбал Багш нь зөвхөн дагаж л чадна, хэдийгээр улам бүр холдоно гэдгийг чинь мэдэж байдаг ч дагаж байдаг бөгөөд та нарыг орхиж чадахгүй, гэхдээ уучлаарай, хөндлөнгөөс оролцож чадахгүй.

Бясалгал дадуулахдаа сонор сэрэмжтэй байгаарай, чөтгөр шулам тун олон шүү! Баруун орноос судар залахаар явахад л чөтгөр шулам таардаг юм биш. Бид ч бас эндээ (*Багш билгийн мэлмийгээ заав.*) өдөр бүр Баруун орноос ном залахаар явдаг. Зам нь Энэтхэг орохоос ч хол, бидний аялал бүр ч хүнд хэцүү. Хүн бүхэнд унах үе бий, гэхдээ эргэж босохоо мэдэж байвал зөв. Унах үедээ биднийг дээш нь татахыг хүссэн хүнийг эсэргүүцэх ёсгүй гэдгээ мэдэж байх ёстой, ингэвэл бид аюул багатай болно. Унасан ч гэсэн тэндээ залхуураад суух хэрэггүй, бас зориуд өөрийгөө

урууддуулж доройтуулчихаад би зүгээр хэвээр байна гэж бодож болохгүй.

Зургаадугаар бүлэг

ИД ШИД БА ИХ БИЛИГ УХААН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шинжү хот, Жяотун их сургууль
1988 оны 4 дүгээр сарын 2.
(Эх нь хятад хэлээр)

Ид шид бол балчир хүүхдийн тоглоом наадгай

Өчигдөр нэг хүн Багшаас нь ид шидийн хүчээ тэдэнд жаахан үзүүлж чадах эсэхийг асуусан. За, өнөөдөр ид шид үзэх хүн байна уу? (*Байна гэж нэг хүн хариулав.*) Үзэх нь гараа өргөөрэй Гараа өргө гэхээр та нар өргөж зүрхлэхгүй байна, хэрвээ хүсэж байгаа хүн олон байвал шид үзүүлж болно, одоо гараа өргөсөн хүний тоо ердөө талд нь ч хүрэхгүй байна, тэгэхээр би больё доо. (*Бүгд инээв.)*

Ид шидийн хүчийг ашиглахад ямар ч асуудал байхгүй, энэ бол ердөө л балчир хүүхдийн нааддаг тоглоом,

Багш нь байнга шид хэрэглэхийг хүсдэггүй. Багшид нь ид шидийн хүч байдаг гэдгийг олон хүн мэднэ, гэхдээ би энэ талаар хэзээ ч ярьж байгаагүй. Хэдийгээр Багш нь ямар ч шид хэрэглэдэггүй ч Багшид нь шидийн хүч байхгүй гэж хэлж болохгүй. Ид шидийн хүчгүй байх нь хамгийн том шидийн хүч мөн. (*Бүгд алга ташив.*)

Та нарт ч бас шидийн хүч байхгүй болохоор ийм байх минь та нартай адилхан болох бус уу? Адил боловч бас адилгүй. Учир нь хэдийгээр Багш нь шидийн хүчгүй ч гэсэн хэн нэг хүн Багштай нь уулзахаар ирвэл тэрээр сэтгэл хангалуун байх ямар нэг зүйл хүртдэг, харин та нартай уулзвал юу ч хүртэхгүй, ялгаа нь үүнд байгаа юм. Хэдийгээр Багш нь ирсэн хүнд зориудаар ямар нэг юм өгөөгүй ч түүнд юу хэрэгтэй байна, түүнийгээ өөрөө л олж хүртдэг, Багшдаа мэдүүлэх ч шаардлагагүй.

Эртний Мэн Чанжүн тун өгөөмөр хүн байсан гэж бид сонссон. Тэр нэр хүндтэй ахмад хүн бөгөөд их баян, хэдэн мянган хүнийг хармыг тэтгэн тэжээж байжээ. Бүгд л тэднийд очин хооллож болно. Тэр хүмүүс хооллож дуусаад түүнд талархлаа илэрхийлэх ч шаардлагагүй. Бас ирсэн, явснаа ч хэлэх хэрэггүй. Хэн хэн ирснийг тэр мэдэхгүй, учир нь өдөр бүр их, бага түшмэд, гуйранчид, ядуу хүмүүс, баячууд гээд олон хүн орж гарна. Тэр хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй, ирсэн бүхнийг хүлээн авч хооллоно.

Бурханы хүч ч адилхан, энд ирсэн хүн бүр ямар нэг зүйл хүртдэг ч Багш нь мэдэх шаардлагагүй, олж хүртсэн хүн ч Багшид нь тайлагнах албагүй, олж хүртэхийн тулд заавал Багшийг нь даган суралцах шаардлагагүй. Багш нь ном тайлах бүрт үргэлж нэг хүн тайзан дээр гарч, ахуй ойлголтоо хуваалцан Багшийнх нь хувилгаан бие гэрт нь ирж, хэрхэн адисалсныг ярьдаг. Өнөөдөр ахуй ойлголтоо ярьсан тэр хүн авшигтан биш, үнэндээ үүнийг ярих шаардлагатай гэж би бодохгүй байна, учир нь энэ бол өчүүхэн жижиг зүйл. Иймт үүх

тун олон гэдгийг дурдахын ч хэрэггүй, яривал мөд дуусахгүй.

Багш нь яагаад ийм зүйлийг ярих дургүй вэ? Учир нь хэн нэг хүн өвчин анагаадаг ид шидийн хүчийг олж авахын төлөө авшиг хүртэхийг би хүсэхгүй. Багш нь хамаг төрөлтнийг аварч, сүнсийг нь гэтэлгэхийг хүсдэг, махан биеийн тухайд бол өөрийн жамаараа л болог. Эдгэх эсэх нь тухайн хүний буян хишиг болон үйл түйтгэрээс хамаарна. Зарим хүн хурдан эдгэрч, зарим нь удаан эдгэрдэг. Энэ нь тухайн хүн хурдан түргэн эдгэрэх хүсэлтэй эсэхээс хамаарна.

Зарим хүний далд ухамсар нэлээд хүчирхэг бөгөөд бүрмөсөн эдгэрч чадна гэх бодол нь бүхнээс хүчтэй болохоор өөрийгөө аварч чаддаг. Заримынх нь далд ухамсар нь нэлээд сул дорой, өөрөө ч эдгэрэх хүсэлгүй байдаг. Үнэн шүү, тэд эдгэрэх хүсэлгүйгээ өөрсдөө ч мэддэггүй. Зарим хүн үнэхээр өвчтэй байх дуртай байдаг. Өршөөгөөрэй, энэ бол үнэн хэрэг, учир нь өвчтэй байвал хүмүүс өөрийг нь тайтгаруулна, өрөвдөнө гэх мэтээр боддог. Гэхдээ энэ бүхэн нь өчүүхэн шалихгүй зүйл, ярих шаардлагагүй.

Багш нь та нарт яагаад хүч чадлаа үзүүлэхгүй байна вэ? Мэдэх хүн байна уу? (*Үзүүлэх шаардлагагүй гэж нэг хүн хариулав.*) Гэхдээ тэд харахыг хүссэн тул шаардлагатай, гэвч Багш нь үзүүлж чадахгүй, учир нь эгэл хүмүүсийн шунал хэдийн маш ноцтой болсон, материаллаг зүйлд шунах нь сайн биш байтал ид шидийн хүчинд шунах нь бүр ч дор.

Эрхэм ариун хүсэл мөрөөдөл хамгийн чухал

Тиймээс хэдийгээр Сүн Үкүн далан хоёр янзын шидтэй, дээшээ диваажинд, доошоо тамд очдог, бас олон зүйлийг өөрчилж чаддаг ч Их Багш Тансанд тэр үйлчлэх ёстой хэвээр. Их Багш Тансан мөн Арьяабалын бясалгалын аргыг дадуулж байжээ. Гэхдээ “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолд түүнийг ид шидийн хүчтэй байсан

тухай дурдаагүй. Түүнд ад чөтгөр ч бурхнаас ялгаагүй. Сүн Үкүн ад чөтгөрийг шийтгэх болгонд Тансан лам тэр даруй түүний толгойн цагаригийг чангалах тарни уншиж толгойг нь өвтгөнө. Учир нь тэрээр Сүн Үкүнийг амь хөнөөхөд дургүй, түүнийг гэм хийгээгүй хүний амийг хөнөөв хэмээн бодно, хэдийгээр тэр нь хүн биш ад чөтгөр гэдгийг Сүн Үкүн мэдэх ч багш нь мэдэхгүй учраас Сүн Үкүнийг шийтгэдэг.

Сүн Үкүн асар их шидийн хүчтэй, тэнгэрийн мэлмий нь маш их нээгдсэн, тиймээс Тансан ламын шавь байх ёстой. Учир нь Тансан ламд эрхэм дээд хүсэл зорилго, чухал үүрэг даалгавар бий. Түүний үүрэг даалгавар маш эрхэм ариун, тэрээр билгүүн ухааны судар ном олныг залж, бурхны номыг Хятад даяар ойлгож мэдэхэд нь туслахын тулд Энэтхэг рүү явах ёстой байсан юм.

Хэдийгээр Сүн Үкүн ид шидтэй, хүч чадал ихтэй ч тун өчүүхэн зорилготой, ердөө л өөрийн үйлийн үрийг цэвэрлэж, өөрийгөө аварч, туулан гэтлэх хүсэлтэй. Олон янзын шидээр наадаж чаддаг ч түүнд эрхэм ариун хүсэл зорилго байхгүй. Хүмүүсийн үнэ цэний ялгаа энд л байдаг. Эртнээс нааш өнөөг хүртэл их бясалгагч бүхэн бид хамаг төрөлтний төлөө өөрсдийгөө зориулах ёстой, хэдий чинээ золиослох тусам бидний зан чанар эрхэм ариун болдог гэж онцлон сургасаар иржээ. Бурханы шашинд энэ нь Бодьсадвагийн зам мөр юм.

Гэхдээ үүнийг хүчээр хийх боломжгүй. Та дотооддоо тийм шинж чанартай, гүн гүнзгий хүсэл эрмэлзэлтэй байвал хийж чадна. Эс бөгөөс, хүчээр хийлээ гэхэд энэ нь жам ёсны бус, хиймэл явдал болно. Гэхдээ зүгээр ээ, аажим аажмаар өөрийгөө дадуулан сургаж чадна, эхлээд үүнийг хийх дургүй байж болох ч дахин давтан хийсээр байвал сүүлдээ энэ нь ая зөнгөөрөө хийдэг жам ёсны дадал болж хувирна.

Тиймээс эрт дээр үеэс жинхэнэ гэрээс гарагчийг хүмүүс ихэд хүндэлсээр иржээ, тухайлбал, хятадууд

гэрээс гарагчийг бүр ч их хүндэлдгийг та нар бүгд мэднэ. Гэрээс гарагчийн зарим нь сүнслэг бясалгал дадуулдаггүй, харахад тийм сүрлэг эрхэмсэг биш, яг л Багштай нь ойролцоо иймэрхүү нуруутай байсан ч (*Бүгд инээв*.) бүгд хүндлэгдэнэ. Энэ нь та бүхэн их буян хишигтэй, зүрх сэтгэлдээ тэдэн шиг хүсэл эрмэлзэлтэй, тэдэнтэй ижил зүйлийг хийхэд бэлэн байдаг гэдгийг харуулж байна. Тийм учраас ижил зүйлээ хараад ихэд дуртай байдаг хэрэг. Ижил нь ижлээ татдаг. Англи хэлээр бас ингэж хэлдэг. Two great minds think alike (Хоёр агуу оюун ухаан адилхан сэтгэдэг).

Өнөөдөр яагаад гэрээс гарагч болох тухай ийм олон зүйл ярьснаа би мэдэхгүй байна. Магадгүй, сонсох хүсэлтэй хүмүүс байснаас тэр байх. Гэрээс гарагч бясалгах хамгаас дуртай байдаг болохоор гэрээс гардаг, тэд аливаа холбоо хамаарлаа таслахыг хүсдэг, ингэвэл бясалгахад хялбар байдаг. Гэрээс гарах гэдэг нь зөвхөн холбоо хамаарлаа таслахаас гадна хүсэл шунал, уур хилэн, харанхуй мунхагийг ч тасална, өөрөөр хэлбэл мөнгөнд шунахгүй, хувцсанд дурлахгүй, гэр бүлдээ хоргодохгүй, ер нь юунд ч шунахгүй байх явдал юм.

Гэхдээ энэ нь хангалтгүй, хамгийн төгс дээд бясалгалын аргыг дадуулахгүй бол туулан гэтлэх аргагүй, тиймээс дан ганц гэрээс гарах нь хангалтгүй. Иймээс Шагжамуни Будда өөрийн хамгийн хайртай шавь Анандад Арьяабалын аргаар бясалгахыг зөвлөсөн байна. Арьяабалын аргаар бясалгахаас өмнө Анандад давж туулах шаардлагатай асуудлууд байсаар байсан тул Шагжамуни Будда түүнд хамгийн төгс дээд бясалгалын аргыг дадуулахыг зөвлөжээ. Тэгснээр хожим нь Ананд гэгээрч, эцэст нь Бурхан Багшийн залгамжлагчийн нэг болсон билээ.

Хэрэв Анандад төвөг учирч, асуудалд ороогүй бол өнөөдөр “Баатараа явагч нэрт их хөлгөн судар” гэж байхгүй, Арьяабалын бясалгалын арга гэж юу болохыг бид мэдэх боломжгүй байх байсан. Мэдээж, Шагжамуни Будда энэ

дэлхийд залрахаас өмнө Арьяабалын бясалгалын арга аль хэдийнээ байсан. Эс бөгөөс Шагжамуни Будда түүнийг хаанаас олж бясалгах вэ? Гэхдээ тухайн үед энэ нь тун нууцлаг байжээ. Зөвхөн маш дээд ангийн брахман хуврагаас өөр хэн ч Арьяабалын бясалгалын арга гэж юу болохыг мэддэггүй байсан. Яагаад гэвэл урьд нь Дээдийн номд суралцахад тун хэцүү байсан. Үүнийг та бүхэн бүгд мэднэ.

Эртний Хятадад ч бас адилхан, өнгөрсөнд Дээдийн номыг тийм ч нээлттэй уламжилдаггүй байсан. Нэгэн алдартай номын багшаас суралцахын тулд уулыг давж, усыг гаталж, хамаг эд хөрөнгөө багшдаа өргөж, багштайгаа хамт амьдарч, түүнд тус дэм болж, хэдэн жил шадарлан үйлчилнэ. Тэгээд хэдэн жилийн дараа л багшаас шавьд ном уламжилна.

Хэрэв та нар Мял богдын түүхийг уншвал Тэрээр багшдаа долоон жил гаруй үйлчилсэн гэдгийг мэднэ. Өдөр бүр зодуулж загнуулна, өдөр бүр байшин барина, барьсан байшингаа нураана, нурааснаа дахин барина, олон жил ингэж соригдсоны эцэст багш нь Түүнд Дээдийн ном уламжилсан байна. Тэр ч байтугай үүнээс өмнө Мял богд хүссэн ч ном хулгайлж чаддаггүй байв, Тэрээр багшийгаа мэхэлж чадаагүй тул шавиас нь ном сурахыг оролдсон ч бас л бүтээгүй. Түүний төлөвлөсөн бүхэн бүтэлгүйтэж байв. Багш нь ном уламжлахыг зөвшөөрөх хүртэл хүлээсний эцэст л сая ном хүртэж чадсан байна. Авшиг хүртсэнийхээ дараа хэдэн жилийн турш үргэлжлүүлэн маш шаргуу бясалгаж, хүйтэн Хималай ууланд идэх хоол, өмсөх хувцасгүй, найз нөхөдгүй, ямар ч материаллаг тав тухгүй байжээ. Хэдий ингэж зүдрэн бясалгасан ч эцэст нь Тэрээр Бодь мөрийг олсон билээ.

Уламжлал нь тасарсан жинхэнэ ном

Тиймээс хэрвээ та бүхэн урьд нь яагаад Арьяабалын бясалгалын арга байгаагүй, эсвэл яагаад Формосад энэ аргыг хэн ч заагаагүйг мэдэхгүй байгаа бол энэ нь бас зүй

ёсны хэрэг. Зөвхөн Формосад ч биш, өөр бусад олон оронд энэ бясалгалын аргын тухай сонсоогүй байдаг. Гэхдээ энэ нь өмнө нь Формосад хүмүүс үүнийг хэзээ ч дадуулж байгаагүй гэсэн үг биш. Байсан, гэхдээ тун цөөхөн хүн дадуулж байжээ, тиймээс номын уламжлал нь бараг тасрах дөхсөн байна. Бумбын шашинтны бясалгалаас энэ бясалгалын арга өнөөг хүртэл уламжлагдахдаа зөвхөн өчүүхэн хэсэг, бага зэрэг нууц л үлдсэнийг мэдэж болно.

Би тэдний судар номуудыг уншаад тэдний сургаалын эзэд, эсвэл их багш нар нь бүгд Арьяабалын бясалгалын аргыг дадуулж байсныг бас мэдсэн, гэвч одоо багахан хэмжээний мэдээлэл л үлджээ. Хожим нь хүмүүс яаж бясалгахаа мэдэхгүй байснаас бүгд буруугаар бясалгасан байна. Тэдний бясалгал дадуулж буй байдлыг хараад гагцхүү өрөвдөх сэтгэл төрсөн. Жинхэнэ номын уламжлал нь тасарсан байх гэдгийг зэрвэсхэн хараад мэдсэн. Одоогийн шавь нар нь, шавийн шавь нар нь өөрсдөө таамгаар сохроор бясалгаж байгаа нь үнэхээр өрөвдмөөр. Үнэндээ тэдний Зам мөрийг олох хүсэл эрмэлзэл маш их, туулан гэтлэхийг үнэхээр чин сэтгэлээсээ хүсдэг, тэдэнд зөвхөн бясалгалын арга л дутуу байдаг. Хэрвээ ийм өндөр дэсийн гэгээрэх хүсэлтэй хүмүүс Арьяабалын бясалгалын аргыг олж авч чадвал маш хурдан Бурханы хутагт хүрэх нь гарцаагүй.

Исламын шашинтнуудын хувьд ч мөн адил, би тэдний мөргөлийн сүмд очиж мөргөл үйлдэх зан үйлийг нь хараад тэд ч Арьяабалын аргаар бясалгаж байсныг мэдсэн, учир нь тэдний бясалгах байрлал нь ялимгүй өөр байв. Үүнийг хараад сэтгэл их өвдсөн ч тэдэнд энэ талаар хэлээгүй, учир нь тэд намайг уриагүй болохоор би ярих боломжгүй. Магадгүй тэдний цаг нь хараахан болоогүй байх.

Энэ нь тохиромжтой тохиол биш байсан тул би энэ талаар яриагүй, хэрвээ яривал зөвхөн үл ойлголцол үүсэж, эсвэл өрсөлдөх мэдрэмж төрүүлж, тэднийг эвгүй байдалд

оруулах болно. Би хаяа тийшээ очиж, ганц хоёр үг хэлээд Коран судар авч яван уншдаг байсан. Багш нь тэдэнд заахыг хүсэхгүй байсан юм биш, гэхдээ тэднийг дэндүү гүнзгий төөрөлдсөнийг хараад ярьсан ч нэмэргүй гэж бодсон юм.

Гэсэн хэдий ч Багшид нь итгэл найдвар байсаар байна, учир нь хэрвээ Багш нь олны өмнө үүнийг яривал зайлшгүй нэг хүн олж сонсоно, тэгээд түүнийг өөрийн хүслээр ном хайж ирэхэд нь гарцаагүй уламжилна. Тэр хүн хариад Зөнч Мухаммедэд мөргөсөн хэвээр байж болно, учир нь Зөнч Мухаммед бол тэдний өмнөх үеийн сургаалын эзэн бөгөөд бидний хүндэтгэлийг хүртэх ёстой.

Исламын шашинтнууд заавал энд ирж, Багшийнх нь шавь болох шаардлагагүй, би зөвхөн тэдэнд ном уламжлахад л хангалттай. Тэд надад үйлчлэх, эсвэл миний төлөө юу ч хийх хэрэггүй, надтай ямар нэгэн байдлаар холбоотой байх ч шаардлагагүй. Хэрвээ Багштай нь гадаа тааралдаад танихгүй мэт дүр эсгэж, зам дээр мэндгүй зөрсөн ч хамаагүй.

Учир нь Арьяабалын бясалгалын арга нь сэтгэлээс сэтгэлд уламжлагддаг, нэг хүнээс нөгөө хүнд ганцааранчилсан байдлаар дамжуулдаг нууц сургаал тул гадны хүмүүст мэдэгдэх шаардлагагүй. Хэрвээ мэдэгдвэл энэ нь тухайн шавийн нийгмийн байр суурь, эсвэл гэр бүлийн харилцаанд хохирол учруулж болзошгүй, тиймээс би Багшийгаа даган суралцаж байгаа ямар ч хүнийг хэнд ч мэдүүлэхийг зөвшөөрдөггүй.

Бусад хүн мэдэх нь тэдний асуудал. Багш нь хэн гэдэг дээд, доод албан тушаалтан, эсвэл гуйлгачин Багшаас нь суралцахаар ирсэн гэж гадна ертөнцөд зарлахгүй. Ийм шаардлага угаасаа ер байдаггүй, надад юу ч хэрэггүй, миний хэчнээн шавьтайг, эсвэл би хэр агуу хүн болохыг бусдад мэдүүлэх шаардлагагүй. Өөрийгөө хэчнээн агуу болох талаар би хэзээ ч бодож байгаагүй. Бидний хүн нэг

бүр агуу, гэхдээ үүрэг даалгавар өөр өөр.

Эмч байх нь чухал ч, хог цуглуулагч ч бас чухал. Түүнгүйгээр манай дэлхий хог хаягдлаар дүүрч, өмхий үнэртэй болох байсан. (*Бүгд алга ташив.*) Багш нь ч бас хог цуглуулагч, бусдын үйл түйтгэрийг тусгайлан цуглуулдаг. Ийм үйл түйтгэр нь хог новшноос ч дор, бүр их өмхий. Тиймээс надад бардамнах юм ер үгүй, би ердөө л нэг хог цуглуулагч, зөвхөн илүү гоёмсог сайхан хувцас өмсөж, өөр харагдаж байгаа төдий. Үнэндээ хамаг төрөлтний үйл түйтгэрийг цуглуулах нь үнэхээр өмхий самхай.

Бурханы хүч бол далд бөгөөд нууцлаг

Өчигдөр Багшийнх нь хариулж амжаагүй нэг асуулт бол Багш нь яагаад та нарт хүч чадлаа үзүүлдэггүй вэ? Үнэндээ бол би харуулдаг, гэхдээ Багшийнх нь хүч чадал жам ёсных бөгөөд ид шидийн хүчийг зориуд ашигладаггүй, тиймээс зарим нь түүнийг мэдэрч чадна, зарим нь чадахгүй. Энэ бол та нарын өөрсдийн асуудал.

Их Багшид хүч чадал бий гэдгийг бид мэднэ гэж өчигдөр зарим нь хэлж байсан, гэвч тэр нь зөвхөн цөөхөн хэсэг бүлэг хүн байсан бөгөөд өөр хэн ч мэдэхгүй. Энэ нь та нарын буруу ч биш, бас та нарын дэс доогуур байснаас ч болсон биш. Өчигдөр Багш нь та нарыг зориудаар жаахан дарамтлан шахаж “нүүрийг тань барж”, бардам сэтгэлийг тань жаахан багасгасан, ингэснээр л сая Арьяабалын бясалгалын аргын чадлыг та нарт тайлбарлан таниулж, нотолж чадсан.

Үнэндээ та нар тийм ч доогуур дэстэй биш, доогуур дэстэй хүн энд ирвэл сонсох ч үгүй, тэр байтугай ирэх ч үгүй, ирсэн ч таван минут болоод л явахыг хүснэ, явахгүй байсан ч тэнд суугаад хурхиран унтана. Гэтэл та нарыг харвал нүд нь гэрэлтээд зарим нь бүр төвлөрсөн царайтай,

маш их сонирхон сонсож байгаа нь илт байна. Энэ бол өндөр дэстэйн шинж. Багшийнхаа хүчийг авшиг хүртсэн шавь нар бүгд мэднэ. Авшиг хүртээгүй зарим хүн ч бас Багшаас нь Гэрэл цацарч байгааг хардаг, эсвэл Багшаас нь ирэх шидийн хүчийг мэдэрдэг, эсвэл бурхан, бодьсадваг хардаг гэх зэрэг явдал болж байдаг. Тэр үед Багшийнх нь бясалгал эгэл биш гэдгийг тэд мэддэг.

Багш нь хэзээ ч хаана ч: “Харцгаа! Би бол Бурхан!” гэж сурталчлаагүй. Багш нь ингэж ярихгүй, яагаад гэвэл би өөрийгөө бурхан гэж мэдэрдэггүй.

Формосад бол үсээ хусуулсан, эсвэл гэрээс гарсан хүнийг багш хэмээн дууддаг. Энэ бол тун түгээмэл нэршил бөгөөд тийм ч том асуудал биш.

Яагаад хүч чадлыг зарим нь мэдрээд зарим нь мэдэрдэггүй вэ? Миний Өвөг Багш нэгэн бурхан энэ тоост хорвоод мэндлэхэд хэн ч энэ тухай мэддэггүй нь үнэхээр хачирхалтай шүү гэж хэлж байсан юм. Хэрвээ нэгэн эмч ирвэл бид бүгдээрээ түүнийг танина, учир нь тэр цагаан халаадтай. Ерөнхийлөгч ирвэл цэгцтэй сайхан хувцаслаж, дагуул олонтой явах тул бид түүнийг тэр дор нь мэдэх болно. Эзэн хаан, эсвэл цагдаа ирвэл бид бүгд мэднэ. Харин манайд нэгэн бурхан залран ирвэл хэн нэгэн хүн танилцуулахгүй л бол түүнийг таних арга бидэнд байхгүй. Тиймээс би нэлээд хэдэн газарт амьдарч байсан ч энэ талаар хэн ч мэдээгүй. Өчигдөр хар арьст америк авшигтан Дээдийн номыг анх хэрхэн хайсан тухайгаа ярьсан. Тэрээр тухайн үед Арьяабалын бясалгалын аргын талаар мэддэггүй байжээ. Нэг удаа тэр хэсэг зуур маш хүнд өвдөөд үхэж, төрөхийн сансрын хүрдэнд эргэлдэхийн зовлонг ухаарсан байна. Тэгээд бурхан, бодьсадвад хандан нэгэн төгс гэгээрсэн жинхэнэ Их Багшийг хайж олоход минь туслаач гэж чин сэтгэлээсээ гуйн залбирчээ, тийм учраас бурхан, бодьсадва түүнд хэлсэн байна. Эс бөгөөс тэр хүн ч бас Багшийг нь хэн

болохыг мэдэхгүй байх байсан.

Тиймээс бид чин сэтгэлээс залбирвал бурхан, бодьсадва бидэнд жинхэнэ Их Багшийг олоход тусална. Хэн нь жинхэнэ Их Багш вэ, хэн нь хуурамч Их Багш вэ гэж Багшаасаа асуух шаардлагагүй. Жинхэнэ, эсвэл хуурамч байх нь бидний чин сэтгэлтэй эсэхээс шалтгаална. Хэрэв бид чин сэтгэлгүй бол хуурамч Их Багштай уулзана, харин чин сэтгэлтэй бол жинхэнэ Их Багштай уулзана. (*Бүгд алга ташив.*)

Есүс Христ мөн: "And the spirit will make flesh and lives among man, but nobody knows Hirm" хэмээн айлдсан байдаг. Энэ нь "Эзэн Бурхан хүн дүрээр бууж ирэн хүмүүстэй хамт амьдарсан ч хүмүүс Түүнийг таньж мэддэггүй." гэсэн утгатай юм.

Энэ бол үнэхээр хачирхалтай явдал. Бид өдөр бүр Эзэн Бурханаас тусламж гуйж, бас өдөр бүр бурхнаас тусламж гуйн залбирдаг мөртөө бурхан залран ирэхэд, эсвэл Эзэн Бурханы хувилгаан бие бууж ирэхэд Түүнийг мэдэх ямар ч аргагүй байдаг. Хэрвээ энэ нь цэцэг байсан бол бид түүний үнэрийг мэдрэх бөгөөд холоос ч үнэрлэж чадна. Гэтэл Эзэн Бурханы хувилгаан бие залрахад бид мэдэрч ч чадахгүй байдаг.

Дүрс хоосноос ялгаагүй, хоосон нь дүрсээс өөрцгүй

Эрт дээр үед ч бас ийм байсан, бид Даяаны бүлгийн судруудаас их бясалгагч, эсвэл ихэд туулан гэтэлсэн хүн хаана ч очсон бай өөрийг нь таних ямар ч ул мөр үлдээдэггүй тухай уншдаг. Учир нь тэд бүрэн хоосорч, оршин буйг нь харах аргагүй болтол хоосорсон байдаг.

Хэрвээ нэгэн үнэхээр сайн бясалгалтан энд ирж, ном айлдвал түүний бие нь бас хоосон, зөвхөн хэсэг гэрэл байхыг бид харах болно. Гэтэл зарим хүн зөвхөн бие махбодын дүр

төрхийг харж чаддаг тул энэ махан бие заримдаа оршин байх шаардлагатай хэвээр байдаг.

Тиймээс “Дүрс хоосноос ялгаагүй, хоосон нь дүрсээс өөрцгүй.” хэмээх сургаал ийм утгыг илэрхийлдэг бөгөөд энэ нь үнэн юм. Их бясалгагчийн бие махбод энгийн нэгэн бие биш, учир нь түүний оршихуйн хэлбэлзэл дэндүү асар өндөр түвшинд хүрсэн байдаг. Хэрвээ бидний хэлбэлзэл хэсэг зуур түүний хэлбэлзэлтэй бараг ижил болбол бид ч бас түүний махан биеийг харах боломжгүй болно. Тэр үед, тэр үнэхээр хоосон, тэр бол энэ махан бие цогцос биш болохыг бид мэднэ.

Багадаа тоглодог байсан эргүүлгэн тоглоомыг та нар санаж байна уу? Хэтэрхий хурдан эргэлдэх үед нь бид хэлбэр дүрсийг нь харж чаддаггүй, тэнд юу ч байхгүй юм шиг байдаг, тийм биз? Харин эргэлдэхээ зогсох үед хэлбэр дүрс нь харагдана.

Үүнтэй ижил, хэрвээ нэгэн их бясалгагчийн хэлбэлзэл дэндүү өндөр бол тэр оршихгүй байгаа мэт санагддаг ч үнэндээ бол оршсон хэвээр байдаг. Тэр хамаг төрөлтнийг гэтэлгэхийн тулд биеэ харагдахуйц болгох хэрэгтэй, тэдэнд түшиг болох хэн нэгэн байх хэрэгтэй учраас үзэгдэх бие махбодтой байх ёстой. Эс бөгөөс түүний оршин байгааг бид мэдрэх боломжгүй.

Би өмнө нь Нью-Йоркод жил гаруй амьдрах үед нэг ч хүн ном гуйж ирээгүйд гайхах зүйл алга. Зөвхөн нэг хар арьст эмэгтэй бясалгагч ирсэн, учир нь тэрээр бясалган сууж байх үедээ Багшийнх нь дүр илрэхийг харсан бөгөөд улмаар дотоодод нь хэн нэгэн энэ Их Багшийг олж уулз гэж хэлэхийг сонсжээ. Тэгээгүй бол Багшийг нь хэн болохыг өөр хэн ч мэдэхгүй.

Түүнийг намайг хайж ирэх болгонд сүмийн хүмүүс

ихэд гайхаж: “Та хэнийг хайгаа вэ?” гэхэд тэрээр: “Би Master Ching (Их Багш Чин)-г хайж байна.” гэнэ. Master гэдэг нь хятад хэлээр “их багш”, “номын багш” гэсэн утгатай. Тэд: “Та хамба ламыг хайгаа юу?” гэхэд тэрээр: “Үгүй, би нэг жижигхэн гэлэнмааг хайж байна.” гэжээ.

Тэр нэг жижигхэн гэлэнмааг агуу Их Багш гэж тэд хэзээ ч сонсож байгаагүй учир маш их гайхсан гэнэ. Хожим нь ирэх хүн улам олширч, түүний найзууд нь хүртэл ирсэн. Ямар нэгэн зүйл хачин байгааг мэдэрч эхэлмэгц Багш нь тэдэнд мэдэгдүүлэхгүйн тулд өөр газар руу тун хурдан нүүсэн. Тэнд би жил гаран амьдарсан бөгөөд Багш дээр нь ирдэг тэр хэдэн хүнээс бусад Багштай нь хамт амьдарч байсан хүн Багшийг нь хэн болохыг мэдээгүй.

Өмнө нь Багш нь Формосагийн нэг сүмд бас жил гаран амьдрахад хэн ч, юу ч мэдээгүй. Харин намайг даяан хийж байхад тэнд ганцаар амьдардаг нэгэн хүн ирж, хаалга тогшин асууснаас өөр надтай хамт амьдарч байсан хүмүүсээс хэн нь ч, юу ч мэдрээгүй. Гэсэн хэдий ч та нар энд ирж ном сонсож байх үедээ зарим нэг онцгой зүйлийг “мэдэрч” чадна. Энэ маш хачирхалтай хэрэг шүү.

Тиймээс нэгэн бясалгагч хүнтэй хамт амьдарснаар түүнийг хэн бэ гэдгийг нь мэдэх аргагүй. Учир нь тэдгээр амжилтад хүрсэн хүнд ямар ч “би” гэх юм цаашид огт байхгүй болдог. Тэр өөрийгөө хэн бэ гэдгээ ярихгүй, хэрэв түүнийг ядуу гуйранч гэвэл “тийм” л гэнэ, зарц барлаг гэвэл бас “тийм” л гэнэ.

Яагаад тэр вэ? Учир нь Тэр маргалдах мэтгэлцэх, хэн нэгэнтэй тэмцэлдэх, эсвэл өөрийн дэсийг хэн нэгэнд үзүүлэхийг хүсдэггүй. Түүний хувьд юу ч үнэхээр амин чухал биш, Түүнд юу ч хэрэггүй, ямар ч бишрэл огт хэрэггүй. Түүний хувьд юм бүхэн ижил, ариун цэврийн өрөө цэвэрлэх нь ном тайлахтай адил. Ямар ч ажлыг хамгийн чухал гэж

боддоггүй.

Учир нь Түүний хувьд дэлхий ертөнц угаасаа асуудалгүй болсон бөгөөд юу ч биш юм, хэрэв Тэрээр ном тайлах, эсвэл хамаг төрөлтнийг гэтэлгэхээр явбал энэ нь хамаг төрөлтний хэрэгцээ шаардлагаас болдог. Эс бөгөөс тэдний гэтэлж чадах, чадахгүй нь хамаагүй. Тэр явахыг хүсдэггүй, гэхдээ энэ нь Тэр явахыг хүсдэггүй гэсэн үг биш юм, Тэр хүссэн ажлаа хийж чадна.

Хамгийн дээд билиг ухаан

Өчигдрийн бас нэг асуулт бол: Яагаад бид заавал бясалгах ёстой вэ? "Их билиг барамид" (Maha Prajna Paramita) гэдэг нь ямар утгатай вэ? Яагаад түүнийг олох хэрэгтэй вэ? Багш нь өчигдөр их товчхон хариулсан. Өнөөдөр арай илүү гүнзгий ярих болно.

"Их билиг барамид" гэдэг нь самгарьди хэлнээс орчуулсан үг. Самгарьдиар Maha Prajna Paramita (Маха Пражна Парамита) гэдэг. Maha (Маха) гэдэг нь Их гэсэн утгатай. Энэтхэгийн Гандиг та нар бүгд мэднэ. Түүнийг Mahatma Gandhi (Махатма Ганди) гэдэг, энэ нь агуу их төрөлтөн гэсэн утгатай. Maha болон Atman (Атман) нийлээд Mahatma болжээ. Энэ нь агуу сүнс гэсэн утгатай юм.

Энэтхэгт агуу сүнслэг бясалгал дадуулдаг хүнийг Mahatma гэх бөгөөд энэ нь Maha, Atman-аас үүсжээ. Maha гэдэг нь их гэсэн утгатай, Atman гэдэг нь сүнс, хамаг төрөлтөн гэсэн үг, нийлээд агуу бясалгалтай хүн, их билиг ухаантан болно.

Maha Prajna Paramita-г тусад нь тайлбарлая. Maha бол агуу их, Prajna нь билиг ухаан, Paramita нь төгс төгөлдөр гэсэн үг. Бид хятадаар "Móhē bōrě bōluómì" (Маха Пражна Парамита), эсвэл "Móhē bōrě bōluómìduō" (Маха Пражна Парамита) гэдэг нь Хамгийн дээд билиг ухаан гэсэн утгатай.

Эзэн Бурханы төгс чадвар, бүхнийг чадагч их хүч болох бурхны билиг ухаан бол хамгийн дээд билиг ухаан мөн. Бид яагаад энэ Хамгийн дээд билиг ухааныг олох ёстой вэ гэдгийг та бүхэнд хэлж өгье! Жишээ нь, зарим гоц хүүхдүүд төрсөн цагаасаа суут ухаантнууд байдаг. Тухайлбал, Моцарт дөрвөн настайгаасаа төгөлдөр хуур тоглож чаддаг байсан. Зөвхөн төгөлдөр хуур тоглоод зогсохгүй өөрийнхөө онгодоор орж ирсэн зүйлсийг тэмдэглэж, хөгжим болгон зохиож өгөхийг ааваасаа хүсэж байжээ.

Бетховен ч мөн багаасаа авьяастай байсан. Эртний Хятад оронд ч Ган Лүо гэх зэрэг гоц авьяастай хүүхдүүд байжээ[7]. Миний одоо нэрийг нь хэлж мэдэхгүй байгаа гоц авьяастай өөр олон хүүхэд байгаа нь мэдээж.

Тэд яагаад гоц авьяастай байдаг вэ? Учир нь тэд энэ хүчийг төрөл төрөлдөө хөгжүүлж, тухайн талбарт өөрийн чадвараа тусгайлан ашигласан байдаг. Жишээ нь, нэгэн хүн шүлэг зохиохдоо тун сүрхий, яг л Ли Бай, Су Дунпотой адил яруу сайхан бичдэг. Өмнөх олон төрөлдөө шүлэг зохиох авьяастай байсан нь түүнд нөлөөлжээ.

Яруу найрагч Жан Жи бас гоц сайхан шүлэг бичиж чаддаг:

Саран шингэж, хар хэрээ ганганан, хяруу тэнгэр дүүрнэм,

Салхин жаварт голын хөвөөний агч мод бөхийж, загасчны гал сүүмэлзнэм.

Сэтгэлд гуниг хурж, нойр үл ирэхүй хажуулдан хэвтэхэд,

Сужоугийн гадаах Ханшань сүмийн хонх

Шөнийн хагаст жингэнэн, жуулчны завинд сонсогдном.

---

7 Редакторын тэмдэглэл: Түүхэн номд дурдсанаар Албан ёсны түүхэн бариmтаас үзвэл Ган Лүо арван хоёр настайдаа их сайд Лү Бүвэйгийн өмнөөс Жао улстай хэлэлцээр хийж, дайн хийлгүйгээр таван хотыг эзлэн авсан бөгөөд Цин (Qin) улсын их түшмэлээр өргөмжлөгджээ.

Энэ нь тэрээр олон төрөлдөө бичгийн чадвараа хөгжүүлж дадуулсан учир зохиох бичихэд тун дадамгай болж, ийм сайхан шүлэг зохиожээ. Энэ нь яг нэгэн мужаан шиг. Хэрэв бага наснаасаа нэг ур чадварыг эзэмшсэн бол өсөх тусам түүндээ улам мэргэшин чадварлаг болно. Сийлбэрчин ч ялгаагүй, өдөр бүр сийлээд дадуулаад байвал ур чадвар нь улам сайжирна. Зарим хүн төрөл тутамдаа өөрийгөө тасралтгүй хөгжүүлэн сургасаар байдаг тул ур чадвар нь улам бүр хөгжиж, гайхалтай болдог.

Зарим эмч их алдартай, анагаах ухааны гайхалтай ур чадвартай байдаг. Учир нь тэд урд төрөлдөө эмч байсан бөгөөд энэ төрөлдөө ч дахин ийм ажил үйл хийвэл тэд үүнийгээ мэддэг байх нь гарцаагүй. Тиймээс бид зарим эмчийг хувилгаан эмч гэдэг. Жишээ нь, Хуа Туо, Биан Чүе нар өнөөг хүртэл алдартай хэвээрээ байна. Одоо алдар цуутай эмч олон бий, учир нь тэд өмнөх олон төрөлдөө эмчийн ажил хийж, анагаах ухааны мэдлэг чадвараа үргэлжлүүлэн хөгжүүлжээ, тиймээс тэдний хувьд одоо энэ ажлыг хийхэд хялбар байдаг, тун амархан ч хийнэ, маш сайн ч хийнэ. Дуу хөгжим, дуулах урлаг, уран зохиол, урлагийн салбарт авьяас нь тодорсон хүмүүс бүгд өмнөх төрлүүддээ хэдийн дадуулан хөгжүүлсэн байдаг.

Аль ч талын авьяас чадвараа хөгжүүлсэн ч энэ нь зөвхөн нэг тал л байх юм. Гэтэл хэрвээ бид “Их билиг барамид”-ыг олбол бүхнийг мэднэ, мэс засал хийнэ, дуу хөгжим зохионо, зураг зурна, өвчин эмнэнэ. Энэ үнэхээр хачин хэрэг шүү! Тиймээс Шагжамуни Будда: “Бид эхлээд нэгэн бурхан болох хэрэгтэй, дараа нь бүх зүйлтэй болно.” гэж онцолсон байдаг. Тэрээр: “Бурхны билиг ухаан бол хамгийн төгс төгөлдөр нь бөгөөд бид энэ төгс төгөлдөр билиг ухааныг олж авах ёстой.” гэж хэлсэн.

Есүс Христ ч мөн адил зүйлийг хэлсэн: “Seek you first the Kingdom of God, and all the things shall be added onto

you", (Эхлээд дотоодын Эзэн Бурханы хаант улсыг эрж ол, тэгвэл дараа нь бүхий л авьяас чадвар болон танд хэрэгтэй бүх зүйл даган ирнэ.), өөрөөр хэлбэл, та жамаараа л олж хүртэнэ, утга нь бол Эзэн Бурхан танд өгөх болно гэсэн үг.

Шагжамуни Буддагийн шавь Молом тойн (Модгальяна) агуу их шидийн хүчтэй байсан бөгөөд тэрээр диваажинд ч хүрнэ, тамд ч очно, маш олон зүйлийг өөрчилж чадна. Гэсэн хэдий ч эцэстээ бусдад хорлогдсон. Тэрсүүдийн талын хүмүүс түүнд атаархдаг байсан тул илүү их хүчтэй шидээр түүнийг хорложээ. Шагжамуни Будда амьд сэрүүн байхдаа түүнд шид хэрэглэж болохгүй, шид хэрэглэх нь ямар ч хэрэггүй гэж байнга сануулж байсан ч тэр гадны хүмүүстэй шидийн хүч чадлаа харьцуулан өрсөлддөг байсан байна. Хэрвээ хэн нэгэн хүн "надад ийм шид бий" гэвэл тэр, "Надад ч бас байгаа" гэнэ, хэрвээ хэн нэгэн хүн би ийм тийм зүйлийг өөрчилж чадна гэвэл тэр "Би ч бас тэр зүйлийг өөрчилж чадна." гэнэ. Өдөржингөө тэрсүүд нартай шидээр өрсөлдөх нь мэдээж тэднийг залхааж уурлуулсан тул дараа нь тэд түүнийг хорлох нэгэн боломжийг олсон нь харамсалтай.

Молом тойн бусдад шидийн хүчээр зодуулаад үхэх гэж байхад нь Шагжамуни Будда түүнийг авчруулахаар шавь нараа явуулсан байна. Тэр үед түүнийг бараг үхэх гэж байхад бусад хүн түүнээс: "Таны ид шидийн хүч чадал тийм агуу байтал яагаад хэрэглэж болсонгүй вэ?" гэж асуухад тэрээр: "Үйл түйтгэр ирэхийн цагт бүх шид мартагддаг." гэж хариулсан байдаг. (*Бүгд алга ташив.)* Тиймээс хамгийн чухал нь өөрийн Бурхан чанарыг олж, нэгэн бурхан болохын тулд бясалгах явдал юм. Бусад зүйлийн хувьд тэд жамаараа болж бүтнэ, эс бөгөөс бид зөвхөн нэг л чадвараа хөгжүүлэх бөгөөд бүрэн төгс билиг ухааныг олж хүртэхгүй. Тиймээс Бурханы шашны судар номд "Их билиг барамид"-ыг, Хамгийн дээд билиг ухааныг онцолсон байдаг. Бурхны

шашинтнууд өглөөний залбиралдаа “Их билиг барамид”-ыг уншдаг.

Библи сударт мөн “Эхлээд дотоодод буй Диваажингаа олох ёстой, тэгвэл бусад зүйл аажмаар тан руу ирэх бөгөөд танд хэрэгтэй бүх зүйл байх болно.” гэж онцолсон байдаг. Үүнийг би өөрийн биеэр мэдэрсэн тул үнэхээр ийм байдгийг гэрчилж чадна. Эхлээд Хамгийн дээд билиг ухааныг олбол бүх зүйл ирнэ.

Тиймээс та нар Багшийнхаа хувилгаан бие авшигтанд мэс засал хийсэн тухай сонсоод ихэвчлэн гайхдаг. Багш нь энэ дэлхий дээр хэзээ ч мэс засал хийхийг сураагүй. Би эмч биш, гэхдээ миний аав, миний хуучин нөхөр, хүргэн ах, нагац ах, авга ах бүгд л эмч хүн байсан. Энэ дэлхийн тухайд өмнө нь би хэзээ ч анагаахын шинжлэх ухаанд суралцаагүй. Гэвч Хамгийн дээд билиг ухааныг олсноор бид дотоодод маань байгаа бүх зүйлийг мэдэх болно. Гэхдээ үүнийг гадна талд хэн ч мэдэхгүй, энэ бол дотоодын асуудал. Тиймээс та бүхэн Багшаасаа шидийн хүчээ үзүүлэхийг гуйх хэрэггүй. Хэрвээ та нар жамаараа харж байгаа бол сайн хэрэг, эс бөгөөс харах гэж залбирах шаардлагагүй. Би та нарт үзүүлэх гэж зориудаар ямар ч хүч гаргахгүй, учир нь бурхан, бодьсадва ингэдэггүй. Хэрвээ Багш нь зориудаар шидийн хүч үзүүлбэл энэ нь ертөнцийн хуулийг зөрчинө. Улс орон өөрийн хуультай байдаг, бясалгал дадал ч гэсэн өөрийн хуультай бөгөөд орчлон ертөнцөд ч өөрийн хууль бий. Та нар дурааараа юу ч хийж чадахгүй. Нэгэнт хууль зөрчвөл асуудалд орно. Жишээ нь, Багш нь Англи улсын иргэн, гэхдээ би Формосад ирэх үедээ танай ёс заншлыг дагаж, хуулийг хүндэтгэх ёстой. Би хууль зөрчиж болохгүй, би бол Англи хүн, Формосагийн иргэн биш учраас юу дуртайгаа хийж болно гэж хэлж болохгүй.

Үүнтэй адил, хэдийгээр бурхан, бодьсадва асар их хүч чадалтай ч энэ хүч чадлаа зөвхөн дотооддоо шавь

нартаа зориулан ашиглаж чадна, гадны хэнд ч мэдрэгдэхгүй. Хэрвээ тэд мэдвэл энэ нь ая зөнгөөрөө л болсон хэрэг, бусдад мэдүүлэхийн тулд Тэд үүнийгээ зориуд ашигладаггүй. Та нар Багшид итгэх шаардлагагүй, миний шавь болох, эсвэл манай бүлэгт элсэх ч шаардлагагүй. Бидэнд ямар ч бүлэг, эсвэл байгууллага байхгүй. Миний шавь нарын дунд католик шашинтан, бурхны шашинтан, мусульман, игуандаогийн шүтлэгтэн ч бий.

Багш нь шашны хооронд ямар ч ялгаа гаргадаггүй. Тэднийг угийн шашин шүтлэгээ өөрчлөхийг шаардахгүй. Миний хувьд, сайн хүн байж, энэрэн нигүүлсэх сэтгэлтэй, гэгээрэх хүсэл эрмэлзэлтэй байвал сайн католик шашинтан, сайн бурхны шашинтан, сайн игуандао шүтлэгтэн мөн.

Би тэднээс итгэл үнэмшлээ өөрчлөхийг шаардахгүй. Хамгийн чухал нь өөрийн дотоодын хүчээ л олох явдал юм. Энэ дотоодын хүч биднийг ямар ч үед аварч, хамгаална. Бид үргэлж Их Багш, бурхан, бодьсадва эсвэл Эзэн Бурханыг бидэнд тусална гэж найдан өөрөө бясалгахгүй сууж байхын оронд дотоодын хүчтэйгээ холбогдох ёстой. Эзэн Бурхан бидний дотоодод байдаг, Есүс Христ: “Диваажин бидний дотоодод бий.” гэсэн бол Шагжамуни Будда: “Бурхан бидний сэтгэлд буй.” гэжээ.

Та бүхэн үргэлжлүүлэн сайн католик шашинтан, сайн игуандао шүтлэгтэн, сайн бумбын шашинтан, күнзийн сайн шашинтан байж болно. Та ямар төрлийн итгэгч байх нь хамаагүй, би зөвхөн хүссэн хамгийн дээд зорилгоо олоход тань туслахыг л хүсэж байна. Жишээ нь, бид өөрсдийгөө бурхны шашинтан гэж боддог бол “Бурхан бидний сэтгэлд буй.” гэдгийг мэдэх хэрэгтэй, дотоодод буй бурхнаа хайж олох хэрэгтэй. Хэрэв та өөрийн өвчнийг эмчилж чадах хүнийг оллоо ч гэсэн энэ нь хэсэг хугацаанд л үргэлжилнэ, ийм хүмүүс Формосад олон байдаг.

Өвчин эдгээх чадвар бидний дотоодод байдаг, хэдийгээр бид хүнээр өвчнөө эмчлүүлж болох ч өөрийн дотоод анагаан эдгээх чадварыг нээж олох хэрэгтэй, энэ нь үүрдийнх байх болно. Өвчин тусвал хүнээр эмчлүүлэх нь ердийн явдал, гэхдээ бид өвчнөөс аврах өөрийн мөнхийн чадварыг олох ёстой. Учир нь бидний дотоодод юм бүхэн байдаг, хэрэв түүнийгээ ашиглахгүй бол үнэхээр харамсалтай, гарзтай явдал болно.

Дотоод ахуй ойлголт зайлшгүй шаардлагатай

"Бурхны гэрэл мөнхөд гийгүүлнэ" гэж ярихыг бурхны шашинтнууд сонссон байх ёстой. "Мөнхөд гийгүүлнэ" гэдэг нь ямар утгатай вэ? Газар бүр гэрэлтэй, хором бүхэн гэрэлтэй байдаг учраас "Бурхны гэрэл мөнхөд гийгүүлнэ." гэж хэлдэг. Ариун орны шүтээн Авид бурхан бол хэмжээлшгүй их гэрэл мөн. Хэрвээ бид Авид бурхны Ариун оронд очихыг хүсвэл энэ "мөнхөд гийгүүлэх бурхны гэрэл"-ийг хаанаас хайхаа мэдэх хэрэгтэй. Хэрвээ "Бурхны гэрэл мөнхөд гийгүүлдэг" юм бол энэ нь цаглашгүй гэрэл байж таарна. Тэгэхээр тэр гэрэл газар бүхэнд байх ёстой, гэтэл бид яагаад харахгүй байна вэ?

Тиймээс энэ "Цаглашгүй гэрэл"-ийг хайж олоход Багш нь та нарт тусална. Учир нь тэр нь "Цаглашгүй гэрэл" бөгөөд "мөнхөд гийгүүлэх" тул та нар гарцаагүй харж чадна. Багш нь та нарт үүнийг олоход тусална гэж амласан бөгөөд та нар үүнийг даруй олж чадна. Дараа нь гэрэл улам бүр "тогтмол гийгүүлж", улмаар "Цаглашгүй гэрэл" болно, бид өөрсдөө Авид бурхан болж, "Цаглашгүй гэрэл" болон хувирна.

Зөвхөн ийм байдлаар л сая жинхэнэ ариун оронтон, жинхэнэ бурхны шашинтан болно. Ойлгов уу? (*Бүгд алга ташив.)*

Авид бурхан бол хэмжээлшгүй их гэрэл болохыг та нар мэдэх үү? Тэр бол мөнхийн гэрэл. Формосад олон хүн Авид бурхныг шүтдэг. Гэвч тэд Авид бурхныг харж чадаагүй байдаг. Бурхны шашинтнууд алгаа хавсран цаг үргэлж "Цаглашгүй гэрэл"-ийг дурсан уншдаг. Авид бурхан гэдэг нь "Цаглашгүй гэрэл" гэсэн утгатай ч "Цаглашгүй гэрэл"-ийг олж харж чадахгүй, зөвхөн амаараа аялгуулан уншиж байдаг.

Багш нь "Цаглашгүй гэрэл"-ийг олоход тань тусалж чадна. Та нар тэр даруйдаа шууд л олж харна, учир нь тэр гэрэл хаа сайгүй оршдог. Авид бурхныг дурсан уншаад гэрэл хараагүй бол мухар сохроор уншсан хэрэг болно.

Хэрвээ та католик шашинтан бол, Есүс Христийн: "I am the lignt of the world, whoever follows me will walk in the light, and never walk in darkness" гэж хэлснийг ойлгох ёстой. Та нар ойлгосон уу? Багшийнхаа орчуулгыг ойлгов уу? Есүс Христ: "Би бол газар дэлхий дээрх гэрэл, намайг дагасан хүн гэрэл дундуур явна, харанхуйгаар явахгүй." гэж айлджээ. Өөрөөр хэлбэл, хэзээ ч харанхуй газрыг харахгүй гэсэн үг.

Католик шашинтнууд бүгд энэ өгүүлбэрийг ойлгож, өдөр бүр гэрэлд алхах ёстой. Гэвч католик шашинтан та бүхэн өдөр бүр гэрэлд алхаж байсан уу? Гэрэл харсан уу? Та нарын дунд католик шашинтан байхгүй юм шиг байна? Байх ёстой. Гэвч хэрэв та нар өдөр бүр гэрэл харж чадахгүй, түнэр харанхуйн дунд өнгөрөөж байгаа бол энэ нь та жинхэнэ католик шашинтан биш бөгөөд Есүс Христийг жинхэнэ ёсоор дагадаггүй гэсэн үг.

Бурхны шашинтны хувьд ч мөн адил. Хэрэв та "Бурхны гэрэл мөнхөд гийгүүлэх"-ийг, эсвэл "Цаглашгүй гэрэл"-ийг хараагүй бол энэ нь та хараахан жинхэнэ бурхны шашинтан биш гэсэн үг. Тиймээс Багш нь та бүхнийг

жинхэнэ бурхны шашинтан, жинхэнэ ариун орны шүтлэгтэн, жинхэнэ католик шашинтан, жинхэнэ христийн шашинтан болоход тань туслахыг хүсэж байна. Та нарыг Есүс Христтэй адил бодолтой байж, Түүний сургаалыг мэдэрч, Шагжамуни Буддагийн ярьсан Үнэн ёсыг ойлгож мэдэрдэг болгоно.

Хэрвээ мусульман шашинтан бол Зөнч Мухаммед сүнслэг бясалгалдаа уянгалаг Гэрэл, хөгжимтэй Гэрэлт мэдэрснийг мэдэж байх ёстой. Тэр бол нэг зүйлийн дотоодын Аялгуу бөгөөд Тэрээр судартаа энэ тухай маш тодорхой өгүүлсэн. Хэрвээ бид өөрсдийгөө мусульман хүн гэж үздэг, Зөнч Мухаммедийг дагаж, Түүний сургаал номлолоос суралцахыг хүсдэг боловч Түүний дотоод ахуй ойлголтыг мэдэрч чадахгүй бол хэзээ ч Түүн шиг болохгүй, жинхэнэ мусульман болж чадахгүй.

Аллах Бурханд мөргөж буй мусульман хүнийг харахад байрлал нь Арьяабалын бясалгалын аргынхтай үнэхээр төстэй, бага зэрэг л ялгаа бий. Энэ бол урьд нь жинхэнэ мусульман хүмүүс Арьяабалын бясалгалын аргыг дадуулдаг байсан гэсэн үг юм. Күнзийн сурталтнуудын тухайд гэвэл, Күнз нэгэн дотоодын Аялгууг сонсоод түүндээ гурван сарын турш автан согтууран сууж байсан гэдгийг та нар мэдэх ёстой. Хэрвээ танд ийм ахуй ойлголт байхгүй бол жинхэнэ Күнзийн шашинтан биш гэсэн үг.

Тиймээс бид ямар ч шашинд итгэдэг, ямар ч ёс журамд суралцсан бай дотоод ахуй ойлголт зайлшгүй шаардлагатай гэдгийг ойлгох ёстой. Хэрвээ ёс суртахуунд сайтар суралцсан, сургаал номыг сайн судалсан бөгөөд дээрээс нь дотоод ахуй ойлголтоо нэмж чадвал төгс болно. Тиймээс Багш нь та бүхнийг шашин шүтлэгээ өөрчлөхийг хүсэхгүй байдгийн учир энэ юм. Учир нь сургаал номлол нь бүгд адилхан, тэдэнд зөвхөн дотоодын ахуй ойлголт л дутмаг байдаг. Бүхий л шашны сургаалын эздийн ярьсан дотоодын ахуй ойлголтууд нь ижилхэн. Багш нь зөвхөн энэ дотоодын

ахуй ойлголтыг олж хүртэхэд тань та нарт тусална. Та бүхэн надад ямар ч өргүй, бас миний өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээх шаардлагагүй. Учир нь энэ зүйл өөрт тань угаасаа байгаа, би зөвхөн хаана байдгийг нь хэлж өгч, түүнийгээ гаргаж ашиглахад тань тусалсан төдий. Багш нь: "Би та нарт ямар нэг зүйл өгнө." гэж хэлж чадахгүй. Жишээ нь, эцэг, эх тань танд их эд хөрөнгө өвлүүлжээ. Гэвч та түлхүүрийг нь гээсэн, эсвэл эцэг, эх тань таныг том болохоор нээж өгөөрэй гээд түлхүүрийг надад үлдээсэн бол миний үүрэг бол та нарт өмч хөрөнгөө хаанаас олж авахыг хэлж, түлхүүрийг нь өгөх явдал юм. Үүнд миний ач ивээл гэхээр ямар ч юм байхгүй, ойлгож байна уу? Би та нарт эд хөрөнгө өгөөгүй. Эдгээр нь миний эд хөрөнгө биш, та нарынх, би өнөөг хүртэл та нарын өмнөөс харж хамгаалж байсан, цаг нь болохоор буцааж өгнө. *(Бүгд алга ташив.)* Тиймээс би та нарыг надад ямар нэг өртэй гэж хэлж чадахгүй, бас бардамнаж ч чадахгүй.

Хэрвээ та бүхэн ирж, Багшаасаа суралцаад аль нэг түвшнийг олбол энэ нь та нарын өөрсдийнх байна, буян хишиг тань боловсорч гүйцээд цаг нь болсон учраас Багш нь та нарт туслах болно. Багшийнхаа хүч чадлын ачаар та бүхэн нэгэн агшинд энэ дэлхийг огоорч, анхаарал сарниулах аливаа бодлоо орхиж, ийм ахуй ойлголтыг тэр дор нь олж авах боломжтой, ийм л юм. *(Бүгд алга ташив.)*

Иймд Багш нь та нарт өдөр, шөнөгүй сануулж, өөрөө бие даан бясалгал дадуулахыг заадаг. Авшиг хүртсэнийхээ дараа Багшид биш, өөртөө найдах хэрэгтэй. Багш нь зөвхөн зааж чиглүүлж, тусалж дэмжиж, урам зориг өгөн урамшуулж, асуултад тань хариулж чадна. Гэсэн хэдий ч ямарваа өмч хөрөнгө, ямар ч авьяас чадвар, бүхий л гэгээрэл, аливаа билиг ухаан бүгд та нарынх. Тийм ээ, та нар энэ бүхнээ гарган авч, ашиглах хэрэгтэй. Тиймээс өөр хэнд ч найдах хэрэггүй, зөвхөн өөртөө л найд. Гэхдээ та нар

хаана найдахаа мэддэг байх ёстой, өөрийн чадварыг хаана байдгийг, аль багш нь бидэнд тусалж, үүнийг хаанаас авахыг зааж чадахыг мэддэг байх ёстой. Авшиг нь ийм юм. Багш нь та нарт эд хөрөнгөө хаанаас авахыг, түүнийгээ хэрхэн өдөр бүр ашиглахыг зааж өгдөг.

Яг л би нэг хүнийг дагуулаад банканд очоод маягт бөглөхийг зааж өгдөг шиг юм, ингэвэл тэр хүн эцэг, эхийнхээ үлдээсэн өв хөрөнгийг банкнаас авч чадна. Би зөвхөн та нарт тусалдаг төдий, эд хөрөнгөтэй тань өчүүхэн ч хамааралгүй. Тиймээс хэрэв хэн нэгэн хүн үүнээс өөр зүйлийг сургаж байвал тэр хүн бусдыг хуурч байна гэж би бодож байна. Хүмүүст сургахдаа илэн далангүй байж, танд маш их эд хөрөнгө бий, танд юм бүхэн байна, та үүнийгээ хэрхэн ашиглахаа мэддэг байх ёстой гэж тэдэнд тодорхой сайн хэлж өгөх хэрэгтэй. Ингэж зааж сургах нь хамгийн зөв арга юм. “Би танд ид шидийн хүч өгнө.”, “Би танд ид шид заана.” гэх зэргээр ярьж, бусдыг хуурч мэхлэх ёсгүй.

Хэн ч өөр хүнд юу ч өгч чадахгүй, эсвэл юу ч зааж чадахгүй. Бид бүгдээрээ бурхан, бид зүгээр л бурхан хаана байдгийг мэддэггүй. Хэрвээ та бүхэн бурхан хаана байдгийг мэдэхийг хүсвэл Багш нь дуртайяа хэлж өгнө. *(Бүгд алга ташив.)*

Долоодугаар бүлэг

ЦАГ ХУГАЦАА, ОРОН ЗАЙНААС ХЭТИЙДСЭН ИХ САЙД

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайчун хот.
1988 оны 6 дугаар сарын 8
(Эх нь хятад хэлээр)

Зам мөрийг үгээр илэрхийлж чадахгүй

Намайг “Хималайн Их Багш” гэж танилцуулахыг сонсоод би айдаг, учир нь та нар харж байгаа, Багш нь ийм жижигхэн! Бид өндөр, том биетэй, мах мариатай, сүр жавхлантай Их Багшийг харах дуртай ч эцэст нь ийм туранхай, жижигхэн биетэй, тийм ч агуу, сүрлэг биш Их Багшийг олж харлаа. (*Их Багш болон бүгд инээв.)* Тиймээс та бүхний санаснаас гадуур болж, урмыг тань хугалсанд уучлаарай, энэ нь “Зам мөрийг үгээр илэрхийлж чадахгүй.” гэдэг нь болсон юм биш үү дээ.

Бидний бодлоор бол Зам мөрийг уламжилж чадах хүн, эсвэл Их Багш гэгдэгч нь өндөр, сүрлэг биетэй, зүс

царай сайтай, өтгөн хөмсөг, том нүдтэй байх ёстой. Гэтэл заримдаа энэ "Зам мөр" нь нэлээд дэггүй, тэр сонгох хүнээ л сонгоно, тэр хүний царай зүс нь гоё сайхан, гоо үзэсгэлэнтэй байх эсэх нь ер хамаагүй. Тиймээс зарим үед бид хүний зөвхөн гадна дүр төрхийг нь харснаар л дотоодыг нь шүүн дүгнэчхэж чадахгүй.

Найман Аршийн нэг болох Ли Тегуай гуай тун царай муутай. Арван найман архад бол Шагжамуни Бурханы хамгийн гарамгай шавь нар. Тэд ч бас тийм царайлаг биш байжээ. Бас та нар Гуан Чин өвгөн хуврагийг мэдэх үү? Тэр бараг л Багш шиг нь намхан, туранхай байсан, гэхдээ тэр нисэж байгаа мэт хурдан алхдаг болохоор бид түүнийг гүйцэхгүй.

Та нар бүгд: "Их Багш аа! Танд ид шидийн хүч бий юу?", "Та нисэж чадах уу?" гэж асуудаг. Надад шидийн хүч байхгүй гэхэд хэн ч итгээгүй, тиймээс өнөөдөр би машинаар ирсэн, Баруун зүгийн Төгс баясгалант орноос нисээд ирээгүй *(Их Багш болон бүгд инээв.)* гэдгээ дахин онцлон хэлье. Бас уулын замаар машинтай явахад миний толгой эргэж, дотор муухайрдаг, та нарт надад шидийн хүч байгаа гэсэн найдлага төрүүлэхгүйн тулд би энэ бүхнээ тодорхой ярьж байна. Та нар хэрвээ шид сурах хүсэлтэй бол Багшаасаа суралцах шаардлагагүй. Үүнийг би тодорхой хэлнэ, бусдыг мэхлэхгүй. Би өдөр бүр хооллох ёстой, өлсөхгүй байсан ч идэх хэрэгтэй хэвээрээ, эс бөгөөс энэ бие махбод хэмээх машин эвдэрнэ. Яг л бид машиндаа түлш хийдэгтэй адил. Жолооч хэчнээн чадварлаг байсан ч машиндаа түлш хийх шаардлагатай хэвээр байдаг, учир нь машинд түлш хэрэгтэй бөгөөд энэ нь жолоочтой ямар ч хамаагүй. Тиймээс Багш нь ном тайлахаар явахдаа нисээд хүрэхийн оронд заавал машинаар явах хэрэгтэй болдог. Бас энэ бие тийм ч сайхан царайлаг, өндөр, том, махлаг тарган, адислал дүүрэн харагддаг биш.

Өнөөдөр би энэ талаар нэлээд бодлоо, би ер нь энэ ажилд тохирохгүй юм шиг байна, энэ “бизнес” миний мэргэжил биш бололтой, ер нь би тааруухан хийгээд байгаа ч юм шиг санагдав. Гэсэн ч шавь нар маань намайг үргэлж тайз руу түлхэн гаргадаг, би одоо ч ном тайлах ёстой хэвээрээ бөгөөд тэтгэвэрт гарах арга алга, гаръя гэсэн ч яаж гарахаа мэдэхгүй байна. Яг л та нар шиг, заримдаа та нар гэрлэхийг хүсдэггүй, гэрлэсний дараа хүүхэдтэй болно, хүүхэд өсгөж хүмүүжүүлэх нь тун амаргүй ажил. Хүүхдээ өсгөхгүй байж болохгүй, заавал үргэлжлүүлэн өсгөх хэрэгтэй. Тэр үед дэндүү оройтсон байх тул нөхцөл байдлыг өөрчлөх ямар ч аргагүй болдог.

Багшийнх нь хувьд одоо бас ижилхэн байна. Аль хэдийнээ шавь нартай болсон учраас тэднийгээ цаашид сургах хэрэгтэй. Тэднийг сургах явцад шинэ хүмүүс нэмж ирэхэд нь дахин эхнээс нь сургана. Жаахан юм сургаж байтал дахиад шинэ хүн ирнэ, улам олон хүн ирж, энэ нь зогсолтгүй үргэлжилдэг. Энэ “бизнес”-ийг зогсооход тийм ч хялбар биш, алдагдалтай эсэхээс үл хамааран заавал үргэлжлүүлэх ёстой, яг та нарын арилжаа наймаа хийдэгтэй л ижилхэн.

Шагжамуни Бурхан гучин хоёр найраг төгс лагшинтай гэж сонссон, харин Багшид нь ганц ч найраг төгс лагшин алга. Сонсоход Шагжамуни Бурханы тэргүүн дээр нэгэн үснир товойж гарсан гэдэг, гэтэл Багшид нь байна уу, хар даа? Байхгүй юм шиг байна! Түүний магнайн голд гуравдагч мэлмий байдаг гэж сонссон, Багшид нь байна уу, үгүй юу, Та нар сайн хараарай. Бас л байхгүй юм шиг байна! Ийм байхад зарим хүн мөн л Багшийгаа Бурхан гэж дууддаг. Шагжамуни Бурханы найраг төгс лагшин гэж юуг хэлдэг вэ? Үүнийг бидний эгэл хүний нүдээр харах боломжгүй. Багшид нь шидийн хүч байхгүй гэдгийг та бүхэн харж байна, гэхдээ ид шид бол мөн л Гурван ертөнцийн доторх

зүйл. Ид шидгүй байх нь л сая сайн.

Лаоз: “Их билгүүн хүн тэнэгдүү харагддаг.” гэжээ. Магадгүй Багш нь бас их билгүүн хүн байх, учир нь юу ч мэддэггүй болохоор их билгүүн гэж хэлдэг.

Нэгэн хүн хоёр ертөнцөд байхуй

Бид уг нь нэг л хүн байсан, гэвч уураг тархиа жинхэнэ биеэ хэмээн буруугаар ойлгодог болохоор хоёр хүн болчхоод байна. Нэг нь энэ дэлхийд байж хооллоно, ажиллана, машин жолоодно, гэрлэнэ, хүүхэд төрүүлнэ, эх орноо хамгаална, гэрээ засна, төрөө төвхнүүлнэ, хорвоо дэлхийг төвшитгөнө гэх зэргээр үйлдэж байдаг. Өөр нэг хүн нь өөр нэгэн түвшинд байж, маш их зүйлийг хийдэг, гэхдээ түүнийг хийдэг гэдгийг нь хэн ч мэдэхгүй, бид өөрсдөө ч мэдэхгүй. Тэр хүн бол бидний жинхэнэ эзэн юм. Жишээ нь, зарим хүн энэ дэлхийд дээд албан тушаал хашиж, эсвэл өөр олон ажил хийдэг, гэтэл тэдний нөгөө бие нь өөр түвшинд өөр төрлийн ажил хийж байдаг.

Сонсоход Шагжамуни Бурхан амьд сэрүүн байхдаа бодь модны дор, эсвэл ямар нэгэн газарт ном айлдаж байх тэр үедээ Тушита тэнгэрийн оронд дээд дэсийн төрөлтнүүдийг ч сургаж байсан гэдэг. Түүнээс гадна, зарим хүн энэ дэлхийд цагдаа, эсвэл энгийн хүн байхын зэрэгцээ тамын оронд шүүгч, эсвэл өөр нэгэн ертөнцөд богд гэгээнтэн, эсвэл арш байдаг гэж бид бас сонссон.

Вэй Жэн Лусын хааны толгойг цавчсан нь

Миний уншсан нэгэн номд нэг луу хүний ертөнцийг түйвээж, олон хүнд маш их төвөг удсан тухай өгүүлсэн байсан. Домогт өгүүлснээр, Тан улсын Тайзун хааны засаглалын үед бороо усыг хариуцсан Фэнхэ мөрний Лусын эзэн Хурмастын хааны зарлигийг дагалгүй, энэ дэлхийд асар их бороо оруулж, олон ардыг хохироожээ. Тиймээс

Хурмастын хаан, тэргүүн сайд Вэй Жэнг илгээж, лусын хааны толгойг авч ирэхийг даалгав. Лусын хааны толгойг авах хүн заавал лусын эзнээс илүү дээд заяатай, илүү хүч чадалтай онцгой нэгэн байх ёстой. Зөвхөн тийм байж л сая Лусын хааны толгойг цавчиж чадна, учир нь луу бол нэгэн төрлийн сүнслэг амьтан болохоос энгийн нэгэн амьтан биш, маш их сүнслэг төрөлтөн учраас жирийн хүн түүнийг хороож чадахгүй.

Лусын хаан үүнийг мэдээд Тан улсын Тайзун хаанд очиж, аврал гуйн мөргөжээ. Тэрээр: “Маргааш үд өнгөрвөл Вэй Жэн ирж, миний толгойг цавчина. Би одоо үхмээргүй байна. Та надад тусалж, маргааш Вэй Жэнг ирүүлэхгүй байхыг танд найдъя.” гэж гуйв. Тэрээр зүүдэндээ Тайзун хаанд ийнхүү хэлжээ.

Тайзун хаан лусын эзэнд туслах арга сүвэгчлэв. Маргааш нь үдийн хоолны дараа Тайзун хаан Вэй Жэнг урьж, шатар тоглоё гэжээ. Үүний зорилго нь шатар тоглоод үд өнгөрвөл Вэй Жэн лусын эзний толгойг авахаар явж чадахгүй болох юм. Тэгэхээр лусын эзэн аюулгүй болно гэж боджээ. Гэтэл яг тэр үед Вэй Жэн нам унтчихжээ. Тайзун хаан түүний унтсаныг хараад ямар ч асуудал гарахгүй нь гэж санаж аюулгүй болчихлоо, тэр унтаад эндээс гарч явахгүй л бол юу ч болохгүй гэж боджээ.

Вэй Жэн унтаж байх үед түүний жинхэнэ эзэн нь өөрөөр хэлбэл сүнсэн бие нь гарч яваад лусын эзнийг хороосон байна, түүнийг буцаж ирэх үед гарт нь бага зэрэг цус үлдсэн байжээ. Хэдийгээр Тан улсын Тайзун хаан үүнийг хараад жаахан эргэлзсэн ч тэрээр сүнслэг бясалгал дадуулдаггүй, тийм ч ихийг мэддэггүй байсан учир итгэж чадахгүй байжээ. Тэр шөнө лусын эзэн дахин зүүдэнд нь ирж ярив гэнэ, тэрээр: “Би танаас туслахыг гуйсан, гэвч та тусалсангүй, би алагдав.” гэжээ. Тайзун хаан: “Хэзээ тэр вэ” гэж асуухад лусын эзэн: “Вэй Жэн унтаж байхдаа ирж

намайг алсан.” гэж хариулжээ.

Тиймээс бидний алхах, зогсох, суух, хэвтэх бүгд бясалгал мөн. Зарим хүн бас унтаж байхдаа маш их зүйлийг хийдэг. Чин гүрний үеийн Юйлан Их Багш зүгээр л унтах ажилтай байжээ, гэвч тэр бүгдийг мэддэг, бүгдийг ойлгодог байсан гэж бид сонссон. Тиймээс бид яг хоёр хүн шиг байдаг: Нэг нь бол бидний эгэл жирийн хүн. Нөгөө нэг нь бидний уураг тархитай ямар ч холбоогүй, бид түүнийг захирч, эсвэл түүнд юу хийхийг нь зааж чадахгүй, тэр бол бидний жинхэнэ эзэн юм.

Төгс Гэгээрсэн Их Багш бол амин холбоог тусгайлан сэргээн засагч

Бидний эзэн угаасаа маш эрхэм дээд. Тэр сахиусан тэнгэр, бодьсадва, арш байж болно, зарим нь газрын арш, зарим нь тэнгэрийн арш, зарим нь бодьсадва, зарим нь гэгээнтэн, зарим нь архад, зарим нь бурхан байдаг. Тэр ийм нэг эгэл хүн бол биш.

Энэ эгэл хүн өөр нэгэн хүнтэйгээ холбоотой байдаг, гэхдээ заримдаа энэ холбоос нь яг л цахилгааны утас шиг тасардаг. Цахилгааны утас тасарвал микрофон дуугарахгүй, гэрэл асахгүй болно, хэрэв хэн нэг хүн утас тасарсан тэр газрыг олж мэдээд бидэнд туслан залгаж өгвөл бид дахин ашиглаж чадна. Бид өөрийн жинхэнэ эзэнтэй угаасаа холбоотой байдаг. Гэвч заримдаа бид дэндүү бүдүүлэг байж, элдэв муу үйл үйлдээд уг амин холбоогоо өөрсдөө тасалдаг, ингэснээр дараа нь их хүч үгүй болж, ихэд ганцаардан сул дорой болно.

Төгс Гэгээрсэн Их Багш энэ амин холбоог сэргээн засаж, жинхэнэ эзэнтэйгээ дахин холбогдоход бидэнд тусалдаг. Тэрхүү хоёр дахь хүнтэйгээ холбогдсоноор бид эгэл жирийн хүний байр сууринаас орчлон ертөнц дэх

өөрийн байр сууриндаа буцна. Хэрвээ бидний эзэн угаас арш байсан бол бид холбогдох үедээ бидэнд аршийн байр суурь байгааг мэдэх болно. Хялбархан зүйрлэлээр тайлбарлавал Төгс Гэгээрсэн Их Багш бол тусгайлан хүмүүсийн амин холбоог сэргээн засагч юм. Жишээ нь, бид өмнөх төрөлдөө бясалгаад газрын сахиусын түвшинд хүрсэн, эсвэл одоо газрын сахиусан хутагтын сууринд хүрсэн байгаа бол холбогдох үедээ өөрөөр хэлбэл бидний амин холбоо сэргэх үед газрын сахиус болохоо гэнэт сэрж ухаарах болно. Хэрвээ бид угаасаа архад байсан бол холбогдсоныхоо дараа буюу амин холбоогоо сэргээснийхээ дараа өөрсдийгөө архад болохыг гэнэт сэхээрнэ.

Мэдэх боловч энэ нь энгийн, эгэл жирийн ухаалаг мэдлэгээр мэдэхтэй адилгүй. Мэдэх нь өөр төрлийн мэдлэг, өөр төрлийн билиг ухаан. Үүнийг оюун ухаанаар ойлгож чадахгүй, уураг тархиар илэрхийлж чадахгүй, үг хэлээр тодорхой тайлбарлаж чадахгүй, зөвхөн гэгээрэх үедээ л сая мэдэрч, ойлгож чадах бөгөөд Зам мөрийг ухаарна.

Тиймээс “Даяанд үг хэл хэрэггүй.”, “Зам мөрийг үг хэлээр илэрхийлж чадахгүй.” гэж ярьдаг. Жишээ нь, бидний эзэн угаасаа Бурхан байж болно, яагаад болохгүй гэж? Шагжамуни Будда төрөлтөн бүхэн Бурхан чанартай гэж айлдсан. Магадгүй бид угаасаа бурхан, гэхдээ бид хараахан мэдэхгүй байгаа. Хэрвээ бид угаас бурхан юм бол сэргээн засах, эсвэл холбогдох үедээ бурхан гэдгээ сэхээрч ухаарах болно. Энэ их амархан, тиймээс л даяанч нар “Шуурхай ухаарал” хэмээх нэгэн зүйл номын ёсны тухай ярьж, Бурхан чанараа харж, агшин зуурт нэгэн Бурхан болж чадна гэж ярьсан байдаг. Энэ бол тэд тоглоом наадам хийсэн явдал ч биш, бас биднийг мэхэлж, худал ярьсан ч хэрэг биш юм. Үүнийг бид өнөөдөр бас биеэрээ туулж мэдэрч чадна. Эртний хүмүүсийн биеэрээ туулж мэдэрч байсныг орчин үеийн хүмүүс бид ч бас мэдэрч чадна.

Эртний хүмүүс бидэнтэй яг адил нүдтэй, чихтэй, амтай, хамартай, бүх юмтай бөгөөд бидэнтэй яг адилхан алхаж явдаг. Өнөөгийн хүмүүс эрт цагийн хүмүүсээс ямар ч ялгаагүй, тийм биз. Ялгаагүй, хувцас нь л өөр байсан. Гэвч хувцас бол гадна талын зүйл, бидний уг хүнтэй хамаагүй. Тиймээс бид шар хувцастай байсан ч, хүрэн хувцастай байсан ч, жийнсэн өмдтэй байсан ч гэгээрч болно, учир нь бидний уг хүн хувцасгүй бөгөөд хувцасны ч хэрэггүй. Бидний уг хүн яг л хүүхэд шиг гэнэн цайлган, цэвэр ариун байдаг. (*Бүгд алга ташив*.)

Тиймээс бид эртний хүмүүс бясалгаад тодорхой нэг хутагтын сууринд хүрсэн, зарим нь арш болсон, зарим нь бодьсадва болсон, зарим нь гэгээнтний хутагт хүрсэн, зарим нь нэгэн бурхан болсон тухай сонссон, учир нь тэд өөрийн амин холбоог сэргээн зассан хэрэг, ийм л юм. Тэдэнд тасарсан амин холбоог нь сэргээн засаж өгдөг тусгайлсан нэгэн хүн байдаг, яг л цахилгааны утсыг засдаг тусгай мэргэжлийн хүн байдагтай адил.

Эртний хүмүүс гэгээрэх үедээ тодорхой нэг үрийн хутгийг олдог тухай бид сонссон. Жишээ нь, Шагжамуни Бурханыг ном айлдаж дууссаны дараа хэчнээн хүн бодьсадвагийн хутагт хүрсэн, хэчнээн хүн архадын хутгийг олсон, хэчнээн хүн сотапаннагийн[8] хутгийг олсон гэх мэт.

8 Сотапанна-Буддын шашин дахь сотапанна гэдэг нь гэгээрлийн дөрвөн үе шатны нэгэнд хүрэгч, Ниббаны "урсгалд орогч" (пали хэлний sota – урсгал, arappa - орогч) аж. "Урсгал" гэдэг нь нирвааныг хүргэдэг Хутагтын найман гишүүнт зам мөрийн зүйрлэл. Энэ нь эхний гурван гав гинж болох амиа бодох, эргэлзэж тээнэгэлзэх болон зан үйлд уягдах явдлыг тасалж, цаашид доод ертөнцөд (амьтан, өлсгөлөн сүнс, эсвэл тамын амьтан) дахин төрөхгүй болсныг илэрхийлнэ. Урсгалд орогч нь гурван төрөл байдаг ажээ.

1.Хамгийн ихдээ 7 удаа төрөл авдаг ч үүнийхээ дараа гарцаагүй гэтлэн чөлөөлөгдөг нэгэн
2. Буянтай гэр бүлд 2 -3 удаа төрж, үүнийхээ дараа гарцаагүй гэтлэн чөлөөлөгддөг нэгэн
3.Хүний ертөнцөд ганцхан удаа эргэн төрөөд энэ төрөлдөө гарцаагүй гэтлэн чөлөөлөгддөг нэгэн.

Урсгалд орогч нь нэг бол тэнгэрийн оронд, эсвэл хүний хорвоод төрж болох ч үүнээс доод ертөнцөд төрдөггүй. Сударт бичсэнээр бол урсгалд орогч нь зан суртахууны хувьд төгс төгөлдөр болсон байдаг ч төвлөрөл болон билиг ухааны хувьд төгс төгөлдөр болж

Энэ бол бясалгалын нэг төрлийн хутагтын суурь болно. Гэвч тэд үргэлж тэндээ зогсоод байхгүй, хэрвээ хичээнгүйлэн сайн бясалгавал өөрийн билиг ухаан, өөрийн хүрэх хутагтын суурийг үргэлжлүүлэн дээшлүүлж болно.

Бид эдгээр судар номыг уншаад ихэд баясаж, аз жаргалыг мэдэрч, сэтгэл догдолж, бид ч бас ийм ахуй ойлголт үзэж чадах болов уу гэж өөрсдөөсөө асуудаг. Тэгэхээр судар ном ч бас их ач тустай. Бид судар ном уншихдаа зарим нэгэн түвшин нь бидний гараг дэлхийгээс өөр байдалтай болохыг олж мэддэг. Зарим түвшин үнэхээр үзэсгэлэнтэй, тэнд найман ач буянт рашаантай, найман эрдэнээр бүтсэн, шувууд нь ном айлдаж чаддаг, орд харш нь бүгд алт, биндэрьяа, болор, гартаам, шүр зэрэг найман эрдэнээр бүтсэн нь хүмүүст тав тухыг мэдрүүлнэ. Хүмүүс нь эргэн тойронд чөлөөтэй нисэж, хүссэн газартаа, хаана ч агшин зуурт хүрнэ, тэд үгээр ярих шаардлагагүй бөгөөд найз нөхөд нь бодлыг нь дор нь ойлгоно. Ийм дэсэд хүрвэл хэчнээн сайхан бэ, эхнэр, нөхөртэйгөө харилцахад илүү хялбар болно гэж бид бодох болно. Заримдаа бид үг хэлээрээ харилцаж чаддаггүй, ярих тусам үл ойлголцол улам гаардаг.

Тиймээс судар ном унших нь бидэнд бас тустай. Хэрэв бодь сэтгэл үүсэж, бясалгахыг хүсэж, ижилхэн ахуй ойлголттой болохыг хүсэж байвал судар ном бидэнд тун их тустай. Зургаадугаар үеийн Өвөг Багш Хүй Нэн “Очироор огтлогч судар”-ын ганц өгүүлбэрийг сонсоод гэгээрсэн гэдэг. Тэрээр Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олох хэрэгтэй, түүнтэй ижилхэн ахуй ойлголттой байх ёстой гэдгийг тэр даруй ойлгожээ. Тэр агшин нь гэгээрэл юм. Хэрэв та гэгээрээгүй бол тэр байтугай Их Багшийн өмнө байсан ч ашиггүй, хэрэв ойлгохгүй бөгөөд бас гүтгэн гүжирдэх санаа агуулж байгаа бол гэгээрээгүй хүн.

чадаагүй байдаг аж. Тэглээ гэсэн түүний хийж буй аливаа үйлдэл нь түүнийг доод ертөнцөд унагачихаар түвшнийх биш байдаг. Википедиа толь.

Тиймээс номын айлдвар сонсоод гэгээрч болно, сударном уншаад бас гэгээрч болно, гэсэн хэдий ч энэ бол зөвхөн бага зэргийн гэгээрэл, зүгээр л бясалгал дадуулах шийдвэрт хүрсэн төдий. Хэрэв бид эртний хүмүүс бясалгалаараа ямар хутагтын сууринд хүрснийг ойлгохоор шийдсэн бол үүнийг бас гэгээрэл гэж үзэж болно. Гэтэл бидний ихэнх нь гэгээрэхийг маш агуу үйл хэрэг гэж боддог болохоор өөрийгөө дорд үзэж, хараахан гэгээрээгүй байна гэж боддог. Энэ нь гэгээрлийн нотолгоо байхгүй байгаатай холбоотой юм.

Гэгээрэх тусам санаа сэтгэл саруулжин, өөдрөг болдог

Гэгээрлийн нотолгоотой болж байж л сая гэгээрлийн хутгаа үүрд алдахгүй болно. Бид агшин зуур гэгээрч болно, гэхдээ гэгээрлийн ахуй ойлголттой болж чадахгүй бол гэгээрлийн тэр нэгэн дэс түвшнээ удалгүй мартаж, бодол санаа урьдынх шигээ болно. Тиймээс заавал гэгээрлийн нотолгоотой болох хэрэгтэй. Юуг гэгээрлийн нотолгоо гэх вэ? Бид хутагтын суурийг олох, дотоодын түвшнийг олох, диваажингийн түвшнийг олох, Бурханы орны түвшнийг олохыг гэгээрлийн нотолгоо гэнэ.

Бид гэгээрлийн нотолгоотой болох тусам улам гэгээрнэ, гэгээрэх тусам санаа сэтгэл уужим, саруул, өөдрөг болж, орчлон ертөнц хаанаас үүсэлтэйг илүү тодорхой ойлгож, өөрөө анх хаанаас ирснээ, бас хаашаа буцахыг хүсэж байгаагаа мэдэх болно. Сударном унших үед хэрэв танд бясалгал хийх, тийм дээд дэсийн ахуй ойлголтыг олох бодь сэтгэл үүсэхгүй бол сударунших нь ач тусгүй байна гэсэн үг. Хэрвээ сударуншаад бясалгал хийх чин сэтгэл төрж, эртний хүмүүсийн адил ахуй ойлголттой болохыг хүсэж байвал сударунших нь ач тустай байгаа хэрэг юм.

Зөвхөн эртний хүмүүс л тийм ахуй ойлголттой

байдаг гэж бүү бодоорой, орчин үеийн хүмүүс ч тийм ахуй ойлголттой болж чадна. Миний шавь нар ч эртний хүмүүстэй ижилхэн ахуй ойлголттой байдаг, ямар ч ялгаагүй. Эртний хүмүүс Баруун зүгийн Төгс баясгалант орныг хардаг байсан бол манай Арьяабалын аргаар бясалгаж буй шавь нар ч бас харж чадна. Зарим шавь такси жолоодож явахдаа Баруун зүгийн Төгс баясгалант орныг хардаг, зарим нь тариа тарьж байхдаа хардаг, эсвэл цагдаа хүн ажил дээрээ жижүүрлэж байхдаа ч харсан байна. Өндөр дээд албан тушаалтан ч бай, эсвэл эгэл жирийн хүн ч бай аль нь ч ялгаагүй Баруун зүгийн Төгс баясгалант орныг харж чаддаг, үүнд ямар ч ялгаа байх ёсгүй.

Шагжамуни Бурханы шавь нар зөвхөн гэрээс гарагчид байсан биш, олонх нь гэрээс гараагүй бодьсадва нар байсан. Өнөөдөр гэртээ байгаа хүн ч бас тийнхүү бясалгал дадуулж болно. Би та бүхэнд Арьяабалын бясалгалын арга үнэхээр их ач тустай гэдгийг дуулгахдаа баяртай байна. Миний хэлж байгааг шавь нар маань бүгд мэднэ, учир нь тэд өөрсдөө мэдэрсэн, тэд маш их талархдаг учраас Багш яримагц алга ташдаг.

Арьяабалын бясалгалын арга биднийг Баруун зүгийн Төгс баясгалант оронд дагуулан хүргэж, Авид бурхантай уулзуулна. Хэрвээ бид Есүс Христэд дуртай бол тэр бас биднийг дагуулан байгаа газарт нь хүрч, Есүс Христтэй уулзуулна. Хэрвээ бид Лаозад дуртай бол тэр бас биднийг Лаозтай уулзуулж өгнө. Бид Күнз, Жи Гүн хутагт (Жигүн амьд бурхан), эсвэл өөр бусад бурхан бодьсадва, ер нь хэнд л дуртай байна, биднийг тэдэн дээр дагуулан хүргэнэ. Тиймээс энэ “Зам мөр ”-д ялгаварлах сэтгэл байдаггүй.

Зам мөрд ялгаварлал байдаггүй

Хэрвээ нэгэн “Зам мөр” нь зөвхөн бурхны шашинтнууд гэгддэг хүмүүсийг л гэтэлгэдэг бол тэр “Зам

мөр”-д ялгаварлал байна гэсэн үг. Тиймээс эгэл хүмүүс бид энэ “Мөр” тийм явцуу, ийм хавчиг, нээлттэй биш гэж бодож болохгүй. Манай Бурханы шашин сайн, Католик шашин муу гэвэл иймэрхүү шүүмжлэл нь бүгд бид “Мөр”-ийг дорд үзсэн, Эзэн Бурханыг дорд үзсэн, Бурхан, бодьсадваг дорд үзсэн хэрэг болно. Эгэл хүний сэтгэлээр бурхан, бодьсадвагийн сэтгэл зүрхийг хэмжиж, эгэл хүний уураг тархиар тэнсэлгүй дээд энэрэл нигүүлсэл, цаглашгүй их хайрын хүчтэй Эзэн Бурханыг дэнслэхийг оролдож байгаа хэрэг. Тиймээс бидний хэлэх үг логиктой байх ёстой, тэгвэл хүмүүс хүндэлнэ. Замбараагүй зүйл ярих хэрэггүй, бидний дэс тун доогуур болохыг хүмүүс мэдчихнэ.

Багшийнх нь ярьж буй Арьяабалын бясалгалын арга бол жинхэнэ “Зам мөр ёс” мөн. Учир нь түүнд ялгаварлал байхгүй. Католик шашинтай хүн Багшаас нь сурахаар ирвэл Библи сударт дурдсан ахуй ойлголтыг олж үзнэ, Игуандао шүтлэгтэн ирж суралцвал Ванму ээж, Жоу Гүн (Дань) богд, Майдар бурхан зэрэг өөрсдийн дуртай гэгээнтнийг харна, бурхны шашинтан хүн ирж Багшаас нь суралцвал Арьяабал бодьсадва, Авид бурхан, Шагжамуни Бурхантай уулзана, бумбын болон күнзийн шашинтан ирвэл тэд бас өөрсдийн хайртай сургаалын эздийг хардаг.

Тиймээс Арьяабалын бясалгалын арга нь баян хоосон, хөгшин залуу ялгалгүй бүх хүн ахуй ойлголттой болдог, ялгаварлал үгүй бясалгалын арга гэдэгт би зуун хувь итгэсэн. Багшийнх нь хамгийн бага шавь таван настай, тэр бас “Эрхэт мэлмийгээр болгоогч бодь сэтгэлтний тийн хувилгаанаар үзүүлсэн Хотол зохилдогч зүйл” дэх ахуй ойлголтуудыг олж үзсэн юм. Тав, зургаан настай хүүхэд худлаа ярих боломжгүй, тэр бас Арьяабал бодьсадваг харсан, Их хүчит бодьсадва, Арьяабал бодьсадва бүгд л тэдний найзууд, тэд бурхадтай тун ойр дотно, танил дасал болсон байдаг. Хамгийн ахмад авшигтан наян настай эмээ

бий. Тэр ч бас ахуй ойлголттой бөгөөд бурхан, бодьсадваг хардаг. Ганц тэр ч биш, ахмад настай өөр олон авшигтан бүгд ийм ахуй ойлголттой байдаг.

Заримдаа ахмад настай хүмүүс бурхан, бодьсадва дээд түвшнийг амархан хардаг нь тэдний зүрх сэтгэл хоосроод энэ ертөнцийн жамыг гүн гүнзгий ойлгож, өчүүхэн ч хоргодох юмгүй, амьдралын хором бүхэн нь үнэ цэнтэй болж, амжихаа больсноо ухаарсан зүрх сэтгэл нь яарч, туйлын их хүсэн хүлээдэг зэрэг нь бурхад, бодьсадвагийн сэтгэлийг хөдөлгөжээ. Залуучууд хүртэл атаархмаар сайн ахуй ойлголттой настнууд олон байдаг. Гэхдээ залуу хүн сайн сүнслэг ахуй ойлголттой байх боломжгүй гэсэн хэрэг бас биш. Ерөөс, баян, ядуу, эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу ямар ч хүн дээд дэсийн ахуй ойлголттой болж болно.

Арьяабалын бясалгалын аргад үнэхээр өчүүхэн ч ялгаварлал байхгүй. Шашны урсгалыг ч ялгаварлахгүйгээс гадна том жижиг, баян ядуу, сайн муугаар нь ялгаварладаггүй. Зарим нь насаараа амьтан хөнөөсөн ч гэм нүглээ агшнаа ухаарч болно, хэрэв тэд яргын хутгаа хөсөр хаяад Багшийг нь даган суралцвал тэр даруй сайн ахуй ойлголт олж авна.

Арьяабалын бясалгалын арга нь их нигүүлсэнгүй, их энэрэнгүй, ихэд гэтэлгэгч, их өгөөмөр номын цогцос мөн. Учир нь ийм олон төрөлтөн ач тусыг нь хүртэж, ийм олон хүн сайн ахуй ойлголттой болсон учраас шавь нар маань Багшийгаа залж, газар бүхэнд ном тайлуулдаг. Хамаг төрөлтөнд ач тустай байгааг хараад Багш нь ч бас их баярладаг юм.

Бурханаас суралцах нь
Бурханы хутагт хүрэхийн төлөө

Арьяабалын бясалгалын арга бол эгэл хүнийг бурхан болгон хувиргадаг цорын ганц номын цогцос гэдэг

нь баталгаатай үнэн. Энэ нь үнэхээр учир зүйтэй тул бид үүнд итгэх ёстой. Бид бүгд угаасаа Бурхан чанартай гэж ярьдаг, тэгвэл яагаад бид бурхад болж чадахгүй байх вэ? Олон хүн бурхнаас суралцдаг, гэвч хэн ч нэгэн бурхан болж зүрхэлдэггүй. Хэн нэгэн хүн Бурханы хутагт хүрсэн гэж сонсохоороо тэд маш ихээр эргэлзэж, хардан сэжиглэж, ихэд чимээ шуугиантайгаар гүтгэж, сэтгэл үймүүлсэн олон зүйл хийдэг. Хэрэв бурхнаас суралцаад бурхан болж чадахгүй бол өөр юу болох вэ? Ад чөтгөр болох уу? Бид бурхнаас суралцаж байж л Бурханы хутагт хүрэх ёстой!

Хэрэв та анагаах ухаанд суралцвал эмч болно, хуулийн мэргэжилд суралцвал хуульч болно, таксины жолоочийн дамжаанд сурвал таксины жолооч болно, гэрлэвэл эхнэр, эсвэл нөхөр болно. Тиймээс хэрэв бурхнаас суралцвал та яагаад нэгэн бурхан болж чадахгүй гэж? Гэвч өнөөгийн Бурханы номд суралцагч, номын цогцсыг дадуулагч гэгдэгчид нь өөрсдөө бурхан болж зүрхлэхгүй, бусдыг ч бурхан болгож зүрхлэхгүй, хэн нэгнийг Бурханы хутагт хүрсэн гэж сонсохоороо яг л галд шатаж байгаа мэт болон тэвчиж чадахгүй, бас итгэхгүй байдаг. Яагаад итгэхгүй байна вэ? Шагжамуни Бурхан: “Төрөлтөн бүхэн Бурхан чанартай байдаг.” гэжээ. Тэгвэл хүмүүс бид яагаад бясалгаад бурхан болж чадахгүй байх вэ? “Богдсын ном Цагаан лянхуа судар”-т: “Лусын охин найман насандаа Бурханы хутагт хүрсэн.” гэж тэмдэглэсэн байдаг. Хүмүүн төрөлтөн бид яагаад Бурханы хутагт хүрч чадахгүй байх билээ?

Хүн төрөлтөн бол түмэн бодисын охь дээж нь, орчлон дээрх хамгийн эрхэм дээд зүйл нь хүний бие. Лусын охин найман насандаа Бурханы хутагт хүрч чадсан байна. Гэтэл бид ийм эрдэнэ мэт үнэтэй нандин, эрхэмсэг сүрлэг, ийм өндөр настай, ийм их эрдэм мэдлэгтэй атал яагаад Бурханы хутагт хүрч зүрхлэхгүй байна вэ? Энэ үнэхээр гайхмаар юм.

Хэрвээ сайн бясалгалын арга дутсан бол түүнийг хайж олох ёстой. Бурханы бясалгалын аргаар дадуулбал гарцаагүй нэгэн бурхан болно. Эндээс ч нэг, тэндээс ч нэг юм сонсож явсаар, эцэст нь зөвхөн Шагжамуни Бурхан л бурхан болж чадна, бид бурхан болж чадахгүй юм байна гэж бодох хэрэггүй! Ингэж ярих нь Шагжамуни Бурханыг гүтгэсэн хэрэг болно, учир нь Тэрээр айлдахдаа, бурхан мэндэлсэн нь хамаг төрөлтөнд бурхны билиг ухааныг ойлгуулахын төлөө юм гэжээ. Зөвхөн бурхан л сая бурхны мэдлэг, үзэл бодлыг ойлгож чадна.

Энэ нь бид бурхад болж чадна гэсэн үг бөгөөд бурхан заларсан нь биднийг бурхад болгохыг хүсдэг учраас юм. Гэтэл Бид өөрсдөө бурхад болж зүрхлэхгүй мөртөө бас бусдыг ч бурхан болж чадахгүй хэмээн хаа сайгүй ярьж явдаг. Энэ нь Шагжамуни Бурханыг гүтгэсэнтэй адил бөгөөд Түүний хэлсэн үгэнд итгэхгүй байна гэсэн үг юм. Би Шагжамуни Бурханд зуун хувь итгэдэг, тиймээс Бурханы хутагт хүрэхийг зүрхлэхгүй хэн бүхэн эндээс явж болно. Харин нэгэн бурхан болохыг зүрхэлсэн хэн боловч хамтдаа бүтээе.

Эмч болгодог бясалгалын арга байна, номын багш болгодог бясалгалын арга байна, хуульч болгодог бясалгалын арга байна, тэгэхээр нэгэн бурхан болгодог бясалгалын арга заавал байх ёстой. Бурханы хутагт хүрэхийн тулд гэрээс гарагч байлаа ч гэсэн үсээ хусуулж, сахил хүртсэнийхээ дараа ч Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж, сайн бясалгалын аргыг дадуулах ёстой. Сахил сахих нь хангалтгүй, учир нь энэ дэлхийд сахилыг тодорхой сахих аргагүй байдаг.

Хүнсний ногоо идсэн ч амь хөнөөнө, амьсгал авсан ч амь хорооно. Бурхан Багш бас: “Усанд наян дөрвөн мянган хорхой бий. (Эх сударт: “Бурхан Багш нэг бадар аяга усыг ажиглаад наян дөрвөн мянган хорхой байгааг харжээ.”) Тарни уншилгүй ус уувал амь хөнөөнө.” гэж айлджээ.

Гэвч бид хоногийн хорин дөрвөн цагийн турш тарни уншиж чадахгүй. Заримдаа мартдаг, мартсан үедээ амь хөнөөсөн үйл түйтгэр үүсгэдэг. Учир нь агаарт үй олон бичил биетэн байдаг тул бид амьсгалахдаа олон амьтны амь хөнөөнө, ус ч бас бичил биетнээр дүүрэн байх тул бид ус ууж байхдаа амь хөнөөж байдаг. Хүнсний ногоон дээр пестицид цацвал бас л амь хорооно. Иймээс энэ дэлхийд бид сахил санваарыг бүрмөсөн тодорхой сахих арга байхгүй.

Тэр ч байтугай Шагжамуни Бурхан гэрээс гарсан хэдий ч мөн л Арьяабалын аргаар бясалгаж байж л сая Бурханы хутагт хүрч чадсан бөгөөд Тэрээр өөрийн хамгийн ойр дотнын шавь Анандад заавал Арьяабалын бясалгалын аргыг дадуулж байж л сая Бурханы хутагт хүрч чадна, арван зүг, гурван цагийн бурхад, бодьсадва нар ч гэсэн бүгд л Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж байж л Бурханы хутагт хүрсэн гэдгийг ярьсан байдаг. Үүнээс бид Бурханы хутагт хүргэж чадах нэгэн бясалгалын арга заавал байдгийг ойлгож болно. Тэр аргыг мэддэг хүнийг олж, түүгээр заалгавал бид Бурханы хутагт хүрч чадна. Энэ нь ер бусын нууцлаг явдал биш, бид заавал эрж олох хэрэгтэй. Энэ эрдэнэт хүний амьдралаа дэмий бүү гарздаарай.

Тиймээс Багш нь хаа очсон ч энэ сайн мэдээг хүмүүст дамжуулдаг. Хэрвээ бүгдээрээ итгэж байвал хамтдаа бясалгаж, энэ ерөөл барилдлагыг хамтдаа эдэлье. Итгэхгүй байсан ч хамаагүй, гэхдээ битгий гүтгэн буруутгах сэтгэл өвөрлөөрэй. Учир нь эгэл хүний дэсэд байхдаа бид хэн нь хэн болохыг харж чадахгүй. Хэрэв Багш нь нэгэн бурхан юм бол -- зөвхөн жишээлж ярьж байгаа шүү -- та нар бурхныг гүтгэвэл их төвөг саадтай учирч, тамд унаад маш удна шүү!

Наймдугаар бүлэг

ИХ БАГШ “УСАН ХӨВӨӨНИЙ ШАСТИР”-ЫН ТАЛААР

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Тайнань хот.
1988 оны 4 дүгээр сарын 21
(Эх нь хятад хэлээр)

Хаан эзэн Тяньши Их Багшийг урьж залсан нь

“Усан хөвөөний шастир”-т тэр үеийн Хятад оронд үлэмж их гамшиг нүүрлэж, бороо хургүй удсанаас ган болж, олон хүн өлсөж үхсэн, мөн тэр үеийн их хаан (Сун Рэнзүн) ард олонд өглөг үйлдэж, гэм ялтай хүмүүсийг өршөөн уучилж, ялаас нь хэлтрүүлэн шоронгоос суллаж, ингэснээр гамшиг зовлонг арилгахыг хүсэн даатгаж гуйсан тухай гардаг.

Хэдийгээр эзэн хаан сайн үйл арвин ихийг үйлдсэн

ч бүгд тус болсонгүй. Нэгэн хүн эзэн хаанд Бумбын шашны арш, их бясалгагчийг танилцуулжээ. Бумбын шашинтан арш гэдэг нь Күнз, Лаозад итгэгчийг л хэлэхгүй, харин их бясалгагч гэсэн утгатай, тэр нь тэнгэр, газрын нууцад гүнзгий нэвтэрсэн, эрхэм дээд ёс суртахуунтай, асар их шидийн хүчтэй хүн юм.

Сонсоход энэхүү арш[9] (Жан овогт Тэнгэрийн багш (Тяньши) хүч чадал нь сэтгэгдэшгүй их, улс орондоо тусалж, байгалийн гамшгийг зайлуулж чаддаг гэдэг.) Сун Рэнзүн хаан ихэд баярлан ард олноо гамшгаас аврахын тулд их жанжин Хун Шинийг томилон явуулж, аршийг хааны ордонд урьж залжээ.

Хун Шин Лунху ууланд хүрээд уулын бэлд Шанчин Гун нэртэй нэгэн хийд байхыг харав. Тэр хийдэд Бумбын шашны олон хувраг бясалган суух ажээ. Хун Шин: "Танай багш хаана байна? Би хааны зарлигаар түүнийг хааны ордонд залж, бясалгалын буян үйлдүүлэхээр ирсэн." гэхэд хуврагууд: "Өө! Түүнийг залах аргагүй дээ, тэр их өндөрлөг газарт суудаг. Түүний зан авир, амьдрах хэв маяг жирийн хүмүүстэй адилгүй. Тэр хүмүүстэй холилдох дургүй, бидэн шиг эгэл хүмүүс түүнийг залж дийлэхгүй!" гэхэд Хун Шин: "Энэ бол хааны зарлиг, залахгүй байж хэрхэвч болохгүй." гэхэд тэд: "Хааны зарлиг байсан ч гэсэн нэмэргүй!" гэж хариулав.

Тэр хуврагууд бас тун даруухан хүмүүс байв. Тэд түүнд тайлбарлан: "Жан овогт Тэнгэрийн багшийн (Тяньши) бясалгал дэндүү хэтийдсэн учраас Түүний бодол санаа, хүч чадал жирийн хүнийхтэй адилгүй. Бид хүртэл Түүнийг уулнаас буулгаж, хамт амьдарч чадахгүй байна, тэгэхээр та буцсан нь дээр!" гэв. Гэвч Хун Шин чин сэтгэлээсээ шийдсэн тул арга зам зааж өгөхийг хуврагуудаас гуйхад эцэст нь тэд: "За яах вэ! Хэрвээ та Жан овогт Тэнгэрийн

9 Жан Тяньши нэртэй, тэрээр Лунху ууланд амьдардаг байжээ.

багшийг (Тяньши) залахыг чин сэтгэлээсээ хүсэж байвал эгэл борог хувцас өмс, мах идэж болохгүй, цагаан хоол идэж, нэг утлагын сав хүж бэлдээд уул өөд өгсөж ганцаараа явах хэрэгтэй. Таны чин сэтгэл Түүний сэтгэлийг хөдөлгөвөл уулнаас бууж, хүмүүсийг аврахыг зөвшөөрч магадгүй." гэж нэгэн арга зааж өгөв.

Хун Шин тэдний хэлснээр цагаан хоол идэж, усанд орж, биеэ цэвэрлээд ордны түшмэлийн торго дурдан хувцсаа хамгийн хямдхан энгийн ёрог даавуун хувцсаар сольж өмсөн даруу төлөв байдлыг илтгэж, нэг сав хүж авч, Их Багшид бараалхахаар уул өгсөн ганцаар явжээ. Өөрийн туслагч, бараа бологчдоос ч дагуулсангүй.

Зорьсон газартаа хүрэхээсээ өмнө замдаа олон сорилттой тулгарч гэнэ. Нэг удаа бар замын хажуугаас үсрэн гарч ирж, идэх шахав. Бараас салаад удаагүй байтал маш хортой, аварга могой хатгахаар иржээ. Хэдийгээр тэр жинхэнээсээ хатгах гээгүй, зүгээр л түүнийг айлгасан ч гэсэн их жанжин уул өөд өгсөхөө болих шахав. Гэвч улс оронд нь нүүрлэсэн гамшиг арилаагүйг бодохоор түүнд урагшлахаас өөр арга байсангүй.

Дараа нь тэрээр Жан овогт Тэнгэрийн багшийг (Тяньши) харсан боловч таньсангүй. Учир нь Их Багш их жижигхэн биетэй, яг л үхэр унаж, бишгүүр үлээх малчин хүү шиг харагджээ. Мөн их жанжин Хун Шин Тяньши Их Багшаас зам асууж: "Уучлаарай, Их Багш хаана заларч байгаа бол?" гэхэд Их Багш: "Өө, би өнөөдөр түүнийг ийм ийм газар харсан, гэвч тэр тогоруу унаад явсан, одоо энд байхгүй дээ." гэв.

Энэ түүх их урт. Багш нь яагаад энэ түүхийг ярьж байна вэ гэвэл нэгд, Төгс Гэгээрсэн Их Багшийг олж уулзах нь тун амаргүй гэж бид бүгд сонссон нь Төгс Гэгээрсэн Их Багш бардам зантай байдгаас болоогүйг бид ойлгох

хэрэгтэй. Шагжамуни Бурхан, Бурханы хутагт хүрснийхээ дараа мөн л уулнаас буух дургүй, хамаг төрөлтнийг гэтэлгэхгүй, Дээдийн ном уламжлахгүй, ер нь юу ч хийх хүсэлгүй байжээ. Тэрээр зөвхөн нирваанд буцахыг хүсэж байв. Нирваанд буцах нь таалал төгсөх биш юм. Нирваан хоёр янз байдаг. Нэг нь бага нирваан, нөгөө нь их нирваан. Бага нирваан гэдэг нь өдөр бүр бясалган сууж, самадид ороод бурхны оронд очиж, баяр жаргалыг эдлэн баясаж, бие, сэтгэлийн тайвшрал, амар амгаланг эдлэх явдал юм. Энэ нь бага нирваан бөгөөд үүнийг өдөр бүр олж авч болно. Их нирваан гэдэг нь бидний амьд явах хугацаа дуусаж, энэ дэлхийг орхих ёстой гэсэн үг. Энэ бол жинхэнэ нирваан болно. Шагжамуни Бурхан нирваандаа буцна гэдэг нь тэр өдөр амиа хорлоно гэсэн үг биш, Тэр тэгэх гэсэн биш шүү. (*Бүгд инээв*.)

“Усан хөвөөний шастир”-т Ли Күй, Луо Жэнрэнийг (Бүтээлт бодгаль) хороосон тухай өөр нэг түүх гардаг. Ли Күй гадагш гартал нэгэн хүү уйлж байжээ. Хүү: “Та яагаад миний багшийг хөнөөчхөв өө?” гэхэд Ли Күй өнөөх хүүг тас цавчин хөнөөжээ.

Энэ түүх юуг өгүүлнэ вэ? Үүнээс хүмүүс бид хэчнээн бүдүүлэг, болчимгүй байдгийг харж болно. Луо Жэнрэн (Бүтээлт бодгаль) Их Багш хэзээ ч харгис муу зүйл хийж байгаагүй, тэр цагаан хоолтон байв. Олон жил аглагт сууж, ертөнцийн явдалд үл оролцон сүнслэг бясалгал дадалд өөрийгөө зориулахыг л бодож байжээ, Ли Күйтэй ямар ч холбоо байхгүй. Луо Жэнрэн шавь нарынхаа нам сэлүүн бясалгалыг хамгаалахын тулд тэдэнд уулнаас буухгүй, амьтны амь хөнөөхгүй, ертөнцийн элдэв явдалд оролцохгүй байхыг анхааруулжээ. Энэ нь зөв, ердөө ч буруу биш, учир нь гэрээс гарагчид угаасаа байлдаж тулалдаж, алалцаж хядалцах ёсгүй бөгөөд үүнийг бүгд мэднэ. Гэсэн хэдий ч хүмүүс маш бүдүүлэг, ихэнхдээ өөрийгөө хянаж

чаддаггүйгээс болоод асар их зовлон зүдүүртэй байдаг.

Их Бясалгагч хүмүүсийн ихэнх нь дэлхий дээр бууж ирэн хүмүүсийг гэтэлгэхийг зүрхэлдэггүй нь үхлээс айдаг учраас биш юм. Хүмүүс Шагжамуни Бурханыг хорлохыг байнга оролдож, Зургаадугаар үеийн Өвөг Багш Хүй Нэнийг хөнөөхөөр мөшгөж, Есүс Христийг загалмайд цовдолж, Күнз, Лаозыг хэд хэдэн улс орон хүлээн авахаас татгалзаж, хөөж тууж, айлган сүрдүүлж, доог тохуу хийж байсныг бид харж байна. Гэвч Тэд энэ бүхнээс эмээгээгүй, харин хамаг төрөлтнийг гэтэлгэх нь хэцүү учраас айж байжээ. Бид түүхээс үзвэл мэднэ. Ямар ч Төгс Гэгээрсэн Их Багш гарч ирээд ном айлдан хамаг төрөлтнийг гэтэлгэхэд үнэхээр амаргүй, бүгд маш олон саад бэрхшээлтэй тулгардаг, Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олоход яагаад хэцүү байдгийн учир нь энэ.

Зугтах аргагүй хувь заяаны үүрэг

Зарим хүн заавал ил гарч Дээдийн ном дэлгэрүүлэх үүрэгтэй байдаг. Түүний хувь тавилан ийм юм, гарахгүй байх боломжгүй. Багшийг нь битүүмжлэн сууж байх үед хэсэг хүн ирж, илрүүлсэн тухай дөнгөж саяхан та нар сонссон. Үнэндээ энэ нь тэдний буруу биш, харин Арьяабал бодьсадвагийн буруу юм. Арьяабал бодьсадва байгаа газрыг маань зааж өгсөн учраас тэд Багшийг нь олж чадсан[10]. Хэрэв бид нуугдаж чадвал зөвхөн хүний нүднээс л нуугдаж чадна, Бурхан, бодьсадвагаас нуугдаж чадахгүй, бидний хаана нуугдаж байгааг тэд бүгд мэднэ. Хэрвээ Арьяабал бодьсадва хэлсэн бол би өөрийгөө ид шидийн хүчээр ч нууж чадахгүй. (*Бүгд алга ташив.*) Хэд хэдэн удаа ингэж илрүүлсний дараа би гарч, нийтэд илээр ном дэлгэрүүлэхээс өөр аргагүй болсон. Дахиж нуугдаад ямар ч нэмэргүй болов, асуудал байсаар байх тул ялгаа байхгүй. Яг л Луо Жэнрэнтэй адил, Тэрээр шавь нараа Ляншангийн хүмүүст туслахын

10 Дэлгэрэнгүйг Их Багшийн товч намтар хэсгээс үзнэ үү.

тулд уулнаас буухыг нь зөвшөөрөхийг хүсээгүй ч эцэст нь бүдүүлэг Ли Күйд тас цавчуулжээ.

Гэхдээ та бүхэн санаа бүү зов, Луо Жэнрэн Их Багш үхээгүй, тэрээр хоёр хулууг хувилган нэг хулуугаар өөрийн биеийг орлуулж, нөгөө хулууг шавийнхаа бие болгожээ, тиймээс Ли Күй зөвхөн хоёр хулуу л цавчсан хэрэг. Ли Күй хэдийгээр Луо Жэнрэнийг алаагүй ч түүний зүрх сэтгэл дэндүү харгис, хэрвээ Луо Жэнрэний ур чадвар, бясалгал дадал хангалттай сайн биш байсан бол аль хэдийнээ алагдах байсан, тийм биз? (*Бүгд алга ташив.*)

Иймээс маш олон их бясалгагч, тэр Бумбын арш, Төгс Гэгээрсэн Их Багш, гэгээрсэн Их Багш бүгд хүмүүсээс маш их эмээдэг, хүмүүсийн зүрх сэтгэл хэтэрхий хорон санаатай байдгаас айдаг. Гэвч би айхгүй, учир нь би бол Их Багш биш. Их Багш л айна, бага багш айхгүй. Та нарыг харахад Багш нь их туранхай, жижигхэн биетэй, тэгэхээр Их Багш биш, тиймээс би айхгүй, айхгүй учраас гарч хүмүүсийг сургана. Би ямар ч шинэ ёс журам заагаагүй. Бүх шашин нэгэн ижил зүйлийг заадаг, сайн үйл хийж, бие биеэ хайрлахыг сургадаг. Хэрвээ гарч ирэн Дээдийн ном дэлгэрүүлсэн тэр Их Багш нар байгаагүй, шашны судар ном хадгалагдаж үлдээгүй бол манай нийгэм ийм соёлжингуй, амар тайван, аюулгүй байж чадахгүй байсан нь магад гэдгийг бид төсөөлж болно.

Ёс суртахуунаар дутмаг цаг үе

“Усан хөвөөний шастир” зохиолыг уншихад тэр үе үнэхээр аймшигтай байсан биш гэж үү? (*Бүгд: Тийм гэж хариулав.*) Шударга ёс байхгүй, их түшмэл нь бага түшмэлээ дээрэлхэнэ, бага түшмэл нь арай бага түшмэлээ дээрэлхэнэ, тэр нь доод түшмэлээ дээрэлхэх бөгөөд хамгийн бага түшмэл нь ядуу ардыг дарамтална. Дээр нь дайн байлдааны үймээн самуун нэмэгдсэнээс зарим хүн дээрэмчин болохоос аргагүй болж байжээ. Тэр цаг үе үнэхээр эмх замбараагүй

байсан. Гурван улсын үе (220-280 он) ч бас их самуун цаг байв. Феодалын нийгмийн Чуньцюгийн үе (НТӨ 770-403 он)-д ч бас ороо бусгаа байсан бөгөөд хамаг төрөлтнийг гэтэлгэхээр хэн ч гарч ирээгүй. Шагжамуни Бурхан Дээдийн ном дэлгэрүүлэхээр гарч ирсэн тэр үе (Нийтийн тооллын өмнөх зургаадугаар зуун)-аас энэ дэлхий арай дээрдэж, тийм ч аймшигтай байхаа больсон юм.

Бид өнөөдөр ургамал хоол идэхийг дэмжиж байгаа бөгөөд зарим хүн сүм хийд барих, ёс суртахуунтай сайн үйл хийхийг дэмжиж байна. Харин "Усан хөвөөний шастир"-ын эрин үед хүмүүс хүний махаар хооллож, хүн нь хүнээ иддэг байжээ, цагаан хоол гэж ярих нь бүү хэл, хүн алаагүй нь хэдийнээ гайхалтай сайн хэрэг байв. Хэрвээ тэдэнд хүн алахгүй байхыг зааж чадвал хэдийн том алхам юм, юун ургамал хоолтон байх, ёс суртахуунтай үйл хийхийг зааж өгөх вэ? "Усан хөвөөний шастир"-ыг уншихад тэр үеийн хүмүүс махыг нь идэхийн тулд амьтан алдаг, идэх амьтан олдохгүй бол зүгээр л хүн алж, махыг нь иддэг байжээ. Тэр үед дээрэмчдийн толгойлогч нь баатар эрд тооцогдоно. Тэд бүгд хүний мах иддэг, дайснаа барьж ирээд цээжийг нь ярж, зүрх, уушгийг нь огтолж, элгийг нь сугалан иднэ. Энэ нь үнэхээр аймшигтай, жигшүүртэй. Гэвч тэр цаг үед тэд бол бусдын хүндлэлийг хүлээсэн хүмүүс байв, хүн бүхэн хүндэлнэ, бүгд тэднийг "ёс суртахуунтай" хэмээн магтана.

Тухайн үеийн хүмүүс ёс суртахуунаар тун дорд, ёс суртахууны талаарх үзэл бодол нь одоогийн хүмүүсийнхээс өөр бөгөөд маш их зөрөөтэй байжээ. Одоо бол хэн нэг хүн хүний амь хороосон гэдгийг сонсвол хүмүүс түүнийг ёс суртахуунгүй хэмээн зэмлэнэ. Гэтэл "Усан хөвөөний шастир" зохиолд харин "ёс суртахуунтай" дээрэмчдийн толгойлогч нь хүний мах иддэг байхад бүгдээрээ нэг их тоохгүй байдаг. Заримдаа ямар нэгэн тосгоны хүмүүс газар нутгаа хамгаалахын тулд хатуу үг хэлж, гэхдээ хараяж загнаа

ч үгүй байхад Ляншан уулын баатар эрчүүдийн уур хилэнг хөдөлгөснөөр тэд уулнаас буун ирж, тосгоны хүмүүсийг бүгдийг алж хяддаг байжээ.

Бясалгагч хүний уудам, өршөөнгүй намба төрх

Бясалгадаг болон бясалгадаггүй хүний хооронд асар их ялгаа байдаг. Бясалгадаггүй хүний хувьд хэрэв хэн нэгэн түүнд муугаар хандвал тэрээр яг тийм хариу барина, хэн нэгэн сайн хандвал тэд сайнаар хандана. Заримдаа бид бусдад маш сайнаар хандсан байтал нөгөө хүн харин ач энэрлийг занал хорслоор хариулдаг, тийм биз дээ. Бясалгагч хүн ийм байдаггүй, бусад хүн бидэнд муугаар хандсан ч гэсэн бид түүнд сайн хандсан хэвээр байна. Есүс Христ загалмайд цовдлогдох үедээ Эзэн Бурханаас өөрийг нь цовдолсон, амийг хөнөөсөн, өөрөөс нь урвасан, өөрийг нь гүтгэсэн, өөрийг нь хэлмэгдүүлсэн хүмүүсийг өршөөн хэлтрүүлэхийг гуйж байсан. Тэрээр: "Эцэг минь, тэднийг өршөөж хайрла! Тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна." гэж хэлж байжээ. Гагцхүү их бодьсадва хүн л ийм агуу уужим сэтгэлтэй байдаг. Зарим хүн Есүс Христ бол бурхан биш, Түүний дэс маш доогуур, Тэр бол бодьсадва биш гэх зэргээр ярьдаг. Би үүнтэй санал нийлэхгүй. Зөвхөн бодьсадва хүн л ийм агуу уужим сэтгэлтэй байж чадна. Тийм биш гэж үү? (*Бүгд алга ташив.)*

Тийм учраас бид энэ шашин сайн, эсвэл муу гэж дурааараа шүүмжилж болохгүй. Бид анхааралтай, тодорхой харах ёстой, өнгөрсөн үеийн сургаалын эзэд, Төгс Гэгээрсэн Их Багш нарыг ялгалгүйгээр хамаагүй гүтгэх ёсгүй. Бид бол эгэл хүмүүс хэвээрээ, хэрэв ямар нэг зүйлийг ойлгохгүй байгаа бол ойлгохгүй байгаагаа хүлээн зөвшөөрч, алгууруар сурч, ойлгосныхоо дараа л жинхэнэ дүгнэлт хийж чадна. Ийм байдаг болохоор олон хүн мэдлэггүй байдаг тул тэр ялгааг нь авч үзэлгүйгээр хамаагүй шүүмжилдэг учраас зөрчил, тэмцэл, тэр ч бүү хэл шашин хоорондын дайн гарах

шалтаг үүсдэг.

Багш нь хаа ч явсан хүмүүсийг ялгаварлал гаргахгүй, бие биеэ алж хөнөөлгүй, ёс суртахуунтай үйл хийхийг зоригжуулж байдаг. Католик шашинтнууд эмнэлэг байгуулж, өглөг үйлдэж, олон нийтэд тусалдаг, тэд ямар ч муу үйл хийгээгүй. Мэдээж католик шашинтнуудын дунд муу хүмүүс байгаа, гэхдээ манай бурхны шашинтнуудын дотор ч бас муу хүн байдаг. Ганц нэг муу хүнээс болж, бүх бүлгээр нь харлуулан гүтгэж болохгүй. Игуандао шүтлэгтнүүдийг муу гэж олон хүн хэлдэг. Тэдний юу нь муу болсныг би мэдэхгүй байна. Тэд алж хөнөөдөггүй, хулгай хийдэггүй, бэлгийн буруу харилцаанд ордоггүй хүмүүс байхыг хичээж байдаг нь нийгэмд хангалттай сайн зүйл. Бид тэднийг шүүмжлэх ёсгүй. Тэдний сайн, эсвэл муу байх нь бидэнд хамаатай явдал биш.

Дэглий, дун хоёрын тэмцлээс загасчин хожсон нь

Дэлхийн хүмүүс хамтрах хэрэгтэй, хамтдаа ёс суртахуун, нийгмийн амар амгаланг бэхжүүлж, ах дүү, хамаатан садан, найз нөхдөө сургаж, тэднийг бясалгахад зоригжуулах хэрэгтэй. Бусад хүн юу хүссэнээ бясалган дадуулаг, тэд өөрсдийн тааваараа, тав тухтай байг. Хэрвээ тэд Арьяабалын бясалгалын аргыг дадуулахыг хүсвэл та нар тэдэнд: "За сайн, ирээд Чин Хай Их Багшийг даган суралцаарай." гэж хэлж чадна. (*Бүгд алга ташив.)* Хэрвээ тэд католик шашинтнуудтай хамтрахыг хүсвэл сүм дуганд очиж, Ариун номлол сонсохыг зөвлөөрэй, хэрвээ Ариун орныг бясалгана гэвэл Бурханы шашны Ариун орны бүлгэмээс суралцахыг хүсээрэй, тэгвэл хүн бүр амар амгалан байх болно. Бид нэг нэгэнтэйгээ тэмцэлдэх биш, хамтрах хэрэгтэй. Хэрэв бид үнэхээр тэмцэхийг хүсэж байвал маяаг эсэргүүцэхийн тулд хамтдаа зүтгэх ёстой. Бидний хамгийн том дайсан бол маяагийн эзэн (адын эзэн), харин найз нөхөд маань бидний дайсан биш, авшигтнуудын тухайд бол бүр ч

хэлэлтгүй. Зөвхөн өөр шашинд итгэдгээс нь л болоод бид хүмүүсийг ад чөтгөр гэж, эсвэл ёс суртахуунгүй гэж хэлж болохгүй.

Хэрэв бурхны шашинтан католик шашинтантай хоорондоо зөрчилдөөнтэй, бурхны шашны тэргүүнүүд католик шашны тэргүүнүүдтэй зөрчилддөг бол бие биеийхээ давуу талаас сурч чадахгүй, хэрэв зөвхөн гүтгээд л байвал мэдээж нөгөө талд нь ч бас өөрийн гэсэн давуу тал байгааг олж харж чадахгүй. Хэрэв хоёр тал хамтрах хүсэлгүй, байнга зөрчилддөг бол энэ нь үл итгэгчдийг улам жигшүүлэх болно. Тэд аль хэдийнээс Бурханы шашинд ч итгэхгүй, Католик шашинд ч итгэхгүй байдалтай явж ирсэн бөгөөд одоо хоорондоо ийм байхаар яахыгаа мэдэхээ больж, итгэж ч чадахгүй болно.

Хятадад нэг ёгт үлгэр байдаг. Нэгэн өдөр дун хорхой хясаагаа дэлгээд наранд ээж байжээ. Түүнийг харсан дэглий шувуу урт хошуугаа сунгаад дун хорхойг идэхийг завдахад тэр хясаагаа хумьж, дэглий шувууны урт хошууг хавчиж гэнэ. Ингээд тэр хоёр тэмцэлдэж, нэг нь: “Би чамайг юм идүүлэхгүй. Тэгэхээр чи эрт орой хэзээ нэгэн цагт өлсөж үхэх болно.” гэхэд нөгөөх нь: “Чи ч бас маргааш өлсөж үхнэ.” гэв. Энэ үед хажуугаар нь өнгөрч явсан загасчин тэднийг хамтад нь шүүрч аваад торондоо хийн харьжээ.

Хэрвээ бид үргэлж бие биетэйгээ тэмцэлдвэл маяа үүнийг далимдуулж, харалган байдлыг нь ашиглан хоёуланг нь устгана. Ийм замаар бид Эзэн Бурхан, бурхны төлөө зүтгэхийн оронд эсрэгээр нь хийнэ. Бурхан, бодьсадва хэзээ ч бидэнд ялгаварлахыг заагаагүй. Есүс Христ, Лаоз, Күнз, ямар ч Их Багш бидэнд ялгаварлахыг заагаагүй. Бид Үнэн ёсыг ойлгодоггүй бөгөөд Үнэнийг ойлгож чадахгүй байна, тиймээс дэлхий хүмүүс одоог хүртэл амар тайвангүй, эсвэл эвлэлдэн нэгдэж чадахгүй хэвээр байгаа юм. Хэрэв хэн нэгэн гарч ирээд хүн бүрийг хамтарч нэгдэхийг уриалбал

бүгд түүнийг буруу номтон гэнэ, тэгдэг биз, тийм биш гэж үү?

"Усан хөвөөний шастир"–ын цаг үед хамаг төрөлтнийг сургахаар гарч ирсэн Төгс Гэгээрсэн Их Багш байгаагүй юм. Бүхэл бүтэн зохиолд хүмүүсийг бясалгал дадуулахыг, эсвэл сайн үйл хийхийг зоригжуулсан зүйл нэг ч байхгүй, бүгд л тэмцэл тулаан, атаа жөтөө, дарамт шахалт, хээл хахууль, бусдын хөрөнгийг хүчээр булаасан тухай л байдаг. Ёс суртахууны хувьд тун дорой байжээ. Тэр үед манай оронд Төгс Гэгээрсэн Их Багш хараахан мэндлээгүй байсан биз ээ. Учир нь улс бүхэнд Төгс Гэгээрсэн Их Багш төрөх хувь тохиодоггүй.

Их бясалгагч хүмүүс улс орон бүхэнд бий, ёс суртахуунтай хүмүүс ч их, бага хэмжээгээр байдаг. Тэр ч байтугай "Усан хөвөөний шастир"-ын цаг үед ч бас ёс суртахуунтай хүмүүс, бясалгалтай хүмүүс байсан, гэхдээ тэд хүмүүсийг сургахаар гарч ирэх нь тодорхойгүй байв. Саяхан ярьсан тэр Луо Жэнрэн ч ууланд нуугдан бясалгаж байсан. Хүмүүс шавь нарыг нь уулнаас бууж ирэхийг гуйхаар ирэхэд тэр явахыг нь зөвшөөрдөггүй байв. Учир нь цаг үе тун самуун байгааг болон хэдийгээр тэр хүмүүст сургасан ч олон хүнийг сургаж чадахгүй байгаагаа хараад зөвхөн цөөхөн хэдэн хүнийг хүлээн авч, ердөө хоёр, гуравхан шавьтай байжээ.

Улс орон бүхэн Төгс Гэгээрсэн Их Багштай байдаггүй. Төрөл тутамд Төгс Гэгээрсэн Их Багш маш цөөн байсан бөгөөд зарим цаг үед үгүй мэт санагдавч үнэндээ нэн ховорхон тохиож байжээ. Хэдийгээр тэд нуугдаж байсан ч хамаг төрөлтнөөс айдаг, хамаг төрөлтөн ирж, хөнөөхөөс айдаг байв. Амиа алдахаасаа айсандаа нуугдсан хэрэг биш, харин зааж сургаж амжилгүй хөнөөгдөхөөс айна, тэгэхээр ер нь сургах хэрэг байна уу? Ямар ч нэмэргүй! Хамаг төрөлтөн огт сонсож чадахгүй болохоор тэд нуугддаг. Энэ

нь тэд амьдралд хоргодсондоо биш. Тэд мянга мянган хувилгаан биетэй байж чадна, тэгвэл яагаад нэг махан биед хоргодсоор байх ёстой болов? Гэхдээ зарим Төгс Гэгээрсэн Их Багшийн үүрэг даалгавар маш бага байдаг. Тэдний үүрэг даалгавар арван хэдэн хүн, эсвэл цөөн хэдэн хүнийг сургахад л хангалттай. Тэд ууланд амьдардаг, тэнд уултай устай, амар амгалан уур амьсгалтай болохоор уулнаас бууж, хамаг төрөлтөнд гүтгэгдэж, дайруулж, үгүйсгэгдээд яах билээ?

Хүний цаана хүн, тэнгэрийн цаана тэнгэр

Ийм нэг түүх байдаг, зарим нь сонссон байх, гэхдээ би өнөөдөр дахиад ярья. Нэг хүн Лаозтай уулзахаар ирж, зөвлөгөө авахыг хүсжээ. Лаоз: “Та яагаад ийм олон хүн дагуулж ирэв?” гэхэд өнөөх хүн эргэж хараад: “Хэн ч байхгүй, би ганцаараа ирсэн.” гэв. Лаоз толгой сэгсэрсэн хэвээр: “Ийм олон хүн дагуулж яах нь вэ?” гэхэд өнөөх хүн ахин дахин эргэн харж, дотроо ихэд гайхан: “Энд нэг ч хүн алга, би яаж тийм олон хүн дагуулж ирж чадах вэ?” гэжээ. Лаоз: “Тэр олон хүн таны бодол санаанд байна.” гэжээ.

Тэр хүн өмнө нь олон багшаас сурч байжээ. Лаоз түүний жинхэнээсээ бясалгал дадуулах шийдвэр төгс гэхээсээ илүү дэлгүүр хэсэж, багш нар, сургаал ном цуглуулдаг атлаа бясалгах чин хүсэлгүйг нь тодотгон хэлсэн аж. Тэр хүн зүгээр л юм юмыг туршиж үзэхийг хүсдэг бөгөөд хүмүүстэй өдөржингөө маргаж мэтгэлцэхийг л боддог. Өөрийгөө хэдийнээ тун сайн, цаашид хэнээс ч суралцах шаардлагагүй гэж үздэг болохоор хаана ч очсон үнэн сэтгэлээсээ Зам мөрийг хайдаггүй, зөвхөн маргаж мэтгэлцэхийг л хүсдэг ажээ. Тэр юу ч яриагүй байсан ч гэсэн уураг тархинд нь тогтсон үзэл, ягшмал бодол дүүрэн байжээ. Тиймээс Лаоз: “Олон хүн дагуулж ирэх хэрэггүй.” гэж түүнд хэлсэн байна.

Багш нь ч бас олон ийм хүнтэй таарч байсан. Анхандаа

би эелдэг байдлаа хадгалж, дуугарахгүй байхыг хүсдэг ч заримдаа тэд намайг шахсанаас болж: "Та нарын бясалгал тийм ч сайн биш, билиг ухаан тань дутуу байна. Жүжиглэх гэж энд ирэх шаардлагагүй." гэдэг. "Би өөрийгөө их билиг ухаантай хэмээн өгүүлэх гэсэнгүй. Гагцхүү та нарын ухаарал хараахан гүйцэд болоогүйг мэдэж байна. Хэрвээ та ямар нэг зүйлийг мэддэг бол танаас ч ихийг мэддэг хэн нэгэн байж магадгүй." гэж аргагүй хэлэхэд хүрдэг. Хүний цаана хүн, тэнгэрийн дээр тэнгэр бий. Орчлон ертөнцийн билиг ухаанд эцэс төгсгөл үгүй, дэс түвшинд ч хязгаар гэж үгүй. Хүрч болох хамгийн дээд дэс байдаг гэж сонссон ч үнэндээ бол тийм зүйл оршдоггүй. Нэг дэс нь нөгөө дэсээс дээш байдаг ч хамгийн дээд дэс гэж байхгүй. Яагаад вэ? Учир нь орчлон ертөнцөд хэмжээ хязгаар гэж үгүй, ертөнцийг хэмжээлшгүй бөгөөд их билиг ухааныг бид төсөөлж ч чадахгүй, бидний эгэл оюун ухаан, эгэл систем, бие махбодоор хэмжиж чадахгүй.

Хэрэв оршихуйн хамгийн дээд дэс гэж байдаг бол, Багш биднийг "түүнд хэзээ ч хүрч үл чадна" хэмээн сэтгэлээр унан, ахин дэвших эрмэлзлээ алдахаас хамгаалан тайтгаруулсан хэрэг юм. Хэрвээ бид өөрийгөө хамгийн дээд дэсэд хүрчихлээ гэвэл тэр нь хараахан хамгийн дээд дэс биш байна, "Нэрлэж болдог нэр нь мөнхийн Нэр биш, Өгүүлж болох Мөр нь мөнхийн Мөр биш" гэж бид бүгд сонсож байсан, Лаозын хэлсэн энэ үгийн утга ийм юм. (*Бүгд алга ташив.*) Зам мөрийг олсон хүн "Би хамгийн дээд дэсэд хүрсэн." гэж хэлэх аргагүй, хэрэв хэлж чадвал тэр нь хамгийн дээд нь биш! Учир нь дэлхийн хэл яриа, дэлхийн ууриг тархи тэдгээр түвшнийг ойлгоход хангалтгүй. Дээд түвшнийг үг хэлээр илэрхийлж, дүрсэлж, тайлбарлах ямар ч боломжгүй.

Тиймээс бид хэрэв аль нэгэн номын багшаас суралцаж, Төгс Гэгээрсэн Их Багшийн билиг ухаанд хандъя

гэвэл үнэнхүү жинхэнээр номхон даруу, чин сэтгэлтэй байх ёстой.

Бид Бурхан, Бодьсадва, Эзэн Бурхан, Ванму ээж, Арьяабал бодьсадваг яаж хүндэлдэг шигээ Төгс Гэгээрсэн Их Багшийг тэгж хүндлэх шаардлагагүй. Бид тэгэх, ингэх шаардлагагүй, учир нь бид Төгс Гэгээрсэн Их Багшийг хэн болохыг хараахан мэдэхгүй байгаа, бас бид хүнийг тийм ихээр хүндлэх чадваргүй байж болно, гэхдээ ядаж л өөдрөг, гэгээлэг бодолтой байх хэрэгтэй, зөвхөн бие биетэйгээ чин сэтгэлээсээ, даруухан, илэн далангүй ярилцаж байж л бид ямар нэгэн зүйлийг олж авч чадна. Бидний мэдлэг хязгаарлагдмал бөгөөд орчлонгийн их, бага бүх зүйлийг ойлгохгүй хэвээр байдаг, тиймээс бардам байж болохгүй.

Хамаг төрөлтнийг гэтэлгэхэд хэцүү байдаг нь, бүгд л эрдэм мэдлэгт халхлагдсан байдгаас болдог, сурсан мэдсэн нь дэндүү их, уншсан судалсан судар ном нь асар олон тул өөрийгөө бүхнийг мэддэг гэж бодно. Харин Төгс Гэгээрсэн Их Багштай уулзсаны дараа суралцах аян замаа бүр эхлээ ч үгүй байгаагаа ухаардаг. (*Бүгд алга ташив*.) Төгс Гэгээрсэн Их Багштай уулзахаас өмнө бид өөрийгөө үнэхээр агуу гэж үзэж байсан байж магад, гэхдээ Их Багштай уулзах үедээ бидний дэс хэчнээн доогуур байгааг ойлгодог. Тэр үед зүрх сэтгэл жинхэнээр хоосорч, үнэхээр суух газаргүй, найдах газаргүй, итгэх зүйл ч үгүй болж, маш их төөрөлдөж, эргэлзэж, арчаагаа алдсан мэт санагдан юу хийхээ мэдэхгүй болно. Дээдийн ном сурах хамгийн сайн цаг бол бидний зүрх сэтгэл хүүхдийнх шиг гэнэн цайлган, цэвэр ариун болох үе юм. Тиймээс эртний Даяаны багш нар, Төгс Гэгээрсэн Их Багш нар шавь нараа маш хатуу сорьж шалгадаг байсан байна. Яагаад сорьж шалгадаг вэ? Учир нь энэ нь тэр шавиас өөрийнхөө дутагдлыг олж харахыг, таньж мэдэхийг, тэрээр хэр зэрэг эрхэм дээд ёс суртахуунтай болон хэр их тэсвэр тэвчээртэй юм, бүр тэсэж тэвчихийн аргагүй хүнд нөхцөл

байдалд ч хэр их номч сэтгэлтэй байж чадахыгаа ойлгохыг шаарддаг.

Хүний хорвоод буусан Тэнгэрийн од

Хэдийгээр "Усан хөвөөний шастир" тун аймшигтай зохиол гэлээ ч тэндээс суралцах хэрэгтэй зүйл олон байна. Бид тэр аймшигт хэргүүдийн тухай уншаад хожим ийм явдал хэрхэвч үйлдэж болохгүйг ухаарна. Энэ нь бас нэг төрлийн сургамж юм. "Усан хөвөөний шастир"-т Сун Жян бол Тянган одны дундаас хамгийн том од, бүх одны хаан, хамгийн том Тянь күй од юм. Тэр уг нь агуу их тэнгэрийн төрөлтөн, гэвч тийм ч сэтгэл сайтай байгаагүй, тиймээс тэнгэрийн хаан түүнийг шийтгэсэн нь дэлхийд сайн хүн байхад суралцуулахаар илгээсэн хэрэг ажээ. Хэдий тийм ч тэрээр хэцүү бэрхтэй тулгарч, хүмүүст хөөгдөөд нэгэн сүмд нуугдах хүртлээ өөрийн жинхэнэ уг байдлаа мэдэхгүй байв. Есөн тэнгэрийн Шюань Нү дагина түүнийг аврахаар гарч ирэн: "Та энэ дэлхийн хүн биш, та бол оддын хаан. Зарим нэг шалтгааны улмаас мөнх бусын энэ ертөнцөд цөлөгдсөн бөгөөд та заавал сайтар бясалгаж байж л диваажин луугаа буцаж чадна." гэж түүнд хэлжээ. Тэр хувилгаан дагинын хэлснийг Сун Жян сонссоныхоо дараа ч ойлгосонгүй. Дагина түүнд бясалгаж дадуулах гурван боть Тэнгэрийн судар өгсөн боловч тэр үүнийг зүүд гэж боджээ.

Гэсэн хэдий ч энэ зүүд маш үнэн бодитой байсан, Сун Жяны сүнс болон сүнсэн биеийг нь хувилгаан дагина дээш аваачиж, гай зовлонгоос зайлуулж, дараа нь дахин биед нь буцаажээ. Гэхдээ тэр үед Сун Жян махан биеэрээ яваагүй юм. Сүнсэн бие бол чөлөөтэй ирж, очиж чаддаг бөгөөд ямар ч үед явах, ирэх нь чөлөөтэй байдаг гэдгийг бясалгадаг хүн ойлгоно. Дээд тэнгэрийн хувилгаан дагина яг л сүмийн арын хашаанд амьдардаг мэт тийм ойрхон байжээ, гэвч дараа өдөр нь түүнийг хайгаад олсонгүй. Үүнээс үзэхэд хүний хорвоод ч бас диваажин байдаг бөгөөд хувилгаан дагина сүмийн

ард амьдардаг гэдэг нь ч бас буруугүй, гэвч эгэл жирийн хүмүүс түүнийг харж чадахгүй, хэрвээ тэр өөрөө л хүмүүст харагдахыг хүсэхгүй бол хэн ч түүнийг олж харж чадахгүй.

Энд диваажин ч бий, там ч бий, нирваан ч бий, Баруун зүгийн Төгс баясгалант орон ч бий гэж сонсдог хэдий ч бид хайж олж чаддаггүй, учир нь эгэл хүний чадвар хязгаарлагдмал байдаг, гэхдээ арш хувилгаадын дэс биднээс үлэмж илүү өндөр. Шюань Нү дагина Сун Жянд жинхэнэдээ хэн болохыг нь хэлж өгсөн ч тэр бас итгээгүй, өдөржингөө дайн байлдаан хийгээд өөрийн агуу байдлыг ухаарч ойлгоогүй бөгөөд цаг нь болоогүй бол бас тийм ихийг мэдэж чадахгүй. Тэр ч байтугай түүнд хэн нэгэн нь түрүүлж илчилсэн ч тэр ямар ч ялгаа мэдрээгүй, би бол эгэл жирийн хүн гэж итгэсээр байсан, учир нь түүнд төлөх үйлийн үр, хийх ёстой ажил, сурах ёстой хичээл байсаар байгаа хэрэг.

Хималайн ууланд байдаг зарим хүн хэдэн мянган жилийн настай гэж сонссон, та нар сонссон уу? (*Сонссон гэж нэг хүн хариулав.)* Та үүнд итгэдэг үү? *(Итгэдэг гэж хариулав*.) Хараагүй зүйлдээ итгэх нь мухар сохроор сүсэглэж буй хэрэг. Гэвч үнэхээр ийм явдал бий. Тэд бол агуу их бясалгагчид бөгөөд Зам мөрийн олон эрдэмд гүн нэвтэрсэн байдаг. Биднээс ялгаатай нь тэд урт наслахын тулд махан биедээ түшиглэдэггүй. Тэднийг олон мянган жил амьдрах чадвартай гэж сонсоод Хималайн ууланд очвол тэднийг харж чадна гэж бид боддог. Гэвч үнэндээ, бид тэдний өмнө нь очсон ч харж чадахгүй, учир нь тэдний бие махбод биднийхтэй адилгүй, хэлбэлзэл нь маш нарийн, эгэл хүнийх шиг бүдүүн бараг биш. Хэрвээ тэднийг харахыг хүсвэл бид өөрсдөө жирийн хүн байх ёсгүй, эсвэл зөвхөн тэд бидэнд харагдахыг хүссэн тохиолдолд л бид харж чадна.

Яг л дээд тэнгэрийн хувилгаан дагина шиг, тэрээр өөрөө харагдахыг хүссэн учраас Сун Жян түүнийг харж чадсан, гэхдээ ганцхан удаа харжээ! Учир нь Сун Жянд тэр

өдөр гай зовлон тохиолдсон тул хувилгаан дагина түүнийг зовлонгоос гарахад нь туслахыг хүссэн бөгөөд гурван боть Тэнгэрийн судар өгөхийн тулд түүнд харагдсан байна, эс бөгөөс Сун Жян түүнийг харах боломжгүй юм. Уг нь тэр хоёр найзууд байжээ. Сун Жян дээд түвшнээс унаж ирсэн болохоор дагина түүнийг харж харгалзан гэртээ хурдан харихад нь туслахаар газар дэлхийд бууж ирсэн байна. Бид өөрсдийгөө Эзэн Бурхан, бурхан, бодьсадва диваажингийн орныг ихэд санан дурсдаг гэж боддог, үнэндээ бол бурхан, бодьсадва биднийг бүр ч илүү их санаж, Эзэн Бурхан биднийг бүр илүү хүчтэй санан дурсаж байдаг. Тийм ч учраас бид бурхан, бодьсадва хувилгаан биеэрээ тоост хорвоод заларч, биднийг аварч, гэтэлгэдэг гэж үргэлж сонсож байдаг. Яагаад вэ? Учир нь бид чин сэтгэлээсээ залбирч даатгах үед тэнгэр, газрыг уяраана, бурхад, бодьсадваг уяраана, тиймээс биднийг аврахаар хүмүүсийг илгээдэг байна.

Өөр өөр үүрэг хариуцлага

Багш нь сая "Усан хөвөөний шастир"-т гардаг маш харгис хэрцгий Ли Күйгийн тухай ярьсан. Тэрээр Луо Жэнрэнийг цавчиж хоёр хэсэг болгохыг завддаг, та нар санаж байна уу? Луо Жэнрэн ч түүнийг эгэл хүн биш гэдгийг мэднэ. Тэрээр Ли Күй бол дээгүүр ертөнцийн тэнгэрийн алуурчин од төрөл аван бууж ирсэн бөгөөд тэнгэрийн хаан түүнийг хүмүүсийг алуулахаар томилсон гэдэг байв. Учир нь дэлхийн хүмүүсийн ёс суртахуун доройтон муудаж, дэндүү олон муу үйл үйлдэх болсон тул тэнгэрийн хаан Хар хуй салхи Ли Күйг газар дэлхий рүү илгээжээ. Хэдийгээр тэр маш харгис, хүмүүсийг галзуу юм шиг л хүйс тэмтэрч байсан ч энэ нь түүний үүрэг даалгавар байв.

Энэ бол үнэн. Зарим хүн, хамаг төрөлтнийг үй олноор хөнөөх даалгавартай томилогдож ирдэг. Энэ бол бодит үнэн. Тийм хүмүүсийг Багш нь магтан сайшаадаггүй, хүн алахгүй байх нь хамгийн сайн. Гэхдээ бүтээн хувирахуйн эргэлтэд

бид дэндүү их хутгалдаж ч чадахгүй. Хэдийгээр зохиолд гарч буй хүн амины хэргүүдэд бид дургүй ч тэдгээрийг шүүн тунгаагаад муу зүйл хийхээс болгоомжлох хэрэгтэй. Ингэвэл ял шийтгэлтэй нөхцөл байдлаас зайлсхийж чадна.

Бид өдөржингөө бусдыг зэмлэн буруутгаад байх биш, өөрөө хэр сайн бясалгаж байгаагаа харах ёстой. Урьд төрөлдөө сайн үйл хийгээгүйгээс болоод энэ төрөлдөө муу хувь тавилантай болсон байж магадгүй. Хэрвээ одоогийн хувь заяа тань сайн байлаа ч гэсэн бас хичээнгүйлэн бясалгах хэрэгтэй. Ингэж байж л сая үргэлжлүүлэн сайн нөхцөл байдалтай байж чадна. Хэрвээ одоогийн байдал тань тааруу бол илүү их хичээж бясалгах хэрэгтэй. Ингэж байж л сая үйл түйтгэрээ өөрчилж чадна.

Ли Күй хүн алах тун дуртай, ах дүүгээ хамгаалахын төлөө ёс суртахуун сайтай хүнийг ч ална. Үнэнч байдлыг нь бас магтаж болох ч хорон муу зан нь түүнийг там руу илгээх болно.

Эгэл хүмүүс сайн, мууг ялгаж чадахгүй ийм л байдаг. Хэрэв ямар нэг зүйл тэдний хүссэнээр болохгүй бол түүнээс салахыг боддог.

Дорнын хүмүүс зурхайд дуртай, хэрвээ зурхайч надад та өмнөх төрөлдөө тэнгэрийн арш, бодьсадва, тэнгэрийн элч, эсвэл долоон бурхан од, өмнөдийн их од байсан, одоо газар дэлхийд бууж иржээ гэвэл бидэнд их л бахархалтай санагдана. Гэхдээ бид бодьсадва, тэнгэрийн элч байж болох ч хэрэв бясалгадаггүй бол бүдүүлэг, харгис хэрцгий, сайн, мууг ялгах хангалттай билиг ухаангүй байж, сайн зүйлийг ч устгах болно, яг л Ли Күй шиг. Тэр Луо Жэнрэнтэй ямар нэг гүн гүнзгий өс хонзонгүй, зүгээр л ах, дүүгээ хамгаалахын төлөө нэгэн сайхан сэтгэлтэй, ёс суртахуунтай, хүч чадалтай сайн хүнийг хөнөөдөг. Хэдийгээр Луо Жэнрэнийг алж чадаагүй ч түүний үйлдэл, бодол санаа нь дэндүү харгис

байсан тул их бясалгагч хүмүүн түүнийг гурав хоног шоронд хорьж шийтгэхээс аргагүй болжээ, дараа нь тэр гэмшээд жаахан засарсан байна.

Хүн бүхэн Бодьсадва байх боломжтой

Энэ зохиолоос бид хүн бүхэн бодьсадва байх боломжтой гэдгийг ойлгож болно. Шагжамуни Бурхан: "Төрөлтөн бүхэн Бурхан чанартай." гэсэн, Есүс Христ: "Бид бүгд Эзэн Бурханы хүүхдүүд." гэжээ. Гэтэл бид яагаад заримдаа уурлаж, маш харгис хэрцгий, заримдаа нэлээд ёс журамтай, ёс суртахуунтай болдог вэ? Энэ бүхэн бид жинхэнэ Дээдийн номын цогцсын бясалгалын аргаар бясалгаагүй, өөрсдийгөө сайтар сургаагүй, ад чөтгөрийн зан чанараа дарж чадаагүй, бурхан, бодьсадвагийн зан чанараа хараахан бүрэн хөгжүүлээгүйгээс болдог. Тиймээс сайн үйл хийх, улс орноо хамгаалах, дэлхий дахинд амар амгаланг авчрах нь хангалттай биш юм.

Күнз сургахдаа: "Хүн өөрийгөө хөгжүүлж, гэрээ эмхлэн төвхнүүлж, улмаар төрөө төвшитгөвөөс сая дэлхий дахин амар амгалан болно." гэж айлджээ.

Бид өдөр бүр "Зам мөр ёсны судар" (Жам ёсны судар), Күнзийн "Хэв дундын ёсон", "Их суртахуй" зэрэг сургаал, мөн *("Дөрвөн ном" Ярианы ном, Их суртахуй, Мэнзийн сургаал, Хэв дундын ёсон)*-ыг уншиж судалдаг ч түүнийгээ бодитоор хэрэгжүүлж чаддаггүй. Түүний гол шалтгаан нь бясалгадаггүй учраас "Зам мөр ёс" гэж чухам юу болохыг жинхэнэ утгаар нь ойлгож амжаагүй байдаг. Зам мөрийг үгээр бүрэн илэрхийлж үл чадна. "Өгүүлж болох Мөр нь мөнхийн Мөр биш" хэмээх утга учрыг бид өөрсдөө олж хүртээгүй тул, сэтгэл санаа ганцаардмал, өөрийгөө хянах чадвар сул хэвээр үлддэг.

Хэрвээ хүн угаасаа төгс төгөлдөр байсан бол Лаоз

“Зам ёс”-ыг бясалгахыг онцлохгүй, Күнз: “Хүнлэг ёс, шударга ёс, ёс журам, билиг ухаан, итгэл үнэмшил”-ыг чухалчлахгүй, Шагжамуни Будда “Зургаан билиг барамид”-ыг айлдахгүй, Есүс Христ “Арван сахил”-ыг сургахгүй байх байсан. Библи судраас бидний уншдаг Есүс Христийн “Уулан дээрх номлол” нь Бурханы шашны бодьсадвагийн сахил, түүний зам мөр, үйл хэрэгтэй гүн утгаараа ижил төстэй юм.

Яагаад бид хэрэгжүүлж чаддаггүй вэ? Учир нь бид “Зам ёс”-ыг олоогүй, дотоодын Бурханы орноо олоогүй, Бурхан чанараа таниагүй байна. Судар, ёс суртахууны ном уншихад л хангалттай байсан бол Шагжамуни Будда өдөр бүр бясалган сууж, самади агуулж, диваажинд хүрч, тамд очиж, хүмүүсийг аврах хэрэггүй байсан. Хэрвээ Библи судар уншаад болчихдог байсан бол Есүс Христ цөлд дөч хоног бясалган сууж, дөч хоног мацаг барьж, элсэн цөлд ганцаараа өөрийгөө ариусгаж, бие, хэл, сэтгэлээ цэвэршүүлсний дараа бусдыг гэтэлгэхээр явах шаардлагагүй байсан. Хэрвээ “Зам мөр ёсны судар” унших нь хангалттай байсан бол өнөөг хүртэл их бясалгагчид, их арш нар ууланд сууж бясалгах хэрэггүй байсан. “Зам мөр ёсны судар”-ыг уншихад л хангалттай байсан бол яагаад өглөө босон нарыг ажиж, шөнө сарыг харах хэрэгтэй байх вэ? Яагаад дан (алт) шүүрүүлж, эмийн ургамлыг судалж, чигийн дасгал хийж, гол (ду, жэн) хоёр судлыг нээх хэрэгтэй байдаг вэ? Тийм үү? Үүнээс бид судар ном бол гаднах сургаал, бясалгал бол дотоод сургаал болохыг ойлгож чадна. Дотоод болон гадаад тэнцвэржих нь сая “Зам мөр ёс” мөн. *(Бүгд алга ташив.)*

Тэгэхгүй бол Шагжамуни Бурхан таалал төгссөний дараа Түүний шавь нар олон мянган судрыг нь эмхэтгэсэн байтал яагаад Махакашиб Дээдийн ном уламжлах ёстой хэвээр байв? Яагаад Ананд Дээдийн ном уламжлах ёстой хэвээр байв? Бас Бодьдарма, Зургаадугаар үеийн Өвөг

Багш Хүй Нэн, Хуанбо, Байжан (Хуайхай) Их Багш гэх зэрэг хүмүүс Дээдийн ном уламжлах ёстой байжээ. Хэрвээ судар ном уншвал л хангалттай байсан бол Тэд хүмүүсийг Тэднийг даган алхам алхмаар суралцуулахын тулд ууланд очуулж, өөрсдөдөө болон бусдад төвөг удах хэрэг байсан уу? Ойлгож байна уу? Та нар санал нийлж байна уу? (*Бүгд алга ташив*.) Тиймээс Багш нь ямар ч шинэ зүйл заагаагүй, судар номд байгаа зүйлсийг л заадаг. Багш нь зөвхөн яагаад заавал бясалган суух ёстой, яагаад гэгээрэх ёстой, яагаад их билиг ухааныг олж авах ёстойг бүгдэд тодорхой тайлбарладаг.

Энэ "Зам мөр ёс"-ыг олсны дараа буян бүхэн жамаараа ирнэ. Лаоз хэлэхдээ: "Зам мөр ёс" байхгүй бол буянт үйлийг бүтээх шаардлагатай, "Зам мөр ёс" байвал бүх юм байж байдаг. ("Зам мөр ёсны судар" гучин есдүгээр бүлэг: Урьд нь Нэг (Зам мөр)-ийг ологсод Мөр ёсыг олсон эртний цагт хүний ухаан саруул болохын тулд Тэнгэр диваажин түүнийг түшдэг, амарч тайван байхын тулд газар дэлхий түүнийг тэтгэдэг, сүнс төгөлдөр байхын тулд бурхад түүнийг ивээдэг, урган цэцэглэхийн тулд тал хөндий түүнийг дэлгэрүүлдэг, амьдрахын тулд эд зүйлс түүнийг даган оршдог, хорвоо ертөнцийг мэргэн цэцэн болгохын тулд хаад ноёд түүнийг хэрэглэдэг байжээ.)

"Зам мөр ёс" гэж юу вэ? " Зам мөр ёс" гэдэг нь дотоодын гэгээрэл, дотоодын их билгүүн ухаан, дотоодын бүхнийг чадагч хүч юм. Бидний хүн нэг бүрд бүхнийг чадагч хүч бий бөгөөд үүнийгээ гаргаж хэрэглэхгүй бол дэндүү харамсалтай, тэгснээрээ өөрийгөө өчүүхэн жижиг, сул дорой, өнчин ганцаардмал, арчаа муутай, хүч чадалгүй хэвээр байлгадаг. Шагжамуни Бурхан Зам мөрийг олсон учраас тийм агуу их хүч чадалтай, агуу их шидтэй, үй түмэн хувилгаан биетэй, оршихгүй газаргүй, там, диваажинд зорчих нь бусад хүн хүнсний дэлгүүр хэсэхтэй л адил тийм амархан болсон юм.

Лаоз “Зам мөр”-ийг олсон учраас одоо ч алдар цуутай. Олон улс оронд Түүний “Зам мөр ёсны судар” байгаа ч дотоод нууцад нь нэвтэрч чадаагүй л байна. Учир нь тэд дотогшоогоо хандаж “Зам мөр ёс”-оо хайгаагүй болохоор мэдээж “Зам мөр ёсны судар”-т юу өгүүлснийг, Лаозын жинхэнэ санаа юу болохыг ойлгож чадахгүй байгаа юм. Хэрвээ бид “Зам мөр ёс”-ыг бясалгаж, ” Зам мөр”-ийг олбол яг Лаозтай адилхан болох бөгөөд өөрсдөө нэгэн “Зам мөр ёсны судар”-ыг бичиж чадна, магадгүй агуулга нь бүр ч илүү сонирхолтой байж мэднэ. Энэ нь бид Лаозаас илүү гарамгай гэсэн хэрэг биш, харин бид одооны хүмүүсийн үг хэлээр бичиж чаддаг болохоор хүмүүс ойлгож, хүлээн авахад нэлээд хялбар болгоно.

Есдүгээр бүлэг

ТҮҮХЭЭР БАГШЛУУЛАХУЙ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ-ын Калифорни муж, Лос-Анжелес хот
1996 оны 3 дугаар сарын 14.
(Эх нь англи хэлээр)

Билиг ухааны эрдэнэсийн сангаа танихуй

Бид сүнслэг бясалгалын хүчээрээ маш олон зүйлийг өөрчилж чадна. Үүнийг бүгд мэднэ. Тэр байтугай сүнслэг бясалгалын дээд дэсэд хүрээгүй зарим лам цаг агаарыг өөрчилж чаддаг. Бидэнд ингэх шаардлага байхгүй. Биднийг шаргуу бясалгаж байх үед аливаа зүйл бидний хүсэл эрмэлзлийн дагуу өөрчлөгдөж болно. Энэ л хамгийн зөв. Энд, Калифорнид хүмүүс Арьяабалын бясалгалын аргыг дадуулах болсноос хойш, миний бодлоор, одоо хамгийн олон авшигтантай газар болсон байна, мөн би энд байнга ирдэг болохоор цаг агаар тэр цагаас хойш улам сайжирчээ.

Энэ нь санамсаргүй тохиолдол ч байж магадгүй, гэхдээ энэ сайн давхцал шүү! (*Бүгд алга ташив.*) Тиймээс би үүнийг маш сайн гэж бодож байна. Бид газар бүхнийг өөрчилнө. Хэрэв бид Арьяабалын бясалгалын аргыг дадуулбал юм бүхэн өөрчлөгдөх болно гэдэгт би итгэлтэй байна.

Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийн тухай түүх байдаг, Тэрээр янз бүрийн улс оронд очиж ном тайлж явдаг байв. Нэг шавь нь Багшийнхаа аяллын замыг тэнгэрийн нүдээрээ шалгаад газрын зураг дээр тэмдэглэн түүний очих газрыг мэджээ. Дараа нь тэр орны шавь нартай нийлж нягтлаад Багшийнх нь очсон газар бүхэн бороотой байсныг олж мэдсэн байна. Тухайн орны цаг агаар их хуурай, яг Энэтхэг шиг, заримдаа бороо хур хангалтгүй байдаг. Гэвч тэр Их Багшийн очсон газар бүхэнд бороо дагаж явсан байв. Түүний явах замыг борооны усаар угаах мэт. Үнэхээр гайхалтай! Тэр шавь "харсан"-ыхаа дараа тэндхийн авшигтнуудтай нийлэн шалгаж үзэхэд үр дүн нь түүний үзсэнтэй яг адилхан байжээ.

Арьяабалын бясалгалын арга үнэхээр сэтгэгдэшгүй! Энэ тэнсэлгүй дээд бясалгалын аргыг дадуулаад олсон ач тус дуусахгүй, бүгдийг нь ярихын аргагүй. Заримдаа би үүнийг дэлхийн бүх хүн мэдээсэй гэж хүсдэг, гэвч бид тэвчээртэй байх ёстой. Хэрвээ та нар намайг хангалттай тэвчээргүй гэж бодож байгаа бол дахин бодож үзсэн нь дээр байх, учир нь хангалттай тэвчээргүй бол би ийм зүйлийг тэвчиж чадахгүй, ийм гайхамшигтай бясалгалын аргыг, бүхнийг чадагч ханьцашгүй их хүчийг хүмүүс үл хайхрах атлаа зовлон зүдгүүр дунд амьдрахыг нь би тэвчихийн аргагүй юм. Тэд өдөр бүр Эзэн Бурханд залбирч, өчүүхэн жаахан буян гуйгаад өөрийнх нь дотоодод юм бүхэн байгааг мэдэхгүй байдаг.

Соёл иргэншлийн оргил үе, олон удаагийн дайн

Олон мянган жилийн өмнө гайхалтай сайхан зүйлс байсан тухай өгүүлэх нэгэн түүхийг ярья. Зөвхөн одоо ч биш, эрт дээр үед маш өндөр хөгжилтэй соёл иргэншил олон байсныг бид үүнээс мэдэж болно.

Эртний соёл иргэншлүүд нь ямар нэгэн байдлаар дайнаас, магадгүй Оддын дайн, эсвэл гараг хоорондын дайн, эсвэл нутаг нэгтнүүд харилцан хөнөөлддөг дотоодын дайн зэргээс болж устаж сүйрснийг түүхийн баримт болон судалгааны тайлангуудаас бид мэднэ.

Учир нь соёл иргэншил бүр дээд оргилдоо хүртэл хөгждөг, хэрвээ тухайн нийгмийн хүмүүс өөрийгөө хянах дотоод хүч чадлаа хадгалахгүй, шинжлэх ухааны мэдлэгээ илүү ухаалгаар ашиглахгүй бол асуудал үүснэ. Хамгийн шинэ нээлт бүтээлийн төлөө өөр хоорондоо өрсөлдөж, бусад улс үндэстэн, газар нутаг, эсвэл бусад гаргуудыг хянаж эрхшээлдээ оруулахыг санаархсанаас дайн дэгддэг. Тэгээд дайн дуусахад бүх зүйл юу ч үгүй болно.

Энэ бол хүн төрөлхтөнд оршин байгаа асуудал юм, бид ерөөс сургамж авдаггүй. Бидний одоогийн энэ дэлхийг хар, олон улс орон энэ сургамжийг аваагүй л байна. Дайнд орох болгондоо улс орон нь дампууран ядуурч, урт хугацааны туршид сэхэж сэргэхгүй, сул дорой хэвээр байх болдог. Улс болгоны удирдагчид дайны хор хохирлыг сайн мэддэг хэдий ч өөрсдийнхөөрөө зүтгэсэн хэвээр байж, энх тайвныг үл эрэлхийлнэ. Заримдаа тэд бусад улс орныг зөвхөн айлган сүрдүүлэхийг санаархдаг. Гэвч төлөвлөгөө нь бүтэлгүйтвэл яах вэ? Хоёр тал бие биеэ буруугаар ойлгоно. Өчүүхэн явдал нь их гамшиг үүсгэн зогсоох аргагүй болж, дахин дайн эхэлж, хүн төрөлхтний соёл иргэншил хоромхон зуур үгүй болж мэднэ, яг л саяхан олж илрүүлсэн Атлантын далайд живсэн эртний Атлантис хот шиг, эсвэл эртний харь гаргийн хүн гэгч шиг.

Бид: “Хөөх! Тэд өмнө нь яаж ийм иргэншсэн байсан юм бэ?” гэж бодно. Тийм ээ, тэд урьд нь соёлжингуй байсан, магадгүй одоогийн биднээс ч илүү соёлжингуй байсан байх. Тэр ч байтугай Библи сударт Лотын эхнэрт тохиолдсон явдлыг тэмдэглэсэн байна. Тэр эргэж харах үедээ давсан багана болон хувирчээ. Энэ нь хүмүүсийг “химижүүлж” чадах химийн нарийн зэвсгийн нөлөө юмуу, атомын бөмбөг маягийн зүйл дэлбэрсний үр дагавар мэт харагдаж байна, тэр нь тэднийг үнс болгон шатаахад дараа нь яг давс шиг болчихдог байна. Тиймээс өмнө нь ч бас маш олон дайн болж байсан бөгөөд мэдээжийн хэрэг маш олон нээлт, шинэ бүтээл байсан нь магадгүй бидний одоогийнхоос илүү дэвшилттэй байжээ. Тийм учраас бид одоо байгаа зүйлүүддээ хэт бардамнах хэрэггүй, эсвэл шинжлэх ухааны багаж хэрэгсэл гэх зэргийн түр зуурын зүйлсэд хэтэрхий найдах хэрэггүй. Гэвч хүмүүс үргэлж л ийм байсаар ирсэн, шинэ нээлт хийх бүртээ өөрсдийгөө агуу хэмээн боддог, дараа нь бүхнийг устгана, тэгээд дахиад л АБВ-гээс нь эхэлнэ.

Одоо би та бүхэнд, магадгүй, үүний жишээ болох нэгэн түүх уншиж өгье. Энэ явдал Хятадад болсон, Хятад хүмүүс орчин үеийн олон тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хамгийн анхны зохион бүтээгчид юм. Мэдээж тэр үед арай болхидуу, эсвэл маш энгийн хэлбэр бүтэцтэй байсан байх. Тэд дараа нь улам боловсронгуй болгосон, эсвэл европчууд болон америкчууд тэднээс санаа авч, улмаар илүү соёлтой, боловсронгуй болгосон байна.

Жишээ нь, хятадууд шинэ жилээр буудуулж, баярын сэтгэгдэл төрүүлэн хүн бүрийг баярлуулахын тулд салютыг зохион бүтээсэн. Нэг талаар чөтгөр шуламсыг зайлуулах, эсвэл гэрлэх ёслол гэх зэрэг амьд, баяр баясгалантай үйл явдлуудыг тэмдэглэхэд бас ашигладаг. Гэхдээ та бүхэнд сануулж хэлэхэд хятад хүн ямар ч үед салют буудуулах тун

дуртай. (*Бүгд инээв.*) Хэн нэгнийг нас барахад буудуулна, гэрлэхдээ буудуулна, сэтгэл санаа тавгүйтвэл буудуулна, баярлавал бас л буудуулна. Төрсөн өдрөө тэмдэглэхдээ буудуулна, бас Чин Хайн өдрийг тэмдэглэхдээ ч бас буудуулна. (*Бүгд алга ташив.*) Багшийн төрсөн өдөр, эсвэл Чин Хайн өдрөөр та нар үүнийг зөндөө олон удаа сонссон. Тэдний гаргах элдэв янзын дуу чимээ нь бидний чихийг дүлийрүүлэх шахдаг. Тэд үүндээ дуртай, гон, бөмбөр цохиж нүднэ, тас тас дэлбэрэгч буудуулна, би ч одоо бүр дасчихжээ.

Салютыг хятадууд хэдэн мянган жилийн өмнө зохион бүтээсэн бөгөөд зөвхөн баярлан цэнгэлдэх үедээ хэрэглэдэг байв. Хожим нь европчууд ирснээр түүнийг хүн алахад хэрэглэх болжээ. Ингэж анх буу бий болсон түүхтэй. Хамгийн эртний буу шийдэм нь хятадуудтай байлдахад зориулагдсан байв. Өмнө нь Хятадад буу байгаагүй, хамгийн анх европчууд бууны сумны дарийг хятадуудын тас тас дэлбэрэгч хийх аргаас олж мэдээд буцахдаа дарь худалдан авч явжээ. Тэгээд хожим нь түүнийг сайжруулан буу болгосныгоо эргүүлээд хятадуудад худалдсан байна. Тэр үед Хятадын хамгийн анхны их буу, тэсрэх бөмбөгтэй зэр зэвсэгтэй болсон хаан нь хамгийн хүчирхэг байлдан дагуулагч болсон юм. Тиймээс яг үүн шиг, анх зохион бүтээгдэхдээ ямар ч хор хөнөөлгүй, хүүхэд тоглоход зориулагдсан зүйл байснаа хожим хэн нэгэн нь хүмүүсийг хөнөөхөд ашиглах болсон байна.

Мөхөөлдөс болон бусад олон зүйлийг ч мөн хятадууд зохиосон. Тиймээс европчууд анх Хятадад ирэхдээ яг л шидэт үлгэрт гардаг шиг ийм үзэсгэлэнтэй сайхан орон байдагт ихэд гайхаж байв. Гэхдээ юмс нэг иймэрхүү байдаг, гоо үзэсгэлэн заримдаа араатныг өөртөө татаж, маш их зовлон авчирдаг. Тиймээс би та нарт яаж хэлэхээ мэдэхгүй байна. Хэрвээ танд гоо үзэсгэлэн, авьяас чадвар, мөнгө төгрөг гэх зэргийн олон зүйл байвал бусад хүн атаархаж магадгүй,

заримдаа энэ нь таны зовлон бэрхшээл, золгүй байдлын эх үүсвэр болдог. Тэгэхээр би та нарыг ядуу зүдүү амьдар гэж хэлэх үү, эсвэл зүгээр л мөнгө төгрөг, иймэрхүү зүйлд санаа тавилгүй энгийн амьдар гэж хэлэх үү? Тэгвэл дараа нь та нарын амьдрал тухгүй болно, ялангуяа Америкт Хималайн ууланд байгаа мэт явган явбал та нар өлсөж үхнэ, учир нь хамгийн ойрын супермаркет хүртэл машинаар наанадаж гурван цаг давхих хэрэгтэй байдаг. Тэнд бүх зүйлийг цагаар тооцдог!

Хаанд өргөсөн бэлэг - хүн робот

Хятадад Жоугийн Му ван хэмээх нэгэн хаан байжээ. Тэрээр ойролцоогоор хоёр мянга таван зуун жилийн өмнө оршиж байсан Байлдаант улсын үеийн нэг хаан юм. Тэр нэгэн удаа гөрөөлөхөөр явжээ. Ихэнх хаан уйддаг, хийх юмгүй болохоор яваад амьтан ална. Үнэхээр аймшигтай! Хэрэв хүн алахгүй бол ан амьтан алдаг. Тэд цаг үргэлж хэрхэн дайтахад өөрсдийгөө бэлтгэнэ. Анхнаасаа л буруудсан хэрэг, тиймээс Хятадын түүх бараг л дан ганц дайны түүх мэт болсон байна, өөрсдөө дотроо дайтахгүй бол хөрш оронтойгоо дайтна, эсвэл тэд явж ан амьтантай дайтна.

Энэ хаан ч бас адилхан. Тэрээр хаа нэгтээ ууланд очиж ан хийжээ. Тэр уулыг Яньшань уул гэнэ. Ан хийж дуусаад ордон руугаа буцах болов. Гэртээ харих замд нь хэн нэгэн түүнд өргөл өргөсөн нь эд зүйл бус, харин төгс төгөлдөр ур чадвартай нэг дархан байжээ. Түүнийг дархан Яньши гэнэ. Хаан тэр дарханыг дуудаж ирүүлээд: “За, чи ямар ур чадвартай вэ” хэмээн асуухад хаанд өргөл барьц болж ирсэн тэр Яньши ингэж хариулав. “Эрхэм дээдэс ээ, таны хий гэсэн бүхнийг би хичээнгүйлэн хийх болно. Гэхдээ би өмнө нь нэгэн машин зохион бүтээсэн. Тэр машин бол хүн-робот. Хэрвээ хаантан таалбал танд өргөл болгон мэлмийг тань баясгая. Эрхэм дээдэс болгооно уу.” гэв.

Хаантан: “Мэдээж, тэгэлгүй яах вэ, маргааш түүнийг надад үзүүлэгтүн.” гэв. Маргааш нь Яньши хүн-роботыг хаанд үзүүлэхээр ирэхэд Хаан ихэд гайхан дархнаас: “Чиний ард яваа хүн хэн бэ?” гэхэд дархан тэр бол миний зохион бүтээсэн хүн-робот гэжээ. Харж байна уу? Энэ нь үнэхээр амьд мэт байсан тул хаан хүртэл хэн нэгэн хүн түүнийг даган явж байна хэмээн хуурtсан байна. Одоогийн хүн-робот ч гэсэн тийм адилхан байж чаддаггүй шүү дээ. (*Бүгд инээв*.) Тэднийг харьцуулах боломжгүй!

“Гурав дахь төрлийн дотно уулзалт” гэдэг кинонд гардаг хүн-робот яг гэрийн тоос сорогч шиг хавтгай байдаг, хүнтэй огтхон ч төсгүй тул биднийг хуурч дөнгөхгүй. Гэтэл энэ дархан 2500 жилийн өмнө хүнээс өчүүхэн ч ялгагдахгүй хүн-робот бүтээж байжээ. Мэдээж бусад гараг дээр ч бас ийм нээлтүүд түгээмэл байсан, би энэ талаар зөвхөн сонсож байсан төдий.

Энэ хүн-робот жинхэнэ хүн шиг харагдаж байв, хаан эзэн ихэд гайхан цочирдож, тэр хүн-роботыг ширтсээр байлаа, хүн-робот алхана, гүйнэ, бас яг л хаан болон их түшмэдэд бид мэхийн ёсолдог шиг хаанд мэхийн ёслов. Түүний үйл хөдлөл бусадтай адил, жинхэнэ хүнтэй яг адилхан байжээ.

Тэгэхээр энэ дархан, энэ зохион бүтээгчийг бид эрдэмтэн гэж хэлж бас болно. Тэрээр хүн-роботын эрүүнд хүрмэгц дуулж эхлэв, дуу хоолой нь маш уянгалаг бөгөөд цэвэр тунгалаг байлаа. Дархан түүний гарыг өргөхөд тэрээр маш чадварлаг бүжигчин шиг маш хэцүү хөдөлгөөнтэй, нарийн төвөгтэй бүжгийн хөдөлгөөн хийн бүжиглэж эхлэв. Үүгээр ч зогсохгүй тэрээр маш чадварлаг, авьяаслаг, сайтар сургагдаж бэлтгэгдсэн хүн шиг төрөл бүрийн зугаа цэнгэлийн үзүүлбэр үзүүлж чаддаг ажээ. Хий гэсэн бүхнийг хийж гүйцэтгэж байв. Энэ хүн – робот ийм уран нарийн, чадвар төгс байсан нь хаан эзнийг үнэхээр цочирдуулж,

түүнийг жинхэнэ хүн хэмээн бодоход хүргэв.

Тэр үед хааны хайртай татвар эмсийн нэг нь үзүүлбэрийг хамт үзэж байсан бөгөөд ордны бусад бүх үзэсгэлэнтэй хатад хүн-роботыг тойрон хүрээлэв. Тэгээд тэд бүгд гайхан мэгджээ. Хүн-робот үзүүлбэрээ дуусгасны дараа тэр ч байтугай нүд ирмэв. (*Бүгд инээв.*) Тэр бас хааны хайртай татвар эм лүү нүд ирмэж, нэг ёсондоо сээтгэнэжээ. Ингээд асуудал эхлэв! Хүн-робот үнэхээр бодит байсанд хаан ихэд уурлав, учир нь тэр нь залуу хүү хөөрхөн бүсгүйд сэтгэл татагдан нүд ирмэхтэй адил байв. Тиймээс хаан уурлаж, маш их атаархав, тэгээд түүнийг бүтээсэн Яньшиг болон хүн-роботыг алахыг хүсжээ. Хаан хоёуланг нь амьд хүмүүс гэж бодсон байна.

Хаанд тэр үнэхээр жинхэнэ мэт харагджээ

Хүн-роботыг бүтээсэн Яньши ихэд айж, тэр даруй сөгдөөд: “Эрхэм дээдэс ээ! Та бүү хилэгнэ. Энэ бол эндүүрэл. Хүн-робот бол жинхэнэ биш, тэр хүн биш шүү. Танд баталж үзүүлэхийг зөвшөөрөөч!” гэв, тэгээд хэдэн эрэг шураг сугалан автал хүн-робот газарт хөсөр унаад хөдөлж чадахгүй болов. Дараа нь Яньши дархан аажмаар хүн-роботын гар, хөл, гэдэс, чих гээд бүгдийг задалж, түүний бүх бие нь зөвхөн машин төдий, жинхэнэ хүн биш гэдгийг хаанд батлан харуулав. Хаан бас хүн-роботын дотор эрхтэн элэг, зүрх бүгдийг мод, төмрөөр хийгээд будгаар будсан байхыг харжээ. Хийсэн бүх зүйл нь зүгээр л механик төхөөрөмж байв. Гэсэн ч яг л жинхэнэ хүн шиг бүр арьсан доор нь цусны эргэлтийн системийн артер, венийн судаснууд нь байгаа мэт харагдаж байлаа. Дархан хүн-роботын шүд, чих, нүдийг нэг нэгээр нь салгаад хаанд шалгуулав. Эцэст нь хаан жаахан итгэж гэнэ. Хаантан Яньшид зүрхийг нь аваадах, юу болохыг харъя гэхэд хүн-роботын ам нь хамхигдаад дахиад юу ч ярихгүй болов гэнэ. Хаан элгийг нь гаргаад ир гэв, тэгэхэд хүн-робот нүдээ ирмэж ч чадахгүй, бүр юм харахгүй

болжээ. Бөөрийг нь авах үед явж чадахгүй болов. Эцсийн эцэст энэ үнэхээр л хүн-робот төдий юм байна гэж бодоод хаан тайвширч санаа алдлаа. Хааны уур хилэн ч намдаж, атаархах сэтгэл нь арилж улмаар тэр хоёрыг өршөөн хэлтрүүлжээ. Гэвч хаантан толгой сэгсрэн гайхширч: "Чи үнэхээр Эзэн Бурханыг орлохыг хүсэж байна уу? Бүтээгчийн ажлыг яаж хийж чадах вэ? Түүнтэй өрсөлдөж байгаа юм уу?" гэж бодов. Магадгүй л юм! Гэхдээ мэдээж зохион бүтээгч юу ч тайлбарлан хэлж чадаагүй. Магадгүй тэр нэг агуу эрдэмтэн байсан байх. Тиймээс үүний дараа хаан шадар туслахдаа Яньши, хүн-робот хоёрыг тэргээр харьяалагдах газарт нь хүргэж өгөхийг тушаажээ.

Дэлхий дээр үнэхээр "шинэ" нээлтүүд байдаг уу?

Хятадууд бас өмнө нь үүлнээс дээгүүр гардаг машин зохион бүтээжээ. Үүлэн дээр гардаг учраас түүнийгээ "үүлэн шат" хэмээн нэрлэсэн байна. Энэ нь бараг хамгийн эртний онгоц байсан байх. Тухайн үед ийм машин байсан нь хэдийнээ гайхалтай зүйл байв. Тэдгээрийг өөр өөр хүн, өөр өөр цаг үед, өөр өөр газар зохион бүтээжээ. Бас нэг хүн нисдэг шувуутай төстэй зүйл бүтээсэн нь магадгүй нэг төрлийн онгоц байсан байх. Эдгээр машиныг зохион бүтээсэн хүмүүс өөрсдийн бүтээлээ хамгийн сайн, дээд зэргийн зүйл гэж боддог байв. Гэтэл хэн ч жинхэнэ хүнээс ялгарах зүйлгүй хүн-робот зохион бүтээж чадна гэж төсөөлж чадахгүй байсан биз. Тиймээс тухайн үед хүн-робот бүтээсэн нь өмнө нь бүтээгдсэн нисдэг шувуу, үүлэн шат зэргийг бүдгэрүүлсэн аж. Магадгүй хятадууд өмнө нь үл танигдах нисдэг биет, онгоцтой байсан байх. Харахад яг л тийм байсан мэт, тэр ч бүү хэл хүн-роботтой! Тэр нисдэг шувуу, үүлэн шат зэргийг зохион бүтээсэн хүмүүс, хүн-роботын тухай сонсоод амаа хамхиж, өөрийн бүтээлээрээ дахин сайрхаж зүрхлэхээ больжээ. Энэ бүхэн мөн л Байлдаант улсын үед байсан байх.

Хятадад Байлдаант улсын үед хачирхалтай үйл явдал олон болдог байсан гэж би сонссон. Тэр үед маш олон онцгой хүн байсан бөгөөд бараг л өөр гаргаас хүрч ирсэн, бидний ярьдаг харь гаргийн хүмүүс шиг. Учир нь тэд өнөөдөр бидний сонссон харь гаргийн хүмүүсийн хэрэглэдэг лазерын буу гэх мэт хүнийг саажилттай, хөдөлгөөнгүй болгодог, тэр ч бүү хэл бүх зүйлийг устгах чадалтай маш олон зэвсэгтэй байсан.

Байлдаант улсын үед ийм хүмүүсийг ид шидтэн гэдэг байсан бөгөөд тэдний хийсэн зүйл яг л ид шид шиг байсан. Тэд агаарт элдэв төрлийн хуурмаг үзэгдэл, объектыг олныг бий болгож, дайснаа ялж чадах бөгөөд түүнийг нь эвдэх ямар ч боломжгүй. Тэр үед бараг гараг хоорондын дайн болсон байх. Тиймээс Оддын дайн нь бүхлээрээ зохиомол зүйл биш юм, нэг хэсэг нь үнэн бодит байж магад. Эс бөгөөс гурван мянган жилийн өмнө алс холын Хятад орон, тэр үед Хятад, Америк, Европын хооронд ямар ч бодитой холбоо харилцаа байгаагүй болохоор тэд яаж ижилхэн хэрэг явдлын тухай ярих билээ?

Тухайн үед тэд жирийн зэр зэвсэг хэрэглээгүй. Тэд буу, эсвэл лазерын зэвсэг зэрэг маш боловсронгуй, асар их үхлийн аюултай зэвсэг хэрэглэж байсан тухай дүрслэн бичжээ. Хятадууд тэр үед тэднийг өндөр дээд ертөнц, диваажингаас ирсэн их хувилгаад хэмээн дүрсэлдэг, яг “Сахиус өргөмжилсөн үлгэр”-т дурдсантай адил бөгөөд иймээс энэ бүхэн ямар нэгэн байдлаар үнэн бодитой байж таарна. Хятадын түүхэн сурвалжуудад ч бас эдгээрийн тухай тэмдэглэсэн байдаг, энэ бол зохиомол бус юм. Иймээс хүмүүс гурван мянган жилийн өмнө өнөөдөр бидэнд байгаа орчин үеийн багаж төхөөрөмжүүдтэй байсан нь бүр ч илүү дэвшилттэй байсан байж магад.

Саяхан би сонинд гурван мянган жилийн өмнө атомын бөмбөг байсныг батлах эд зүйл олдсон тухай

бичсэнийг уншсан. Археологичид, атомын бөмбөгөнд өртөн сүйрч, газарт булагдсан балгасыг малтлагаар илрүүлээд уг малтаж олсон нотлох баримтуудыг шалгаж үзэхэд одоо ч цацраг идэвхт бодис ялгаруулсан хэвээр байгааг тогтоож, атомын бөмбөгийн үлдэгдэл гэж үзэж байна.

Магадгүй Библид гардаг Лотын эхнэрийн тухай түүх нь энэхүү гурван мянган жилийн өмнөх атомын бөмбөгтэй дүйцэж давхцаж магадгүй. Иймээс, манай гараг улс төрийн ямар нэг шалтгаанаар, эсвэл улс төрийн өөр өөр засаглалын янз бүрийн тогтолцооны улмаас бид өөрөө өөрсдийгөө сүйрүүлсэн, эсвэл өөр бусад гаргуудтай хийсэн дайнаас болж сүйрсэн бололтой. Тиймээс магадгүй нарны дор ямар ч шинэ зүйл байхгүй.

Дэлхий ертөнцийн түмэн бодис тасралтгүй шинэчлэгдэн хөгжиж байдаг. Тиймээс магадгүй бид одоо мэдэж байгаа зүйл, эсвэл эзэмшсэн шинжлэх ухааны аливаа ололт амжилтдаа бахархах хэрэггүй. Бидний өвөг дээдэс энэ бүхнийг хэдийнээ мэддэг байсан бөгөөд одоогийн биднээс ч илүү сайн, илүү дээр хийж байжээ. Гэхдээ тэд үүнийг юунд ашиглаж байв? Зөвхөн өөрсдийгөө хөнөөх, эсвэл устгахад ашигласан, энэ нь магадгүй санамсаргүй, эсвэл дайны хянах аргагүй үйл явцаас болсон байх. Тэгэхээр энэ нь сайн зүйл биш гэдгийг та нар харж байна. Хүн хөнөөх арга, төхөөрөмж хэрэгслийг зохион бүтээсэн нь хүн төрөлхтөнд хэзээ ч, ямар ч ач тус болоогүй. Гэсэн хэдий ч хүн төрөлхтөн сургамж аваагүй хэвээрээ, одоо ч нэг нэгнээ алж хөнөөсөөр байна.

Дэлхийн бүх улсын удирдагч Хятадын “Байлдаант улсын бодлого”, “Сахиус өргөмжилсөн үлгэр”, “Гурван улсын түүх” зохиолыг заавал унших хэрэгтэй. Магадгүй тэднээс ямар нэг зүйл сурах байх, гэхдээ тэд: “Хөөх! Бас л хятадууд, тэд гайхалтай уран сэтгэмжтэй юм.” гэж бодох байх. Үүнд ямар нэгэн үнэн байгаа гэдэгт тэд итгэхгүй байж магадгүй. Би “Байлдаант улсын бодлого” зохиолыг уншаад

яг өнөөгийнх шиг ид шидтэй зүйлс тэр үед олон байсныг олж харсан. Жишээ нь, уг зохиолд тухайн үеийн дайнд оролцож байсан нарийн мэргэшсэн, эсвэл мэргэн ухаалаг хүмүүс нэгнээ устгахын тулд ид шид хэрэглэж байсан тухай ямар нэг зүйлийг дүрсэлсэн байдаг. Тэд мэдээ хүлээж авах аргатай байсан бөгөөд хэн нэг нь гэртээ сууж, эсвэл агуйдаа бясалган сууж байхад гэнэт этгээд сонин салхи хажуугаар нь үлээхийг сонсвол салхины эхлэлийг өнгөрөөнө, дараа нь салхийг атгаж аваад сонсож, түүнд байгаа мэдээ юу болохыг мэднэ. Энэ юу байж болох вэ? Та түүхийг уншиж чадна, тэгээд мэдэх болно. Та нар үүнийг уншвал мэднэ, хэрэв уншаагүй бол уншсан нь дээр байх. Тэр гайхалтай ном. Хятадын уран зохиолын эрдэнэсийн нэг. Би тун бага байхдаа уншиж байсан, 6, 7 настай байсан ч гэсэн тэр номд аль хэдийнээ татагдсан байсан, өдөр шөнөгүй уншиж билээ. Тэр номын гайхамшигтай ер бусын ертөнцөөс аав намайг татан гаргах хүртэл (*Бүгд инээв.*) уншдаг байсан. Дараа нь би өөр нуугдах газар хайж олоод үргэлжлүүлэн уншина, эсвэл аавыг явсны дараа уншдаг, учир нь тэр ном үнэхээр сэтгэл татам байсан. Хятадын алдартай уран зохиол гэдгийг нь мэдээгүй ч гар тавилгүй уншсан.

Хятадын сонгодог уран зохиолуудыг би бараг бүгдийг нь уншсан гэж бодож байна. Хятадын ямар л алдартай сонгодог зохиол байна, жаахан байхдаа би бүгдийг нь уншиж дуусгасан. Долоон настайдаа Хятадын бүх хаант улсыг "дуусгачихсан", бүгдийг нь "байлдан дагуулчихсан" байж билээ. (*Их Багш болон бүгд инээн алга ташив.*)

Тиймээс та бүхэн анзаарвал, түүх дахин дахин давтагдаж байдаг, энэ үгийг бид байнга хэлдэг боловч жинхэнээр мэддэггүй, бас түүхийг хянах гэж оролддоггүй. Өнөөдөр олон орны эрх баригч нөгөө л эрс тэс ноцтой арга замаар түүхийг бүтээж, цусаар бичихийг оролдсоор байна.

Дэлхийн хүмүүс бүгд сэрж сэхээрэх болтугай

Дэлхийн хүмүүс нэг л өдөр бүгд сэрж сэхээрэн Үнэн ёсонд эргэн нэгдэж, Арьяабалын аргаар бясалгахгүй ч гэсэн энх тайвнаар зэрэгцэн оршино хэмээн би найдаж байна. Хүн бүхэн энх тайвны тухай ярьдаг. Засгийн газрууд ч бас: "Бид эрх чөлөө, ардчиллын төлөө, ард түмэн, хөгжил цэцэглэлтийн төлөө, шударга ёс болон ах дүүгийн ёсны төлөө, тэгш эрхийн төлөө, бүх зүйлийн төлөө байдаг!" гэж хамаг чадлаараа хашхиралдаж байдаг. Гэвч тэд улс орон, ард түмэндээ юу хийж байгааг хар даа, үнэхээр инээдтэй шүү. Хар худал, цагаан худал, худал үгээр дүүрэн атал юу ч мэдэрдэггүй!. Тэд ийм зүйл ярьчхаад шөнө нь яаж амар тайван унтаж чаддаг юм бол гэж би их гайхдаг. Эсвэл тэд хэтэрхий хийрхэж, бүр өөрсдийнхөө алдааг ч олж харж чадахгүй болсон байх. Магадгүй тэд төрөлхөөсөө ийм зан чанартай байж, энэ бүхэн тэдний хувьд хэвийн зүйл болсон байх, яг л загас усанд сэлэх, шувууд тэнгэрт нисэх мэт төрөлхийнх болчихсон.

Зарим хүн төрөлхийн алуурчин байж магад, хар санаатай болж, сөрөг болж, алж хөнөөхдөө сурамгай болж, бүр үй олноор хоморголон устгахаар төрсөн. Хэрвээ та нар энд хүн алах юм бол асуудалд орно. Харин дайны үед тэд буугаа ямар ч гэм зэмгүй мянга мянга, сая сая хүмүүс, хүүхдүүд рүү чиглүүлдэг ч тэднийг ялладаггүй. Тэд зөвхөн: "Арай ч хэцүү юм боллоо.", "Дайн дууслаа!" гэдэг. Дайнаас болж олон зуун хүний амь нас хохирч, гэр бүл хагацан салж, үр хүүхэд өнчирч, эд хөрөнгөөрөө хохирч, залуу авьяастнууд эмгэнэлтэйгээр сүйрсэн ч энэ талаар хэн ч, юу ч ярихгүй. Магадгүй дараа нь тэд уучлалт гуйдаг. Заримдаа бүр уучлалт ч гуйдаггүй. Тэд зөвхөн: "Маш муу" л гэж хэлдэг. Тэгээд энэ бүх гэр бүл, найз нөхдийн хагацал зовлон, тэр бүх эд хөрөнгө, залуу нас, оюун ухаан, хүний амь, үнэт зүйлийн гарз хохирлын дараа хэн ч, юу ч хэлдэггүй. Магадгүй хожим нь тэд бага зэрэг уучлалт гуйж, "Уучлаарай" гэнэ, эсвэл бүр тийм ч юм байдаггүй.

Хэрвээ тэд үнэхээр санаа зовдог байсан бол дайныг зогсоож, хэзээ ч дахин дайн дэгдээхгүй. Гэхдээ ихэнх удирдагч яагаад дайн эхлүүлдэг вэ? Учир нь дайн тэдэнд бараг нөлөөлдөггүй, тийм их нөлөөлдөггүй. Хэчнээн хүн амь насаа алдаж, хэчнээн их улсын эд баялаг үрэгдсэн ч тэдэнд санаа зовох зүйл байхгүй. Тэдэнд хүнс хоол цаг үргэлж хангалттай байж, урьдын адил тансаг амьдарсаар байдаг. Тэд үнэтэй тансаг машин хөлөглөн хувийн онгоцоор зугаална, хувийн бие хамгаалагчтай гэзэг өөр юу ч юм бүгд тэднийг тэр бүхнээ алдах сүүлчийн минут хүртэл нь байна байх. Тэгээд сүйрч унах гэж байгаа сүүлчийн мөчид улсынхаа бүх эд баялгийг хамж аваад хувийн онгоцондоо суугаад “Үүрд баяртай” гэх болно. Тэд хаа нэгтээ яг л хаан шиг амьдарсан хэвээр байж, зөвхөн хаант улсгүй л хаан байдаг, тэгээд л болоо.

Тиймээс олон удирдагчид дайн дажин, эсвэл энх тайвны аль нь байх нь хамаагүй байдаг. Учир нь тэд бол жинхэнэ удирдагч биш, тэд албан тушаалаа ашиглан зөвхөн өөртөө эд баялаг, хүч чадал, ганцаар ноёрхох эрх мэдэл хуримтлуулдаг. Тийм учраас бид удирдагчаа сонгохдоо маш анхаарал болгоомжтой байх ёстой. Мэдээж бид хэзээ ч төгс төгөлдөр нэгнийг, эсвэл бидний санаанд бүрэн нийцэх нэгнийг олж чадахгүй ч ядаж л хамгийн сайн бөгөөд хамгийн хөнөөл багатай нэгнийг, гавьяа байгуулахгүй ч ядаж л гай тарихгүй, биднийг хамгаалж чадахгүй ч ядаж хохироохгүй нэгнийг сонгох хэрэгтэй. Тэгэхэд л болно. Тиймээс наад зах нь ийм хүн байх хэрэгтэй. Тийм ч учраас тэр юу ч ярьсан бай хамаагүй, эхлээд бид үйлдлийг нь сайтар ажиглан харах хэрэгтэй. Ийм нэг ерөнхийлөгч бидэнд үнэхээр ач тустай байж чадах уу, тийм нэг хаан бидэнд үнэхээр сайн байх уу гэдгийг бид мэдэх ёстой. Ерөнхийлөгчийг бол сольж болно, харин эрх баригч нь хаан бол сайтар бодох хэрэгтэй, хэрвээ та хувьсгал хийвэл хамгийн түрүүнд толгойгүй болно. Одоо бидэнд ганцаар эзлэн захирдаг хаан тийм ч олон байхгүй нь

үнэхээр зол юм.

Өмнө нь хаан бол Эзэн Бурхан л гэсэн үг. Хэн ч түүнийг эсэргүүцэж чадахгүй. Амаа хамхиж амжаагүй байтал толгой тань аль хэдийн алга болчихсон байх болно!

Та тэр ч байтугай юу ч хэлж, эсвэл эгцэлж харж ч болохгүй. Хаан эзэн хаа нэгтээ гадагш мориор явах бүрт та өвдөг сөхөрч, толгойгоо газарт наан мөргөх ёстой. Хэрвээ толгойгоо өргөн харваас толгойгүй болно. Хааны царайг харж амжаагүй байтал толгой тань хэдийнээ хаа нэгтээ хэвтэж байж магадгүй. (*Бүгд инээв.*)

Газар сайгүй ийм чанд хатуу байсан. Хэчнээн хүн өлсөж даарахын зовлон эдэлж, халуунд халж, хүйтэнд хөрж, байгалийн гамшигт нэрвэгдэж байсан ч хаан эзэн хамгийн тансаг амьдарч байдаг. Хатдын ордондоо мянга мянган татвар эм болон эхнэртэй бөгөөд үй олон тайгантай. Тэдэнд ямар ч хүндрэл бэрхшээл байгаагүй учраас жинхэнэ зовлон гэж юу байдгийг тэд мэддэггүй байсан.

Хайрын хичээл

Францын хааны хатан Мари Антуанеттын тухай алдартай түүхийг та бүхэн мэдэх үү? Тэр амандаа алтан халбага зууж төрсөн гэдэг. Хүмүүс түүнд ард түмний амьдрал бэрх байна, идэх талх ч үгүй болов хэмээн туйлын өлсгөлөн нүүрлэв гэсэн санааг хэлэхэд тэрээр “Хэрэв талх байхгүй бол бялуу иднэ биз.”гэж хариулжээ. (*Бүгд инээв.*)

Талх ч үгүй байхад бялуу яаж байх билээ дээ? Гэвч тэр ийм нөхцөл байдлын талаар юу ч мэдэхгүй, талх бол эгэл ардын хувьд бүх юм нь, өдрийн гурван хоол нь, амь амьдрал нь гэдгийг тэр мэдэхгүй. Энэ нь яг л хятад хүмүүс: “Бид идэх цагаан будаагүй болжээ!” гэвэл бид идэх юмгүй болж, өлсөж байна гэсэн санаа шиг юм. Цагаан будаа бол америк, европчуудын хувьд талх ямар байдаг шиг, хоолыг

бэлгэддэг хэлц үг.

Мари зэрэг хааны хатдын хувьд тэд магадгүй хэзээ ч өлсөж, даарч байгаагүй байх. Магадгүй тэр хэзээ ч хазгай газарт гишгэж үзээгүй, мөн өмнө нь ордноос гарч, жирийн ард иргэдийн аж амьдралтай танилцаж байгаагүй. Тэр хаашаа ч явсан бай хүмүүс түүнээс зайлсхийж, эсвэл хүмүүсийн бодол санал, үнэн байдлыг нуун дарагдуулдаг байсан бөгөөд түүнийг тойроод бас олон давхар хамгаалалттай байдаг болохоор тэр хэзээ ч юу ч хараагүй, тэгэхээр ард түмний амьдралыг огт мэдэхгүй. Магадгүй тэр тийм ч хүйтэн сэтгэлтэй хатан байгаагүй байх. Гэвч түүний амьдрал дэндүү их хамгаалалт, дэндүү их худал хуурмаг, дэндүү их шаардлагагүй тансаглалаар хүрээлэгдсэн байжээ. Тиймээс заримдаа хаан болон хатад юу хийж байгаагаа мэддэггүй. Энэ үнэхээр хэцүү шүү!

Хүмүүс хаад, хатдын эсрэг үргэлж хувьсгал хийж, эзэн хаан, хатан хаанаа цаазын тавцанд гаргадаг нь гайхах зүйл биш юм. Тэд зөвхөн дарангуйлагч засаглал, улс төрийг өөрчилж, хүмүүсийн ахуй амьдралыг хөнгөвчлөхийг хүсдэг.

Учир нь эрт дээр үед хаан эзний өөдөөс дуугарах эрхгүй, буруутгаж бүр ч болдоггүй байсан. Одоо ч мөн адил болохгүй хэвээрээ л байна. Гэхдээ та зарим ерөнхийлөгчид бол юм хэлж болно. Ядаж л өмнөх үеийг бодвол арай илүү чөлөөтэй болж, жаахан ч гэсэн өөрчлөгджээ. Өмнө нь бид хааны эсрэг, эсвэл засгийн газрын эсрэг юу ч хэлж чаддаггүй, зөвхөн тэдний хэлснийг хийдэг байсан.

Харин өнөөдөр та засгийн газар, ерөнхийлөгчийн эсрэг үг хэлж, шүүмжилж болно, гэхдээ тэдний хүссэн зүйлийг хийх ёстой хэвээрээ. (*Бүгд инээв.*) Ялгаа нь гэвэл бид “үг хэлэх эрх чөлөө”-тэй болжээ. Та хүссэн зүйлээ ярьж болно, гэхдээ та “үүнийг хийх” ёстой. (*Их Багш болон бүгд инээв.)* Үнэндээ энэ нь тийм ч их ялгаатай биш. Гэхдээ

магадгүй хүмүүс мэдрэмжээ илэрхийлж хэлж чаддаг болж, “Өө, би эрх чөлөөтэй байна. Ядаж л үүнийг хэлж чадна.” гэдгээ мэдэрдэг, хэлсний дараа зарим үл ойлголцлыг арилгах боломжтой. Тиймээс ажил хийх ёстой байсан ч хүмүүс тийм их дарамт мэдрэхгүй. Энэ нь бас л нэг асуудал.

Би та нарт оросуудын тухай онигоо ярьсан билүү? Нэг америк хүн Орост ажлаар очжээ. Тэр тэнд олон нууц цагдааг харсан бөгөөд хүмүүс нь их айдастай байдаг, огт инээдэггүй болохыг олж харсан байна. (Энэ бол өмнө нь болсон явдал, одоо ямар болсныг би мэдэхгүй.) Тиймээс тэр найзаасаа: ”Юу болоо вэ? Яагаад ийм байна вэ? Та нар юу ч ярьж зүрхлэхгүй байна. Америкт бол хүмүүс засгийн газар, ерөнхийлөгчөө хэзээ ч, ямар ч цаг үед, ямар ч зүйл дээр чөлөөтэй шүүмжилж болно” гэхэд орос найз нь: “Тийм тийм, манай энд Америкийн засгийн газар, ерөнхийлөгчийг хүссэн үедээ шүүмжилж болно.” гэж хэлжээ. (*Их Багш болон бүгд инээн алга ташив.)*

Ирээдүй бидний гарт

Ау Лакт харь гаргийн нисдэг биет газардсан тухай би өмнө нь та нарт ярьж байсан. Бараг дөрвөн мянган жилийн өмнөх явдал юм. Тухайн үед харь гаргийн тэр хүн Ау Лакыг аврахыг хүсжээ. Тун жижигхэн биетэй байсан ч өөрийгөө маш хүч чадалтай, өндөр том болгон хувиргажээ. Тэрээр галт мориор тэнгэр лүү нисэн одсон бөгөөд тэр галт морь газарт буухад газарт дугуй нүх үүсэж байжээ. Тэр нь ямар төрлийн морь байсан юм бол? Энэ нь хөл бөмбөг шиг бөөрөнхий дугуйрсан байх ёстой. Тэгэхээр тэр ямар ч байсан харахад жирийн морьтой адилгүй төдийгүй, төмрөөр хийсэн байжээ. Хоёр талаасаа галаар тургина, уг галын дөл хүрсэн газарт тэнд байсан дайсан бүгд устана, үхнэ. Тэр морь болон түүнээс гарах галын дөлийг эсэргүүцэх ямар ч аргагүй. Үүнийг сонсоход яг л галт буу, эсвэл үл мэдэгдэх нисдэг биет зэрэг орчин үеийн төхөөрөмж шиг санагдана.

Манай энэ цаг үе бол хамгийн иргэншсэн үе, бид бүх зүйлийг нээчихсэн бөгөөд маш их зүйлийг мэддэг гэж үргэлж боддог. Гэвч үнэн хэрэгтээ бид илүү даруу байхын тулд түүхийг дахин дахин унших хэрэгтэй. Энэ нь сэтгэлээр унахын тулд биш, харин илүү их итгэл найдварыг мэдрэхийн тулд юм. Хэрвээ эрт дээр үед хүн төрөлхтөн соёл иргэншлийн ийм хөгжингүй оргилд хүрсэн юм бол бид ч бас ирээдүйд үүнийг дахин хийж чадах нь гарцаагүй. Гэвч бидний суралцвал зохих хичээл бол хүн төрөлхтний оюун ухааны хүч чадлыг буруугаар ашиглаж болохгүй. Хамгийн гол нь бид өөрсдийгөө дотооддоо сургаж, ёс зүй, зан суртахууны хэм хэмжээгээ тогтворжуулж, эрхэм дээд үзэл санаа, хайр, энэрэн нигүүлсэх сэтгэлтэй байх ёстой. Тэгвэл бид юу ч зохион бүтээсэн, бүр ийм аюултай машин байсан ч бие биеэ хөнөөж устгахын оронд түүнийг энхийн зорилгоор ашиглаж, хүн төрөлхтөнд үйлчлэх, соёл иргэншлийн хөгжлийг хурдасгахад туслах амар амгалан хэрэгсэл болгон ашиглаж чадна. Хүн бүр үүнийг сурч чадна гэж би найдаж байна. (*Бүгд алга ташив*.)

Аравдугаар бүлэг

ХАТУУ, ЗӨӨЛНИЙГ ХОСЛУУЛЖ ЧАДВАЛ ТӨГС ТӨГӨЛДӨР МӨН

Күнз болон түүний шавь нарын түүх

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Хонконг, Шатин, Тэншан ашрам
1994 оны 4 дүгээр сарын 6.
(Эх нь хятад хэлээр)

Күнз болон Түүний дөрвөн шавь

Күнз болон Түүний шавь нарын тухай нэгэн түүхийг Лиэзи бичжээ. Нэгэн Зисиа нэрт хүн Күнзээс: “Ян Хуй ямархуу хүн бэ?” хэмээн асуужээ. Күнз маш олон шавьтай, тэдний нэгийг нь Ян Хуй гэдэг байсан уу? (*Тийм гэж нэг хүн хариулав.*) Күнз: “Ян Хуй энэрэн нигүүлсэх сэтгэлээр надаас илүү!” гэв. Тэр үргэлжлүүлэн: “За тэгвэл, Зигүн ямархуу хүн бэ?” гэж асуухад Күнз: “Зигүний мэтгэлцэх

чадвар минийхээс илүү" гэв. Зисиа дахин Күнзээс: "За тэгвэл, Зилу ямар хүн бэ?" гэхэд Күнз: "Зилу надаас илүү эр зоригтой" гэв. Зисиа цааш нь асуув: "Тэгвэл Зижаны тухайд, Зижан ямар хүн бэ?" гэж асуухад Күнз: "Тэр надаас илүү сүр жавхаатай" гэлээ.

Дараа нь Зисиа босож зогсоод Күнзээс: "Тэгвэл тэр дөрөв яагаад Таныг даган суралцахаар ирсэн юм бэ?" гэж асуув. Дөрвүүлээ зарим талаараа Күнзээс илүү байтал яагаад заавал Түүнээс суралцахаар ирэв гэсэн санаа юм, Күнз: "Та суугтун!" гэв. Зисиагийн сэтгэл нь ихэд хөдөлснөөс босож зогссон аж. "Та суу, суу, би танд хариулъя. Та мэдэхгүй байна гэж үү! Ян Хуй өршөөл энэрлийг мэднэ, гэвч ямар үед өршөөж энэрэхгүй байхыг үл мэднэ". "Зигүн мэтгэлцэж чадна. Гэвч тэр ямар үед дуугүй байхыг мэдэхгүй." Тэр хэзээ мэтгэлцэхгүй хүн байх ёстойгоо мэддэггүй гэсэн утгатай юм, ойлгож байна уу? Хэрэв та юм бүхнийг мэддэггүй мөртөө цаг үргэлж маргалдан мэтгэлцдэг бол энэ нь хүмүүсийн дургүйг хүргэнэ! Тийм биз?

Күнз үргэлжлүүлэн: "Зилу эр зоригийг мэддэг ч хэзээ айхаа мэддэггүй." Ойлгож байна уу? Тэр айсан дүр эсгэх, эсвэл хэзээ, хэрхэн айх ёстойгоо мэддэггүй. Жинхэнээсээ "айхгүй байна" гэдэг нь хэзээ сул дорой байхаа мэдэхгүй байна гэсэн үг. Яах вэ, үнэнээсээ "айх" биш, харин хаяа номхон даруу байх ёстой гэсэн үг. Тэр хэзээ даруухан байхаа мэддэггүй.

"Зижан маш сүр жавхлантай, гэвч бусадтай хэзээ зохицож, найрсаг нийцтэй байж буулт хийхээ мэдэхгүй. Тэдний бүх давуу талыг нэгтгэж, миний хангалттай сайн биш талуудтай солилцъё гэвэл би лав солилцохыг хүсэхгүй." Хэдийгээр тэд хэчнээн сайн байсан ч тэдний Күнзээс илүү сайн талуудыг нь нэгтгээд Күнзийн муу талуудтай сольё гэвэл Күнз солихыг хүсэхгүй гэж хэлжээ. Тэгэхээр тэр дөрвөн хүн ирж, Күнзэд багшаа хэмээн мөргөж, хоёргүй

үнэнч сэтгэлээр даган шавилах ёстой байжээ. Үнэнч сэтгэл гэдэг нь халширч няцахгүй, итгэлээ алдахгүй, харамсахгүй гэсэн санаа.

Өршөөл энэрэлтэй байх болон өршөөл энэрэлгүй байх

Энэ бол гайхалтай түүх шүү! "Өршөөл энэрэл" гэдэг нь юу гэсэн утгатайг та нар мэдэх үү? Энэ нь хүн бүхнийг маш их хайрлана, маш өгөөмөр уужим сэтгэлтэй байж, бусдыг сайн ойлгоно, амархан уучилна, хэзээ ч бусдыг буруутгахгүй, үргэлж хайраар хандана гэсэн үг. Энэ бол энэрэнгүй нинжин сэтгэл юм. Хэн нэгэнд асуудал бэрхшээл тулгарсныг сонсвол түүнийг хайрлаж, түүнд тусална, бусад хүн алдаа гаргавал уучилна. Ер нь бидэнд яагаад ийм зан чанар байж болохгүй билээ?

Бид яагаад үргэлж ингэж үйлдэж болохгүй гэж? Энэ нь илүү дээр хэрэг биш гэж үү? Та хэзээ энэрэнгүй байж болохгүйг мэдэх ёстой гэж Күнз яагаад хэлсэн бэ? Энэ нь юу гэсэн утгатай вэ?

Үүнийг мэдэх хүн байна уу? *(Нэг хүн: Муу хүнд хандахдаа гэж хариулав.) (Хүнийг хайрлаж чаддаг ч гэсэн бас хайрлахгүй байж чаддаг. Хайрлахгүй байна гэдэг нь хүнд өршөөл энэрлээр хандахгүй байх гэсэн үг. Аль алин нь байх хэрэгтэй гэж өөр нэг хүн хариулав.)*

Тийм ээ, аль алин нь байх хэрэгтэй. Арга, билиг тэнцвэртэй байх ёстой. Өршөөх ёстой үедээ өршөөнө, энэрэх ёстой үедээ энэрнэ. Өршөөл энэрэл хэрэггүй үед өршөөж энэрэхгүй. Энэ бол жинхэнэ сайн, миний хэлэх гэсэн санаа ийм юм. Бид хэзээ энэрэнгүй байж, хэзээ энэрэнгүй байж болохгүй вэ? Жишээ нь, нэг найз маань хүндрэл бэрхшээлтэй тулгарвал бид сайн найзын хувьд мэдээж түүнд туслах ёстой. Тэрээр хожим бие дааж амьдарч чадах учраас бизнес эрхлэхэд нь мөнгөөр туслах хэрэгтэй,

хэрвээ мөнгөтэй болбол тэр бидэнд буцааж төлж болно. Буцааж төлөхгүй байсан ч бид нэг их тоохгүй. Хэрвээ бид маш их мөнгөтэй бол найз маань авч хэрэглэх, эсвэл ах дүү, хамаатан садан хүмүүс авч хэрэглэх үү гэдгийг бид нэг их тоохгүй.

Гэхдээ хэрэв тэр хүн мөнгө аваад бизнес хийхгүй, муу явдал үйлдэж, мөрийтэй тоглож, архи тамхи хэрэглэж, элдэв муу хэрэг хийчхээд дараа нь биднээс дахин мөнгө нэхвэл тэр үед үргэлжлүүлэн өршөөл энэрлээр хандах боломжгүй, энэрэнгүй байж чадахгүй! Хэрвээ түүнд муу хүн байхад нь тусалж, нэгэн бусдаас хараат, амиа аваад явж чаддаггүй хүн болоход нь тусалж, үргэлжлүүлэн түүнд өршөөл энэрлээр хандаад байвал түүнийг улам хохирооно. Улам бүр бие даах, өөрийн чадвараа хөгжүүлэх чадваргүй болж, улам бүр бусдаас хараат, сул дорой, ичгүүр, гэм зэмийн мэдрэмжгүй, хүний мөс, чанаргүй, бидний найз байхад зохисгүй нэгэн болж хувирна. Тэр аажмаар бие даах урам зориггүй хүн болж, авьяас чадвараа хөгжүүлэхгүй болно. Ингэвэл бид нэгэн найзыгаа алдаад зогсохгүй, түүнийг хорлож, амьдрал нь улам дордож, бие даан босох чадваргүй болно.

Нэгэн шилдэг эрдэмтний найздаа элдэг бусаар тусалсан түүх

Манай Хятадад ийм нэгэн түүх байдаг. Хоёр найз хоёулаа бичгийн хүмүүс, сэхээтнүүд байжээ. Тэднийг Лю Пин, Янь Ли гэнэ. Нэг нь ихээхэн хичээл чармайлттай тул эрдэмтний шалгалтад тэнцэж, хааны ордонд шилдэг эрдэмтэн болоод төрөлх хотдоо сүр жавхлантайгаар буцаж ирэв. Нөгөө найз нь идэж ууж, наргиж цэнгэх дуртай. Хэдийгээр найз шигээ авьяаслаг ч нэлээн залхуу, хэчээж сайн суралцдаггүй тул эзэн хааны шалгалтад тэнцээгүй аж. Шалгалтад тэнцээд түшмэл болсон найз нь их сайхан сэтгэлтэй бөгөөд өмнө нь дотно найзууд байсан болохоор нөгөө найзыгаа дурсан санасан хэвээр байлаа. Найзыгаа

одоо тийм ч сайнгүй л яваа даа гэж бодоод хүн явуулжээ.

Найз нь ирэхэд өнөөх эрдэмтэн өргөөндөө тун завгүй байгаа мэт дүр эсгэж, түүнийг гаднаа удаан хүлээлгэв. Найз нь дахин асуулгахад зориуд нэгэн бага түшмэлийг явуулан бараа болгуулж, эгэл борог зүйлсээр хооллоод доод тушаалын хүмүүст, эсвэл нэн ядуу хүмүүст өгдөг шиг шальдар булдар эд хүргүүлж, олигтой сайхан хүлээж авсангүй гэнэ. Найз нь түүнтэй уулзахыг хүссэн ч завгүй дүр эсгэн хүлээж бай, эсвэл дараа нэг өдөр ир гэж хэлүүлжээ. Өөр нэг өдөр найз нь хүрч ирэхэд бас л өмнөх шигээ хандаж гэнэ. Түшмэлийн шалгалтад тэнцээгүй өнөөх ядуу найз нь тун их дургүйцэж, үзэн ядаж, ичиж гутраад түшмэл найзтайгаа уулзахаар дахин ирсэнгүй. Хариад өдөр бүр их л бухимдангуй байх болжээ. Тэрээр сэтгэлээр ихэд унасан үедээ амьдрахыг хүсэхээ больж, юу ч хийх хүсэлгүй болоод байтал гэнэт нэгэн бүсгүйтэй таарч гэнэ. Тэр тун үзэсгэлэнтэй, ялдам эрхэмсэг байсан ч энгийн даруу хувцастай байв.

Тэр бүсгүй гэнэт гарч ирснээр тэр хоёр уулзан танилцжээ. Бүсгүй түүнийг урамшуулж, сэтгэл санааг нь ойлгож, түүний хэцүү нөхцөл байдал, найз нь хэрхэн урвасан гэх мэтийг бас сонсжээ. Бүсгүй түүнийг дэмжихээр шийдэж, “Зүгээр дээ, чи үргэлжлүүлэн суралц, би даавуу нэхэж, өөр олон гар урлалын зүйл хийгээд чамд тусална. Би бас чамд туслаарай гэж дотоодын Их Багшдаа даатгана, чи санаа зовох хэрэггүй” гэв. (*Их Багш болон бүгд инээв*.) Тэгтэл өнөөх залуугийн санаа сэтгэл амарч, хичээл номдоо шамджээ. Залуу бас бүсгүйд сайн сурч, эзэн хааны шалгалтад тэнцээд дараа нь чамайг эхнэрээ болгож авна аа гэж амлав. Бүсгүй нэг их юм хэлсэнгүй, зөвхөн, “За, тэр үедээ л ярья! Энэ бол жижиг асуудал, дараа нь болъё. Одоо эхлээд сайн суралц!” гэв. Бүсгүй дандаа л ингэж хэлдэг байжээ. Залуу түүнтэй ямар нэгэн холбоо үүсгэхийг хичээвч ер бүтэхгүй. Бүсгүй түүнд хичээл номдоо л сайн шамд, хайр сэтгэлийн асуудлаас

болж, анхаарлаа бүү сарниул, энэ асуудал хаа хол хэвээр байна, эхлээд заавал эрдэмтний шалгалтад тэнцэх хэрэгтэй гэж байнга хэлнэ. Тэгээд залууг амар тайван суралцуулж, харж хандсаар байлаа. Дараа нь залуу эзэн хааны шалгалтад тэнцэж, шилдэг эрдэмтэн болжээ.

Шилдэг эрдэмтэн хэмээн зөвшөөрөгдсөнийхөө дараа хамгийн түрүүнд очиж уулзахыг хүссэн хүн бол түүний хуучин найз, өнөөх өөдгүй, түүнээс урвасан, зэвүү хүргэсэн шилдэг эрдэмтэн түшмэл найз нь байлаа. Тэрээр даруй түүнтэй уулзахаар очжээ. Тэр маш их онгирч, одоо хамгийн шилдэг эрдэмтэн түшмэл болсон гэдгээ харуулан олон дагуултай очив. Өмнө нь яаж муухай хандсаныг нь хэлж, тэр муу найзыгаа нэг сайн загная гэж боджээ. Тэр удтал загнахыг хүссэн ч өнөөх найз нь доод түшмэлдээ хандан ямар нэг зүйл шивнэхэд доод түшмэл нь дотогш гүйж ороод нэгэн бүсгүйг дагуулан гарч ирэв. Шинэхэн түшмэл маань бүсгүйг хараад тэр дор нь танив, тэр бол гурван жилийн турш түүнийг харж хандан суралцахад нь зоригжуулж байсан нөгөө бүсгүй байлаа. “Чи яагаад энд байгаа юм бэ?” гэж асуухад хуучин түшмэл: “Энэ бол миний эхнэр.” гэлээ. (*Их Багш болон бүгд инээв.)* Та нар ойлгов уу? Найзынхаа төлөө эхнэрээ золиосолсон байна шүү дээ.

Эхнэрээ явуулж, найзыгаа харж хандуулан хичээл номд нь шамдуулжээ. Түүнийг унаж доройтохоос нь сэргийлж, нэгэн чадварлаг хүнийг гарздаж, авьяас чадварыг нь бөхөөхгүйн төлөө тэгжээ. Найз нь мэдэж ойлгоогүй байх, түшмэл найзынхаа сайхан сэтгэлийг ойлгоогүй. Түүнийг өөрт нь маш муухай хандсан гэж буруутган өшөө авахыг л бодож, загнахыг хүсэж байв. Сүүлд нь мэдээд өвдөг сөгдөн бөхийв. Тэр хоёр тэврэлдээд сэтгэл нь хөдөлж, уйлцгаажээ. Энэ түүхийг та нар мэддэг байх ёстой. Хятадын түүх, тийм үү? Энэ түүх Ау Лакт ч бас их алдартай. Энэ бол эрхэм хүний өршөөл энэрэлгүй байдал юм. Муу санаатны

өршөөл энэрэл заримдаа бусдад хор болох нь ч бий. Гэтэл эрхэм их хүмүүний өршөөл энэрэлгүй нь үнэхээр олон хүнд тусална, өөртөө тусална, бусдад тусална, энэ бол жинхэнэ өршөөл энэрэл мөн. Тиймээс бид ч бас зарим үед хэрхэн өршөөл энэрэлгүй байхыг мэддэг байх ёстой. Багшийнхаа санааг ойлгов уу?

Хатуу зөөлнийг хослуулж чадвал жинхэнэ сайн хүн мөн

Энэ түүхээр дамжуулан Күнзийн сургасан өршөөл энэрлийг мэдэж авна. Гэвч хэдийд өршөөл энэрэлгүй байх вэ гэдгээ мэддэг байх хэрэгтэй, энэ нь хатуу, зөөлнийг хослуулж чадна гэсэн үг. Эс бөгөөс бид өршөөнгүй энэрэнгүй чанартаа баригдаж гацах болно. Хэрвээ бид үхтэл зууралдаад үл огоорвол энэ нь сайн зүйл биш. Заримдаа орхих хэрэгтэй болдог. Жишээ нь, хэрэв бидэнд эрдэнэс байгаа бол дайн эхлэхэд бид эрдэнэсээ тэврээд очир эрдэнэ, алт, гартаам, шүр зэргээ нийлүүлж боон нуруунаасаа салгахгүй авч явна. Аюул осолгүй газар олтлоо хаа ч явсан үүрээд л явна. Гэвч аюулгүй газарт хүрсэн бол буулгах хэрэгтэй, эсвэл ах дүү, хамаатан садан, найз нөхөд тань өлсөж цангавал тэдэнд хоол авч өгөхийн тулд нэг хэсгийг нь зарж мөнгө болгох хэрэгтэй. Бид зөвхөн үнэт эдлэлээ хадгалахын тулд бусдыг үл тоомсорлож болохгүй. Тиймээс энэрэн нигүүлсэхүйг ч, өршөөл энэрэлгүй байдлыг ч хослуулах хэрэгтэй. Хэрэв бид үүнийг хэрхэн зөв ашиглахаа мэддэг бол өршөөл хайргүй байдал нь энэрэнгүй сэтгэл болно. Аргаа үл мэдвээс өршөөл хайр нь ч өршөөл хайр биш, хор болж мэднэ.

Олон хүн “энэрэн нигүүлсэхүй” нэрийг буруугаар ашиглаж, хүн заавал нигүүлсэх сэтгэлтэй байж, хэзээ, хаана ч гэсэн энэрэнгүй байж, өдөржин инээмсэглэж, хэнд ч ялгаагүй: “Сайн байна! Сайн байна!” (*Их Багш болон бүгд инээв.)* гэж ярих ёстой гэж үздэг. Энэ бол тэнэг хэрэг, зөвхөн модон бурхан л ингэх байх. Хүн ийм байж болохгүй. Эрхэм

хүн бол урагшлах, ухрахыг тэнцүүлж, хатуу, зөөлнийг хослуулахыг мэддэг байх ёстой. Тэгж байж л жинхэнэ сайн хүн болж чадна. Тиймээс Күнз: Би Ян Хуй шиг өршөөл энэрэлтэй биш гэсэн нь ийм учиртай байжээ. Тиймдээ ч заримдаа өршөөлгүй, заримдаа нинжин сэтгэлээ хойш тавьж, зарим хүнд тийм ч эелдэг ханддаггүй юм шиг санагддаг тул Ян Хуй түүнээс илүү өршөөлтэй гэж хэлжээ. Магадгүй Ян Хуй үргэлж өрөвч сэтгэлтэй байсан бөгөөд хэзээ "үгүй", "ойлгохгүй байна", эсвэл "чадахгүй" гэж хэлэхээ мэддэггүй байжээ. Бүх зүйлийг "тийм", "тийм", "тийм" гэж хүлээж авах нь энэрэнгүй сэтгэл биш, харин тэнэглэл юм.

Энэрэн нигүүлсэхүйн дээд хэлбэр

Тиймээс Ян Хуй маш өршөөл энэрэлтэй, хайраар дүүрэн нэгэн боловч түүнд хайрлангуй бус байх тэр нэг хэсэг нь дутуу, энэрэн нигүүлсэх сэтгэлээсээ хэзээ салахаа үл мэднэ. Жинхэнэ хайранд суралцахын төлөө, илүү агуу дээд хайр нигүүлсэл, өршөөл энэрэлд суралцахын тулд Ян Хуй Күнзийн шавь болжээ. Энэ нь Күнз өршөөл энэрлийг мэддэггүй байсан юм биш, харин Тэрээр энэрэн нигүүлсэхүйн дээд хэлбэрийг мэддэг байсан.

Бид нэгэн Төгс Гэгээрсэн хүний тухайд ярихдаа Түүнийг бүрэн энэрэл нигүүлсэлтэй биш гэдэг. Түүний өршөөл нигүүлсэл, зан араншин, эсвэл аливааг хийх арга барил нь хүн төрөлтөн бидний төсөөлдгөөс өөр байдаг. Энэ нь бидний төсөөлж чадах ёс суртахуун, хүнлэг ёс, шударга ёс, ёс журам, билиг ухаан, итгэл үнэмшлийн хүрээнийх биш юм. Тэр хэдийнээ уг цар хүрээг давчихсан. Тэр хэзээ энэ цар хүрээнд байх ёстой бол байна. Бүр ч илүү олон хүнд тусалж, бүр ч илүү агуу үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд тэрхүү цар хүрээнээс давах ёстой болсон үед бол үүнээс давна. Түүний ирэх, явах чөлөөтэй. Бидний ихэнх нь яаж гарах, эсвэл яаж буцаж ирэхээ мэдэхгүй, зөвхөн энэ цар хүрээндээ л үлдэж чадах тул энэ нь нэг урсгалтай зам шиг арай илүү хөшингө

байдаг: явахаа мэддэг ч буцаж ирэхээ мэддэггүй.

Яг үүн шиг Зигүн уран илтгэх авьяастай, маргаж мэтгэлцэхдээ тун гаргуун. Гэвч тэр хэзээ маргаж мэтгэлцэж болохгүй, зүгээр л гэнэн цайлган хүн байх ёстойг мэддэггүй. Мэдэхгүй бол мэдэхгүй гэдгээ заавал хэлэх ёстой, бүхнийг мэддэг байх ёстой биш. Бидний мэдэх ёстой бүх зүйлийг бид мэднэ, бидний мэдэх ёсгүй зүйлийг бид мэдэх шаардлагагүй. Хэрэв мэдэхгүй бол: "Би мэдэхгүй ээ! Учир нь би ийм зүйлийг мэдэх шаардлагагүй." гэж хэлж болно. Зөвхөн мэдэхгүй байснаасаа болоод та үхэхгүй. Би мэдэх ёстой, хийх ёстой бүх зүйлээ мэднэ, эсвэл мэдэх ёсгүй зүйлтэй ороцолдохгүй.

Тэр ч байтугай, би мэддэг гэж хэлсэн ч заримдаа жинхэнэ ёсоор мэдэхгүй байдаг. Таныг юу гэж асуусан ч үргэлж хариулт өгдөг хүмүүс байдаг. Хэн ч тэднийг өөрөөр итгүүлж чадахгүй. Заримдаа хүмүүс хэт ядраад тэдэнтэй маргахыг хүсдэггүй, гэхдээ энэ нь тэд бүгдийг мэддэг гэсэн үг биш. Тэд дэндүү сониуч, ялан дийлэх дуртай, бүгдийг мэдэхийг, бүх зүйлийг ойлгохыг хүсдэг, тэгснээр энэ нь заримдаа үнэхээр ядаргаатай том ачаа болж хувирдаг. Тэгээд та хожигдохыг тэвчиж чадахгүй, та заримдаа маш жирийн, гэнэн цайлган, мэтгэлцэхийг мэддэггүй, хэн ялах нь хамаагүй хүүхэд шиг нэгэн болж чадахгүй байдаг.

"Төгс төгөлдөр"-ийн жинхэнэ утга

Өнөөдөр энэ түүхийг уншаад би өөрийгөө жаахан тайвшрууллаа, учир нь би заримдаа нөгөө талдаа итгүүлж чаддаггүй, цаад хүн маань өчнөөн сонгодог судар, баахан онолыг тасралтгүй ярьсаар байдаг, надад ч бас зөв санагдаад утга учиртай юм байна гэж боддог. (*Их Багш болон бүгд инээв.*) Тэгээд би ялагдчихаж байгаа юм. Гэртээ хариад бодох нь ээ, нээрээ Төгс Гэгээрсэн Их Багш байтлаа ингэж нүүрээ барах гэж бодогдов. (*Их Багш болон бүгд инээв.*) Тэгээд би

“За, нэгэнт л нүүргүй болчихсон юм чинь ялагдсан эсэх нь хэнд хамаатай юм.” гэж бодсон. (*Их Багш инээв.)*

Өнөөдөр Күнзийн: Заримдаа би ярих үедээ гацах хэрэгтэй болдог гэж ярьсныг уншлаа. Тэрээр Зигүн их уран яруу ярьдаг, мэтгэлцэх чадвар маш сайтай, гэвч хэзээ гацах ёстойгоо мэддэггүй байсан гэжээ. Тэгэхээр гацах нь ямар хэрэгтэй юм бэ? Энэ нь бид уран цэцэн биш гэсэн үг биш, гэвч тэр болгонд ялах шаардлагагүй, мөн тэр болгонд гайхалтай байх шаардлагагүй. Цаг үргэлж гайхалтай байдаг нэгнийг бусад хүн тэвчихийн аргагүй байдаг, тэр өөрөө өөрийгөө ч тэвчиж чаддаггүй. Хэрэв хүн хэзээ гацахаа мэдэхгүй, ингэж дасаагүй, дандаа ялдаг бол ялагдсан тохиолдолд үүнд дасаагүй болохоороо амиа хорлоно, ийм хүн байх нь хэтэрхий уян хатан биш. Тиймээс та энэ ертөнцөд хэтэрхий төгс байж болохгүй. Хэтэрхий төгс биш байх нь хэдийн төгс төгөлдөр мөн.

Энэ нь, хэмжээ дамжааг нь зохицуулж, хэдийд, юуг хийхэд тохиромжтой цаг болохыг мэдэх, хэдийд мэтгэлцэх, хэдийд нь үл мэтгэлцэхээ мэдэх, хэлгүй, эсвэл дүлий байх нь зүгээр, хамаагүй, ямар ч асуудалгүй байх нь л эрх чөлөөтэй, саадгүй тайван тогтуун байх гэсэн утгатай. Үргэлж сайн хүн болж, сайн нэр төрөө хадгалахыг бодож, хэн, юу ярьсан ч үргэлж мэтгэлцэн маргалдах нь дэндүү уйтгартай, дэндүү элдэг бус, төгс бус, бас хөгжилтэй биш. *(Их Багш инээв.*) Үргэлж нэг хэвийн байвал сонирхолгүй болно!

Төгс Гэгээрсэн Их Багш нөхцөл байдалд нийцүүлэн даруухнаар зохицуулж байдаг

Күнз хэлэхдээ: Зилу надаас илүү зоригтой гэв. Гэвч тэрээр хэдийд аядуу зөөлөн, хэдийд айж эмээсэн царай гаргах хэрэгтэйг мэддэггүй. Заримдаа ийм байх ёстой, үнэхээр ингэх ёстой шүү! Түрүүчийн удаа би та нарт хэлж байсан, бид нэгэн улсад Ау Лакын дүрвэгсдэд тусалж байх

үед тэд биднийг хүчээр дарангуйлан хязгаарлаж байсан. Мэдээж бид бас нэлээн олуулаа байсан болохоор эсэргүүцэж болно, гэтэл хоёр этгээд хоёулаа хатуурхан мөргөлдөөн үүсгэж зодолдвол та нарын бодлоор ямар үр дагавартай байх байсан бол. Мэдээж сайн биш, тийм биз? Нэгд, би бол зочин хүн бөгөөд хэн нэгний улсад байна. Хоёрт, бид бол сүнслэг бясалгал дадуулагчид. Гуравт, бид туслахаар ирсэн болохоос нөхцөл байдлыг хүндрүүлж, үл ойлголцлыг гүнзгийрүүлэхээр очоогүй. Ингэвэл хоёр талд алинд нь ч хохиролтой, тийм биз дээ?

Тэр үед хэрвээ Багш нь зөөлөн байгаагүй, орхиж яваагүй, тэдний хүчнээс айсан дүр үзүүлээгүй, бууж өгөхгүй бол энэ нь маш их төвөгтэй, ээдрээтэй болж, Ау Лакын дүрвэгсдэд ямар ч тус болохгүй байсан. Хэрэв бид ялсан бол яах байсан бэ? Удалгүй буцахын тулд онгоцны тасалбар худалдаж авах шаардлагатай байсан. (*Их Багш болон бүгд инээв.*) Бид тэнд үүрд амьдрах биш. Тиймээс юу хийсэн ч дэндүү сэтгэл хөөрч болохгүй, жинхэнэ баатрыг ялалт ялагдлаар нь, амжилт, бүтэлгүйтлээр нь дүгнэж болохгүй.

Одоо ч, урьд ч Хятадын тулааны урлагийн суралцагсад, багш, мастерууд зэвсгийн эрдмээ хамаагүй үзүүлж, гайхуулахыг хүмүүст үргэлж хориглодог, мөн тэсвэрлэх чадваргүй болтлоо тэсвэрлэж, хамгаалахын тулд л довтлохыг сургадаг байжээ. Тэднийг хүн тулаанд дуудмагц шууд л өөрийн тулааны эрдмийг үзүүлж болохгүй байсан, тийм үү? Ингэлээ гээд зориггүй, тулалдах эрдэмгүй болчихгүй, тэвчиж чадах нь харин жинхэнэ тулааны урлаг мөн, тулалдахгүй байх нь дээр.

Мэдээж хэрэг, хэрэг гарвал ашиглах ёстой ч бид хэнээс ч айдаггүй, бидний тулааны урлагийн чадвар ямар мундаг, бид ямар авьяастай, мөн ямар хүчирхэг вэ гэдгээ бусдад мэдрүүлэхийн тулд байнга харуулаад байх шаардлагагүй. Тиймээс зарим үед Төгс Гэгээрсэн Их Багш

энэ дэлхий дээр аливаа асуудлыг жам ёсны дагуу, нөхцөл байдалд нийцүүлэн даруухнаар зохицуулж байдаг.

Яг л Шагжамуни Бурхантай адил, хүмүүс Түүнтэй ид шидээ мөчөөрхөх гэвэл Тэр ерөөс мөчөөрхдөггүй, агуу гайхамшигт хүчийг эзэмшсэн ч тулаанд дуудах үед Тэрээр бусадтай өрсөлдөхөөс татгалздаг байв. Есүс Христ ч мөн маш их ид шидийн хүчтэй. Хүмүүс Түүнийг цовдлохыг хүсэж байгааг Тэр сонсоод энэ бол Түүний хувь тавилан бөгөөд хамаг төрөлтнийг аврахын тулд загалмайд цовдлогдох ёстой гэдгээ мэдсэн тул цовдлогдохыг зөвшөөрсөн. Энэ нь Тэр зугтаж чадахгүй байсан гэсэн үг биш юм, Тэрээр олон шавьтай байсан, ид шидийн хүчээ ашиглах ч шаардлагагүйгээр зугтаж чадах байсан, гэхдээ Түүний цаг дууссан гэдгийг Тэр аль хэдийн мэдэж байв. Энэ нь Тэр мэдэхгүй байсан гэсэн үг биш, Тэр урьтаад зугтаж чадах байсан, гэхдээ ид шидийн хүч ашиглах ч шаардлага байгаагүй

Арван нэгдүгээр бүлэг

БАО ШУЯ, ГУАНЬ ЖУН ХОЁРЫН САЙН ҮЛГЭР ДУУРАЙЛ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шихү ашрам.
1996 оны 1 дүгээр сарын 7
(Эх нь хятад хэлээр)

Эртний Хятадад гэгээнтэн мэргэд олон байсан ч хүн бүр тэднээс суралцаагүй нь үнэхээр харамсалтай! Жишээ нь, урьд Бао Шуя, Гуань Жуныг хэрхэн танилцуулсныг харахад түүний үйлдэл үнэхээр гайхалтай.

Чүньцюгийн ороо бусгаа цаг үеийн хоёр суу билигтэн

Өмнө нь Гуань Жун, Чи улсын Хуань гүнийг харваж хараахан аминд нь хүрээгүй аж. Тэр үед Хуань гүн үхсэн мэт дүр эсгэжээ. Дараа нь Хуань гүн Чи улсын хаан болоход Гуань Жун өөр улс руу зугтсан байна. Бао Шуя Гуань Жун

бол үнэхээр эрдэм төгс хүмүүн гэдгийг сайн мэдэж байсан тул түүнийг даруй эргүүлэн авчирч, Чи улсын Хуань гүний дор чухал албанд томилохыг хүсжээ. Гуань Жун бол улс орноо төвшитгөж чадах их сайд бөгөөд түүнгүйгээр Дундад улс нэгдэж, энх тайван тогтож чадахгүй гэдгийг Бао Шуя ойлгож байв. Иймээс Бао Шуя найзыгаа аварч, буцааж авчрахын тулд бүх арга замыг эрэлхийлэн, түүнийг авчрахыг доод албан тушаалтнууддаа тушаажээ.

Тэр үед Гуань Жун Лу улсад орогнож байжээ. Лу улсын нэгэн их түшмэл түүний эрдэм чадлыг олж хараад хаандаа хандан: "Эрхэм дээдэс ээ, та энэ хүнийг суллаж явуулж болохгүй, хэрвээ та түүнийг ашиглахгүй бол алах нь зөв." гэжээ. Лу улсын хаан, Гуань Жуныг яагаад ашиглах ёстой, бас яагаад алах ёстой вэ гэдгийг асуухад мэргэн түшмэл нь: "Гуань Жун бол энэ дэлхийн нэгэн их авьяас билигт хүмүүн болно, түүнийг одоо Чи улсын Хуань гүний талд өгвөл түүнийг нэн чухал албанд томилох нь тодорхой. Тэгвэл та өнгөрнө! Хэрвээ та түүнийг ашиглахгүй бол алсан нь дээр. Бусдын гарт өгөх нь дэндүү аюултай!" гэжээ. Улс төр гэдэг үнэхээр аймшигтай шүү. Нэгэн авьяас төгөлдөр хүнийг олж авах нь тун ховор явдал, хэрэв өөрөө ашиглахгүй бол бусдад ашиглахыг нь зөвшөөрч болно оо доо, яагаад болохгүй байх вэ? Магадгүй тэд Арьяабалын бясалгалын аргыг дадуулаагүй болохоор бусадтай хуваалцах сэтгэлгүй, эрхэм ариун үзэл санаагүй байсан хэрэг, тийм учраас л ийм зан гаргадаг байна.

Лу улсын хаан мэргэн түшмэлийнхээ саналыг сонсоод эхэндээ Гуань Жуныг хороох бодол агуулж байсан ч Бао Шуягийн илгээсэн шадар туслах нь илүү ухаалаг байв, тэрээр: "Хэрвээ та энэ хүнийг алчхаад цогцсыг нь бидэнд өгвөл өгөөгүйтэй адил болох бөгөөд энэ нь та манай хааныг дорд үзсэн хэрэг болно. Гуань Жун өмнө нь манай Чи улсын хааныг харвасан бөлгөө, тэр өсийг хаан хараахан аваагүй

байгаа болохоор үхэвч амар амгалангүй байх болно.” (Энэ бол дайснаа хуурах нэг зүйлийн арга мэх байжээ.) “Эрхэм дээдэс та түүнийг манай Чи улсад буцаан өгч шийдүүлэхгүй аваас манай хоёр улс хоорондоо дайтаж мэднэ.” гэв. Лу улсын хаан үүнийг сонсоод өөр аргагүй болохыг ухаарчээ. Түүний улс нэлээд ядуу буурай, тэгээд ч тэдний хүнийг алах шалтаг байхгүй, хэдийгээр өөрт нь тусгүй боловч өөр аргагүй тул хаан, түшмэл хоёр хүлцэн тэвчээд Гуань Жуныг буцааж гэнэ.

Гуань Жун ч бас тун ухаалаг байсан, түүний хойноос нэхэж, амийг нь хөнөөнө гэдгийг тэр мэдэж байв, тиймээс маш олон дуу зохиож, замдаа хоригдлыг харгалзан яваа хуягуудаар зохиосон дуунуудаа дуулуулж явснаар зам ч тун хурдан хорогдож гэнэ. Лу улсын их түшмэл түүнийг хороохоор хойноос нь мөшгөсөн ч гүйцсэнгүй. Энэ бол гайхалтай хэрэг, бүгд ухаалаг байсан. Хүмүүс бүгдээрээ ийм сүрхий! Хэрвээ бид бүгд тэдэн шиг гайхалтай байсан бол хэчнээн сайн хэрэг байх вэ! Энд ийм мундаг хүн байна уу? Бараг л алга, цорын ганц ухаалаг нь би бололтой. *(Их Багш болон бүгд инээв.)*

Бао Шуя найзыгаа амжилттай аварч чаджээ. Гуань Жун ч мүглэнтэй тэргэнд өөрийгөө аварч чаджээ. Мүглэнтэй тэрэг, Чи улсад ирээд зогсоход Гуань Жун Чи улсад буцан ирснийг Бао Шуя сонсоод даруй угтахаар очив. Тэрээр шоронгийн мүглэнтэй тэргийг нээж, даруй Гуань Жуныг суллав. Гуань Жун: “Хараахан зарлиг хүлээж аваагүй байхад чи ийм хурдан хаалга нээж болохгүй.” гэхэд Бао Шуя: “Айх хэрэггүй ээ, би тун удахгүй чамайг Чи улсын хаанд танилцуулна.” гэв. Гуань Жун маш даруухнаар: Миний эзэн нэгэнт нас барсан, эзнээ хамгаалж чадаагүй би ямар нүүрээрээ өнгөрсөн эзэнтэйгээ Шар булгийн (газар доорх) оронд золгох вэ? гэв.

Шууд хүлээн авахад жаахан эвгүй, тэр ичиж байсан

тул зөвшөөрөхөөс нь өмнө бусад хүн түүнийг ятгах ёстой байв. Гэнэтхэн гарч ирээд л “За, би их сайд болж чадна.” гэж хэлж чадаагүй хэрэг. Бао Шуя ч мөн түүнд итгэсэн дүр эсгэн: “Зүгээр дээ, энэ бол өчүүхэн асуудал. Эрдэм чадалтай хүн үүнийг хийж чадна, бид улс орны их үйл хэрэг, дэлхий дахины энх тайванд анхаарал хандуулж, өчүүхэн жижиг булан тохой, эсвэл аль хэдийн өнгөрсөн хүнтэй зууралдах ёсгүй. Бид ганц хоёрхон хүнд бус, дэлхий ертөнцөд үйлчлэх ёстой.” гэв. Гуань Жун өөрийгөө үнэ цэнтэй гэдгийг мэдрээд үхэх хүсэлгүй болж гэнэ.

Тэр эхлээд магадгүй үхэх санаатай байсан байх, би сайн мэдэхгүй. Хэрвээ үнэхээр үхэхийг хүссэн бол тэр яагаад харгалзагч хуягуудаар дуу дуулуулж, хурдлуулан зугтсан юм бол? *(Бүгд инээв.)* Зүгээр л түүнд итгэцгээе дээ!

Гэгээн мэргэн хаанд хүртэл цэгц шударга их сайдын тусламж хэрэгтэй

Тэр хоёр ярьж тохироод дараа нь Бао Шуя, Чи улсын Хуань гүн дээр очиж: “Эрхэм хаанд айлтгах хоёр зүйл байна. Эхнийх нь, улсын их үйл хэргийн төлөө та өөрийн сэтгэл хөдлөлөө тэвчиж, хайр хорслын сэтгэлээ тасдах хэрэгтэй, энэ талаар би харамсаж, эзэн таныг маш их өрөвдөж байна. Удаах нь, эзэн хаанд баяр хүргэх зүйл бол энэ дэлхийн агуу авьяаслаг хүмүүн Гуань Жун хэдийнээ аврагдсан. Эзэнтэн минь, та өнөөдрөөс эхлэн танд туслах ухаалаг мэргэн хүнтэй болно.” гэв. Чи улсын Хуань гүн: “Тэр хүн намайг харвасан билээ. Үүний хариуг би авах болно, сумыг нь ч бас хадгалсаар байгаа гэдгийг санаарай. Би түүнийг хэрэглэж яаж болох вэ? Түүнийг буцаж ирэхээр нь алж, түмэн хэсэг огтчиж хаяна.” гэв.

Хэдийгээр нэгэн улсын сүр жавхлант эзэн хаан атал өчүүхэн өсөрхлөө мартаж чадаагүй. Түүнийг магтсан хэнийг ч удаан хугацаанд мартахгүй үргэлж санаж байх

бөгөөд хэн нэгэн нь түүний тухай муу үг яривал гурван үй (ургийг) нь "чөлөөлж" мэднэ. *(Гурван үй ургийг устгах гэсэн утгатай. «гурван ураг» (эцэг, эх, эхнэрийн тал) «гурван үе» (үе дамжсан удам) биш.) (Бүгд инээв.)* Ихэнх хаадын хүлцэн өршөөх чанар нь ихэвчлэн тун бага байдаг тул дэргэд нь зөвлөгөө өгөх ёс зүйтэй, үлэмж их авьяаслаг хүмүүс, дээд дэстэй лам нар, эсвэл сүнслэг бясалгалтай хүмүүс байх хэрэгтэй байв, олон байх тусмаа сайн. Гэхдээ ихэнх нэр хүндтэй хувраг, эрхэм дээд ёс зүйтэй хүн түшмэл болдоггүй, тэд юм бүхэн цөм жүжиг гэдгийг мэдэх тул тэнд очиж жүжиглэхийг хүсдэггүй. Заримдаа уйдсан үедээ л оролцдог, гэсэн хэдий ч тэдний ихэнх нь ийм айхтар зовлонт газар очихгүй, тамын гал руу орохгүй.

Аз болоход Гуань Жун, Бао Шуя хоёр байгаа нь тун сайн хэрэг. Магадгүй их сайд болж, эзэн хаанд туслах нь тэдний хувь тавилан байх, эс бөгөөс хаан эзэн юу ч хийж чадахгүй. Буян хишигтэй боловч ёс суртахуунаар дутмаг, буяны үрээр хаан болсон ч ертөнцийн явдал, улсын хэргийг зохицуулах билиг ухаан, ёс суртахуун байхгүй. Тэдгээр их сайд ёс суртахуунтай ч хаан болох буянгүй, зөвхөн түшмэл хийх л буянтай. Тэд түшмэл байх буянаа хаан эзэндээ туслахад ашиглаж чадна.

Үнэндээ тэд бүгд зөвхөн жүжигт оролцон тоглохоор бууж ирдэг, нэг нь эзэн хаан байхыг, нөгөө нь их сайд болохыг сонгоно, нэг нь гол дүрд, нөгөө нь хэдий алдартай ч туслах дүрд тоглодог, энэ хамаагүй, авах мөнгө нь л харьцангуй бага байх. *(Бүгд инээв.)* Нэг их ялгаа байхгүй, туслах жүжигчин байхгүй бол гол дүрийн жүжигчин тоглох аргагүй, гол дүрийн жүжигчин үгүй бол туслах жүжигчин ч хэрэггүй, найруулагч ч хэрэггүй. Тиймээс бид байхгүй бол Эзэн Бурхан хэрэггүй! Түүнээс бүү ай. *(Бүгд алга ташив.)*

Бао Шуя хэлрүүн: "Бүх үнэнч сайд нар өөрийн эзэндээ

чин сэтгэлээсээ үйлчилдэг. Тэр үед Гуань Жун, зөвхөн Жиу ханхүүд л үйлчилж байсан. (Ханхүү Жиу, Хуань гүн хоёр ах дүү байсан ч тухайн үед хаан суурийн төлөө өрсөлдөж байжээ.) Жиу ханхүү түүний эзэн нь байсан тул мэдээж өөрийн эзэн Жиу ханхүүгийн төлөө эрхэмсэг хаан таныг харвасан нь мэдээж хэрэг. Одоо хэрэв та түүнийг өндрөөр үнэлэн хүндэлж, чухал албанд томилбол тэр таны төлөө энэ сумаар дэлхийн бүх хүнийг харвах болно." гэв. Хуань гүн ийм хүнийг олж авах болсондоо ихэд баярлав. Аз болоход тэр эцэст нь ойлгож сонсжээ. Миний хэлсэнчлэн, хаан байх амархан, ерөнхийлөгч байх ч амархан, бусдын үгийг сонсдог байхад л болно. Хэрэв ухаалаг, мэргэн ухаантай, авьяас төгөлдөр хүмүүсийн санал, зөвлөгөөг сонсдог байвал хаан ширээнд он удаан сууж, улс орноо төвшитгөн захирч чадна.

Үүнтэй адилаар, бясалгагчид бид хэрэв гэгээнтэн мэргэдийн зааврыг үл дагаж, эртний хүмүүсийн мэргэн сургаалыг сонсохгүй бол өөрсдийн өчүүхэн зүйлсийг хэрхэн зөв сайн хийж гүйцэлдүүлж чадах вэ? Бид мэдэхгүй, тиймээс илүү мэргэн ухаантай, илүү сайн мэддэг хүмүүсийн сургаалыг сонсох хэрэгтэй. Эрт дээр үеэс дэргэдээ сайн, мэргэн зөвлөхүүдтэй байж чадсан ямар ч хаан үргэлж маш ухаалаг байдаг. Тэр авьяас чадвартай, эсвэл мэргэн ухаантай байх шаардлагагүй. Даруухан, ухаалаг, бусдын зөв сайн санаа бодлыг хүлээн авах хүсэл эрмэлзэлтэй байхад л хаан байж чадна. Хаан байх ийм амархан юм чинь та нар оролдоод үзэхийг хүсэж байна уу? (*Их Багш болон бүгд инээв.) Би*лиг ухаантай хэдэн хүнийг хайж олоод хамжилцуулбал хаан болж болно, зүгээр л гэртээ хаан болж болно, Чи улсын хаан Хуань гүн, Бао Шуягийн хэлэхийг сонсоод Гуань Жуныг өршөөн хэлтрүүлсэн боловч түүнийг дэргэдээ авах бодол байсангүй. Гуань Жуныг авьяас чадвар төгс хүн гэдгийг Бао Шуягаас сонссон хэдий ч үнэндээ ямар авьяастай болохыг

нь мэдэхгүй байв. Тэрээр зөвхөн Бао Шуяд л хаан төрийн бүх их хэргийг хариуцуулах санаатай байжээ. Бао Шуя: “Хаан эзний их ивээл нигүүлслийн ачаар манай бүхий л гэр бүлийн аж амьдрал элбэг хангалуун, сэтгэл дүүрэн байдаг тул танд тун их талархаж байна. Улсын их хэргийг зохицуулахад миний авьяас чадвар дутах тул би хариуцлага хүлээж зүрхлэхгүй гэж хэлжээ. Чи Хуань гүн түүнийг үргэлжлүүлэн ятгасан ч тэр: “Үнэхээр болохгүй, өчүүхэн би ёс журмыг мэднэ, жаяг дүрмийг ойлгоно, хаан эзнээ маш их хүндэтгэнэ. Гэсэн хэдий ч төрийн хэргийг Гуань Жун шиг сайн шийдэж зохицуулж үл чадна. Хэрвээ хаантан намайг хүчээр хэрэглэх аваас сайн нь бага, саар нь их байх болно. Төрийн үйл хэрэгт мэргэн байхын тулд дээшээ тэнгэрийн хөвгүүн (эзэн хаан)-д гавьяа байгуулж, доошоо ноёдод ивээл хайрлах хэрэгтэй, ингэснээр улс орон тогтвортой байж, эзэн хаан улам алдаршин түмэн үедээ алдар нэр тань мөнхрөх болно. Үүнийг онцгой чадвартай нэгэн хийж чадахаас жирийн хүмүүн яахин чадах буй.” гэв. Тэр өөрийгөө эгэл жирийн хүн, авьяас чадвар төгөлдөр биш нэгэн хэмээн үзэх ажээ. “Хаан эзэнтэнд үнэхээр улс орныг удирдаж чадах хүмүүн хэрэгтэй бол гагцхүү Гуань Жун л байна. Түүнээс илүү сайн хүнийг би олж харахгүй байна.” гэв. Бао Шуя үнэхээр хүн таних хурц мэлмийтэй, хэрвээ манай энд түүн шиг нэг хүн байвал хэчнээн сайн бэ, хаа нэгтээ тийм хүн таарвал та нар бариад ирээрэй.

Нийтийн хэргийг шийдэхэд хувийн сэтгэлийг огоорох хэрэгтэй

Чи Хуань гүн Бао Шуяд тун их итгэнэ. Бао Шуя түүнтэй жаргал зовлонгоо хамтатгаж, яг л найз нөхөд, ах дүүс мэт байнга хамт байсан. Хуань гүн сайн сайхан зүйл юу байна, түүнийгээ Бао Шуяд өгөх гэтэл Бао Шуя татгалзсан болохоор мэдээж сэтгэл нь тавгүйтнэ. Тэр бусад хүнд итгэдэггүй байв. Бид бүгд ийм байдаг, хамт амьдардаг

хүмүүстээ дуртай, тэдэнтэй сэтгэл зүрхээрээ холбогдсон байдаг учраас илүү дассан байдаг, ингэж бид тэдэнд сэтгэлийн өртэй болсон тул аливааг хийхэд хэцүү болдог.

Бид олон нийтийн хэргийг шийдвэрлэхдээ шударга хандах ёстой, авьяас билигтнийг хүмүүст танилцуулж, хүндэтгэн дахин чухал албанд томилох нь зүйтэй, ингэх нь олон түмэнд ач тустай. Энэ миний сайн найз, эсвэл миний ах, эгч гээд түүнийг нэн тэргүүнд тавьж болохгүй. Ингэх нь буруу! Бид хэрэг учрыг шийдэхдээ үргэлж хувь хүний хайрын сэтгэлээ оролцуулдаг болохоор бүр ч илүү ээдрээтэй болгодог. Олон хаад хайртай татвар эм, үзэсгэлэнт бүсгүйд шунаснаасаа болж, улс гүрнийхээ их хэргээр наадаж, эцэст нь улс орноо мөхөж сүйрэхэд хүргэдэг. Эрт дээр үеэс л ийм байсаар ирсэн. Сүнслэг бясалгагчид бид эдгээр сургамжаас суралцах нь сайн хэрэг, хараахан Бурханы хутагт хүрээгүй байгаа үедээ түр зуур энэхүү “дайны тактик”-ыг түр ашиглах нь бас тустай.

Бао Шуя хэдийнээ олон зүйлийг зөвлөсөн ч Чи Хуань гүн харин эргэлзсэн хэвээр байв, эцэст нь: “За яах вэ, тэгэхээр чи түүнийг дуудаж авчир! Би түүний авьяас чадварыг шалгая.” гэлээ. Хуань гүны яасан ч яах вэ гэсэн тоомжиргүй царайг хараад Бао Шуя ингэж болохгүй гэв. “Хэрвээ нэгэн хүний байр суурь маш доогуур байх аваас баян хүнийг захирч чадахгүй, эдийн засгийн их эрх мэдэлгүй бол баян чинээлэг гэр бүлийн асуудлыг шийдэж чадахгүй. Нэгэн дорд байр суурьтай хүн юу ч хийж чадахгүй, баян язгууртан эрхмүүдтэй үг ярьж ч чадахгүй, тэднийг өөрийгөө сонсохыг шаардах нь битгий хэл хэрхэн тэдэнтэй үг ярьж чадах вэ? Хэрвээ хаан эзэнд Гуань Жун хэрэгтэй бол түүний авьяас чадварт нийцүүлэн их сайдын суурийг соёрхож, эсвэл эцэг, эх шигээ хандах хэрэгтэй.” гэжээ.

Та нар юу гэж бодож байна? Гуань Жунд ах шигээ, эцэг шигээ хандвал тэр түүнд туслах болно. Та нар намайг

Багш-Ши фу[11] гэж дууддаг нь аргагүй юм байна. Би одоо л мэдлээ! *(Бүгд инээв.)* Өөрсдийн тусын тулд надад ямар ч нэр өгнө. Хуурмаг нэр алдар, хий хоосон байр суурь өгч байгаад намайг галзуу юм шиг л ажиллах болгодог. Энэ хөгшин үнэхээр хэтэрхий тэнэг юм даа, арга мэхэнд нь унажээ. Өнөөдөр эртний хүмүүний түүхийг уншаад удаан хугацаанд хууртагдсанаа сая л ойлголоо. Үүнээс хойш би та нарыг Ши фу (багш - аав) гэж байя. *(Бүгд инээв.)* Бид ажлаа солилцьё доо. *(Үгүй ээ гэцгээв!)*

Дээд суудалд очих тусам даруу чанар улам чухал

Бао Шуя үргэлжлүүлэн: "Хэрвээ түүнийг их сайд болгоё гэвэл нялх хүүхэд мэт, эсвэл нэгэн ямар ч нэр төргүй доодос мэт, эсвэл эгэл жирийн хүн мэт дуудан ирүүлж яаж болох вэ? Дэндүү үл хүндэтгэсэн, дэндүү хайхрамжгүй хэрэг болно. Гуань Жун бол түмнээс төгөлдөр авьяас чадвартай нэгэн. Хаантан минь та нэгэн билиг дэмбэрэлтэй өдрийг сонгож, өөрийн биеэр түүнийг залж ирэх нь зөв." гэжээ. Нэгэн их сайдыг залахдаа ингэх ёстой. Хожим нь Чи Хуань гүн Хятадын Дунд орны эзэрхэгч хаан болсон нь гайхах зүйл биш юм байна. Тэр үүнийг хүртэх эрхтэй. Хаан эзэн ийм даруу байх нь сайн хэрэг.

Өнөөдөр энэ дэлхий дээр хэчнээн хаан, улс төрч, улсын тэргүүн ийм эгэл даруу байж чадах вэ? Байж магадгүй, гэвч бид мэдэхгүй. Хэрэв байгаа бол гайхалтай, дэлхийдээ баяр хүргэе. Эгэл даруу эзэн хаад, ерөнхийлөгчтэй улс орнуудын өмнөөс бид баяртай байна. Ийм удирдагчид, хаад хэдий чинээ олон байвал манай дэлхий төдий чинээ илүү амар амгалан, тав тухтай байх болно.

Хаан хүн ийм даруу төлөв байх хэрэгтэй. Байр суурь хэчнээн өндөр дээд байх тусмаа улам даруу төлөв байх ёстой. Бид энэ дэлхий дээр ямар ч байр суурьгүй, өчүүхэн

11 Хятадаар багш-аав гэсэн үг

жижиг хүн л шүү дээ, тиймээс бүр ч даруу байх ёстой. Би бахархаж байвал хамаагүй *(Их Багш инээв. Бүгд алга ташив.)*, би бол Их Багш! Ихэнх Их Багш нар ийм байдаг, өөрөөр байвал Их Багш шиг биш болчихно. Жүжиглэх нь ч бас тун сонирхолтой шүү. Би дотроо их даруухан, та нар үүнийг харж чадахгүй байсан ч итгэх хэрэгтэй. *(Их Багш болон бүгд инээв.)*

Үнэнч шударга, мэргэн ухаант Бао Шуя

Бао Шуя хааныг ятгасаар байв. Тэрээр: "Хэрвээ хаантан Гуань Жун шиг ийм чадвартай авьяаслаг хүнд хүндэтгэлтэй хандвал дэлхий даяараа таныг маш ихээр биширч, улам их хүндлэх болно. Учир нь хаантан та хувийн өшөө хорслыг тэвчсэн төдийгүй, улс орон, дэлхий дахины төлөө гэгээн мэргэн чадвартныг хүндэтгэн хэрэглэсэн болохоор хожим даян дэлхий таных болох нь гарцаагүй." гэв. Тэр тэнгэрийн бошго хожим нь үнэхээр биелэх юм шиг ярьжээ. Чи улсын Хуань гүн толгой дохин зөвшөөрөв. Чи улсын энэ хаан үнэхээр сайн хүн бөгөөд хожим нь тэрээр Хятадын эзэрхэгч эзэн болсон нь зүй ёсны хэрэг байжээ.

Үүнээс бид Бао Шуя хэчнээн агуу хүн болохыг мэдэж болно. Тэр ач гавьяандаа дулдуйдан алдар нэр, ашиг хонжоо хайсангүй, мэргэн авьяастныг хавчин боомилсонгүй, Гуань Жуныг нуун дарагдуулж, түүний талаар муугаар өгүүлсэнгүй. Харин ч арга бүхнийг сүвэгчлэн түүнийг аварч, эзэндээ өргөжээ. Хэрэв эрх мэдэлтэй түшмэл ийм байвал тэр нь энэ дэлхийн хамгийн шударга түшмэл юм. Хэрэв хүн бүр ийм байвал тэр нь энэ дэлхийн хамгийн сод мэргэн хүмүүс болно. Хэрэв ийм найз байвал тэр нь энэ дэлхийн хамгийн сайн нөхөр мөн.

Манай дэлхийд ийм хүмүүс олон байвал хэчнээн

сайхан бэ, үнэхээр сайхан байх болно. Сүнслэг бясалгагчид бид ч бас. Энэ бол хүний хувьд бидний хийх ёстой хамгийн бага зүйл, бид аливаа зүйлд маш шударга хандах ёстой, хувийн өс хонзонгоор бусдыг нуун дарж, дээш дэвшүүлэхгүй байж болохгүй, дарамталж байгаад авьяасыг булшлах ёсгүй. Улс орноо, эх дэлхийгээ улам баян чинээлэг, энх амгалан болгох хэрэгтэй гэж өөртөө сануулах ёстой. Энэ цаг үед хэн нэгэн нь жаахан авьяас чадвартай бол харьцангуй аюултай нөхцөл байдалд байна. Ер нь ихэнх цаг үед ийм л байсан. Аз болоход, чадвартай хүмүүсийг хэрхэн хэрэглэхээ мэддэг хүмүүс байсаар байна.

Хэдийгээр Бао Шуя өөрийгөө улс гүрний чухал үйл хэргийг шийдэх авьяас чадваргүй гэх боловч миний бодлоор тэр үнэхээр сайн хүн. Ухаантай хүн гэдэг нь өөрийгөө таньж мэддэг хүнийг хэлнэ. "Өөрийгөө болон бусдыг таньсан хүн зуунтаа ялна." гэдэг үг бий. Хэрвээ тэр өөрийн дутагдлаа хэдийнээ мэддэг бол тэр тун сайн хүн, төгс төгөлдөр хүн гэсэн үг. Бидний төсөөлдөг "төгс төгөлдөр хүн" гэдэг нь ихэвчлэн тэнд зүгээр л сууж нүдээ аньсан эсвэл нээсэн хэвээр, юу ч болсон ч үл хөдөлдөг бусдын хараал, магтаалд яах ч үгүй нэгэн мэт байдаг, Түүнд хайрлах сэтгэл ч үгүй, хүмүүстэй харилцах ч үгүй, найз нөхөд ч үгүй, хүний сэтгэл хөдлөл ч байхгүй гэж төсөөлдөг. Гэвч төгс төгөлдрийн тухай ийм ойлголт үнэхээр буруу. Хэрэв бид тийм бол тэнд зүгээр л нэг чулуу эсвэл мод тавиад л "төгс төгөлдөр хүн" гэж нэрлэж болох биш үү! *(Бүгд инээв.)*

Төгс төгөлдөр хүн өөрийн давуу талаа хөгжүүлдэг

Төгс төгөлдөр хүн өөрийн давуу болон сул талаа мэднэ. Сул талаа дарж, эсвэл хойш тавина, эсвэл түүнийгээ хянаж чадна, зөвхөн шаардлагатай үед ашигладаг. Тэрээр давуу талаа бусдад болон өөртөө туслахын тулд тасралтгүй хөгжүүлж байдаг. Энэ бол төгс төгөлдөр хүн мөн. Хэрвээ хүн төгс төгөлдөр, арван хуруу тэгш өөлөх юмгүй боловч

ямар ч сэтгэл зүрхгүй, амьдралын ямар ч хувиралгүй бол тун уйтгартай. Тиймээс би та нарыг хааяа нэг зэмлэж, жаахан амтлагч нэмдэг бөгөөд та нар ч бас үүнд дуртай байдаг. *(Бүгд алга ташив.)* Хэрвээ та нарт таалагдахгүй бол би ч бас тоохгүй, модон бурхны дүрд тоглож чадна. Та нарыг ирэх болгонд "Сайн сайн!" гээд толгойг тань илээд сууна. Үнэндээ ингэх нь зүгээр, надад сайн бөгөөд намайг улам таргалуулна. *(Бүгд инээв.)*

Гэтэл энэ дэлхий дээр ийм хариуцлагагүй их багш аль хэдийнээ олон болсныг би харж байна. Бас сүм хийдэд олон модон бурхан байдаг, өөр нэг нь болох гэж дүр эсгэх шаардлага надад байхгүй. Манай дэлхийд ихээхэн ажил хэрэгч, уян хатан, аливааг илүү сайн хийдэг, илүү арга ухаантай бурхан хэрэгтэй байна. *(Бүгд алга ташив.)*

Хэрэв сүнслэг бясалгагчид аливааг хийхдээ Бао Шуя шиг ийм даруу, ухаалаг биш бол ичих хэрэгтэй. Хятадад ийм хүмүүс хааяа байсан учраас бусдаас илүүтэй өөрийн өвөг дээдсээс суралцах нь бидний хувьд илүү сайн гэдгийг санаж байхыг би хүн бүхэнд сануулж байдаг. Гурван хүн хамт явж байвал тэдний нэг нь лавтай миний багш байх ёстой гэж богд гэгээнтэн ярьсан байдаг. Магадгүй гурвуулаа ч байж болно, тэд бидэнд өөр өөр зүйлийг зааж болох билээ.

Бао Шуя, Гуань Жуныг бахдан магтдаг болохоор та нар тэрээр Гуань Жуныг бүх зүйл дээр бишрэн хүндэлдэг гэж бодсон байх, гэхдээ яг тийм биш байж мэднэ! Тэр өгөөмөр уужим сэтгэлтэй хүн. Улс орныхоо төлөө бүхнийг хойш тавина. Хожим нь Гуань Жун, хаан эзний хамт өглөөнөөс үдэш болтол идэж уун зугаацан цэнгэдэг байв. Хааны ордон бол тансаг жаргалд ташуурах газар, Гуань Жун ч бараг адилхан орчинд байлаа. Бао Шуя түүний энэ зан чанарт төдийлөн дуртай биш байсан юм. Тэгээд түүнд хандан: Хаан эзэн тансаг жаргалд ташуурч байхад түшмэл нь болсон чи арвич хямгач байхыг ятгахын оронд харин ч түүнтэй хамт

тансагладаг. Үүнийг юу гэж ойлгох вэ гэхэд Гуань Жун хариуд нь: Чи улсын хаан олон жил шаргуу ажилласан тул үнэхээр их зүдэрсэн байна. Одоо эцэст нь хаан ширээнд залраад жаахан амсхийж, жаргал цэнгэлийн таашаал авахыг хүсэх нь мэдээж. Энэ асуудал биш! гэв. Хэдийгээр Бао Шуя түүнтэй маргаагүй ч сэтгэлд нь нийцээгүй нь лавтай.

Бао Шуя арай хуучинсаг үзэлтэй, энгийн даруу амьдралтай, баян тансаг хэрэглээгүй, бас Гуань Жун шиг хашир, сэргэлэн аргат хүн биш юм, энэ тал дээр түүнээс дутуу. Тиймээс Гуань Жун их сайд болж, харин Бао Шуя чадаагүй. Өөрөө үүнийгээ мэддэг боловч хүний сэтгэл үргэлж тодорхой нэг зүйлд хүлэгдэж байдаг. Тийм биш бол хүн биш болчихно! Тиймээс тэр өөрийн найз Гуань Жуныг дэндүү үрэлгэн тансаг амьдарч байна гэж буруутгаж, бусад түшмэлийг үрэлгэн байдалд уруу татдаг хэмээн байнга шүүмжилнэ. Энэ хамаагүй! Тэд улс орноо сайн удирдаж чадаж л байгаа бол хамаагүй! Олон ядуу хүн хүнд хэцүү амьдралаар амьдарч байсан, гэхдээ тэд бас улс орноо удирдаж, эсвэл хүн бүрийг хамтдаа эв найртай амьдруулахын тулд бүх Хятадыг нэгтгэж чадахгүй. Чи улсын хаан Хуань гүн илүүхэн үрэлгэн байж магадгүй, гэхдээ тэр аливаа зүйлийг зохицуулж чаддаг байсан бол энэ нь ямар хамаатай юм бэ? Бүхэл Хятадад зөвхөн тэр л тансаг амьдарлаа гэхэд энэ нь нэг их ялгаа гаргахгүй, тэр ч байтугай тэрээр өөрийн бүхий л эд хөрөнгийг эх орондоо өргөсөн ч улс орон нь илүү цэцэглэн хөгжсөн орон болчихгүй.

Нэгэн үеийн их эзэн Чи Хуань гүн

Гуань Жун, Бао Шуя хоёр тийм сайн найзууд ч гэсэн тэдэнд үзэл баримтлалын ялгаа байсаар байв. Энэ дэлхийд найз нөхдийн дунд заримдаа үзэл бодлын бага зэрэг зөрөлдөөн гарах нь гарцаагүй бөгөөд энэ нь байх л зүйл гэдгийг бид ойлгох ёстой. Энэ бол асуудал биш, зүгээр. Хүн бүхэн өөрийн гэсэн үзэл ойлголт, өөрийн

гэсэн санаа бодолтой байдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Найзууд бүгдээрээ яг адилхан байх албагүй, учир нь тийм байвал дэндүү уйтгартай байх болно. Эс бөгөөс ганц хүн л хангалттай, найзтай байх гэж зовоод яах юм бэ? *(Бүгд инээв.)* Энэ нь тийм ч их нөлөө үзүүлэхгүй. Хэрэв найзууд хоорондоо ихэнх санал бодол дээрээ бие биетэйгээ санал нийлж чадвал сайн хэрэг. Гуань Жун юу чухал, юу нь чухал бус болохыг ялгаж чаддаг болохоор хэрэв хаан жаахан тансаглавал түүнийг загнаж зэмлэхгүй, эвгүй байдалд оруулахгүй гэдгээ тодорхой харж байжээ.

Чи Хуань гүн ч дэндүү илэн далангүй хаан, Гуань Жунтай анх уулзаад л цэрэг дайчдыг хэрхэн хэрэглэх гэх зэрэг улс гүрний их үйл хэргийг шууд ярилцаж байжээ. Гуань Жун ч асуултад нь чөлөөтэй оновчтой хариулж чадаж байв. Хаан зөвхөн Бао Шуя танилцуулснаас ч болоогүй, өөрөө Гуань Жуныг үнэхээр чадвар төгс хүн болохыг нь мэдсэнийхээ дараа л түүнийг их сайдын албанд томилохыг зөвшөөрсөн бөгөөд түүнийг Жунфу (Эцгийн дайтай түшиг хүн) хэмээн авгайлж, яг л хаан эзний төрсөн эцэг мэт их л хүндэтгэлтэй хандана. Хаан Гуань Жуныг ихэд биширдэг байсан бөгөөд түүнтэй тун ч илэн далангүй ярилцдаг байв. Тэрээр Гуань Жунд хандан: Надад нэг дутагдал байна. Эмэгтэй хүний тачаангуй байдлыг илүү таална. Энэ зан улс оронд хор хохирол учруулах уу гэж асуухад Гуань Жун: Бүсгүй хүнд шунах нь улс гүрэнд хор хөнөөл авчрахгүй. Харин мэргэдийн зөвлөгөөг сонсох дургүй байх нь улс гүрэнд болоод дэлхий дахинд хор хөнөөлтэй гэжээ. Тэр үнэн хэлсэн. Хэрвээ хаан өө сэвгүй бол сайн хүнийг хэрэглэх шаардлага түүнд байхгүй, хэрэв хаан бүхнийг мэддэг бол хүмүүст хийх ажил олдохгүй болно. Хэрэв хүн дэндүү төгс төгөлдөр бол бодол санаа нь үймрэн, ихэд дарамттай байдаг тул аливаа зүйлийг тийм ч тодорхой сайн ухаарч ойлгохгүй болно. Бао Шуя бол Гуань Жун шиг ухаалаг, овсгоотой биш, учир нь Бао Шуя дэндүү ёс журамтай, дэндүү шулуун,

дэндүү төв чигч, дэндүү сайн, дэндүү төгс төгөлдөр нэгэн байв.

Хувиа үл бодогч, би гэх үзэлгүй Гуань Жун

Гуань Жун өөр байсан, төгс байхын тулд яаж хийхийг мэддэг учир тэр үүнд санаа зовдоггүй. Тэр юу хийх ёстой байна, түүнийгээ төгс эсэхээс нь үл хамааран олны ашиг тусын тулд хийнэ, төгс төгөлдөрт баригдахгүй. Улс орондоо үйлчлэхийн тулд олон янзын албан ёсны, явцуу дүрэм журмыг огоорч, тэдгээрийг үл хэрэгсэнэ. Ялгаа нь энэ.

Хаан ч мөн ийм байсан. Хэрэв тэр өдөржингөө тасралтгүй зөвхөн төрийн хэргийг шийдэж, охид бүсгүйчүүдтэй уулзахгүй, чамин тансаг идээ хүртэхгүй, дарс ч амсахгүй, өөр юу ч хийхгүй байвал түүнийг хэр удаан тэсэж чадна гэж бодож байна вэ? Хамгийн ихдээ гурав хоног. Тэр үхэж магадгүй, тэгдэггүй юм аа гэхэд сүнс сүлд нь унаж, оюун ухаан нь самуурч үймэрч тавгүйтэн хэвийн биш, тэнцвэргүй хүн болно. Тэр юу ч ойлгох чадваргүй болно, учир нь нэг зүйлд хэт төвлөрвөл өргөн хүрээнд харж чадахаа больдог. Яг л хэрэв маргааш шалгалттай бол өмнөх өдөр нь хүүхдүүд юу ч сурч чадахгүй байдаг шиг. Тиймээс зүгээр л амарч тайвшрах нь дээр. Оюун санаа амарч тайвширсан цагт л хүний бодол цэгцэрч, чөлөөтэй сэтгэж чадна. Оюун санаа хэт ачаалалтай үед хүн ямар нэг зүйлийг тунгаан бодож чадах уу? (*Чадахгүй! гэцгээв.*)

Тиймээс бясалган суух арга нь логикт нийцдэг. Бид өдөржингөө завгүй байдаг бөгөөд бидний нүд, билиг ухаан, уураг тархи маш нарийн хүрээнд явцууралд ямар ч хариулт олох боломжгүй байдаг. Хэрэв та хэт ойроос харвал ямар нэг зүйлийг тод харж чадах уу? *(Их Багш нэг зүйлийг нүднийхээ өмнө тулгаж барив.)* Энэ боломжтой юу? *(Боломжгүй гэцгээв.)* Тодорхой орон зай, цаг хугацаатай байвал бид сая олон зүйлийг шийдэж чадна.

Энэ нь сүнслэг бясалгагч бидний хувьд ч адил. Өмнө нь би ийм олон шавьтай байгаагүй, бид бүгд майхан бариад би нэг талд нь, шавь нар нөгөө талд нь амьдардаг байв. Намайг цайлж суухыг зарим хүн хараад эргэлзэн бүр: "Сонин юм аа! Төгс Гэгээрсэн Их Багш байж яаж цай ууж, дэмий юм чалчиж чадаж байна аа?" гэж шүүмжилж байсан. Зөвхөн Төгс Гэгээрсэн Их Багш л цайлж, чалчиж байх ёстой. *(Бүгд инээв.)* Гэгээрээгүй хүмүүс цайлж, дэмий чалчиж зүрхлэхгүй байдаг. Би аль хэдийн гэгээрсэн, тиймээс яагаад тэгж болохгүй гэж? *(Бүгд алга ташив.)* Багш хүн гадагш гарч бөмбөг, хөл бөмбөг, гольф тоглож, эсвэл машин барьж зугаалж болно. Учир нь тэр сургуулиа аль хэдийнээ төгсчихсөн, бүх зүйлийг мэддэг болчихсон. Тэр ч байтугай хэрвээ тэр ямар нэг зүйл мэдэхгүй хэвээр байгаа бол зугуухан суралцаж болох бөгөөд энэ нь ер хамаагүй! Оюутнууд л шалгалтад бэлдэн сууж, гэрийн даалгавраа чармайн хийх хэрэгтэй. Багш бол харин цагаа зохицуулж болно, сурагч, оюутнууд шиг тэгж их шаргуу хичээн суралцах шаардлагагүй. Багшид ч бас их ажил байдаг. Шөнө орой болтол ном уншиж, маргааш оюутнуудад заах хичээлийн сургалтын материалаа бэлдэх шаардлагатай байж болох ч сурагч, оюутнууд шиг тэгж их чармайх хэрэггүй. Оюутнууд шалгалт болон цаг хугацаагаар хязгаарлуулж, зав чөлөөгөө дурарааа зохицуулж чадахгүй байхад багш цагаа хэрхэн зохицуулахаа мэднэ.

Тайвшрал бол ухаарлын эхлэл

Сурч боловсроход дэндүү их зүдрэх хэрэггүй. Тиймээс бид бясалгахдаа ч, долоо хоногийн даяан хийхдээ ч гал дэлдэж (галын дэргэд цуглаж) веган шорлог хийж, дуулж бүжиглэж, тоглолт хийх зэргээр цэнгэж байдаг. Баяр наадам болох үеэр бид гоё ганган хувцаслаад хөгжилдөн цэнгэдэг ч бясалгал маань ялгаагүй л сайн хэвээр байдаг. Нөлөөлөгдсөн хүн байна уу? Гараа өргөөд надад харуулаарай, улам

сайжирсан, тийм үү? Ямар нэгэн ахиц дэвшил гарсан уу? *(Тийм! гэж хариулцгаав.)* Бид хаяа нэг амарч болно, зүгээр л буцаж ирэхээ санаж байгаарай! Хүн битгий хэл үхэр, адуу ч хэт хүнд хүчир ажлыг тэсвэрлэхгүй, тийм биз? Тэднийг өдөржин хүчээр ажиллуулж, хорин дөрвөн цаг анжис чирүүлбэл тэсэх үү? Тэсэхгүй! тэд үхчихнэ шүү дээ! Машин техник ч мөн адил. Машин, онгоц зэрэгт ч засвар үйлчилгээ хийх, амраах цаг хэрэгтэй.

Америкийн нэг ерөнхийлөгч төрийн ажил хэрэг хэтэрхий их ачаалалтай байвал нэг, хоёр хоног бүгдийг орхиод амрахаар явдаг байжээ. Үнэндээ амарч байхдаа тэр илүү бүтээмжтэй сайн ажилладаг байж. Ер нь асуудалтай тулгарсан үедээ бид үргэлж түүнийгээ бодож, өөрийгөө хүчилж, хурдан хийхийг, шийдвэрлэхийг хичээдэг ч эцэст нь олигтой хийж чадахгүй байдаг. Тиймээс бид зүгээр л орхиод унтаж амарч, эсвэл зурагт үзэж болно. Гэхдээ тэр үед бидний далд ухамсар зурагт үзэхгүй, сүнс, билиг ухаан маань ажилласан хэвээр байдаг. Цаг гарах үед тэр бидэнд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг аажуухан бөгөөд үл үзэгдэх байдлаар хэлж өгнө. Тиймээс зурагт үзсэний дараа бид юу хийхээ мэдчихсэн байдаг! Би үргэлж ингэдэг. *(Бүгд алга ташив.)* Ихэнх ажил хэргийг Багш нь орондоо л шийддэг. Одооных шиг ийм албан ёсны, гоёмсог хувцастай байхдаа тийм ч олон ажил амжуулж чаддаггүй. Ажилгүй байх үедээ л сая аливаа асуудлыг шийдэж чаддаг. Учир нь, тэр үедээ би завтай, бас харьцангуй нам тайван байдаг юм. Энэ нь энэ дэлхийн хэрэг явдлуудыг хэлж байгаа хэрэг. Нүдэнд үл үзэгдэх зүйлсийн хувьд би цаг үргэлж зохицуулж байдаг. *(Бүгд алга ташив.)*

Арван хоёрдугаар бүлэг

УЛСАА ТӨВШИТГӨХ УХААН, ДЭЛХИЙГ АМАР АМГАЛАН БОЛГОХ НЬ СҮНСЛЭГ ЗАМ МӨР

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шихү ашрам.
1995 оны 9 дүгээр сарын 10
(Эх нь хятад хэлээр)

Билгүүн ухаантан хэт туйлширдаггүй

Гадна дүр төрх бидний дотоодын түвшнийг илэрхийлж чадахгүй байж магад. Хамгийн чухал нь бидний сэтгэл ганхсан эсэх, цэвэр ариун байгаа эсэхийг мэдэх хэрэгтэй. Энэ чухал, тийм биз? Тийм учраас Лаоз: “Хэт цэвэр цагаан байвал бага зэрэг бүдэг харагддаг, хэт төгс ёс суртахуунтай хүн дутагдалтай мэт ойлгогддог.” гэжээ. Ёс суртахуунтай хүнийг хараад бид танихгүй байж магадгүй. Заримдаа юм хэтрэхээрээ тийм ч сайнгүй байдаг. Жишээ нь, эртний олон хүн эзэн хаандаа сохроор үнэнч байснаасаа

болон эцэст нь хохирдог, эсвэл эрдэнэт амиа алддаг байжээ, учир нь тэд нэр төрөө дэндүү эрхэмлэдэг байв. Тэд шударга ёс, ёс суртахуун, цэвэр ариун нэр хүндийг дэндүү шүтсэнээс заримдаа хэт туйлширч, улмаар өөрийгөө хорлодог байна. Ингээд улсдаа ч, нийгэмдээ ч бүтээсэн гавьяагүй болно.

Бо И, Шү Чи хоёр юуны төлөө өлсөж үхсэн бэ? Зөвхөн цэвэр ариун нэр төрөө хамгаалахын тулд юм. Чюй Юань (Qu Yuan) юуны тулд мөрөнд үсрэв? Ердөө л нэг мунхаг хаанд үнэнчээ харуулахын төлөө байжээ. Хэрвээ гэгээн мэргэн хаантай бол түүнд санаа тавьж, хамгаалж, дэмжиж, зөвлөгөө өгч, үнэнч байх ёстой. Гэвч хэрэв та нэгэн мунхаг хаанд үнэнчээр хандвал тэнэг гэсэн үг шүү! Үнэнч сэтгэлтэй тэнэг.

Сүнслэг бясалгагчид бид хэт туйлширч, хэтэрхий хатуу байж болохгүй. Уян хатан байж, нөхцөл байдлыг харж, юу хийх ёстойг билиг ухаанаараа дүгнэх ёстой. Заримдаа нэр хүндэд хэтэрхий дурласан, ёс суртахууны тодорхой талд хүлэгдсэн, эсвэл амьдралын ямар нэгэн хэв маягт баригдсан бол хэдийгээр бясалгагч байсан ч билиг ухаантайд тооцогдохгүй. Аливаа дүрэм журам, нэр алдар, ёс суртахуун нь хүнийг хамгаалахын тулд л байдгаас биш нэр алдрыг хамгаалахын тулд хүн байдаг биш юм. Багшийнхаа санааг ойлгов уу? *(Бүгд ойлголоо гэж хариулав.)*

Ихэнх хүн Бо И, Шү Чи, Чюй Юань зэрэг эзэн хаандаа үнэнч, эх оронч сэтгэлтэй хүмүүсийг бахдан магтдаг. Гэвч миний бодлоор тэд тийм ч хангалттай сайн байгаагүй, учир нь тэдэнд билиг ухаан байхгүй. Хэрвээ шаардлагагүй бол өөрийгөө тэгж хохироох хэрэггүй. Учир нь бүхий л нийгэмд зөвхөн нэг эзэн хаан, нэг мунхаг эзэн ганцаар оршин амьдарч байдаг биш, бид түүнийг амьдралынхаа цорын ганц зорилт болгож болохгүй. Тэд өөрийгөө дэндүү чухалд үзсэнээс ийм зүйл хийсэн байх аа. Мунхаг хаантныг сонсмооргүй бол түүнийг дагах хэрэггүй. Эсвэл заримдаа

дагаж, учир явдал хийж буй дүр үзүүлж, алгууруар түүнд нөлөөлөхийг оролдох, эсвэл чимээгүйхэн сайн зүйл хийж болно, харин нэгэн тун их ёс суртахуунтай хүн гэж олонд өөрийгөө харуулах гэхийн хэрэггүй, ийм байвал хэн таныг тэвчих вэ? Хэрэв хаан нэр хүнд муутай, та сайн нэр төртэй бол тэр танд дуртай байх уу? *(Бүгд инээв.)* Тэр хаан таны үгийг сонсох уу? Таныг өршөөх үү? Өршөөсөн ч хажуудаа байлгахгүй, хажуудаа байлгасан ч таныг сонсохгүй, тийм биз? Тиймээс та бүхэн энэ дэлхийд тусалж, дэлхийг аврахыг хүсэж байвал тодорхой газарт хүлэгдэж уягдах хэрэггүй. Бид нөхцөл байдлыг ажиглан харж, хаана чадах байна, тэнд л чимээгүйхэн тусална.

Улс орноо амаржуулж, дэлхийг засагч Их мэргэн Гуань Жун

Чи улсын Гуань Жун бол маш алдартай их сайд байсан. Тэрээр мунхаг эзэн Чи улсын хаанаас ялгаагүй байж, хаан эзэн юу хийнэ, тэр бас түүнийг хийнэ, эзэн хаан мунхрахад тэр бүр ч илүү мунхарна. Өөрийн ёс суртахууныг хаанд өчүүхэн ч мэдүүлэхгүй, хаан эзнээс илүү нэгэн гэж огт бодогдуулахгүй. Ингэснээр л улс орноо төвшитгөж, дэлхий дахиныг амар амгалан болгож чадсан, мунхаг эзэн болон ард иргэддээ тусалж чадсан байна. Учир нь хаан биш, ард түмэн илүү чухал. Хэрэв та түүнийг ашиглаж чадвал ашиглана, хэрэв түүнийг хөнөөвөл таны нэр төрд тийм ч сайн биш. Зүгээр л түүний дэргэд байж, түүнтэй хамт тогло, тэгвэл тэр нэгэнт танд итгэснийхээ дараа таныг сонсох болно.

Тэгээд таныг өөртэй нь яг адилхан гэж харна. Хоёулаа мунхаг дотнын анд найзууд болно, хоёулаа их адилхан, ойлгож байна уу? (*Их Багш болон бүгд инээв.*) Чи Хуань гүн архи уувал Гуань Жун түүнээс ч ихийг ууж буй мэт аяглана. Чи Хуань гүн согтоод элдэв янзын ааш гаргавал их сайд түүнээс ч илүү завхарсан мэт элдэвлэнэ. Тэрээр хааныг зүрх сэтгэлдээ нэвт шувт маш сайн мэддэг

болсон байв. “Өөрийгөө болон бусдыг таньсан хүн зуунтаа ялна.” гэдэг шиг Гуань Жун ёс суртахуун, авьяас чадвараа гайхуулах шаардлагагүй байв, тэр улс орныг чимээгүйхэн удирдаж байжээ. Тэр үед Чи Хуань гүн биш, харин Гуань Жун хаан байсан бөгөөд энэ нь илүү дээр байсан аж. (*Бүгд алга ташив*.)

Хэдийгээр хаан ширээнд Чи Хуань гүн сууж байсан ч улс орныг удирдаж, дэлхий дахинд амар амгаланг авчирдаг хүн бол Гуань Жун байв. Учир нь тэр их уян хатан, хорон муу хүнийг ч ашиглаж, олиггүй зальхай түшмэдийг ч уучлан сэтгэлдээ багтааж хүлээн авдаг. Харин Бао Шуя ингэж чадахгүй, тиймээс их сайд болж чадахгүй. Мөн Бао Шуя үнэхээр маш сайн хүн боловч дэндүү сайн, хэт туйлширдаг нэгэн. Сайн хүнийг тэр туйлын их хайрлана, гэвч муу хүнийг бол алсан ч сэтгэл нь амрахгүй тийм л хүн. (*Их Багш болон бүгд инээв.*) Тэр нүдээ ч цавчихгүй хүн хөнөөж тун магад. Тиймээс улс орныг Гуань Жун шиг сайн удирдаж чадахгүй юм. Хэдийгээр Бао Шуя нэгэн үнэнч шударга сайд, чигч шулуун түшмэл байсан боловч улс орондоо тийм ч их тусалж чадаагүй. Гуань Жуны найр цэнгээн, архи дарс, тамхи, үүлэн бороoны явдал нь яг л хааных шиг замбараагүй байсан ч тэр улс гүрэндээ хамгийн их тусалсан, хамгийн шилдэг агуу баатар байжээ.

Бид зөвхөн Бурханы шашны судар ном, эсвэл Их Багшийн айлдварыг уншвал л сая ач тустай гэсэн биш, түүхээс ч мөн ямар нэг зүйлийг сурч болно. Хэрвээ бид билиг ухаантай бол юунаас ч суралцаж чадна. Бусад хүн улс, орноо хэрхэн удирдаж, амар амгалан болгож байсныг ажиглавал бид ч хэрхэн ингэхийг сурах болно. Улс орныг удирдаж, дэлхий дахиныг төвшитгөх нь яг л хамаг төрөлтнийг гэтэлгэхийн тулд сүнслэг бясалгал хийхтэй ижилхэн, ямар ч ялгаа байхгүй. Арга зам нь ижил, стратеги нь ижил, бусдад үйлчлэх сэтгэл нь ижилхэн.

Нэгэн эгэл жирийн их сайд улс гүрэн, ард түмнийхээ төлөө өөрийн нэр төрийг золиосолж чадна. Ингэж байж л эх оронч, эзэн хаандаа үнэнч хүнд тооцогдоно. Энэ бол жинхэнэ үнэнч шударга байдал юм. Гуань Жун байгаагүй бол Чи улс аль хэдийн бусад улсад идэгдэж, Чи Хуань гүн ч хаан болон засаглаж, алдар суу, эд баялгийг эдлэх боломжгүй байх байсан. Тиймээс Гуань Жун бол жинхэнэ үнэнч шударга түшмэл байжээ. Тэр өдөржингөө зааж тушааж, эсвэл хаан эзнээ шүүмжилж, зэмлэн буруушааж, түүний сэтгэлийг зовоож байгаагүй, ингэснээр сая шударга үнэнч сайдад тооцогдоно. Шударга үнэнч сайд гэдэг нь ажлаа чимээгүй хийдэг хүн.

Жинхэнэ чадвар нүдэнд ил харагддаггүй

Улс орноо удирдаж, ард түмэндээ тустай байя гэвэл бүр өөрийн нэр төрийг ч хайхрах хэрэггүй. Бусдад өөрийн цэвэр ариун, үнэнч шударга байдал, улс орныг удирдах их билиг ухаан, авьяас чадвараа мэдүүлэх хэрэггүй. Зүгээр л өөрөө хий, тайлбарлах, эсвэл үзүүлж харуулах шаардлагагүй, заримдаа ийм байх нь илүү дээр байдаг. Хэрэв хүмүүс хэтэрхий ихийг мэдвэл таныг үргэлж магтах болно. Заримдаа та хангалттай ёс суртахуунтай биш байдаг, жишээлбэл, таны ёс суртахууны оноо ердөө наймхан байхад хүмүүс таныг арван хоёр оноогоор сайшаан магтвал та бүр ч илүү тавгүйтнэ! Хүн бүр танаас илүү ихийг хүлээнэ. Өөр нэгний ээлж болоход тэр таныг арван таван оноотой болгон магтана, энэ үед таны оноо бас тал хувьд нь л байгаа болохоор танд асуудал үүсэж, маш их бачимдан юу ч хийсэн туйлын хянамгай болгоомжтой байж, биеэ барьж эхлэн тав тухгүй байх болно, учир нь та хүмүүсийн танаас хүлээж байгаа нэр хүндээ цаг үргэлж хамгаалах ёстой, тиймээс ажил хийхэд хэцүү болж эхэлдэг, ингэх амаргүй. Эрх чөлөөтэй тааваараа ажиллах нь илүү таатай байдаг, учир нь хүмүүс танаас юу ч хүсэн хүлээхгүй. “Энэ хүн угаасаа ийм л хүн,

түүнээс юм хүлээх хэрэггүй, тийм ч сүрхий сайн хүн биш, хэн ч түүнийг тоохгүй. Тэр их хайнга, эгэл жирийн хүн, идэж ууж, наргиж цэнгэхээс цаашгүй, ямар ч тусгүй. Түүнд санаа зовох, анхаарал хандуулах хэрэггүй, тэр өрсөлдөх чадваргүй хүн. Би бол тун ёс суртахуунтай хүн, тиймээс хүмүүст таалагдах нь гарцаагүй. Харин тэр юу ч биш гэж бодно. Ийм байх нь ямар ч өрсөлдөгчгүй болж, хэн ч танаас юу ч хүлээхгүй учир та бүх зүйлийг саадгүй хийх болно. Хэн ч таныг харж чадахгүй байхын тулд нүүрний багийн ард инээмсэглэж байгаа юм шиг л юмсыг чимээгүй, хэнд ч анзаарагдалгүй хий. Та нар хэзээ нэгэн цагт тийм баг харж байсан уу? Зөвхөн хоёр нүд л харагдахаар хэв дарж бүтээдэг, та ард нь инээж, эсвэл уйлж байхыг хэн ч харахгүй. Үүний нэгэн адил, бид энэ дэлхий дээр бусдад туслахыг үнэхээр хүсэж байвал бусад хүн юу гэж бодохыг тоох хэрэггүй.

Хэрэв та үнэхээр нэр төр ольё гэвэл энэ нь амархан, сурталчилгаа сайтай, бусдын нүдэнд өртөх сайн аргатай байх хэрэгтэй. Хэдэн жил замаа зассаны дараа хүн бүр таны сайн гэдгийг мэдэх болно. Жишээ нь, ерөнхийлөгчөөр сонгогдъё гэвэл тун амархан. Хэрвээ үнэхээр ерөнхийлөгч болъё гэвэл эхлээд замаа зас. Сонгогдох гээгүй мэт эхлээд өөрөө замаа засаж, хүн бүхэнд сайн уу гэж хэлж, сүм хийд бүхэнд зочилж, чуулган, олон нийтийн байгууллага бүхэнд бараалхаж, хүмүүстэй уулзах гэх мэтээр үйлд, дараа нь удалгүй хүмүүс таныг урин залах бөгөөд улс даяараа таныг хамгийн ёс суртахуунтай, маш их сүнслэг бясалгагчийн зан чанартай гэдгийг харах болно. Тэгэхэд нь та: “Үгүй ээ, намайг уучлаарай!” гэнэ. (*Бүгд инээж, алга ташив.*) Хүмүүс таныг дахин дахин урьж, нэр дэвшүүлнэ, дараа нь та: “За за! Гэхдээ би маш их ичиж байна!” гэнэ. Энэ бүхэн нь бүгд хуурамч ёс суртахуун, хуурамч нэр хүнд. Жинхэнэ ёс суртахуунтай, нэр хүндтэй хүмүүс ихэнхдээ үл анзаарагдах бөгөөд жинхэнэ авьяас чадвараа харуулдаггүй, чадвартныг гадна талаас нь хараад мэдэж чадахгүй!

Эх орноо хайрлахад нэр хүнд ч золиос байж болно

Жоу Вэнь ван тухайн үеийн хаан эзнээсээ ч илүү ухаалаг чадвартай байжээ. Улсын хаан уруудаж доройтсон, маш шунахай сэтгэлтэй, харин Жоу Вэнь ван тун өгөөмөр хүн байв. Хожим нь тэрээр хаан ширээнд сууж улсын эзэн болжээ. Учир нь түүний хийсэн бүхэн хаан эзнээс илүү сайн байсан юм. Тиймээс хүмүүс түүнийг хожим хаан ширээнд залсан байна. Гуань Жун сайн хүн байхыг хүссэн бол Чи Хуань гүний хаан ширээг булаах байсан, учир нь тэр үед Чи Хуань гүн нэр хүндээ ихэд алдсан байв. Гэвч Гуань Жун тийм үйлдэл хийгээгүй. Бусдын хаан ширээг булаах дургүй хүн. Тэр зөвхөн улсдаа л туслах хүсэлтэй, жинхэнэ эх оронч байснаас биш нэр төрд дурлагч биш байжээ. Тийм ч учраас нэр хүндээ ч алдахад хүрсэн юм.

Эх орныхоо тусын тулд элдэвтэй, олиггүй хүний дүр эсгэж явснаар хаан эзнийхээ эргэлзээг тайлж, алдар нэрээ ч хаан эзнээс дээш гарахааргүй болгосон ажээ, ингэж л тэр эх орондоо туслах боломжтой болсон юм. Энэ үед тийм нэг хаантай таарсан болохоор тэр юу хийж чадах вэ? Хааныг хороовол нэр хүндээр сайнгүй болно. Хэрэв өөр хүн байсан бол тэр нь Чи Хуань гүнээс илүү сайн байж чадахгүй байж ч магад. Гуань Жун нэгэнт хааныхаа итгэлийг олсон тул тэр давуу талаа ашиглан нөхцөл байдалд нийцүүлэн ажиллаж байжээ.

Тэр үед Гуань Жуны ачаар Чи улсад энх тайван тогтсон төдийгүй Хятад орны эзэрхэгч гүрэн болж чаджээ. Чи Хуань гүн тийм ч сүрхий биш, тэр харин Гуань Жуныг дэргэдээ ажиллуулсан нь түүний хамгийн сайн тал нь болсон. Гуань Жуны хувьд тэр нэг мунхаг хааныг ашиглаж чадсан нь бас хамгийн сайн явдал болсон. (*Бүгд инээн алга ташив.*) Тэрээр мунхаг хааныг ашиглаад зогсохгүй, хааны дэргэдэх бусад зальхай түшмэдийг ч ашиглаж чадсан. Тэр хэнийг ч ялгаварлан гадуурхдаггүй, ингэж байж л тэр

аливаа зүйлийг хийж чаддаг байв. Гуань Жун үнэхээр агуу хүн, шилдэг мэргэний туйл байв. Бид сүнслэг бясалгалдаа Гуань Жунаас суралцаж чадвал тун гайхалтай! Тэр маш өгөөмөр сэтгэлтэй, үнэхээр сайн хүн, гэхдээ гаднаа биш. Энэ нь тэр дотооддоо сайн биш гэсэн үг биш, тэр зүгээр л хүмүүс өөрийг нь дэндүү сайн гэж бодоосой гэж хүсээгүй. Тэр ямар ч хүнийг сэтгэлдээ багтааж чаддаг байсан, тийм учраас улсыг засаглаж, дэлхий дахинд амар амгаланг авчирч чадсан байна.

Би Гуань Жуныг сайн гэж бодож байна! Бид заримдаа эртний түүхээс ямар нэгэн зүйлийг сурдаг, тиймээс тухайн хүний талаар үнэлэлт дүгнэлт бичих, эсвэл түүнийг таньж мэдэхийг хүсэж байвал билиг ухаантай байж, тэр хүнийг ямар хүн болохыг нь гүн гүнзгий ойлгох ёстой. Зөвхөн гаднах төрх байдлыг нь хараад зогсохгүй, хийсэн зүйлийнх нь үр дүн, үйлдлийнх нь үр нөлөөг нь харах хэрэгтэй, гагцхүү хэрхэн аяглаж байгааг нь л харах биш юм. Түүний гадна төрх байдлыг харах хэрэггүй, харин зан байдал, дадал зуршил, аливаа зүйлийг хийх арга барилыг нь харна. Гаднах төрх байдал биднийг заримдаа хууран мэхэлдэг. Түүний хийсэн ажлынх нь үр дүн сайн байгаа эсэхийг харах нь сайн.

Түүхэнд Гуань Жунтай холбоотой сэтгэгдэл тийм ч сайн биш, түүний үр хойчис ямар ч алдар нэр эдлээгүй, Гуань Жуны эрх мэдэл, өв хөрөнгийн ашиг тусыг ч хүртээгүй. Тэр ард түмнийхээ төлөө үнэхээр бүхнээ зориулж байснаас биш, хойч үедээ дурсагдах нэр алдрын төлөө яваагүй, тиймээс түүний үр удам ямар ч сайн алдар нэр олж аваагүй юм. Тэр үр хүүхдэдээ ямар ч байр суурь, эрх мэдэл, эсвэл санхүүгийн эх үүсвэр үлдээгээгүй. Хойч үеийн хүмүүс Гуань Жуны үр удмыг нэг их хүндлээгүй. Түүнийг хэн ч тоосонгүй, учир нь Гуань Жуныг амьд ахуйд нь хүмүүс түүний сайн чанарыг олж харсан нь маш бага. Тэд түүнийг зөвхөн яг л хаан шиг идэж ууж, зугаа цэнгэл хөөцөлдөж байгаа хүн гэж л харжээ.

Хаан эзний нэр төр угаасаа аль хэдийн муу байсан, гэтэл түүнийх хааныхаас бүр ч дор байсан! (*Их Багш болон бүгд инээв.)*

Түүний гадна талын багийг хэн нэвт харж, эх оронч сэтгэлийг нь мэдэж, хаанд үнэнч зан чанарыг нь ойлгож чадах вэ? Дэлхийн хүмүүс тун харалган байдаг. Ихэнх хүн түүн шиг сайн байдаггүй тул бие биеэ татах боломжгүй байв. Хэн ч түүнийг дотнын найзаа гэж үзэхгүй, хэн ч түүнийг ойлгохгүй тул түүнийг хүндэлдэггүй, хайрладаггүй, зөвхөн алдар нэр, хувийн ашиг сонирхлын үүднээс мунхаг хаантай хамт дураараа аашлагч, хаанд зусардаг хүн *(Их Багш болон бүгд инээв*.) л гэж боддог байжээ. Түүний улс орноо удирдан залах, энх тайван, тогтвортой байлгах авьяас чадварыг, мөн түүний дотоодын цэвэр ариун, эх оронч, эзэн хаандаа үнэнч жинхэнэ зүрх сэтгэлийг хэн ч үнэлээгүй.

Ау Лакын мандан бадралт

Ау Лакт бас Гуань Жун шиг тийм нэгэн их сайд байжээ. Тэр бас тааруухан нэр хүндтэй байсан, түүнийг Тран Тху (陈首度) гэдэг. Та нар түүнийг мэдэхгүй байх. Тэр их алдартай. Амьд сэрүүн байхад нь хүмүүс бүгд хараж, түүхэнд ч түүний талаар муугаар бичсэн. Тухайн үед балчир хүүхэд хаан сууринд суусан тул бүх эрх мэдэл нь мэдээж их сайдынх байсан. Бас тэрээр талийгч хааны нэг татвар эмтэй гэрлэсэн юм. Хааныг нас барсны дараа татвар эмтэй нь гэрлэсэн нь хайр сэтгэлээс болсон уу, эсвэл хаан төрийн бүх эрх мэдлийг хянахын төлөө байсан уу гэдгийг мэдэхгүй.

Яг үнэндээ тэр бүгдийг захирч байв. Эзэн хаан ихийг үл мэдэх тул тэр бүхнийг шийднэ. Энэ сайд бас их зөрүүд хүн тул түүхэнд сайнаар бичигдээгүй, дарангуйлагч, нялх хааныг сүрдүүлэгч, хаан төрийн эрхийг урвуулан дураар ашиглагч зэрэг олон хэрэг хийсэн гэсэн тааруухан нэртэй. Гэвч бид түүхийг нарийн сайн анхаарч уншвал түүнийг

агуу их хувьсгалч, ардчилагч хүн байсныг олж мэднэ. Одоо бидний улсын хаан, ерөнхий сайдтай ийм тогтолцоог үндсэн хуульт хаант засаглал гэдэг. Тийм үү? Гэвч хаан тийм ч их эрх мэдэлгүй, харин ерөнхий сайд маш их эрх мэдэлтэй тэр үед их сайд үндсэн хуульт хаант засаглалын тогтолцоог хэрэгжүүлж байсан ч манай Ау лак хүмүүс үүнд сайн дасаагүй байв. Бидний хувьд хаан бол тэнгэрийн хөвгүүн бөгөөд хаан эзний зарлиг л бол зарлиг, юу ч хэлсэн зөв, олон ноёд түшмэд зөвхөн толгой бөхийн: “Yes,Sir! No,Sir! ” (За дээдэс ээ! Үгүй ээ дээдэс ээ!) гэхээс цаашгүй байсан, тиймээс бид ч дасахгүй, ноёд ч бас дасахгүй байв. Түүний эрх мэдэл дэндүү их, бүх зүйлийг өөрөө л шийддэг, нялх хаантны хувьд хэлэх үггүй байжээ. Гэхдээ өөр өнцгөөс харвал эзэн хаан нас бага, ухаан суугаагүй, хэрвээ тэр их сайд байгаагүй бол манай Ау Лак тэр үед тийм ч амар амгалан, тогтвортой байж, олон талаар цэцэглэн хөгжихгүй байх байсан. Гэвч бүгд л түүнийг хэмжээгүй их эрхтэй, эрх мэдлээ хэтрүүлсэн, эзэн хааныг дарамталсан гэх зэрэг олон хэргийг зохиож тохсон. Ямартаа ч түүнд олигтой нэр алдар байгаагүй, түүхэн бичигт ч түүнийг сайнаар тэмдэглээгүй. Гэвч тэр үед манай Ау Лак олон талаар чөлөөтэй хөгжиж чадсан. Хэрвээ их сайд юу ч ойлгохгүй нялх хааны үгээр явсан бол яаж улсаа удирдах вэ? Хааны үгээр явсан бол улс үндэстэн дуусах байсан! Зарим үед хаан зөвшөөрөөгүй ч их сайд бас тамга дардаг байжээ. (*Их Багш болон бүгд инээв.)* Өөрөө тамгалчихдаг тул бүгд түүнийг жигшин зэвүүцдэг.

Үнэндээ тэр маш сайн хүн. Хэрвээ тэр үнэхээр муу хүн байсан бол хааны татвар эмийг авчихсан, бүх эрх мэдэл түүний гарт байсан тул тэр хааныг орлож чадах бөгөөд хаан суудалд өөрөө ч сууж болох байв. Тэр үед хүмүүс байнга л ингэдэг байсан. *(Их Багш болон бүгд инээв.)* Энэ нь тун нийтлэг байв, маш их алдартай, ялангуяа Хятадад, тийм үү? *(Тийм гэж бүгд хариулав.)* Хэрэв хаан нэлээд сул дорой, харин танд ямар нэг эрх мэдэл байгаа бол та шууд л хаан

сууринд сууна. Тэгээд төр эргүүлнэ. Уг нь Ли номын эгч байснаа шууд Ван номын ах болж хувирна. *(Их Багш болон бүгд инээв.)* Тиймээс хэрэв Шоуду үнэхээр хаан ширээ, эсвэл эрх мэдлийг авахыг хүссэн бол тун амархан олж авч болох байлаа. Хаан эзэн балчир бага, эрх мэдэл өөрт нь байсан, мөн өмнөх хааны үед залгамжлагч их сайд байсан тул эрх мэдэл маш ихтэй. Өмнөх эзэн хаан бүх эрх мэдлийг түүнд атгуулж, балчир хаан болон хаан төрийг даатгасан байжээ.

Билиг ухаанаар түүхийг эргэн шинжихүй

Иймээс бид Гуань Жун үнэхээр нэр төрийн төлөө байгаагүйг мэдэж болно. Учир нь хэрэв тэр ийм байдлаараа хийсээр байвал нэр төр нь улам дордох байсан ч тэр эзэн хаанаа дэмжин тусалсан хэвээр байжээ. Дараа нь төрийн бүх ажлыг өөрөө хийж байжээ. Хүмүүс түүнийг үзэн ядна. Үнэндээ тэр бол маш мундаг улс төрч байсныг бид ажлынх нь үр дүнгээр мэдэж болно. Түүхэнд бичигдсэн олон түүх, тайлбар сэтгэгдэл нь хойч үеийн хүмүүст энэ хүн муу, тэр хүн сайн, энэ хүн ёс суртахуунтай, тэр хүн эзэн хаанд үнэнч, тэр хүн эх оронч гэж ойлгуулдаг. Тиймээс бид ахин уншиж, бодит байдал дээр тэр баримтууд нь түүхэнд бичигдсэн шигээ байсан уу гэдгийг дахин тунгаан бодох хэрэгтэй. Мөн түүхийг хэн бичсэн бэ?

Аливаа түүхч хүн ч гэсэн мөн л хүн шүү дээ, тэд өөрийн гэсэн өрөөсгөл хандлагатай байдаг бөгөөд билиг ухаан нь дутмаг, өөрийн тогтсон үзэл, өрөөсгөл бодол, мэдрэмж, өшөө хорслоор түүхийг бичнэ. Бид түүхийг хараад л амархан үнэмшиж болохгүй. Бид өөрийн билиг ухаанаа ашиглах хэрэгтэй. Хэрэв бид үнэхээр түүхээс суралцахыг хүсвэл аль хүн үнэхээр сайн, аль хүнээс нь суралцахад үнэхээр үнэ цэнтэй вэ гэдгийг мэдэхийн тулд бид өөрсдөө тодорхой дүн шинжилгээ хийх ёстой.

Арван гуравдугаар бүлэг

ГЭГЭЭНТНИЙ ӨВЧИН

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Формоса, Шихү ашрам.
1996 оны 2 дугаар сарын 4
(Эх нь хятад хэлээр)

За өнөөдөр нэгэн гэгээнтэн хүний түүхийг ярья. *(Бүгд алга ташив.)* Энд өөрийгөө гэгээнтэн гэдгээ мэддэггүй нэгэн хүний тухай өгүүлдэг. Тэр та нар шиг биш, та нар бол хүн бүр гэгээнтэн гэдгээ мэдчихсэн хүмүүс. (*Бүгд инээв.*) Харин тэр өөрийгөө гэгээнтэн гэдгээ мэдэхгүй, "илүүдсэн" хүн[12] гэж боддог аж. (*Бүгд инээв.*) Түүний нэрийг Лун Шу гэнэ. Тэрээр Вэн Жи гэдэг эмч дээр очжээ. Вэн Жи бараг Хаврын-Намрын ба Байлдаант улсын үед төрсөн байх, ямар ч өвчнийг эмчилдэг маш их алдартай хүн байжээ. Вьянь Цюэ эмч нэг удаа Байлдаант улсын үеийн Чи улсын Мин ван хааны өвчнийг эдгээж байсан гэдэг. Мин ван хаан ямар

12 "Гэгээнтэн" болон "илүүдсэн" гэсэн үг нь хятад хэлээр ижил төстэй сонсогддог.

өвчин туссанаа мэдэхгүй Вэн Жийг ирж оношилж, эмчилгээ хий хэмээн дууджээ. Вьян Цюэ эмч Мин ван хаанд ямар ч эм хэрэглэсэнгүй, зөвхөн түүнийг уурлуулаад л эдгээсэн байна. Та нар энэ түүхийг мэдэх үү? (*Бүгд мэдэхгүй гэж хариулав.*)

Нэн ховор тохиолдох нэгэн "хачин өвчин"

Лун Шу, Вьян Цюэ эмч дээр очиж: "Таны эмнэх эрдэм үнэхээр гайхалтай гэдгийг дэлхий даяараа бүгд мэднэ. Би нэг хачин өвчин тусаад байна, намайг эмчилж туслаач." гэв. Вьян Цюэ эмч: "Болно, болно. Гэхдээ эхлээд та ямар өвчин туссаныг би мэдэх хэрэгтэй байна, энэ өвчнийхөө талаар надад ярина уу" гэв. Лун Шу: "Энэ өвчний нэрийг ч, шалтгааныг ч, бас хаанаас гаралтайг нь ч мэдэхгүй. Хэрэг явдал ийм юм, би тосгондоо он удаан жил амьдарсан ч одоо надад улам хачин санагдаж байна, би өөрийгөө танихгүй харь хүн гэдгээ мэдэрдэг, бас хэнтэй ч дотно харилцаатай биш, өөрийгөө улам л этгээд сонин үл таних хүн мэт бодох болов. Жишээ нь, манай тосгоны хүмүүс бүгд намайг магтан сайшаахад надад ер бахархалтай санагдахгүй, өөр тосгоны хүмүүс намайг дороомжлоход би бас гутарч гуньж, сэтгэл зовдоггүй. Тэр ч байтугай би жаахан үнэт эрдэнэстэй болсон ч баярлахгүй, ямар нэг зүйл алга болоход ч санаа зовдоггүй, сэтгэл шаналж, харуусахгүй. Надад амьдрал, үхэл хоёр адилхан санагддаг, бүр маргааш үхсэн ч болно, зүгээр. Баян, ядуу хоёрт ямар ч ялгаа олж харахгүй байна. Хамгийн муу нь би бусдыг яг гахай мэт харах болсон. (*Бүгд инээв.*) Би өөрийгөө тэдэнтэй яг адилхан бас гахай гэж хардаг. (*Их Багш болон бүгд инээв.*) Өөрийнхөө гэрт амьдардаг ч яг л дэн буудалд байх шиг санагдана. Өөрийн тосгонд байгаа ч харь оронд байх шиг, миний төрөлх нутаг биш юм шиг санагдана. Энэ бүх этгээд хачин зуршил, бодлоос гадна надад өөр маш олон дутагдал байна. Жишээ нь, эрх мэдэл, байр суурь, нэр хүнд, тэр ч байтугай хааны ордонд амьдрах, төрийн өндөр хэргэмтэй алба хашихын алиныг ч тоодоггүй,

энэ бүгд надад энгийн зүйл мэт бодогддог. Би ямар ч шийтгэлээс айхгүй, амьдрал ч, үхэл ч, сайн, эсвэл муу ч бай миний зүрх сэтгэлийг огт хөдөлгөхгүй. Тиймээс би улс орондоо тусалж чадахгүй, хаандаа үнэнч байж чадахгүй, эзэндээ ч шадарлан үйлчилж чадахгүй болов. Найз нөхөд, хамаатан садантайгаа ойр дотно байж чадахгүй, үр хүүхэд, хань ижлээ захирч сургаж, тэдэнтэйгээ харилцаж чадахгүй. Эхнэр, хүүхэдтэйгээ нэг ижил санаа сэтгэлтэй байж чадахаа больсон нь хамт амьдрахад бэрх болгов. Гэрийн үйлчлэгч, шивэгчин нараа ч захирч чадахгүй байна. Би үнэхээр гайхаж байна! Энэ ямар төрлийн өвчин бэ? Та надад үүнийг эмчлэхэд тусалж чадах уу?" гэв. Вьян Цюэ эмч Лун Шуд түүний биеийг тэнгэрийн нүдээрээ харахын тулд эргэж харан наран дор илүү гэрэлтэй газар зогс гэж хэлэв. Тэгээд тэнгэрийн мэлмийгээрээ тольдоод их дуугаар: "Аан! харлаа!" гэж хашхирав. "Та юу харав?" гэж Лун Шу асуухад: "Таны сэтгэлийг харлаа." гэв. "Миний сэтгэл ямар байна?" гэхэд тэрээр: "Сэтгэл тань дөрвөлжин, өргөн бөгөөд дотроо хов хоосон, яг л гэгээнтэн хүний сэтгэлтэй их төстэй шиг. Зургаан сүв нь нээгдэж, одоо нээгдээгүй ганц сүв л үлджээ." гэж хэлжээ. Магадгүй тэр сүв нь нээгдээгүй учраас өөрт туссан өвчнөө тэр Лун Шу мэдэхгүй байсан байх. "Хэрвээ тэр сүв нь нээгдчихвэл өвчнийхөө учрыг тэр маш тодорхой ойлгоно." гэж хэлжээ. Лун Шу: "Энэ одоо ямар өвчин бэ?" гэхэд Вьян Цюэ эмч: "Энэ цаг үед гэгээнтэн хүний билиг ухааныг хүмүүс өвчин гэж үздэг, магадгүй энэ нь таны өвчин байх. Хэрвээ та гэгээнтний тийм өвчин туссан бол миний эмнэх чадвар танд нэмэр болохгүй." гэв.

Та нар ойлгож байна уу? ("*Тийм ээ!" гээд бүгд алга ташив.*) Түүнд ямар өвчин туссаныг би ойлгохгүй байна, гэхдээ та нар ойлгож байгаа нь сайн хэрэг. Та нар үнэхээр ойлгож байна уу! Хөөх! Та нар яаж ойлгож чадав аа? Та нар чинь түүнтэй яг адилхан байх, тийм үү? Тэр бол гэгээнтэн, тиймээс л ижил нь ижилдээ татагджээ, энэ

нь ийм л учиртай байх. Гэхдээ та нарыг эхнэр, хүүхдээ орхиод энд ирж, Багшдаа Дээдийн ном дэлгэрүүлэхэд тусал гэвэл, "Би амжихгүй нь ээ!" гэнэ дээ. Энэ нь та нар бараг энэ хүнээс ч хэтийдсэнийг харуулах бус уу? Тэр хамаатан садан, найз нөхөдтэйгөө холбоотой байж чадахгүй. Харин та нар түүнээс давж гараад нэг алхам цаашилж, хамаатан садантайгаа маш ойр байдаг, тиймээс тэднийгээ огоорон орхиж чадахгүй байна. Хэлэхэд амархан ч хийхэд хэцүү. Гэхдээ бодоод байхад, магадгүй бид бүгдээрээ адилхан байх. Олон хүн ийм асуудалтай байдаг, надад ч гэсэн ийм асуудал байгаа юм шиг санагддаг. Гэвч би гэгээнтэн биш учир бусдаас л халдсан байх.

Энэ дэлхий дээр маш олон төрлийн өвчин байдаг, жишээлбэл, зарим хүн мах идэж, тамхи татаж, архи, өнгөнд дэндүү автсанаас ДОХ гэх зэргийн эмчлэхэд хэцүү өвчин тусдаг! Мөн хэдийгээр танд ямар нэг асуудал байгаагүй ч гадагш гаран ийш тийш дураар явж, бусдын угаалгын өрөө, ариун цэврийн өрөөг ашигласнаар заримдаа бас ийм өвчний халдвар авдаг. Эсвэл зарим хүн дэндүү их ядарснаасаа болж уушгины өвчинтэй болдог, дараа нь та түүнтэй уулзаж, хэсэг хугацаанд ойр дотно харилцаж байвал бас тийм өвчинтэй болно.

Би гэгээнтэн биш ч гэсэн надад бас тийм "гэгээнтний өвчин" байгаа бололтой. Хэн надад халдаасныг мэдэхгүй байна, гараа өргөөд надад харуул даа. (*Бүгд инээв.*) Энэ өвчнийг хэн надад халдааж зүрхэлсэн бэ? Гараа өргө дөө! Та нар өөрсдийн алдааг мэдэж байх ёстой! Мэдэхгүй царайлах хэрэггүй шүү, тийм биз? (*Бүгд инээв.*) Яагаад гэвэл би та нартай л уулздаг, өөр хаашаа ч явдаггүй, хэнтэй ч холбоогүй байдаг. Тиймээс би ямар нэгэн өвчин туссан бол та нараас л болсон хэрэг, тэр хүн хэн бэ? Одоо үүнийг өвчин гэдгийг сонсоод хүлээн зөвшөөрч зүрхлэхгүй болчхов уу? (*Их Багш болон бүгд инээв.*)

Аливаа бүхэн ая зөнгөөрөө байг, хүчлэх хэрэггүй

Та нар халдаасан нь бүр тодорхой байна! Эс бөгөөс би яалаа гэж ийм болох вэ? Өмнө нь би дэлгүүр хэсэх, юм хум худалдаж авах, хамтдаа дуулж, бүжиглэх хүмүүсийг олох дуртай байсан. Үгүй бол ганцаардан өнчрөх байлаа. Одоо бол өдөржингөө унтсан ч хамаагүй, хэрвээ та нар ирэхгүй бол үргэлжлүүлэн унтсаар л байна, өлсвөл босож, иднэ. Би өдөрт нэг, хоёр, эсвэл гурван удаа хооллох нь хамаагүй, идмээр санагдвал иднэ, гэхдээ ихэнхдээ идэх дургүй. Би бараг ийм өвчин туссан байх, тиймээс хамаатан садан, найз нөхөд гэж нэг их сүйд болохгүй байдаг байх. Энэ нь би тэдэнд хайргүйдээ биш, миний тэднийг хайрлах нь та нарыг хайрлахтай яг ижил. Тэднийг хайрлавал хайрлана, үгүй бол үгүй, хүрч ирэхэд нь маш их хайрлана, явсан даруйд нь мартана, мартахад маргааш хүртэл хүлээх хэрэггүй, түүнийг эргэж харангуут би ч бас эргэж харна (*Бүгд инээв.*), миний сэтгэл санаа, хайрын сэтгэл ч өөрчлөгдөнө, сонин шүү! (*Бүгд алга ташив.*) Би ийм төрлийн "Гэгээнтний өвчин" туссан бололтой! Магадгүй халдвар авсан байх, би явж Вьян Цюэ эмчийг олж уулзъя, байз! (*Их Багш болон бүгд инээв.*)

Магадгүй Лун Шу ямар нэг сүнслэг бясалгал дадуулсан байх! Бид сүнслэг бясалгал дадуулснаас хойш ийм болсон юм болов уу? Тийм л бололтой! Бага зэрэг? (*Бүгд тийм гэж хариулав.*) Аан, тэгэхээр та нар л надад халдаасан байх нь. Одоо л та нар хүлээн зөвшөөрлөө. Өмнө нь би ийм байгаагүй, магадгүй бага зэрэг л байсан. Гэтэл одоо улам бүр ийм мэдрэмж төрж байна. Жишээ нь, та нар анхандаа хэн нэгнийг үзэн яддаг байснаа, дараа нь дургүйцэхээ больдог, яасан ч яах вэ гэх маягтай, энэ нь зүгээр л хамаагүй болсон хэрэг. Ирэх дуртай нь ирэг, явахыг хүссэн нь яваг, тэгж их шаналахаа больсон. Та нар шаналсан ч хоёр, гуравхан өдөр л болдог, тийм үү? (*Тийм гэж хариулав.*) Бас та нар тийм ч удаан шаналахгүй. Бид өмнө нь ямар нэг юмаа алдвал,

жишээ нь, бизнес маань бүтэлгүйтвэл маш их шаналдаг байсан. Одоо ер хамаагүй болжээ, бид бусдыг, эсвэл Эзэн Бурханыг буруушаахгүй, өөрөө дахин шаргуу ажиллах болно.

Аль эрт Байлдаант улсын үед гэгээнтнүүд байсан байна. Тэрнээс зөвхөн одоо, зөвхөн Мяолид дөнгөж сая гэгээнтэн гарсан хэрэг биш шүү! (*Багш болон бүгд инээв.*) Та бүхэн өөрсдийгөө Хятадын цорын ганц гэгээнтэн гэж битгий бодоорой. Өмнө нь гэгээнтнүүд байсан байна шүү. Сүнслэг бясалгалын арга төрөл тутамд байсан гэж би та нарт аль хэдийн хэлсэн. Асуудал нь бид гэгээрсэн багшаас суралцах барилдлагатай эсэхэд байдаг, бид ямар Их Багштай барилдлагатай байна, тэр Их Багшаасаа суралцах болно. Лун Шу магадгүй өмнөх төрөлдөө сүнслэг бясалгал дадуулж байсан байх, тэгээд энэ төрөлд ирэхдээ жаахан л бясалгах үлдсэн, жишээ нь, тэр бясалгаад хэдийн дөрөвдүгээр ертөнцөд хүрсэн бол зөвхөн бага зэрэг хичээх л үлдсэн хэрэг шүү!

Үл уягдах, үл таалагдах хоёрын ялгаа

Хэрэв Вьян Цюэ эмч түүнд Төгс Гэгээрсэн Их Багшийг хай гэж хэлсэн бол тун сайн болчих байсан! Түүнд нээгдээгүй нэг л сүв үлдсэн, тэр сүвээ нээлгэмэгц даруй гэгээрч, өөрийгөө өвчтэй гэж бодохоо больчихно. Эсвэл тэр өөрийгөө өвчтэй гэж боддог нь олон хүнтэй уулзаж, харилцаа холбоотой байдгаас болсон байж магад. Хүн бүхэн түүнийг: “Та яагаад ийм этгээд хачин, зүрх сэтгэлгүй, хүйтэн хөндий юм бэ?” гэнэ. Энэ зүрх сэтгэлгүй, хөндий хүйтэн байдал нь бидний бусдыг таалахгүй байхтай адилгүй. Өнөөдөр энэ түүхийг сонсоод хүмүүстэй хүйтэн хөндий харилцаж, (*Бүгд инээв.*) тэгээд энэ бол гэгээнтний “мөс мэт чанар” гэх хэрэггүй[13]. (*Их Багш болон бүгд инээв. Учир нь хятад хэлний*

13 Учир нь хятад хэлний “мөс” гэх үг, “чанар” гэх үгтэй бараг адилхан дуудагддаг.

“мөс” гэх үг, “чанар” гэх үгтэй бараг адилхан дуудагддаг.)

Зарим хүнд ч бас ийм “мөс мэт чанар” байдаг гэж би боддог, цэвдэг хүйтэн зантай, тэд ярихдаа бусдыг үл тоодог, хүн юм асуувал ойлгодоггүй, тэр ч байтугай мэдэж байсан ч хариулдаггүй, эсвэл үгээ зөөж ядан маш удаан хариулна, шинийн нэгэнд асуусан асуултыг арван тавны өдөр сая хариулдаг. (*Бүгд инээв.)* Энэ чинь хүнийг ихэд зовооно, үнэхээр муухай, ойлгов уу? (*Бүгд, Тийм! Ойлголоо гэж хариулав.)* Заримдаа хүмүүс завгүй, хийх зүйл ихтэй, амжуулах ажил өчнөөн олон тул таны эргэн тойронд дэмий сэлгүүцэхийг хүлээх цаг тэдэнд байдаггүй.

Ийм хүн өөрийгөө өөрчлөх хэрэгтэй. Энэ бол “би гэх үзэл”-ийн өвчин, хүнийг хэцүү байдалд оруулах, бусдаар өөрийгөө гуйлгах дуртай, өөрт нь байнга анхаарал хандуулахыг бусдаас хүсдэг учраас зориуд удаан хугацаагаар сунжруулж, бусдад хариулахгүй уддаг, эсвэл тэр өөрийгөө маш агуу, эрхэмсэг сайхан хэмээн ойлгуулахын тулд үүнийг маш удаан хийдэг. Энэ бол эрхэмсэг байдал биш, тэнэг бөгөөд утгагүй явдал юм! Ганц, хоёр удаа бол магадгүй хүмүүс ичиж зовно, гэхдээ танд элдэг хандсан хэвээр байж, танаас тусламж хүсэж, тантай харилцсаар байна. Яваандаа тэд үүнээс залхана. Ямартай ч энэ дэлхий дээр ийм хүн олон байна, тэд яах гэж тан шиг олиггүй, уйтгартай, хөдөлж ядсан хэсэг мөсийг эрж хайх ёстой вэ? Багшийнхаа санааг ойлгов уу? *(Тийм! гэцгээв.)* Тиймээс бидний энэ дэлхийд үл хүлэгдэх, энэ дэлхийг үл таалах хоёр ялгаатай. Лун Шу үнэхээр өвчин туссан юм биш, ердөө л хамаатан садан, найз нөхдөдөө ч, төрсөн хот, газар нутагтаа ч тэгтлээ их хүлэгдээгүй хүн. Гэсэн хэдий ч тэр хүйтэн хөндий хүн байгаагүй, сэтгэлдээ бол тун хэвийн хүн. Тэр санаатайгаар бусдын ажлыг хүндрүүлж, бусдад өөрийгөө гайхуулж, гэгээнтэн гэдгээ мэдүүлэх гэж байгаа хэрэг биш. Гэтэл зарим хүн түүнээс ялгаатай нь маш хүйтэн хөндий байж, удаан ярьж, цагаан

сарын шинийн нэгэнд ярьсан өгүүлбэрээ арван таван болтол дуусгадаггүй, эсвэл хүн уулзахаар ирэхэд зориуд дуугарахгүй: Та юу хийхийг хүсээ вэ? Би танд туслах уу? гэх зэргээр хариу өгдөггүй. Хүнд даруйхан халуун сэтгэлээр туслахын оронд үгээ зөөж ядан, мм... мм... мм… гэсээр маш их удна, хоолойд нь юу тээглэдгийг би мэдэхгүй, магадгүй тэнд үйл түйтгэр нь тээглэн гацдаг биз. *(Их Багш болон бүгд инээв.)* Үгүй бол, тэр цастай уулнаас дөнгөж бууж ирсэн, магадгүй, цаст уулын их багш, эсвэл Хималайн их багш мөн байх аа *(Их Багш болон бүгд инээв.),* хүмүүст тэндхийн хүйтэн, хүйтэн агаар ямар байдгийг мэдүүлэхийг хүссэн байх! Би тийм хүйтэн хөндий, мөс мэт хүнтэй харилцаатай байхаас айдаг. Тийм хүн ажлаа хийхдээ алгуурлан цаг үрж, зориуд хүмүүсийн анхаарлыг татаж, бусдаар өөрийгөө гуйлгахыг боддог. Энэ бол үнэндээ маш хүнд би гэх үзлийн өвчин, өөрийгөө дорд үзэх гутрангуй өвчин юм. Хэрэв хүн өөртөө итгэлтэй байсан бол ийм зан байдал гарахгүй, маш үнэнч шударга, найрсаг халуун сэтгэлтэй, юуг ч тэгж удаан хийгээд байхгүй байх байсан. Эсвэл тэр өмнө нь өөрийгөө дүүжилсэн байх, тэр дурсамж нь энэ амьдралд нь байсаар, өнөөх олс шидэмс хүзүүг нь боомилсноос хоолойгоор нь үг давахгүй болжээ. *(Бүгд инээв.)*

Мэдсэн даруйдаа зас

Хүмүүс бид дутагдал ихтэй, заримдаа өвчтэйгөө ч мэддэггүй. Лун Шу өөрийгөө өвчтэй гэж бодсон ч үнэндээ тэр ямар ч өвчингүй. Бидний олонх нь өөрийгөө өвчингүй гэж боддог ч үнэн хэрэгтээ өвчтэй байдаг. Тиймээс бид ямар өвчтэй болохыгоо олж мэдэх хэрэгтэй. Хүн бидэнд нэг, хоёр, эсвэл гурван удаа засаж хэлж өгөхөд бид өвчин маань хаана байгааг мэдэж, аль болох хурдан өөрийгөө аврах ёстой. Хэрэв бид өөрсдийгөө аварч чадахгүй бол ном уншиж, бусдаас тусламж хүсэх хэрэгтэй, тэндээ үүрд гацах хэрэггүй.

Хэрвээ бид алдаа дутагдлаа засахгүй бол Төгс Гэгээрсэн Их Багшийг дагасан ч бай, үгүй ч бай ялгаагүй дараагийн удаа дахиад төрөл авах болно. Учир нь бид тэр нэг зүйлтэйгээ зууралдаад тавьж чадахгүй, түүнээсээ зуурсаар байдаг, түүнийгээ бусдыг хүндрүүлэх зүйлсийг хийж, хүмүүсийн анхаарлыг татахад зэвсэг болгон ашигладаг. Энэ нь бид ийм нөхцөл байдалд буцаж очихыг хүсэж байгаа гэсэн үг юм! Энэ дэлхийн хууль маш шударга, юу хүснэ, түүнийгээ авдаг. Төгс Гэгээрсэн Их Багшийн хувьд ч мөн адилхан, Тэр таныг хүчээр туулан гэтэлгэж болохгүй, та өөрөө хүссэн байх хэрэгтэй. Эмч ч адил. Тэр танд хүчээр эм уулгаж, бас хүчээр хэвлийг тань нээж ч болохгүй, та өөрөө гуйгаагүй бол ингэж болохгүй. Тийм биз? (*Тийм гэцгээв.*) Тэр ч байтугай та ухаан алдаад хүссэнээ хэлж чадахгүй боллоо ч гэсэн хамаатан садан тань таны өмнөөс хүсэлт гаргаж болно, өөрөөр хэлбэл та хэдийн сэтгэлдээ зөвшөөрсөн гэсэн үг бөгөөд зөвхөн та зөвшөөрсөн тохиолдолд л үүнийг хийх боломжтой.

Хэрэв та өөрөө зориудаар алдаа дутагдалтайгаа эвлэрэн зууралдаад байвал дараагийн удаад дахин төрөл авах ёстой болно, мөн та Төгс Гэгээрсэн Их Багштай дахин уулзахгүй байж магадгүй юм. Тэгвэл та зургаан сүв нь нээгдчихсэн сэтгэлээ тээгээд хаа сайгүй явах Лун Шу шиг болно. Өвчнөө хаана байгааг мэдэхгүй хэвээр, тэгээд долоо дахь сүвээ нээхэд их хэцүү байх болно. Та нар энэ талаар бодоорой, ямар дутагдал байна, түүнийгээ даруй засах хэрэгтэй, учир нь хэрэв та тэдгээрийг одоо өөрчлөхгүй бол маргааш, эсвэл нөгөөдөр өөрчлөх хэрэгтэй болно. Эс бөгөөс хойшлуулах тусам улам төвөгтэй болж, танд улам их асуудал гарч ирэн хүү нь нэмэгдэнэ. Тэгээд тэр муу зуршил нь улам бүр бэхжиж, тогтворжиж, түүнээсээ салах нь бидэнд улам бүр хэцүү болдог.

Арван дөрөвдүгээр бүлэг

ГЭГЭЭНТЭН ХИЙГЭЭД ЭГЭЛ ХҮНИЙ ЯЛГАА

““Жуанз”-ын “Амь тэжээхүйн эзэн” бүлгийн тайлбар”

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
АНУ, Вашингтон муж, Сиэтл
1993 оны 4 дүгээр сарын 8.
(Эх нь англи хэлээр)

Хязгааргүй мэдлэгийг сурч яаж барах вэ?

“Жуанз”-ын дотоод бүлгүүдийн гуравдугаар бүлэг (Амь тэжээхүй эзэн)-д: “Хүний амьдрал хязгаартай, харин мэдлэг хязгааргүй. Хязгаартай амьдралтай хүн хязгааргүйг хөөцөлдвөл аюултай!” гэж дурджээ.

Амьдрал хязгаартай, харин эрдэм мэдлэгт эцэс төгсгөл гэж үгүй! гэдгийг та нар мэдэх ёстой. Учир нь бидний амьдрал түр зуурынх, тиймээс бид энэ насаараа

амьдрах бүхий л хугацаагаа энийг ч, тэрийг ч сурахад зарцуулах боломжгүй, дэлхий дээрх бүх мэдлэгийг эзэмших боломжгүй! Жишээ нь, бид эмнэлгийн мэргэжилтэн болсон бол электроникийн мэргэжилтэн болж чадна гэдгийг хэлэхийн аргагүй. Тэр ч байтугай үргэлжлүүлэн суралцсан ч энэ дэлхийн бүх мэдлэгийг сурах боломжгүй. Хэрвээ бид бүх амьдралаа энэ дэлхийн эрдэм мэдлэгээс илүү өргөн, илүү цар хүрээтэй билиг ухааныг сурахад зориулна гэвэл хэзээ ч суралцаж дуусахгүй. Бурханы хутагт хүрэх эсэх нь хэчнээн олон судар ном мэддэгээс, эсвэл энэ дэлхийн ямарваа багаж хэрэгслийн өгч чадах боломжоос шалтгаалахгүй, харин бидний дотоодод аль хэдийн оршин байгаа мэдлэгийн асар их сан хөмрөгөө дахин нээх эсэхээс шалтгаална. Тэр үед бид бүх зүйлийг, тэр дундаа дэлхийн мэдлэгийг ч бас аяндаа л мэдчих болно.

Тиймээс та бүхэн өөрсдийн туршлагад үндэслээд өмнө нь ойлгодоггүй, эсвэл хийх боломжгүй байсан олон зүйл байсныг мэдэж чадна. Авшиг хүртэж, хэсэг хугацаанд бясалгал дадуулаад дотоодын Мөн чанараа олсны дараа бүх зүйлийг ойлгодог, олон зүйлийг мэддэг гэдгээ нээж олдог, тийм үү? *(Тийм гэцгээв.)* Та нар бүгд ийм ахуй ойлголттой байдаг, надад ч бас ийм ахуй ойлголт бий. Жишээ нь, хөгжим зохиож, төгөлдөр хуур тоглоход маань хүмүүс намайг маш олон жил хөгжмөөр хичээллэсэн, эсвэл хөгжим тоглож байсан гэж боддог ч энэ нь тийм биш юм! Би ямар ч бэлтгэлгүйгээр хүссэн үедээ тоглож чадна. Уран зураг, интерьер дизайн, эсвэл загварын дизайны хувьд ч мөн адил байдаг, надад бэлтгэл хийх шаардлага байхгүй, гэхдээ би энэ бүх мэдлэгийг ямар ч сургуульд сурч эзэмшээгүй.

Энэ дэлхийн эрдэм мэдлэг хүртэл бидний дотоодод хэдийнээ байж байдаг, бид хаалгаа нээх үед тэнд мэдлэг бүхэн тов тодорхой байж байх болно. Жишээ нь, би хэзээ ч анагаах ухааны сургуульд сурч байгаагүй, гэвч олон хүн

өвчлөх үедээ, эсвэл хагалгаанд орох үедээ Багш нь очиж туслахыг харсан бөгөөд тэдний өвчин удалгүй эдгэрсэн нь жирийн эмчилгээ хийлгэснээс хамаагүй илүү үр дүнтэй байсан гэдэг. Энэ бол Багшийнх нь дотоодод анагаах ухааны нууцлаг мэдлэг байдаг учраас тэр юм.

Бидний ихэнх нь энэ газар дэлхийд олон тэрбум жил амьдарсан бөгөөд олон төрлийн зүйл хийж байсан, тэр бүхэн маань бүгд бидний ой санамжид хадгалагдан үлддэг байна. Тиймээс бид өөрийн билиг ухааны их санг нээвэл бүх мэдлэг тэнд байж байгааг олж мэдэх болно. Бид аль хэдийн сурчихсан болохоор дахин сурах шаардлагагүй! Бүхнийг сурчихсан бол илүү өндөр дээд дэс түвшинд дэвших чадвартай болно, өөрөөр хэлбэл гэгээнтэн, бурхан болно.

Үнэн хэрэгтээ, орчлон ертөнцөд хамаг төрөлтөн бүтээгдэн бий болохоос өмнө билиг ухааны үр дотор түмэн бодис хэдийнээ суулгагдсан байдаг. Одоо бид бүх зүйлийг нэгээхэн өнцөг булангаас нь сурахыг оролдож байгаа нь зүгээр л цаг үрсэн хэрэг! Хүн бүр Бурхан Багшийг “анагаах ухааны хаан” “King of Medicine” хэмээн магтдаг нь анагаах ухаан хийгээд бусад бүх салбарын хамгийн дээд нь гэсэн утгатай, учир нь Бурхан Багш бүх зүйлийг мэддэг. Бурхан Багш хэзээ ч ид шидийг дадуулж байгаагүй, гэвч ид шидийн хүчтэй байсан, Бурхан Багш хэзээ ч анагаах ухаанд суралцаагүй, гэвч өвчнийг анагааж чаддаг байсан.

Билиг ухааны эрдэнэсийн сангаа нээвэл бүхэнд нэвтэрнэ

Манай бүлгийн хувьд ч мөн адил. Та нар бүгдээрээ л Их Багшийн ид шидийн хүч чадал тун их, өвчин анагааж чаддаг, бусдын бодлыг мэддэг, хамгийн осолтой үед биднийг ирж авардаг гэх зэргээр ярьдаг. Гэхдээ энэ бүхэн тийм ч сүрхий зүйл биш. Бүх мэдлэг билиг ухааны агуулахад хадгалагдаж байдаг. Та өдөр бүр бясалган суух үедээ янз бүрийн салбарын мэдлэгийг өөрийн мэдэлгүй сэргээж

байдаг, энэ нь таныг бүх талаар маш билиг ухаантай болгох бөгөөд дараа нь та: “Яаж ийм боломжтой болчхов оо? Би хэзээ ч үүнийг сурч байгаагүй, би яаж мэдээд байгаа юм бол оо?” гэж бодно. Онцгой нөхцөл тохиолдож, гүн бөгөөд нарийн мэргэжлийн мэдлэг шаардагдах үед та өөрөө хийж чаддагаа гэнэт олж мэдэх болно!

Хэрвээ үнэхээр хийж чадахгүй бол ердөө л дотоодын Их Багшдаа даатгаж, түүнийг шийдвэрлэхэд туслахыг гуйхад л болно. Та нар энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүс шүү. Та нар хийхийг хүссэн бүхэндээ Багшаасаа үргэлж тусламж гуйдаг. Гэтэл үнэндээ та нар дотооддоо маш хүчирхэг шүү! Хэрвээ та суралцах шатандаа байсаар байгаа, өөрийн билиг ухааныг бүрэн ашиглах чадваргүй байгаа бол мэдээж дотоодын Их Багшаасаа тусламж гуйх хэрэгтэй, тийм учраас багш хэрэгтэй байдаг. Гэхдээ дараа нь та бүх зүйлийг өөрөө хийх болно. Жишээ нь, та дагалдан мужаан байх үедээ зарим зүйлийг хийхэд хүндрэлтэй байдаг, мөн яаж хийхээ мэдэхгүй бол багшаасаа тусламж хүснэ, мэдээж багш тань даруй ирж тусална. Дараа нь та түүнийг яаж хийхээ мэддэг болно.

Хэрвээ бид дэлхийн бүх зүйлийг сурахыг хүсвэл бидэнд хангалттай цаг хугацаа байхгүй. Тиймээс өөрийн билиг ухааны их санг нээх нь илүү дээр. Тэнд мэдлэг бүхэн бий. Хэрвээ та өөрийн агуу гэдгээрээ бахархахыг хүсэж байвал тэр бахархалдаа үнэхээр тохирч тэнцэхээр байх ёстой. Хэрвээ өөрийгөө агуу гэж бодохыг хүсэж байвал зөв үзэл ойлголттой байж, өөрийгөө үнэхээр агуу гэдгээ ойлгох ёстой. Эхлээд та бүхэн гэгээрэх хэрэгтэй, дараа нь бясалган сууж, Аялгуу ажих үеэр олон зүйл хүрч ирэх болно, маш олон үзэл ойлголт, маш их мэдлэг, олон хариулт ундран гарна. Энэ бол бидний суралцах шууд зам, хажууд багш байх шаардлагагүй, учир нь бид дотооддоо харилцдаг, тэр үед л бид жинхэнэ сургаал юу болохыг үнэхээр мэдэх болно.

Бүх аман сургаал, эсвэл номын айлдвар нь миний сургаалын багахан хэсэг бөгөөд ердөө л гучин хувийг эзэлнэ. Миний сургаалын далан хувийг та нар чимээгүй байж, бясалган сууж байхдаа, эсвэл унтаж байхдаа олдог. Унтаж байхад тань Багш нь таныг дагуулж нэлээд дээд түвшний сургуульд хүргэж, тэнд сургаж байдаг. Тиймээс хэдийгээр заримдаа та бүхэн бясалган суух үед ахуй ойлголт тийм их байдаггүй ч билиг ухаан тань арав дахин, хорь дахин, зуу дахин өссөөр, нэмэгдсээр л байдаг. Таны энэрэн нигүүлсэх сэтгэл болон дэс түвшин тань бас олон талаар дээшилдэг. Энэ бүхэн чимээгүй сургаалтай холбоотой.

Гэгээрсэн хийгээд гэгээрээгүй хоёрын ялгаа

Шавь нараа гэгээрүүлэхийн тулд ямар ч Төгс Гэгээрсэн Их Багш үг хэрэглэхгүй, үгээр гэгээрүүлж, эсвэл зааж сургасан байлаа гэхэд энэ нь бүх зүйл биш байдаг. Бид дотооддоо холбогдсон л бол сургаалыг цаг үргэлж шууд хүлээн авах бөгөөд ингэснээр илүү их билиг ухаантай, мөн бүх талаар улам их мэдлэгтэй болж, юу ч тохиолдсон хэрхэн шийдвэрлэхээ мэдэх болно. Хэдийгээр өмнө нь та нар тийм ч хурдан хариу үйлдэл хийж чаддаггүй байсан бол одоо тэгж чадна! Энэ нь та нар бясалгаж суугаа үедээ, унтаж байхдаа, эсвэл өдөр тутмын амьдралдаа өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн Төгс Гэгээрсэн Их Багш нараас шууд, тогтмол суралцсаар байгаагаас болжээ. Та нар хоногийн хорин дөрвөн цагийн турш адислагдаж байдаг, энэ бол гэгээрсэн хийгээд гэгээрээгүй, авшиг хүртсэн хийгээд хүртээгүй хоёрын ялгаа юм.

Заримдаа би өөрөө ялгааг нь мартдаг ч надад мэдэх боломж олддог, бас та нар үргэлж мэдэх боломжтой, учир нь дэлхийтэй хамт байх боломж та нарт надаас илүү байдаг. Тэр ч байтугай хэрэв зарим хүн мэргэжлийнхээ чиглэлээр маш сайн мэдлэгтэй, маш ухаалаг, маш авьяаслаг, нийгэмд эзлэх байр суурь өндөртэй байлаа ч түүнтэй харилцах үедээ

та ялгааг нь мэдэх болно. Зөвхөн та нар л мэдэх бөгөөд нөгөө хүн мэдэхгүй ч байж магад. Тиймээс судар номд: “Бурханыг зөвхөн Бурхан л ойлгоно.” гэж өгүүлсэн байдаг.

Хэдийгээр та бүхэн дотоодын боломжит Бурхан чанараа бүрэн ухаарч ойлгож чадаагүй байгаа боловч ядаж л Бурханы орон луу явах зам дээр байгаагаа бүгд мэдэж байгаа шүү дээ. Одоо ч доод талд, эсвэл гадна байсаар байгаа тэр хүмүүстэй харьцуулах үедээ та нар Арьяабалын бясалгалын аргыг дадуулан бясалган сууснаар хэчнээн их ач тусыг олсноо мэднэ. Түүнээс биш ямар ч их мэдлэг, ярилцлага, номын тайлал нь хүнийг гэгээнтэн болгох, эсвэл гэгээрүүлэх аргагүй юм. Энэ нь үнэхээр тэнгэр, газар шиг ялгаа юм.

Жишээ нь, бид одоо хэдийнээ том болсон ч заримдаа хүүхдүүдтэйгээ тоглохдоо зориуд баярлан хөөрсөн царай гаргадаг, мэдээж, бид өөрсдөө бас тоглож наадаад баясдаг л байх. Энэ нь бид хүүхдүүдээ хайрладаг, тэдэнтэйгээ хамт байж, баярлан хөөрөхийг хүсдэг учраас тэр юм. Бид тэдэнтэй тогловол тэд баяртай байдаг, бид ч бас баярладаг. Магадгүй бид бага насаа дурсаад хэдэн хором хөөрөн баясдаг, гэсэн ч том хүн тоглоом наадгайд хүүхэд байсан үе шигээ тэгтлээ татагдахгүй.

Үүний нэгэн адил Арьяабалын аргаар бясалгаж гэгээрсэн хүмүүс жирийн хүнтэй адилхан харагддаг, тэд заримдаа санаа сэтгэл нь уймарч, бухимдаж уурладаг, гэвч хэзээ ч хүний энэ түвшинд удаан оршихгүй, өөрийн сэтгэл хөдлөлийг сэрж мэдэрч байдаг ч түүндээ живдэггүй. Яг л бид хэдийнээ өсөж том болсон тул балчир хүүхэдтэй хамт тоглож байхдаа тэдэн шиг тоглоом наадгайдаа автдаггүйтэй адил юм. Үүнтэй адил, манай бүлгийн гэгээрсэн хүмүүс эгэл жирийн хүнтэй адилхан харагддаг ч тэд жирийн хүнээс өөр. Та бүхэн үүнийг маш сайн ойлгож байгаа, тийм биз? *(Тийм гэцгээв.)* Ойлгож байгаад тань би их баяртай байна.

Би мэдэхгүй тул зарим үед та нар надад сануулах хэрэгтэй. Миний хувьд бүх хүн Бурхан, заримдаа би: “Өө, тийм шүү! Тэд хэдийгээр Бурхан боловч зөвхөн мунхаг Бурхан юм байна!” гэж ойлгодог. Яг л зарим хүүхэд өсөж томроод тэс өөр, бадируун, өндөр, хүчтэй харагддаг шиг. Тэднийг алсаас, эсвэл гаднаас нь хараад бид том хүн байна гэж боддог, тэгээд дараа нь түүнтэй ярилцаж үзээд: “Өө! Дөнгөж аравхан настай хүүхэд байна.” гэдгийг нь ойлгодог.

Дэлхийн хүмүүс заримдаа тун ухаалаг мэт санагддаг ч тэр нь гэгээрэл биш, ухаарал нь гүн гүнзгий биш байдаг. Хэрэв тэдэнтэй арай илүүхэн ярилцвал хоорондын ялгаагаа олж харна. Иймээс та бүхэн өөрийн гэгээрэл, ухаарлын дэсэд эргэлзэж байвал хэн нэгэнтэй ярилцаад үзээрэй. Зөвхөн гэгээнтнүүдтэй уулзах гэж үргэлж залбирах хэрэггүй, эгэл хүнтэй уулзсан ч зүгээр, тэд ч бас та нарт тустай, ингэснээр та нар ямар ахиц дэвшил гаргаснаа ойлгож мэдэх болно.

Цагааныг хартай харьцуулбал илүү тод харагдана. Хэрвээ дэлхийн бүх зүйл цагаан бол хэн ч “энэ бол цагаан” гэж бодохгүй, ийм байх нь зүй ёсны хэрэг, учир нь угаасаа л ийм байдаг гэж үздэг. Гэхдээ цагааныг хартай харьцуулбал цагаан гэдгийг нь мэднэ. Үүн шиг, хэрэв бид хаяа бусад хүнтэй уулзаж байхгүй бол тийм ч итгэлтэй байж чадахгүй, тиймээс олны дунд байх нь бидэнд бас сайн.

Нөхцөл байдал ямар ч байсан та нар хүлээн зөвшөөрч, тэндээс суралцах хэрэгтэй, үгүй бол та нар яаж мэдэх вэ? Та нар гэгээнтнүүдийн бүлэгт байхын ашиг тусыг мартсан байна. Хэдийгээр энэ нь зөвхөн хаалганы дотор болон гадна байхын л ялгаа, үүдний орох хэсэгт бага зэрэг л гэрэлтэй байдаг ч бид нэгэнтээ алхан орсон л бол үүрд өөрчлөгддөг. Үүд хавьд зогсож байна уу, эсвэл өндөр дээд дэсэд нэвтэрсэн байна уу хамаагүй, урьд нь хаалганы гадна зогсож байснаасаа өөр болсон байдаг. Бүрмөсөн өөр болдог! Мэдээж, бид урагшлах тусам, илүү ихийг олж нээнэ, энэ нь

бидний амьдралыг огт өөр болгох болно!

ЭХ СУРВАЛЖИЙН ЛАВЛАГАА

Та бүхнийг энэ дэлхийд залран буй Төгс Гэгээрсэн Их Багшийн айлдваруудын эх хувилбарыг сонсож, илүү их адислал хүртэхийг урьж байна.

12 дугаар хуудас

Арьяабалын бясалгалын аргыг дадуулж байсан Найман арш

1988 оны 4-р сарын 8-нд Формосагийн Тайбэйд хятад хэлээр айлджээ. (аудио бичлэгийн дугаар CE5B, аудио № 347, видео бичлэгийн дугаар байхгүй). Эх сэдэв нь: Найман арш ч бас Арьяабалын бясалгалын аргыг дадуулж байсан. Ау Лак хэлээрх "Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 14 дүгээр ботид нийтлэгдсэн.

29 дүгээр хуудас

Нүйва чулуу хайлуулж, тэнгэрийг нөхсөний далд утга санаа

1988 оны 5-р сарын 11-нд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Формосагийн Гаосюн хотод хятад хэлээр айлджээ. (аудио бичлэгийн дугаар CE6B, аудио № 360, видео бичлэгийн дугаар байхгүй.)

Эх сэдэв нь: Бурханы хутагт хүрэх нөхцөл байдал. Ау Лак хэлээрх "Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 13 дугаар ботид нийтлэгдсэн.

42 дугаар хуудас

Ян Зигийн билиг ухаан

1988 оны 5-р сарын 19-нд Формосагийн Пиндунд хятад хэлээр айлджээ. (аудио бичлэгийн дугаар CE7A, видео бичлэгийн дугаар байхгүй) Эх сэдэв нь: Арьяабалын алдрыг “унших”-ын жинхэнэ утга. Ау Лак хэлээрх “Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр” номын 13 дугаар ботид нийтлэгдсэн.

57 дугаар хуудас

“Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолын дүрүүд

1993 оны 10-р сарын 1-нд Хонконгийн Шатины Тянь Шан (Тэнгэр уул) ашрамд хятад хэлээр айлджээ. (видео бичлэгийн дугаар # 381)

Хонконгийн хоёр хоногийн даяан, Намрын дунд сарын “Сарны баяр”-ын айлдвар, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 97 дугаарын “Анхаарвал зохих ном” хэсэгт нийтлэгдсэн.

64 дүгээр хуудас

Бясалгал бүтээлийн зам дахь ад чөтгөрүүдээс болгоомжил!

1991 оны 8-р сарын 1-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлджээ. (видео бичлэгийн дугаар #190) Эх сэдэв нь: Яагаад бид хамтдаа бясалгал хийх ёстой байдаг вэ? Аливаа бүхэн сэтгэлээр бүтээгддэг , Урт наслах нууц арга, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 97 дугаарын “Анхаарвал зохих ном” хэсэгт нийтлэгдсэн.

67 дугаар хуудас

Ид шид ба Их билиг ухаан

1988 оны 4-р сарын 2-нд Формосагийн Шиньжү-д хятад хэлээр айлдав. (видео бичлэгийн дугаар #6) Эх сэдэв нь: Их Багшийн ид шид ба их билиг ухаан, Ау Лак хэлээрх "Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 14 дүгээр ботид нийтлэгдсэн. SMTV.tvWOW 364, 365

89 дүгээр хуудас

Цаг хугацаа, орон зайнаас хэтийдсэн их сайд

1988 оны 6-р сарын 8-нд Формосагийн Тайжун хотод хятад хэлээр айлдав. (аудио бичлэгийн дугаар CE8A, аудио № 373, видео бичлэгийн дугаар байхгүй). Эх сэдэв нь: Төгс Гэгээрсэн Их Багш бол заяа тавиланг засварлагч юм. (1, 2). Ау Лак хэлээрх "Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр" номын 14 дүгээр ботид нийтлэгдсэн.

104 дүгээр хуудас

Их Багш "Усан хөвөөний шастир"-ын талаар

1988 оны 4-р сарын 21-нд Формосагийн Тайнань хотод хятад хэлээр айлдав. (аудио бичлэгийн дугаар # CE6A, аудио № 352, видео бичлэгийн дугаар байхгүй.). Эх сэдэв нь: "Усан хөвөөний шастир" зохиолын түүхүүд ба сүнслэг бясалгал. Ау Лак хэлээрх "Агшин Зуур Гэгээрэхийн түлхүүр" номын 13 дугаар ботид нийтлэгдсэн.

124 дүгээр хуудас

Түүхээр багшлуулахуй

1996 оны 3-р сарын 14-нд Америкийн Калифорни муж, Лос Анжелест англи хэлээр айлдав. (видео бичлэгийн дугаар # 537). Эх сэдэв нь: Оюун ухааныхаа хүчийг болгоомжтой ашигла (1,2) Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 128 дугаарын "Их Багшийн айлдвар" хэсэгт нийтлэгдсэн .SMTV.tvBMD 52 (р-1,2) 2007-03-26&27

141 дүгээр хуудас

Хатуу, зөөлнийг хослуулж чадвал төгс төгөлдөр мөн - Күнз болон түүний шавь нарын түүх

1994 оны 4-р сарын 6-нд Хонконгийн Шатиний Тянь Шан (Тэнгэр уул) ашрамд хятад хэлээр айлдав. (аудио бичлэгийн №1407, Чин сэтгэлийн өглөг, видео бичлэгийн дугаар #415) Эх сэдэв нь: Чин сэтгэлийн хувь нэмэр. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 38 дугаарын "Их Багшийн айлдвар" хэсэгт нийтлэгдсэн .SMTV.tvBMD 630, 632, 2008-06-05&07

152 дугаар хуудас

Бао Шуя, Гуань Жун хоёрын сайн үлгэр дуурайл

1996 оны 1-р сарын 7-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав. (аудио бичлэгийн №1629, видео бичлэгийн дугаар #522) Эх сэдэв нь: Гэгээнтэн Мэргэн гэгээнтнүүдийн түүх (Гуань Жун ба Бао Шуя), Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 55 дугаарын "Их Багшийн айлдвар" хэсэгт нийтлэгдсэн .SMTV.tvWOW 1577, 1578, 1580 (р-1,2,3), 2011-01-08&09&11

168 дугаар хуудас

Улсаа төвшитгөж, дэлхий дахиныг амар амгалан болгох нь мөн л сүнслэг зам мөр

1995 оны 9-р сарын 10-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 51 дугаарын "Их Багшийн айлдвар" хэсэгт нийтлэгдсэн. SMTV.com BMD (р-1-10) , 2024-04-10&19.

179 дугаар хуудас

Гэгээнтний өвчин

1996 оны 2-р сарын 4-нд Формосагийн Шихү ашрамд хятад хэлээр айлдав. (аудио бичлэгийн №1634. Гэгээнтнүүдийн түүхүүд - Жинхэнэ гэгээнтэн, видео бичлэгийн дугаар #522). Эх сэдэв нь: Гэгээнтэн мэргэдийн түүх (Гуань Жун ба Бао Шуя) Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 56 дугаарын "Их Багшийн айлдвар" хэсэгт нийтлэгдсэн.

187 дугаар хуудас

Гэгээнтэн хийгээд эгэл хүний ялгаа

"Жуанз"-ын Амь тэжээхүй эзэн хэсгийн бүрэн тайлбар

1993 оны 4-р сарын 8-нд Америкийн Вашингтон мужийн Сиэтл хотод англи хэлээр айлдав. (видео бичлэгийн дугаар #349) Эх сэдэв нь: Үггүй сургаал, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Мэдээ сэтгүүлийн 99 дугаарын "Их Багшийн айлдвар" хэсэгт нийтлэгдсэн.

АВШИГ ХҮРТЭХҮЙ – АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажих” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажих багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон сүнслэг бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Тэрхүү Аялгуу нь Эзэн Бурхантай хамт оршиж байсан, төдийгүй Аялгуу өөрөө Эзэн Бурхан мөн байв.” гэжээ. (Иохан 1:1) Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Шабд (Shabd)”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодист нэвчин хэлбэлзэж, бүхий л орчлон ертөнцийг бүхэлд нь тэтгэн тэжээдэг. Энэхүү дотоод хэмнэл нь аливаа шархыг эдгээж, бүхий л хүсэл эрмэлзлийг гүйцэлдүүлэн, эгэл ертөнцийн шунал тачаалыг намжаана. Тэрээр бүхнийг чадагч, хайраар бялхсан оршихуй мөн. Бид энэхүү Аялгуунаас үүссэн тул түүнтэй холбогдоход сэтгэл амирлан ханана. Түүнийг сонсохуйд бид бүхэлдээ хувирч, амьдралыг үзэх үзэл маань үндсээрээ шинэчлэгддэг.” гэжээ.

“Гэгээрэх” гэдэг нь дотоодын гэрэл- “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авхуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид

Бурханыг дотоодын Гэрэл, Аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр Гэрэл болон Аялгуу ажихад онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын Аялгууг сонсож, дотоодын Гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Насан туршдаа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж, Бурхан болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй

бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө сүнслэг дадал бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө дадуулан бясалгаж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрж хайдаггүй. Мөн гишүүнчлэлтэй байгууллага байгуулж, хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөн мөргөхийг зөвшөөрдөггүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээн авдаггүй тул ямар нэгэн өргөл барьц өргөх шаардлагагүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болон сүнслэг дадал бясалгалдаа өөрийгөө дэвшүүлж, гэгээрэлд хүрэхийг хүссэн чин сэтгэлийг тань л хүлээн авдаг.

ТАВАН САХИЛ

1. Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ.*

2. Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ.

3. Өөрийн бус зүйл авахыг цээрлэнэ.

4. Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ.

5. Согтууруулах, мансууруулах болон аливаа хорт бодис хэрэглэхийг цээрлэнэ.**

*Энэ сахил нь цэвэр веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, зайрмаг гэх мэт) амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

**Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи уух, тамхи, хар тамхи татах, мөрийтэй тоглоом тоглох, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг үзэх, ном, сэтгүүл унших, цахим тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх багтана.

ВЕГАН ХООЛНЫ АЧ ТУС

Насан турш веган (ургамал) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгалын авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтан бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь ярангүй. Бусдад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь “Ямар үйл хийнэ, тийм үр хүртэнэ.” хэмээх үйл үрийн хуулиар зохицуулагддагтай холбоотой. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан, өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг.

Зарим хүн сүнслэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн цагаан хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбийн их сургуулийн доктор Г.С.Хантинген хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Маханд байгаа эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээс шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлхтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдсэнд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез уураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез уураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг

байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хатах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махны холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсэхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй. Амьтан нэг бүрийг бүү хэл зүсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаях маягаар өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ургамал хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: “Бид веган хоол хэрэглэвэл, идэж буй хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн амьтнаас гаралтай бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллож чадна.” хэмээн хэлсэн байдаг.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стеройд зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодис хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махны антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажиллах хугацаандаа эмнэлгийн ажилтан, өвчтөнүүд нь бүгд веган хооллодог эмнэлэг байгуулжээ. Тэрээр: "Орчин үеийн шинжлэх ухааны ачаар анагаах ухаанд их дэвшил гарсан ч эм тан зөвхөн өвчнийг л анагаадаг. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэдэг." хэмээн онцолсон байна. Мөн тэрээр: "Ургамлаас авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүнд байдаг ихэнх өвчнийг тээдэг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?" гэжээ. "Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч эрүүл саруул байх бүрэн боломжтой." гэж Доктор Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард "Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй." гэж зарлажээ.

Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 цагаан хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд цагаан хоолтнууд нь илүү тэсвэр хатуужилтай болох нь харагджээ. Туршилтад оролцогчдоор гарыг нь аль болох удаан өргүүлсэн бөгөөд үр

дүн нь тун тодорхой байв. Махан хоолтон 15 хүний зөвхөн хоёр нь гараа 15-30 минутын турш өргөж чадсан бол цагаан хоолтон 32 хүний 22 нь 15 минутаас илүү, 15 нь 30 минутаас илүү, 9 нь нэг цагаас илүү, 4 нь хоёр цагаас илүү хугацаанд гараа өргөж чадсан бөгөөд нэг хүн гурван цагаас дээш хугацаанд гараа өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Море 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг эвдсэн байна. Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ байхыг би хүссэн юм” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний ууураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4.5 хувийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%-ийн илчлэгийн эх үүсвэр нь ууураг юм. Иймээс мах хэрэглэхгүй веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тос хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин,

батга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусанд байгаа чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно. Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.

ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд шатааж устгасан 5 квадрат метр ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр цочирдмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр тэжээхэд хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болохсон. Хэрэв нэг акр газарт овьёос тарьж малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас

8 дахин их уураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцай (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их уураг, илчлэг, ниацин өгдөг. Ийм тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялаг илүү үр ашигтайгаар зарцуулагдана.

Веган хоол танд энэ гараг дээр "өр төлөөсгүй амгалан амьдрах" боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд, амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

АМЬТНЫ ЗОВЛОН

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100 гаруй мянган үхэр нядалдгийг та бүхэн харсан уу?

Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг "үйлдвэржсэн аж ахуй"-д тэжээж байна. Эдгээр фермүүд бага зардлаар олон мал амьтныг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд тэжээлийн мах бэлтгэх машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. "Чи нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно." гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Ургамал хоол бол хүнлэг, энэрэнгүй чанарын өндөр шалгуур юм.” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтанд ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.

ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид жишээ нь, Платон, Диоген, Сократ нар ургамал хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” хэмээн айлджээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хувраг ургамал хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувуудын хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө.” гэж (Эхлэл 1:29) Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн

өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай.” гэсэн үг юм. (Эхлэл 9:4) “Эзэн Бурхан: Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэгтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ цустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм нүглээ наманчил.” (Исаиа1: 11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг.” гэсэн байдаг. (Ромчуудад илгээсэн захидал, 14:21).

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр тодруулсан олон эртний судар ном олж илрүүлсэн байна. Есүс: “Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол үхдэл хүүрийн мах идэж байгаа хэрэг юм.” гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь “Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!” (Энэтхэг шашны сахил).

Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг.

Хятадын агуу их Зэн Багш Ханьшанзи мах идэхийг эрс эсэргүүцсэн найраглал туурвиж: “Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!” хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаач, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс ургамал хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолдо Эмерсон, Хенри Дэйвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Г.Уэллс, Альберт Эйнштейн, Рабиндранат Тагор, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Альберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар цагаан хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв.

Альберт Эйнштейн хэлэхдээ: “Миний бодлоор бол ургамал хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай юм. Иймээс хүмүүс ургамал хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай юм” гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, цэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Сэтгэл санаагаа сэргээж, өдөр тутмын амьдралд урам зориг өгөхөд зориулан Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сургаал айлдварын баялаг цуглуулгыг ном, видео бичлэг, аудио бичлэг, хөгжмийн хуурцаг, DVD, MP3, CD хэлбэрээр авах боломжтой.

Хэвлэгдсэн ном, хуурцгаас гадна Их Багшийн олон төрлийн сургаалыг интернетээс хурдан бөгөөд үнэ төлбөргүй авах боломжтой. Жишээлбэл, байнга хэвлэгддэг Мэдээний сэтгүүлийг хэд хэдэн цахим хуудсаар унших боломжтой. (“Арьяабалын бясалгалын цахим хаяг” хэсгийг

үзнэ үү.) Бусад онцлох онлайн хэвлэлүүд нь Их Багшийн яруу найраг, урам зориг сэргээх онч үгс, түүнчлэн видео болон аудио файл хэлбэрээр байгаа айлдваруудаас бүрддэг.

НОМ

Завгүй өдрийнхөө дундуур Төгс Гэгээрсэн Их Багшийн номуудын нэгийг сөхөн унших нь чухам л аврал гэлтэй. Түүний үгс нь бидний жинхэнэ Мөн чанарыг тод сануулдаг. Түүний "Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр" цуврал дахь сүнслэг мэдээлэл бүхий айлдварууд эсвэл "Аниргүй нулимсыг хайрлахуй" номын нигүүлсэнгүй яруу найргуудын алийг ч унших нь танд мэргэн ухааны эрдэнэс хүртээх мэт билээ.

Дараах номын жагсаалтад авч болох номын дугаарыг хэл тус бүрээр нь хаалтанд бичсэн болно.

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр

Ау Лак (1-15), Англи (1-5), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-10), Польш (1-2), Португал (1-2), Солонгос (1-11), Тай (1-6), Төвөд (1), Унгар (1), Фин (1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт

Ау Лак (1-4), Англи (1-2), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1-2) Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1-2), Хятад (1-3), Чех (1), Япон (1)

Төгс Гэгээрсэн Багш болон Сүнслэг бясалгагчдын захидлууд

Ау Лак (1-2), Англи (1), Испани (1), Хятад (1-3)

Төгс Гэгээрсэн Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд
Төгс Гэгээрсэн Ау Лак (1-2), Хятад (1-2)

“Долоо хоногийн даяан” /тусгай хэвлэл. 1992 он.
Англи (1), Ау Лак (1)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал, 1993 он.
Англи (1-6), Хятад (1-6)

Их Багшийн ярьсан үлгэр, түүх
Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

Эзэн Бурхан ба хүмүүсийн тухай - Библийн үлгэрүүдээс
Англи, Ау Лак, Хятад
Эзэн Бурхантай шууд холбогдох - Энхтайванд хүрэх зам
Англи, Ау Лак, Хятад

Амьдралаа солонгоруулъя
Англи, Ау Лак, Монгол, Хятад

Эрүүл мэндээ ухаарахуй -
Жам ёсны зөв амьдралын хэв маягт эргэн орохуй
Англи, Ау Лак, Монгол, Хятад

Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд
Англи, Ау Лак, Монгол, Хятад

Гэрт чинь хүргэж өгөхөөр Би ирлээ
Англи, Араб, Ау Лак, Болгар, Герман, Грек, Индонез, Испани,

Итали, Монгол, Орос, Польш, Румын, Солонгос, Түрк, Унгар, Франц, Хятад, Чех

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг
Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!
Англи/Хятад (ном + CD)

Онч мэргэн үгс (1)
Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман, Англи/Солонгос, Англи/Япон

Онч мэргэн үгс (2)
Англи (1), Хятад (1)

Тэнгэрлэг зоог - Олон улсын ургамал хоолны гал тогоо
Англи/Хятад, Ау Лак, Япон

Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт
Англи/Хятад

Диваажингийн урлаг
Англи, Ау Лак, Хятад, Монгол

Жинхэнэ хайр
Англи, Хятад, DVD, MP4

Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)
Англи/Ау Лак/ Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог

Англи/Ау Лак/ Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
урлагийн бүтээлийн цоморлог. Уран зургийн цувралууд
Англи (1), Хятад (1)

Тэнгэрийн хувцас
Англи/Хятад

Миний амьдрал дахь шувууд
Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

Миний амьдрал дахь ноход
Англи, Ау Лак, Герман, Испани, Монгол, Польш, Солонгос, Хятад, Япон

Эрхэм ариун амьтад
Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

ШҮЛГИЙН ЦОМОРЛОГ

Аниргүй нулимс
Англи, Ау Лак, Герман, Испани, Португал, Монгол, Солонгос, Франц, Филиппин, Хятад

Вуузуу шүлгүүд
Англи, Ау Лак, Хятад

Мартагдсан дурсамж
Англи, Ау Лак, Хятад

Хайрга ба Алт
Англи, Ау Лак, Хятад

Эрвээхэйн мөрөөдөл
Англи, Ау Лак, Хятад

Өмнөх амьдралын зам мөр
Англи, Ау Лак, Хятад

Эрт дээр үе
Англи, Ау Лак, Хятад

Эрин зууны хайр
Англи, Ау Лак, Монгол, Хятад

Аниргүй нулимсыг хайрлахуй
Англи, Хятад, CD, DVD, MP4

Амьдрал болоод ухамсрын тухай бодрол

Доктор Янез Дрновшекийн бичсэн ном
Хятад хэлээр

Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган зам мөр номыг *http://crisis2peace.org хаягаар олон хэлээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.*

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

Төгс ГэгээрсэнИх Багш Чин Хайн айлдвар, хөгжим, тоглолтын аудио, видео хуурцаг, MP3, MP4, CD, DVD Араб, Армени, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Финлянд, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Мандарин, Монгол, Непал, Норвег, Перс, Филлипин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словак, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэлээр үзэж танилцах боломжтой.

Бэлэн байгаа ном хэвлэлүүдийн жагсаалтыг авахын

тулд та орон нутгийнхаа Төвөөс лавлаж эсвэл дараах цахим хуудсанд зочилж болно:

http://smchbooks.com/new-c/cover/cover.htm

Celestial: http://www.thecelestialshop.com

Eden Rules: http://www.edenrules.com

Нэмж хэлэхэд, интернэтийн сүлжээгээр цацагдаж буй "Мэдээ" сэтгүүлийн материалуудад саяхан шинээр гарсан ном, хуурцгийн жагсаалтыг тусгасан байдаг.

Хэрвээ шаардлагатай бол та Формоса дахь төв байрнаас шууд захиалан авч болно. Хаяг: P.O. Box 9, Hsihu, Miaoli, Formosa, ROC (36899). Дэлгэрэнгүй каталогийг таны хүсэлтээр үзүүлэх боломжтой.

БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг
Формоса, Мяоли, Шихү, Шуудангийн хайрцаг №9 (шуудангийн код 36899)
Сан Хосе, Калифорни 95173-0247, АНУ, Шуудангийн хайрцаг 730247

Суприм Мастер Телевиз
И-мэйл: Peace@SupremeMasterTV.com
Утас: 1-626-444-4385, Факс: 1-626-444-4386

Ном орчуулгын алба:
И-мэйл: divine@godsdirectcontact.org
(Та Их Багшийн номыг олон хэлээр орчуулах ажилд оролцож болно.)

Мэдээний алба:
И-мэйл: lovenews@godsdirectcontact.org

S.M. Celestial Co., Ltd:
И-мэйл: smclothes123@gmail.com;
Vegann@hotmail.com
Утас: 886-3-4601391
Факс: 886-3-4602857

Цахим хуудас:
http://www.smcelestial.com http://www.sm-celestial.com

Сүнслэг асуулт хариултын баг:
И-мэйл: lovewish@godsdirectcontact.org

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани
И-мэйл: smchbooks@godsdirectcontact.org
Утас: 886-2-23759688
Факс: 886-2-23757689 http://www.smchbooks.com

Онлайн дэлгүүр
Celestial Shop: http://www.theCelestialShop.com (Англи)
Eden: http://www.EdenRules.com/ (Англи, Хятад)

Цэвэр веган бүтээгдэхүүний онлайн дэлгүүр
http://www.lovingfood.com.tw

“Loving Hut” Олон Улсын Веган Хоолны Сүлжээ ресторан
И-мэйл: service@lovinghut.com
Утас: 886-3-4683345
Факс: 886-3-4681581
Цахим хуудас: http://www.lovinghut.com/tw/

АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН ЦАХИМ ХУУДАС

Бурхантай шууд холбогдох - Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:
https://www.godsdirectcontact.org.tw/en2/index.php#related_links

Энэхүү хаягаар та дэлхийн олон хэлээрх Арьяабалын бясалгалын цахим хуудасны хаягт хандах, 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон “Урлагийн Ертөнцөөр Аялахуй” телевизийн хөтөлбөрийг үзэх боломжтой. Мөн “Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр” номын Үлгэр дэвтрийн олон орны хэлээр хэвлэгдсэн хувилбаруудыг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн “Мэдээ” сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

Суприм Мастер Телевиз

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.
Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнаар үзэх хаяг:
http://suprememastertv.com/mn1/

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр (Үлгэр дэвтэр)-ийг олон хэлээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэлээр)
http://sb.godsdirectcontact.net http://www.direkter-kontakt-mit-gott.org/booklet http://www.godsdirectcontact.com/sb/index.html

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр-10

Хятадын эртний домог үлгэр дахь сүнслэг бясалгалын агуулга
Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани
Хаяг: Тайбэй хот, Жүнжэн дүүрэг, Жүнсяю баруун замын 1-р хэсэг, 72-р байр, 8-р давхар, 16 тоот
Утас: 886-2-23759688, Факс: 886-2-23757689
И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org, http://www.smchbooks.com
Шуудангийн дугаар: 19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987~2016
Зохиогчийн эрх: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Энэхүү номын агуулгыг дахин хэвлүүлэх нээлттэй бөгөөд үүний тулд анх хэвлүүлж түгээсэн компаниас зөвшөөрөл авах ёстойг анхаарна уу.

Анхны хэвлэл: 2007 оны 1 дүгээр сар
Гурав дахь хэвлэл: 2011 оны 5 дугаар сар
Хялбаршуулсан хятад хэлээр бичсэн I хэвлэл: 2009 оны 1 дүгээр сар
Хялбаршуулсан хятад хэлээр бичсэн II хэвлэл: 2010 оны 4 дүгээр сар
Кирилл үсгээр бичсэн товчилсон хувилбар: 2015 оны 7 дугаар сар

Энэ хувилбарыг монгол хэлнээ орчуулсан 2023 оны 2 дугаар сар
Цахим хувилбар: http://www.gegeerel.mn/ 2023 оны 4 дүгээр сар
Хоёр дахь цахим хувилбар: 2026 оны 10-р сар

Та бүхэн номын талаарх санал сэтгэгдлээ mon.nomiinbag@gmail.com хаягаар илгээнэ үү.

Улсын номын сангийн бүртгэлийн лавлах

Агшин Зуур Гэгээрэхийн Түлхүүр
Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Дахин хэвлэл Тайбэй хот:
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг 2004
Тайваны он тооллоор 93 он
1 боть; 13x19 сантиметр
ISBN 978-986-6895-01-2 (Боть 1: хатуу хавтастай)
1. сүнслэг бясалгал 2. оюун санааны амьдрал
192.1 93018084

Энэ дэлхийд залран буй Төгс Гэгээрсэн Их Багштай учрахад хэцүү, жинхэнэ дээд номыг хүртэхэд бэрх гэдгийг үнэнийг эрж хайсан бидний бэрхшээлт замнал гүнзгий ухааруулсан юм.

Арьяабалын бясалгалын арга нь эртний жинхэнэ багш нараас уламжлагдан ирсэн охь дээд номын дамжлага мөн учраас хүмүүний мөн чанарын билиг билгүүнийг сэрээж, үнэн номыг ухааруулж чадна.

Энэхүү номын ёсоор бясалгаад бид бүхэн хэмжээлшгүй их ач тусыг хүртсэн тул бидний багш Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон оронд айлдсан дээдийн номын айлдваруудыг эмхэтгэж, энэ төрөлдөө сансрын хүрднээс ангижрахыг хүссэн, жинхэнэ үнэн номыг хайсан, үхэж төрөх, бясалгал, гэгээрэл, үнэн мэдлэгийн тухай асуултууддаа хариулт хайж буй хүмүүст туслахыг зорин энэхүү номыг өргөн барьж байна.